

# МОНГОЛЫН ГАЙХАМШИГТ БРЭНДҮҮД



ХААН БАНК



Gatsuurt



КАПИТАЛ БАНК

# МОНГОЛЫН ГАЙХАМШИГТ БРЭНДҮҮД



ТАЛХ ЧИХЭР ХК

1984  
ТАЛХ ЧИХЭР ХК



MONNIS

МОННИС ИНТЕРНЭШНЛ



BISHRELT



ULAANBAATAR MONGOLIA

МОНОС



# MONGOLIAN BRAND ROYALTY

Монголын гайхамшигт брэндүүд  
Эрхлэн гаргасан: ШИЛДЭГ НОМ цуврал

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Өмнөх үг

"Монголын гайхамшигт брэндүүд" хэмээх эл номонд орсон брэндүүд хэн нэгний хайр хүндэтгэлийг хүлээж, итгэлийг дааж чадсан баялаг бүтээгч бөгөөд хүнлэг зан чанартай. Эдгээр брэндүүдийг сонгохдоо юуны өмнө "Монголын гайхамшигт..." гэсэн шалгуурыг тавьсан билээ. Тийм ч учраас эдгээр брэндийн зарим нь шинэ технологи, шинэчлэн бүтээгч зан төрхийнхөө хажуугаар улс орны нүүр царай болж, олон хүний оюун санаанд гэрэлтэж байдаг ноён сүмбэр байдлаараа шалгуурыг давсан хэрэг. Үүний тодхон жишээ бол Мэгжид Жанраисиг бурхан, Чингис хааны морьт хөшөө юм.

Зарим компаниуд үүнд багтаагүйн учир нь хязгаарлагдмал үйл ажиллагаа, нэг хэв загварт баригдсан сэтгэлгээгээр ажиллаж буй тул брэнд болтлоо хөгжин цэцэглэж, хэрэглэгчийнхээ зүрх сэтгэлд хоногшиж чадахгүй байгаа юм. Уг номонд багтсан эдгээр 38 брэндийн зарим нь олон жилийн туршлагаас гадна зуун хувь хувийн өмчлөлд шилжсэн үеэсээ стратеги, менежментээ хүчтэй явуулж дэлхийн стандартад хүрэх зорилгоо хэрэгжүүлж эхэлжээ.

Мөн улс орны хөгжил дэвшилтэй уялдуулж уурхай, газрын тосны хайгуул судалгаа, олборлолт боловсруулалтыг хийж Монголын нэрийг дэлхийн түвшинд гаргасан Петроматад, Энержи Ресурс, Шарын гол зэрэг компаниуд ч зүй ёсоор энэ номын бүрэлдэхүүн болж байгаа юм. Бас ногоон дэлхий, экологийн чиглэлээр оновчтой бодлого барьж буй Гацуурт, Жастын салбар компани болон үндэсний үйлдвэрлэгч Говь, Гоёо зэрэг ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид ч зүй ёсны байраа эзэлсэн гэж үзэж байна. Шинэчлэл өөрчлөлт, хөгжил дэвшлийн нүүр царай банк, санхүүгийн зөв тогтолцоогоор тодорхойлогддог. Иймээс энэ салбарт мөс зүсэгчийн үүрэг гүйцэтгэж буй Голомт, Капитал, Хадгаламж, Хас, Хаан банкууд ч улсын мөнгөний бодлогыг тодорхойлогч, хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ ойр дөт үйлчилгээ нэвтрүүлж байгаагийнхаа хувьд уг шалгуурыг давж гарсан хэрэг.

Үүнээс гадна импорт экспортын зүй зохисыг зөв хослуулж, дотооддоо жижиг дунд үйлдвэрийг дэмжих бодлогоор ажиллаж байгаа Номин, Бишрэлт, Моннис холдинг болон Монос, MCS группын стратеги, менежментийн шинэлэг, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлсэн байдал нь яах аргагүй "Монголын гайхамшигт" гэсэн шалгуурыг даван туулж байна.

Ер нь номын бүтэц бүрэлдэхүүнийг бий болгохдоо аль болох магтаал рекламнаас зайлсхийсэн бичлэг, бусдад үлгэр жишээ болсон үйл ажиллагаа, шинэчлэгч өнгө аясыг нь товойлгон гаргахыг зорьсон бөгөөд нийгэмд үгүйлэгдэж байсан менежмент, шинэлэг үйл ажиллагааг бий болгосон байдал зэргийг түлхүү анзаарахыг хичээсэн юм. Үгүйлэгдэж байсан үйлчилгээ гэсний гаргалгаа нь дотоодод агаарын тээврийн үйлчилгээний найдвартай байдлыг хангасан Аэромонголиа компани гэхэд МИАГ-ийн дээгүүр алхаж тухайн номыг бүтээгч болсон явдал. Тиймээс жудаг, ёс суртахуун зэрэг зөөлөн шалгуурыг энэхүү номдоо бид тавиагүй бөгөөд зөвхөн үнэнийг эрэлхийлж үйл ажиллагааны зөв урсгалд автаж, сэтгэлгээг сэрүүн тунгалаг болгох өнгө аясыг илэрхийлэхийг хичээсэн билээ.

Эрхэм уншигч та энэ бүхнийг тухайн номноос олж харна гэдэгт бид огтхон ч эргэлзэхгүй байна.



بصيرتكم من  
تجسسكم  
وحطفكم من

**MONGOLIAN BRAND ROYALTY**



ТҮҮХ СОЁЛ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
БРЭНДҮҮД



© Л.ЭЛБЭГЗАЯА



### **Монгол түмний бахархал болсон брэнд**

Хамаг амьтны зовлонг арилгах "УМ МА НИ БАД МЭ ХУМ" хэмээх тарнийг зүрхэндээ гэрэлтүүлсэн бурхан бол Мэгжид Жанрайсиг бөлгөө. Энэхүү зүрхэн тарнийг мэдэхгүй, дотоод сэтгэлээ гэрэлтүүлэн уншдаггүй монгол хүн гэж үгүй биз ээ. Тэнгэр заяат монголчуудын өглөг буянаар бүтсэн Жанрайсиг бурхан нь ХХ зууны хосгүй бүтээл хийгээд гадна дотны хүмүүсийн өмнө улс орны нүүрийг тахалдаг Буддын шашны ариун бурхадын нэг яах аргагүй мөн. Тиймээс ч бид Мэгжид Жанрайсиг бурханаа Монгол түмний брэнд хэмээн нүүр бардам нэрлэж байна.

Аливаа улс орон өөрийн гэсэн тусгаар тогтнол, аюулгүй байдал, газар шороо, байгалийн баялаг, ард иргэдийн сайн сайхан амьдрал гээд олон зүйлийг багтаадаг. Үүний нэгэн адил хамаг бурхан бүгдийн таалал нь нигүүлсэнгүй хэмээх нэгэн мөн чанартай агаад билгийн мэлмийг нээхийн тулд Жанрайсиг бурханыг хувилуулдаг хийгээд Арьяабал.Логишура, Жигдэнванчуг зэрэг гуч гаруй дүр байдаг. Хэдий ийм олон дүрд оршин байвч мөн чанар нь нэг юм.

Мэгжид Жанрайсиг бурхан бол хотол баясгалангийн наран саран гэрлийн төвд цэцгэн мандалд хөл дээрээ тэгш босч өмнөд хоёр мутраараа номын төгс утгыг хураасан тарнийн чагжа тэмдэг зохион, дээд хоёр мутартаа амьтан болгоныг алагчлалгүй үзэх толь, рашаан

бүхний шим дээж бүхий бумба барин бүхэнд туслахын амгалан тайван үйлсийг бэлгэдэж, эрдэнийн дун адил цагаан баринтагийг лагшиндаа асааж, таван язгуурын үзэсгэлэнт тэмдгийг тэргүүндээ өргөөд, алагчлал үгүй сэтгэлийн тусыг гийгүүлэгч мишээнгүй номхон дүрээр амьтныг энэрч, сайн үйлсийн хүсэл бүхний шимийг болгоон ширтэж, эхлэл болоод төгсгөлгүй цагийн чинад, орон зай цаглашгүйгээс энэрэл бүхнийг өршөөхүйн утгыг илт биеэсээ гэрэлтүүлэн байдаг шүтээн бөлгөө.

Анх 1911 онд VIII богд Жавзандамбатан бээр "Мэгжид Жанрайсиг бурханыг наян чи хэмжээтэй бүтээлгэвээс нэн сайн" хэмээн лүндэн буулгаснаар сайшаал дэмжлэгийг олж Монгол улсын тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө төрийн мэлмийг амгалан, гэгээн болгох хоёр их хэргийн үүднээс бүтээж олноо өргөгдсөний гуравдугаар оны зуны эхэн сарын шинийн долоонд Жанрайсиг дуганы дотор түмэн Аюуш бурханаар хүрээлүүлэн оршоож Дашням равнай, Бат-Өлзий өргөх ёслолыг таван өдөр дараалан үйлдэж нийт олноороо чин сэтгэл гүн бишрэл үүсгэн хуран чуулж залжээ. Гэвч энэхүү хосгүй үнэт шүтээн 1935 онд их хэлмэгдүүлэлтэд өртсөн билээ.

1996 онд Монгол улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат сүсэгтэн олон болоод Соёлын сан, МУЭХ, Гандантэгчэнлин хийдийн саналыг дэмжин Мэгжид Жанрайсиг бурханыг дахин залах тухай 33 тоот зарлигийг гаргаж төр, ард түмнийхээ өргөн оролцоотойгоор их шүтээнийг дахин шинээр бүтээж 1996 оны аравдугаар сарын 25-27-нд их Дашням равнай өргөн хоёр дахь удаагаа залсан түүхтэй.

Монгол улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж уг шүтээнийг урлан бүтээх, цогцлоон равнайлах ажлыг Засгийн газарт даалгахын зэрэгцээ энэ их ажилд бүхий л талаар дэмжин оролцсон явдал нь Мэгжид Жанрайсиг бурханыг улсынхаа хойморт төрийн их шүтээнээр нандигнан залж байх төрийн бодлого байлаа.

Мэгжид Жанрайсиг шүтээнийг дахин залах тухай ард иргэд, сүсэгтэн олны санал санаачлагыг МБШТөв Гандан тэгчэнлин хийдийнхэн тун сайхан хүлээн авч төр, түмний өглөг хандиваар эдүгээ монголчуудын оюун шүтэхүй, урлан цогцлуулахуйн брэнд болсон Мэгжид Жанрайсиг бурхан маань дахин мэндэлсэн билээ. Монгол хүмүүний ур ухаан, авьяас билиг гэдэг юутай арвин, юутай хосгүйг бүтээх чадвартай болохыг дан ганц энэ л бурханыг бүтээсний жишээн дээр өгүүлэхэд хангалттай.

Тухайн үед Хамба лам Д.Чойжамц хэлэхдээ "Мэгжид Жанрайсиг шүтээний бүтээлийн үйлсэд даган баяссанаар аливаа зовлон гамшиг, өлзий бус бүхнийг амирлуулж, буян хишиг дэлгэрүүлэн, хотол олноор ариун шимийн дээд утгыг танин гэгээрч, төр улс, түмэн олны билгийн мэлмийг цог төгөлдөр болгогч их бурхан энх амгалан бүтэж, Монгол улсын тусгаар тогтнол өнө бат байхын сахиус болохын учир бүрдмүй. Буян сүсэг арвидах болтугай" хэмээн сүсэгтэн олон түмнээ дэмжин уриалан дуудсан нь Мэгжид Жанрайсиг бурханыг түмэн олныхоо шүтээнд нандигнан залж байх Монголын бурханы шашны бодлого байлаа.

Ийнхүү төр, шашны бодлого Мэгжид Жанрайсиг бурханыг шүтээнээр залахад хослон нэгдсэн түүхтэй.

Харин монгол түмний "Амьд бурхан" хэмээн хүндлэн биширдэг Дээрхийн гэгээн



Далай багш Данзанжамц айлдахдаа "Сүрлэг том Мэгжид Жанрайсиг бурханыг бүтээж байгаа нь юутай сайн. Их Бурханы шүншгийг жинхэнэ шашны ном ёсоор, аль болох нандин сайн хийхийг чухалчлаарай" хэмээн захиж бурхан багшийн өмнөх Одсүрэн бурханы шүдний пэлдэн, судар тарнийн ном, Богд Зонхова болон түүний шавь нарын зохиол бүтээл, тэдний лагшиндаа асааж байсан намжирын хэсэг, мөн өөрөө өвөртлөн ирсэн бурхан багшийн ринсрэл, их бурханыхаа зүрхэн тус нандин газарт залаарай хэмээн манай Богд нарын өмнөх дүр Жонон Дарнатыг шүтэж байсан удаа дараагийн Далай багш нарын тэргүүний үс, XIII Далай лам, X Ванчин Богд нарын гарын ураар бүтсэн бурхадын дардас, бурхан багшийн дүрийг цагаан хадгийн хамт өргөсөн бөгөөд мөн бурханы бумбыг равнайлан адислаж өгсөн нь их шүтээнээ нандигнан залахыг хүссэн Монгол хүн бүрийн сэтгэлд наран мандсан адил үйл явдал болжээ.

Мөн тухайн үед Энэтхэгт суралцаж байсан Г.Пүрэвбат ламтанг шүншиглэн бүтээх ёсонд суралцуулж шашныз өвлөхөөр ажиллуулсан бөгөөд их бурханыг бүтээх үйлст Ерөнхийлөгч П.Очирбат, Соёлын сайд Н.Энхбаяр, Энэтхэгт суугаа Элчин сайд Н.Чулуундорж нарын олон хүн сэтгэл оюунаа дайчлан зүтгэсэн юм.

Шүншиглэх зан үйлийг хэрхэн гүйцэлдүүлсэн талаар товч өгүүлбэл, Богд уулаас залсан амин модыг урлахуй ёсны дагуу бэлтгэж засаад бурханы тэргүүн, хоолой, зүрх, хүйс нууцын орны таван хүрдэн тус газарт үүсгэлийн хөрөнгө үсгүүдийг дөрвөн талд нь алтаар бичиж тэмдэглээд байх ёстой тогтоол тарни, соёрхол сожон, бат оршилын номыг өргөжээ. Мөн Бурханы үс нэрийн, тэргүүний, хоолойн, тааллын, лянхуан суурины шүншгүүдийг гол номлолд заасны дагуу ёсчлон гүйцэтгэжээ.

Чингээд зогсохгүй урлах, мэдрэх, хүртэхүйн бэлгэ тэмдэг болон морин хуурын аялгууг шингээн эгшиглүүлж, нүүдэлчин монголчуудын амьдрал аж ахуй, орон суурин, зан үйл, аж төрөхүйн хишиг даллага болгож өргөө цагаан гэр барьж тулганд нь галаа бадрааж, цайгаа чанан дээжлээд 84 зүйлсийнх нь хамт өргөсөн түүхтэй. Энэ бол 1996 оны 4-р сарын 7-ны өдөр.


Их шүтээнийг шүншиглэж, алтдаж дууссаны дараа бурханаа бүрэн төгс бүтээх ёс нь "мэлмийг нээх" бөгөөд 1996 оны 9-р сарын 20-ны өдрийг сонгон товлож энэ өдөр зурж бүтээн "мэлмийг нээх" шүтээн урлагаа төгс төгөлдөр гоо сайхны манлай болгон амилуулсан билээ.

## "Женко тур бюро" ХХК

### Аялал жуулчлалын гайхамшигт брэнд

Женко Тур Бюро ХК бол аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Монголын аялал жуулчлалын ууган компаниудын нэг. Тус компани 2005 онд аялал жуулчлалын салбарт давтагдашгүй өнгө төрхийг харуулсан үзмэр, цогцолборууд хийхээр санаачилж төслийн ажлаа эхлүүлсэн билээ. Тэд жилийн дараа л эртний монголчуудын аж байдал, ахуй соёлыг харуулсан XIII зуун цогцолборыг ашиглалтад оруулж Монголын аялал жуулчлалын салбарт нэгэн шинэ хуудсыг нээв. XIII зуун нь монголчуудын үе байсан хэмээн дэлхий дахинаараа нэгэнт хүлээн зөвшөөрч гайхан биширсээр байгаа нь тохиолдлын хэрэг биш юм.





Энэ зуунд монголчууд дэлхийн түүхийн тавцан дээр гэнэт тэсрэлт болон гарч ирсэн нь хүмүүн төрөлхтөний түүхийн зүй тогтлоор үүдэн гарсан урьд хожид гараагүй хосгүй явдал билээ. XIII зуунд Өрнө, Дорнын олон улс түмнийг нэгэн тугийн дор нэгтгэсэн монголчууд дэлхий дахины улс төр, соёл урлаг, худалдаа бизнесийн орчныг хөдөлгөөнд оруулсан гэж үздэг. Харин бид Чингис хааны удирдлагаар дэлхийн талыг эзэлж байсан XIII зууны үеийн ахуй амьдрал, ёс заншил, цэрэг

дайны тухай кино дэлгэц, сонин сэтгүүл, театрын тайзнаас харж мэдэж болох ч өөрөө яг тэр орчин дотор нь алхаж явах боломж байхгүй билээ. Тэгвэл Женко Тур Бюро компани энэхүү боломжийг бий болгон өвөг дээдсийнхээ амьдарч байсан тэрхүү аугаа он цагийг нийт монголчууддаа төдийгүй дэлхий дахинаа нээн үзүүлэхийн тулд XIII Зуун цогцолбор төслийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. XIII Зуун цогцолбор нь Улаанбаатар хотоос 96 км зайд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Ёл уулын эргэн тойрон 88 га газарт байрлаж буй юм.

Төслийн хүрээнд XIII зууны монголчууд хэрхэн амьдарч, хөдөлмөрлөж байсныг бодитоор бий болгон зочдыг тухайн цогцолборт үзэж сонирхоход нь цаг хугацааны машинд суусан мэт сэтгэгдэл төрүүлэх, бичил хаант улс байгуулах зорилтыг тавьжээ. Цогцолборт Монгол үндэстний аж амьдрал, ёс заншлыг харуулсан хонио ноослон эсгий хийх, төл малаа хөнгөлөх, цагаан идээ боловсруулах гэх мэт зан үйл болон жилд ганц зохиох Туг, Тэнгэр

тахих зан үйл, Хурим найрын ёслол, Гүү барих, Үрс гаргах, Унага тамгалах, Эрийн гурван наадам зэрэг онцгой тэмдэглэлт ёслолуудыг үзэх боломжтой юм.

Улмаар Женко Тур Бюро компанийнхан 2008 онд Чингис хааны хөшөөт цогцолборыг ашиглалтад оруулж Монголын төдийгүй дэлхийн түүхэнд хамгийн сүрлэг Чингис Хааны морьт хөшөөг босгосон нь өдгөө Монгол Улсын аялал жуулчлалын брэнд үзмэр болоод байна.

Уг цогцолбор Улаанбаатар хотоос 54 км зайд байгалийн үзэсгэлэн цогцолсон Туул голын ойролцоо Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Цонжин болдог хэмээх түүхэн үйл явдалтай холбогдох газар байрладаг. Уг газар нутгаас Тэмүүжин багадаа ташуур олсон гэдэг домог бий бөгөөд энэ үйл явдал нь дэлхийг эзэлсэн их хааны байлдан дагуулалтыг бэлгэдсэн ид шидийн зүйл байсан гэдэг. Энэхүү нүсэр бүтээн байгуулалт нь Монгол улсын бахархалд чухал нөлөөтэй зүйл юм.

Чингисийн морьт хөшөөний нийт өндөр нь газрын гадаргаас дээш 40 метр, суурь нь 10 метр орчим өндөр баганаар хүрээлэгдсэн байгууламжтай аж. Цогцолборын нийт талбай 100 га бөгөөд төвд нь морьт хөшөө байрлана. Хөшөөний эх биеийг дөрвөн мм зузаантай 250 тн ган төмөр хийцээр урлажээ.

Морьт хөшөөг тойрон 200 гаруй гэр буудал, хиймэл нуур, спорт талбай, үйлчилгээний төвүүд байхаар төлөвлөгджээ. Хөшөөний ерөнхий архитектур дизайнер нь Монгол улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Эрдэмбилэг юм.

Чингис Хааны хөшөөт цогцолбор нь суурийн байгууламжиндаа уран зургийн галерей, үзэсгэлэнгийн танхим, Хүннү гүрэн хүрэл зэвсгийн үеийн музей, дэлхийн хамгийн томд тооцогдохуйц есөн метр өндөртэй монгол үндэсний гутал, зоогийн газар, хурлын танхим, бэлэг дурсгалын дэлгүүр зэрэг үзвэр, үйлчилгээний газруудтай бөгөөд хөшөөний эх бие нь барилгын конструкцйн хувьд морины сүүл дотуур цахилгаан шатаар өгсч, морины дэлэн дээр гарч хааны мэлмий дороос Чингис хааны төрсөн нутгийн барааг харах боломжтой юм.

Морины хөшөө нь гангаар хийгдсэн бөгөөд Чингис Хааныг наран ургах зүг хандуулан баруун гарт нь алтан ташуур бариулан, бүсний аралд нь мөнхийн бэлгэдэл болох нар, сар, гал гурвыг, морины цээжин хэсэгт Боржигон овгийн сахиус болох Цагаан шонхор шувууг шигтгэн урласан нь тун гоёмсог, сүрлэг харагдуулдаг.

Монголын Аялал жуулчлалын холбоо, БОАЖЯ зэрэг байгууллагууд санаачлан байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газар, хүний гараар бүтсэн хосгүй нандин бүтээл гэсэн хоёр зүйлээр Монголын есөн гайхамшигийг тодруулах ажлыг 2008 онд эхлүүлсэн юм. Уг шалгаруулалтад нийт 113 материал ирсэний 37 нь байгалийн үзэсгэлэнт газар, 76 нь хүний гараар бүтсэн бүтээл байсныг шигшиж, ард түмний дунд нээлттэй санал авалтыг өдөр тутмын сонин, телевизүүд, вэб сайтуудаар авчээ. Женко Тур Бюро ХК-ийн байгуулсан 13-р зууны цогцолбор, Чингисийн морьт хөшөөт цогцолбор нь олон санал авч Монголын есөн гайхамшигт багтсан байна.

Чингисийн морьт хөшөө нь зөвхөн гадаадын зочин гийчдийн нүдийг баясгах бус дотоодын жуулчид, монголчуудад зориулагдсан брэнд үзвэр юм. Хүүхэд багачуудын танин

мэдэхүйн хүрээг тэлж, их түүхээрээ, Монгол хүн болж төрснөөрөө бахархах омогшил, бардамналыг бий болгоход энэ үзвэрийн хамгийн гол ач холбогдол оршино.

Энэхүү цогцолбор нь Их эзэн Чингис хааны дурсгалын хамгийн том цогцолбор болохынхоо хувьд монгол хүн бүр очиж үзвэл зохих байгууламж байх бөгөөд нийслэл хотод ойр байрлалтай, ирж очиход зардал, цаг хугацааны хувьд ч ихээхэн хэмнэлттэй юм. Монголын төдийгүй дэлхийн аялал жуулчлалын үзмэрийн шинэ брэнд болон сүндэрлэсэн гайхамшигт урлагийн бүтээл Чингисийн морьт хөшөө нь үеийн үед алдар суугаа мандуулсан эзэн Чингис хааны нэр алдар шиг мөнхийн брэнд байх нь лавтай юм.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.genco-tour.mn](http://www.genco-tour.mn) Байгуулагдсан он: 1997 он

Компанийн хаяг: Монгол Улс.Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал-офис, 4 тоот

Үйл ажиллагааны чиглэл: inbound, outbound, domestic болон жуулчны баазын үйлчилгээ үзүүлдэг.

## Тухлаг орчныг түмэнд мэдрүүлсэн брэнд

Төв Азийн цээжинд орших Монгол орныг харийнхан гандаж сэмэрсэн эсгий гэрт амьдардаг, сайртсан улаан хацартай, хөдсөн дээлтэй хүмүүс талын нэг тарчихсан нүүдэлчин ард түмэн хэмээн төсөөлж байсан цаг саяхан билээ. Дэлхийн хамгийн хоцрогдсон, буурай хөгжилтэй улсын нэг болох Монголд Ардын хувьсгал ялснаар тусгаар тогтнолоо тунхагласан ч хойд хөрш ЗХУ-ын хараа хяналтад бид 70 жилийг өнгөрүүлсэн билээ. Энэ бүх хугацаанд бид хаагдмал байдалд байж, дэлхийн хөгжлөөс ангид явж ирсэн. Дэлхийн талыг эзэлсэн их Эзэн Чингис хааны суу билгийг соёлт хүмүүн төрөлхтөн марталгүй манай улсыг зорьж, танин мэдэхийг хүсч байсан нь ойлгомжтой. Гагцхүү бид тэдний өмнө том хэрмэн хана босгочихсон байлаа.

1980-аад оны сүүлчээр ардчилал, өөрчлөн байгуулалтын салхи хөдөлж тэрхүү хэрмэн хана нурсан билээ. Ингэснээр Монгол Улсыг зорих жуулчдын цуваа ийнхүү тасралтгүй хөврөх болсон юм. Гэтэл тэднийг хүлээн авч, тохь тухтай байлгах зочид буудал байсангүй. Ердөө л "Улаанбаатар", "Баянгол" гэсэн хоёрхон буудал байсан гэхэд хилсдэхгүй. Дээр нь аялал жуулчлалын бизнесийн нарийн учрыг манайхан төдийлөн ойлгодоггүй байв. Гадны жуулчид манайд ирээд чанартай үйлчилгээ авч чадахгүй, хөдөө гадаа явсан нэг нь гэрт хоноглож, хээр гадаа бие засч, үүнээс үүдсэн онигоо хүртэл зохиогдож байсан юм. Халуун усанд орохын тухайд бодохын ч хэрэггүй байлаа. Энэ хэрээр Монгол Улс жуулчлалаас орж ирэх асар их мөнгийг шингээх чадваргүй байв. Тиймээс бид ч гэсэн гоё сайхан үйлчилгээ, тав тухтай орчныг өөрсдөө хүсэмжлэн гадаад орныг зорих болцгоосон юм.

Тэгвэл Гацуурт компани үүнд цэг тавихаар шийджээ. Үүгээрээ тэд дэндүү зоримог алхам хийв. Гацууртынхан байгалийн сайхан цогцолсон газарт дэлхийн хэмжээний үйлчилгээ, тав тухыг мэдрүүлэх өндөр зэрэглэлийн зочид буудал барихаар зориглож ажилдаа оржээ. Тэдний уйгагүй зүтгэл, нөр их хөдөлмөрийн үр дүнд байгуулагдсан Тэрэлж зочид буудал нь Горхи Тэрэлжийн байгалийн Дархан цаазат цогцолбор газарт орших Монголын хамгийн анхны тансаг зэрэглэлийн таван одтой зочид буудал бөгөөд "Дэлхийн Жижиг Тансаг Буудлуудын холбоо"-ны гишүүн юм. Нийслэл Улаанбаатар хотоос 65 километрийн зайд сүрлэг уул, цэнгэг ус, цэвэр агаарын эх булаг болсон үзэсгэлэнт байгаль дунд сүндэрлэх Тэрэлж зочид буудал болон Тэрэлжмаа спа нь ирсэн зочид гийчдэд тансаг харшийн өнгө төрх хийгээд зочлохуйн урлагийн гайхамшигийг мэдрүүлж байна. Их гүрнийг байгуулсан Эзэн Чингисийн уугуул нутаг дахь Тэрэлж амралтыг шинэчлэн засварлаж, гэр бүлээрээ ирсэн зочдод зориулсан өрөө хоёр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандарт энгийн өрөө хоёр, энгийн стандарт өрөө 18, дээд зэрэглэлийн люкс өрөө, жүниор жижиг стандарт энгийн өрөө 12, дээд зэрэглэлийн ерөнхийлөгчийн өрөө нэг, бал сараа тэмдэглэгсдийн өрөө зэрэг нийт долоон төрлийн 52 өрөө, өөр өөрийн өвөрмөц онцлогтой зоогийн газрууд, дээд зэрэглэлийн спа гоо сайхан, усан бассейн, саун, уурын өрөө, жакүзи, фитнес клуб, тоглоомын талбай, хурлын иж бүрэн хэрэгсэл бүхий өрөө, хуримаа мартагдашгүй тэмдэглэн

Өнгөрүүлэх танхим бүхий өргөө босчээ.





Гацуурт ХХК-ийн зуун хувийн хөрөнгө оруулалттайгаар сүндэрлэсэн тус буудал Монгол улсын аялал жуулчлалын салбарт хийсэн хамгийн том хөрөнгө оруулалт гэж болно. Канадын Graham & de Araujo ХХК-ийн мэргэжилтнүүдийн гаргасан дизайны дагуу канад инженерийн удирдлага дор барилгачдын уран чадварлаг, нөр их хөдөлмөрөөр баригдсан билээ. Хуучин Тэрэлж амралтын газрын нурсан балгасыг эдгээр олон орны нарийн мэргэжлийн ажилчдыг хөлслөн чанарын өндөр түвшинд долоон корпус бүхий хоёр давхар, уртаашаа сунаж байрласан барилгыг босгоход таван жил зарцуулсан гэдэг.

Аливаа зочдод ямар ч үед ирсэн сайхан сэтгэгдэл төрүүлдэг өндөр үйлчилгээ гэдэг үгний цаана бүтээгдэхүүний чанар байнга нягт уялдаатай байдаг. Тэрэлж зочид буудал нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн брэнд бүтээгдэхүүнээрээ үйлчлүүлэгчдээ татдаг агаад тэдний сэтгэл ханамжийн баталгааг хадгалсаар ирсэн билээ. Бага зүйл гэж орхигдуулалгүй анхаарч ажилладаг болохыг буудлын засал чимэглэл, өрөөний тохилог тавилга, цэвэр цэмцгэр байдал, амьд цэцгийн сэнгэнэсэн үнэрээс харж болно. Дэлхийн алдарт сүлжээ буудлуудын хэрэглэдэг мини баар, зоогийн газар, зочин хүлээн авах хэсгийн тооцооны тогтолцоо нь Монголдоо анхных юм.

Өөрийн гэсэн онцлог бүхий тав тухыг хангасан гурван зоогийн газар болон гурван кафе, бааранд франц, бельги, филиппин, монгол тогооч нарын олон орны зоогийн тусгай



жорын дагуу бэлтгэсэн хоол, зууш, амттан тэргүүтнийг тухлан хүртэх боломжтой. Дэлхийд алдартай гал тогооны тоног төхөөрөмж болох Хобарт (Hobart), Алта Шаам (Alta Shaam) зэргээр бүрэн тоноглогдож, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан цэвэр орчинтой хоёр гал тогоо энд бий.

Тус буудалд байрлах Тэрэлжмаа спа, гоо сайхны салонд гадны мэргэжилтний удирдлага дор бэлтгэгдсэн гоо сайханч нар зочдынхоо алжаалыг тайлах олон төрлийн массаж, маникюр, педикюр, гоёлын үс засалт зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Тэрэлжмаа спа Францын Phytomer, Английн алдарт Crystal Clear, Aromatherapy Associates брэндийн гоо сайхны бүтээгдэхүүнээр үйлчилэхээс гадна Америкийн алдарт Jessica брэндийн маникюр, педикюрын иж бүрдэл хэрэгслээр үйлчилж тав тухтай орчинг бүрдүүлжээ.

Тэрэлж зочид буудалд тухласан ямар ч зочин мэдээж хэрэг усан бассейнд оролгүй өнгөрнө гэж үгүй. Энэхүү бассейн нь 23 метр урт, есөн метр өргөн, 1,8 метрийн гүнтэй, эргэн тойрны ханан плита нь халаалттай юм. Бассейны усыг хэт ягаан туяаны тусламжтайгаар цэвэршүүлж, зохих стандартад нийцсэн халууны хэмд байлгадаг аж. Мөн Финланд улсын Naivia брэндийн нарс модоор хийсэн саунтай бөгөөд бассейны хажууд байрлах фитнес өрөө нь Италийн Technogym брэндийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

Тэрэлж зочид буудал нь үндэсний өнгө төрхийг орчин үеийн тансаг хэв маягтай хослуулсан бөгөөд ирж буй зочид нь Монголын эртний эдлэл, үндэсний өвийн цуглуулгуудаас сонирхох төдийгүй түүх соёлтой танилцаад явах боломжтой юм. Буудлын ханаар өлгөсөн Монгол орны түүхийн гэрч болсон урлаг, соёлын хосгүй бүтээлүүд нь ирсэн гийчдийн нүдийг баясгаж, сэтгэл сэргээх өвөрмөц онцлогтой юм.

Энд амралт, ажил, хурим найр гээд аль ч зорилгоор ирсэн Тэрэлж зочид буудал нь үргэлж халуун дулаан уур амьсгал, мартагдашгүй дурсамжийг үлдээх болно. Танд үзэсгэлэнт уул ус, онгон байгаль, эсгий гэрт аж төрж буй Монгол айлыг үзэж сонирхох санаа төрж болох юм. Монголын онгон байгалийг үзэж нүд тайлахаар ирсэн нэгэнд нь "Тэрэлж-Тур", "Улаанбаатар Хот-Тур" зэргийг зочдын хүсэлд нийцүүлэн зохион байгуулдаг байна. Буудлын гадна болон дотор байрлах нүүдэлчин монголчуудын аж төрдөг үндэсний гэрийг жуулчин, гийчид заавал үзэж сонирхдог.

Тэрэлж зочид буудал гэр бүлийн буудал гэж нэрлэгддэг нь гэр бүлээрээ ирж буй зочдыг үргэлж найрсгаар хүлээн авч бүх насныханд цагийг зугаатай, үр бүтээлтэй өнгөрүүлэх амралтын хэсэг, тоглоомын талбай, хүүхдийн кпуб зэрэг олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг аж.

Зөвхөн зуны цагт бус жилийн дөрвөн улиралд Тэрэлж зочид буудалд та амрах боломжтой. Тэсгим өвөлд ч мөсөн хотхон, мөсөн гулгуурын талбай, морин тэрэг, бамбартай аялал гэх мэт сэтгэл хөдөлгөм адал явдлаар дүүрэн өвлийн харшид байгаа мэт тансаг мэдрэмжийг ч эндээс авч болно.

Жил бүр уламжлал болсон баяр цэнгүүнийг Тэрэлж зочид буудал алгасалгүй

тэмдэглэдэг сайхан уламжлалтай тул сүүлийн үед анд найз, гэр бүл, хамт олноороо баярын өдрүүдийг энд хамтдаа тэмдэглэж хэзээ ч мартагдахааргүй дурсамж дүүрэн гэр гэртээ харьцгаадаг уламжлал тогтоод байна. Өнгөрсөн жил Шинэ оноо угтах гэсэн хүмүүст зориулсан тусгай багц үйлчилгээг хямд үнэтэйгээр хүртэх боломжийг олгосноор хамт олон, гэр бүлээрээ ирж амрагсдын тоо нэмэгдэж буудал бүрэн хүчин чадлаараа ажиллахад хүрчээ.

Тэрэлж зочид буудал байгуулагдаад удаагүй ч богино хугацаанд Монголдоо төдийгүй дэлхийн хэмжээнд үйлчилгээний стандарт, тохь тухаараа танигдаад байна. 2010 онд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим тус буудлыг байгальд ээлтэй байгууллагаар тодруулж, эко шошго олгосон агаад Тэрэлж зочид буудал таван навчны болзол хангаж өргөмжлөгдсөн байна. Мөн оны аравдугаар сард Тайланд улсад зохион байгуулагдсан Дэлхийн Тансаг Зочид Буудлуудын Шагналт уралдаанаас Тансаг зочид буудал номинацийн эзнээр тодроод байгаа билээ.

Энэ мэтчилэн Тэрэлж буудлын чанар чансааг дурдвал маш олон хуудас болох учраас та бүхэн өөрсдөө очиж нүдээрээ үзэн, биеэрээ мэдрэх нь хамаагүй дээр биз. Тэрэлж зочид буудлыг зорих гадаад, дотоодын гийчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна.

### **Амжилтын нууц**

- Тэрэлж зочид буудал Монголд анх удаа таван навчны болзол хангаж, байгаль орчинд ээлтэй байгууллагаар тодров.
- Дэлхийн Тансаг Зочид Буудлуудын Холбооноос 2010 оны аравдугаар сард Тансаг зочид буудал номинацийн эзнээр тодруулжээ.
- Эзэнгүйдсэн балгасыг Гацуурт ХХК зуун хувь дангаар хөрөнгө оруулж тавхан жилийн дотор уг буудлыг ашиглалтад оруулжээ.
- Ирсэн зочид гийчдийг тав тухтай байдалд байлган, дэлхийн хэмжээний үйлчилгээг үзүүлдэг.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.tereljhotel.com](http://www.tereljhotel.com) Байгуулагдсан он: 2008 он

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хотоос 65 километрийн зайд орших Горхи Тэрэлжийн Байгалийн Дархан Цаазат цогцолбор

Үйл ажиллагааны чиглэл: Зочид буудлын үйлчилгээ, аялал жуулчлал



## **Монгол орныг дэлхийд таниулсан брэнд**

Эзэн Чингисийн цэргүүд тив дэлхийг байлдан дагуулж асан тэр л цаг үеэс чухамхүү монголчууд бид харийн соёл, түүх, ёс заншлыг бага сага судалж мэдэхийн сацуу гадаад ертөнцийг анх нээж байсан түүх бий. Монголчууд харь улсыг эзлэн авч "нээдэг" байсан тэр үед монголчуудын догшин довтолгоон, юунд ч саатахгүй үерийн ус шиг дайралтаас айсан гадаадынхан элч төлөөлөгчөө явуулж, "Монгол гэж ямар улс юм бол?" гэж сонирхож байжээ. Ийм зорилготой жуулчдын жишээ бол Марко Поло, Плано Карпини, Вильгельм Рубрук нар юм. Эндээс харахад монголчууд аль дээр үеэс аялал жуулчлал үүсч хөгжихөд хүчтэй нөлөө үзүүлсэн гавьяатай үндэстэн билээ. Тэгвэл орчин цагийн даяаршиж буй өнөө үед гадаадад зорчиж, галуу шувууны мах иднэ гэдэг ердийн үзэгдэл болсон гэхэд хилсдэхгүй. Тэр ч бүү хэл, монгол хүн харь нутагт ажиллаж амьдарч, сурч боловсрох, гадны соёл иргэншлийг сонирхон судлах явдал байдаг л нэг хэвийн зүйл болжээ.

Дэлхий нийт сүүлийн үед манай улс руу ихээхэн анхаарал хандуулж байна. Энэ нь зүй ёсны хэрэг. Чингисийн Монгол бол эзгүй хээр тал нутаг гэж, хэдэн бор гэрээ шовойлгон амьдардаг нүүдэлчин мэтээр гадныхан биднийг төсөөлдөг байсан цаг саяхан билээ. Харин ардчиллын буянаар хил хязгаар чөлөөтэй болж гадаадын жуулчдын Монголд айлчлах хүсэл сонирхол ихэд нэмэгдэх болов. Улс орныхоо үүсэл хөгжил, соёл иргэншил, түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газар гээд харийн гийчдийн сонирхсон бүхнийг үзүүлж, санаснаар нь болгохыг зорьж тэмүүлж байдаг аялал жуулчлалын олон байгууллага дотроос Нью Жуулчин Туре брэнд бол яах аргагүй тэргүүлэгчдийн эгнээнд жагсана.

Тус компани 2003 оноос эхлэн Монголын аялал жуулчлалын зах зээл дээр өөрийн гэсэн нэр хүнд, байр суурийг бий болгох, улмаар Монголын аялал жуулчлалын тэргүүлэх компанийн нэг болох зорилтыг тавин үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм. Компанийн үйл ажиллагаа эхэлснээс хойш багахан хугацаа өнгөрсөн боловч дэлхийн аялал жуулчлалын зах зээл дээр Juulchin World Tours Corporation of Mongolia гэсэн өөрийн брэндийг бий болгож чадав.

Монгол орны цэвэр байгаль, нүүдэлчдийн түүх, ахуй соёл, эдгээрт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох ажлыг тэд шинэ эрч хүчээр хийж байна. Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлалын салбарын уламжлалт болон сонгодог бүтээгдэхүүний зэрэгцээ авто ба мото аялал, тэмээн жингийн хийгээд явган адал явдалт аялал, нүүдэлчний соёл ахуйтай танилцах аялал, цэвэр байгаль чимээгүй орчинд алжаал тайлах аялал, галт тэргээр Орос Монгол Хятад орноор нэвт явах аялал зэрэг 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн бий болгож гадаад зах зээлд худалдаалж байгаа нь өнөөгийн дэлхий нийтийн анхаарлын төвд буй Монгол орны хувьд ойрын ирээдүйд аялал жуулчлалын салбар улам бүр хөгжих магадлал өндөр байгааг илтгэнэ.

Үүний үр дүнд 2010 оны жуулчны улиралд тус компани дэлхийн 20 гаруй орны 100 гаруй пүүсийн найман мянга орчим анчин, жуулчинг хүлээн авч үйлчлэхдээ 3.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 400 сая орчим төгрөгийн ашигтай ажиллажээ. Нью Жуулчин Туре компани уламжлалт болон өөрийн брэнд болсон аяллуудыг зохион байгуулсны зэрэгцээ аялал жуулчлалын зах зээл дээр МIСЕ хэмээн нэрлэгддэг бизнес уулзалт, incentive аялал, хурал зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг гэсэн бүтээгдэхүүний шинэ чиглэл, мөн спорт аялал, монголчуудад зориулсан аяллуудыг амжилттай зохион байгуулав. Сүүлийн жилүүдэд гэхэд Олимпийн албан ёсны тасалбар борлуулагчаар шалгаран ажиллахдаа Афин-2004 Зуны олимп, Турин-2006 Өвлийн олимпийн хөгжөөн дэмжигчдийн аялал, Доха-2006 Азийн наадмын хөгжөөн дэмжигчдийн аяллыг гардан гүйцэтгэжээ.

Монголын Үндэсний Олимпийн Хороо, Бээжин-2008 Зуны олимпийг зохион байгуулах хороотой хамтарч Зуны 29-р олимпийн "албан ёсны тасалбар борлуулагч"-ийн онцгой эрхийг авч, үзэгч, хөгжөөн дэмжигчдийн долоо хоногийн аяллыг амжилттай зохион байгуулжээ. Энэ үеэр Монголын баг тамирчдын гаргасан бахдам амжилтад тэдний буянаар явсан олон мянган хөгжөөн дэмжигчид ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэхэд буруудах зүйлгүй.

Түүнчлэн Нью Жуулчин Турсынхан Ванкувер-2010 Өвлийн олимпийн албан ёсны тасалбар борлуулагчаар ажиллаж,

Гуанжоу-2010 Азийн наадмын хөгжөөн дэмжигчдийн аяллыг зохион байгуулахын зэрэгцээ бид бүхний хүсэн хүлээж байгаа Лондон-2012 Зуны олимпийн тасалбар борлуулах онцгой эрхийн гэрээг Лондонгийн Олимп зохион байгуулах хороо, Үндэсний Олимпийн Хороотой байгуулан бэлтгэл ажилдаа ороод байна.

Тус компани Монгол орны баруун бүс нутгийг хамарсан нарны бүтэн хиртэлтийг ажиглах аяллын гэрээг 2006 онд хийсэн бөгөөд үүний бэлтгэл ажил болгож 50 гэр, 100 хүний суудалтай ресторан, боловсон бие засах газар, халуун ус бүхий түр хугацаагаар ажиллах жуулчны баазыг байгуулж 280 хүний аяллыг Ховд аймгийн Үенч сумын нутагт зохион байгуулсныг та санаж байгаа байх.

Тэд жуулчдад зориулж Япон, Солонгосын тусгай нислэг, Монгол үндэсний найрал хөгжмийн өдөр, Чингис хааны морин цэргийн үзүүлбэр, Алтан наадам зэрэг олон талт арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. Брэндийнхээ имижийг олон талаас нь харж бодож тооцоолж бүрдүүлэхээ Нью Жуулчин Турсынхан сайн мэднэ. Зөвхөн өнгөрөгч онд гэхэд тус компанийн хамт олон монголчуудынхаа нүдийг нээж Хонконгийн шууд нислэг, Дэлхийн Хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг үзэж сонирхох хөгжөөн дэмжигчдийн аялал, Шанхай Экспо 2010 аяллыг амжилттай зохион явуулж Хайнан, Бээжин, Малайз, Сингапур, Вьетнам, Индонез, Эмират, Итали, Франц, Герман, Япон зэрэг дэлхийн 20 шахам оронд мянга гаруй хүн аялуулжээ. Эдүгээ Японы зах зээл дээр MJ tours Co.,Ltd, Америкийн зах зээл дээр Mongolian travel USA Incorp, Европын зах зээл дээр Mongolei Reizen GmbH, Хятад, Зүүн Өмнөд Азийн зах зээл дээр Juulchin World Tours Beijing office зэрэг төлөөлөгчийн газруудад зогсоо зайгүй ажиллаж байна.

Жуулчны үйлчилгээтэй холбоотой ажлын байр шинээр бий болгох боломжийг ч тэд бас бүрдүүлэв. Тус компани орон тооны 50 ажилтантай бөгөөд жуулчны улирлын хугацаанд

дунджаар зуу гаруй хөтөч орчуулагч, хоёр зуу орчим жолооч гэрээгээр ажиллуулдаг юм.

2005 оноос эхлэн тэд Улаан-Үд-Улаанбаатарын чиглэлд Олон улсын зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж олон улсын тээврийн үйл ажиллагаа эрхлэх багагүй туршлагатай болжээ.

Нью Жуулчин Туре компанийн аялагч бүр нутгийн иргэдийг дэмжих, байгалийн унаган төрхийг хадгалах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монголын нүүдэлчний түүх, ахуй, ёс заншилтай танилцахын зэрэгцээ малчдыг малжуулах, тэдний ахуй амьдралыг дээшлүүлэхэд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж байна. Аялах явцдаа жуулчид малчин айлд тодорхой цагаа өнгөрүүлж, малчин өрхийн үйлдвэрлэлийн аргаас суралцах боломжтой юм.

Байгалийн тэнцвэрт байдлыг хангах, хүлэмжийн хийг багасгах зорилгоор зочилж байгаа хүмүүс нь жуулчны бааздаа мод тарьж ногоон байгууламжийг өргөтгөх ажилд хувь нэмрээ оруулах боломжийг ч тэд бас бүрдүүлжээ. Мөн зэрлэг ан амьтан хамгаалах төслийг Төв, Баян-Өлгий, Дорноговь аймгийн зургаан ч суманд хэрэгжүүлж, Угалз хамгаалах сан, Мазаалай хамгаалах сантай хамтран ажиллаж эх орныхоо ховор ан амьтдыг нөхөн үржүүлэх, хамгаалах, улмаар байгалийн амьд музей буй болгохоор зорилт тавин ажиллаж байна. Нью Жуулчин Турсынхан хүмүүнлэгийн үйлст ихээхэн анхаарал хандуулдаг.

Тэднийхэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан 100 ширхэг тэргэнцэрийг Япон, Тайванийн Арслан клубтэй хамтран олгож Дархан, Улаанбаатар хотын Хүүхдийн эрхийн төвд тусламжийн гараа сунгаж, жил бүр өндөр настны амралт сувилалд тодорхой тооны хүн амруулдаг уламжлал нэгэнт тогтжээ. Мөн Монгол хаад цуврал номыг 10 жилийн турш, Хүүхдийн Нархан сэтгүүлийг сүүлийн гурван жил ивээн тэтгэж байна.

Тус компани Лондонгийн WTM, Берлины ITB, Хятадын CITM, АНУ-ын SCI convention зэрэг дэлхийн томоохон аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцон ихээхэн туршлага хуримтлуулж байдаг нь жил ирэх бүр өгөөжөө өгч байдаг аж.

Энэ бүхний үр дүнд МҮХАҮТанхим, Оюуны Өмчийн газраас олгодог Үндэсний брэнд шагналыг 2005 онд хүртсэнээр Juulchin World Tours Corporation of Mongolia брэндээ баталгаажуулж чадсан юм.

Нью Жуулчин Туре компанийн хийсэн ажил, хийж бүтээх урам зориг ч бас арвин их ажээ. Монгол Улсаа, хайртай эх орноо харь нутгийн зочин гийчдэд сурталчилах амаргүй үүргийг тэд нэр төртэй биелүүлж байна.

### **Амжилтын нууц**

- Олон улсын аялал жуулчлалын зах зээл дээр JUULCHIN WORLD TOURS CORPORATION OF MONGOLIA гэсэн брэндтэй болсон.

- Аялал жуулчлалын гол гол зах зээл дээр өөрийн салбар компани, төлөөлөгчийн газруудыг ажиллуулж, маркетингийн шилдэг үйл ажиллагаа эрхэлдэг.

- Инсентив аялын мэргэжлийн зохион байгуулагч, Евент санаачлан зохион байгуулагч, Олимпийн тоглолтын албан ёсны тасалбар борлуулагч, мөн монголчуудад зориулсан аяллыг зохион байгуулагч нь юм.

- Туршлагажсан хүний нөөцтэй компани бөгөөд өөрийн гэсэн үйлчилгээний сүлжээтэй болж чадсан.


- Байгаль орчинд ээлтэй, байгалийн цэвэр био бүтээгдэхүүн хэрэглэгч тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэгч компани.

### Компанийн тухай товч мэдээлэл:

Цахим хаяг: [www.juulchinworld.mn](http://www.juulchinworld.mn) Байгуулагдсан он: 2003 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж 5/3, Марко Поло ордон

Үйл ажиллагааны чиглэл: аялал жуулчлал, жуулчны баазын үйлчилгээ, авто тээвэр



SKY  
RESORT



[www.skyresort.mn](http://www.skyresort.mn) 16•16



## Эрүүл мэндийг эрхэмлэгч брэнд

Цас оров уу, үгүй юу ойролцоох уул руу гарч цана, чаргаар гулгах гэсэн хүүхэд насны дэвэргэн хүсэл цаг ямагт оргилж, уулын өөд чаргаа чирсээр эцэж цуцахаа мэдэхгүй мацдаг байсан цаг саяхан мэт. Амралтын өдөр болуут халуун саванд хоол, цай хийж бариад Хандгайт, Богинын амыг зорих хүмүүсийн цуваа ер тасардаггүйсэн. Хэдийгээр бид цэвэр агаарт гарч, эрүүл мэндээ анхаардаг байсан ч гар хийцийн том төмөр чарганд дайруулчихалгүй гулгах, нэг ёсны овсгоо самбаа шаардсан эр зоригийн "гулгалт" хийдэг байсныг уншигч та лав санаж байгаа байх.

Тархи толгойгоо хагалах, хөл гараа хугалах гээд олон ч осол тэдгээр уулын бэлд гардаг байсан нь хэнд ч нууц биш. Гэтэл хэдэн жилийн өмнөөс Скай Резорт хэмээх мундаг том цанын бааз нээгдэх гэж байгаа талаар ам дамжин шуугисан нь худал үг бус харин бодит ажил байсан нь олны талархлыг хүлээв. Дэлхийн түвшний шаардлага хангасан тийм л цанын баазыг нийгмийн хариуцлагатай MCS групп болон Петровис компанийн хамт олон Монголдоо байгуулахаар санаа шулуудсан нь эдүгээ нэгэнт биеллээ олжээ. Тиймээс ч хүүхэд залуусын очих дуртай газрын нэг болоод байгаа Скай Резорт цанын баазыг эрүүл мэндийг эрхэмлэгч брэнд хэмээн өргөмжлөхөд буруудах зүйлгүй юм.

Энэхүү брэнд XXI зууны монголчуудын хувьд зайлшгүй хэрэгцээтэй байсан тул асар богино хугацаанд олон нийтэд илүү нээлттэй болсон билээ.

Уг цанын баазыг байгуулахдаа энэ салбарт тэргүүлэгч олон улсын мэргэжилтэн, шинжээчдийг урьж оролцуулсан төдийгүй өндөр хүчин чадал бүхий техник, тоног төхөөрөмжүүдийг стандартын дагуу авч суурилуулжээ.

Олон улсын стандартад нийцсэн Скай Резорт цанын бааз нь Улаанбаатар хотоос зүүн тийш 13 км-т Богд Хан уулын хаяанд, Хатан Туул голын хөвөөн дэхь Хүрхрээгийн аманд байгуулагджээ. Энэ нь хотоос зайдуу оршдог бусад газруудыг бодвол хамаагүй ойр хийгээд амралт, чөлөөт цагаа тав тухтай өнгөрөөх бүхий л нөхцлийг бүрдүүлсэн гэдгээрээ давуу талтай юм.

Тус цанын бааз нь анхан, дунд, мэргэжлийн түвшний нийт 6000 метр урт цана, чарга, боардын есөн замтай, мөн 1000 метрийн тойрог гүйлтийн цанын замтай, нэгэн зэрэг 1500 хүнд үйлчлэх хүчин чадалтайгаас гадна Францын MAS limited, Италийн Techno Alpin, АНУ-ын GolfPlan, Австралийн Hydro Plan зэрэг дэлхийд нэртэй компаниудтай хамтран ажилладаг юм.



Тухайн төслийг эхлүүлсэн нэг гол үндэслэл нь Монголд олон улсын түвшний цанын баазын цогцолборыг сонгодог утгаар нь оруулж ирж нийт ард иргэддээ өвлийн цагт эрүүл цэвэр орчинд идэвхтэй амарч өнгөрөөх боломжийг олгох зорилготой байсан бөгөөд ашгийг нэн тэргүүнд тавиагүйд гол цөм нь оршино. Хэрэв хөрөнгө оруулалтын буцаалт болон зах зээлд таниулан сурталчилах маркетингийн зардал, мөн нийт 150 гаруй ажилчдын цалин хангамжийн өртгийг давахуйц байхаар тооцож үйлчилгээний үнээ тогтоосон бол харьцангуй өндөр гарах байсан нь ойлгомжтой. Үнийн хувьд Азийн орнууд, цаашлаад дэлхийн бусад цанын баазтай харьцуулахад хэд дахин хямд байна.

Тус цанын бааз нь урсдаг, чирдэг, дүүжин гэх гурван төрлийн долоон лифттэй бөгөөд хүсвэл та зориулалтын гэрэлтүүлэг бүхий орчинд шөнийн гулгалт ч хийж болно. Скай Резорт цанын бааз Монголд анх удаа орчин үеийн цас хийгч төхөөрөмжийг өвлийн олимпийн албан ёсны түнш Италийн Techno Alpin компаниас иж бүрнээр нь авч суурилуулжээ. Энэхүү төхөөрөмжийн тусламжтайгаар цанын бааз жил бүрийн 11-р сараас 4-р сарын дунд үе хүртэл ажилладгаараа онцлогтой.

Үүнээс гадна цасыг жигд тараах, дагтаршуулах, сийрэгжүүлэх үүрэгтэй Герман улсад үйлдвэрлэсэн Pisten Bully брэндийн хоёр машинтай аж.

Мөн цанын зам дээр осол гарахаас урьдчилан сэргийлж анхааруулга өгөх, осол гарсан тохиолдолд анхан шатны тусламжийг мэргэжлийн түвшинд цаг алдалгүй үзүүлэх чадвартай 20 хүний бүрэлдэхүүнтэй цанын эргүүлийн баг ажиллаж байгаа юм. Үүнээс харахад төмөр чарганд дайруулж элдэв гэмтэл авдаг байсан үе хэдийнэ өнгөрсөн зуунтайгаа хамт үгүй болсныг илтгэнэ. Хөнгөн бэртэж, гэмтсэн үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үзүүлэх зорилгоор анхан шатны эмнэлгийн төвд мэргэжлийн эмч, сувилагч нар ажиллаж байна.

Хэрвээ та анх удаа гулгах гэж байгаа бол эхний удаа цана болон боардын сургалтыг санал болгодог. Энэ нь аюулгүй байдлын үүднээс авч хэрэгжүүлж байгаа зүйл бөгөөд ингэснээр таныг болон бусад үйлчлүүлэгч нарыг гэмтэж бэртэхээс 100 хувь урьдчилан сэргийлдэг аж. Алжаалаа тайлж сэтгэлээ сэргэтэл гулгахаас гадна эрүүл агаарт сайхан зоог барих, халуун кофе уух дургүй хүн гэж хаана байх вэ?

Скай Резорт цанын бааз нь дээд зэргийн тав тух, найрсаг соёлтой үйлчилгээ, сайхан амттай үндэсний болон ази, европ хоолоор нэгэн зэрэг 300 зочинд үйлчлэх хүчин чадал бүхий ресторанаар үйлчилж байна. Харин энэ бүхнийг гагцхүү өөрийн биеэр мэдэрсэн тохиолдолд Монголд өвлийн спортыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжих шинэ брэнд бол яах аргагүй Скай Резорт юм даа гэж дуу алдахад хүргэнэм. Учир нь эднийх олон улсын стандартын цанын баазын үйлчилгээг Монголд нутагшуулаад зогсохгүй хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчилж чадсан. Энэ нь юу вэ гэвэл өмнө нь хүмүүсийн хувьд өвлийн цагт амралт, чөлөөт цаг гэдэг нь зөвхөн хагас, бүтэн сайн өдрийн 11 цагаас үдийн 16 цагийн хооронд л үргэлжилдэг гэдэг сэтгэлгээг эвдэж, долоон хоногийн зургаан өдөр нь гулгах бүрэн боломжийг олгосон. Мөн дээрээс нь нээгдсэн цагаасаа хойш Монголын өвлийн спортын баг тамирчдыг үргэлж дэмжиж, цанын бааз дээрээ үнэ төлбөргүй дасгал сургуулилт хийлгэж ирсэн нь эхнээсээ үр дүнгээ өгч хамгийн сүүлд Казахстанд зохиогдсон Азийн өвлийн наадмаас монголчууд анх удаа нэг мөнгө, дөрвөн хүрэл медаль авч багаараа тавдугаар байрт орсон билээ.

Тэдний спорт барааны дэлгүүрээс та дэлхийн нэртэй брэндүүдийн цана, боард, цанын хувцас, нүдний шил, хамгаалалтын малгай, бусад хэрэгслүүдийг худалдан авч хүссэн үедээ Хүрхрээгийн амыг зорих алтан боломж амьдрал дээр нэгэнт биеллээ олжээ.

### **Амжилтын нууц**

- Энэ салбартаа тэргүүлэгч олон улсын мэргэжилтэн, шинжээчдийг урьж ажиллуулсан бөгөөд өндөр хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжүүдийг стандартын дагуу авч суурилуулсан.

- Үйл ажиллагаа нь улирлын чанартай явагддаг, өртөг болон зардлаа удаан хугацаанд нөхөх магадлалтай, эрсдэл өндөртэй бизнест зоригтойгоор хөл тавьж хэний ч өмнө нүүр улайхааргүй цанын баазыг байгуулсан нь бахдам амжилт юм.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.skyresort.mn](http://www.skyresort.mn) Байгуулагдсан он: 2009 он

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 210620а, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр, 5 давхар

Үйл ажиллагааны чиглэл: Цанын бааз, гольфын цогцолбор

بصيرتكم من  
تجسسكم  
وحطفكم من

**MONGOLIAN BRAND ROYALTY**



**ДЭЛХИЙН СТАНДАРТЫГ  
ҮЙЛДВЭРЛЭЛД  
НЭВТРҮҮЛСЭН БРЭНДҮҮД**



## Монгол хүний сэтгэл шиг брэнд

Хол газар явж буй нэгнийгээ үдэж мордуулах үед монголчууд цагаан сүүнийхээ цацлыг өргөдөг жамтай. Харин холоос ирсэн айлчинг гэрийн хоймортоо хүндэтгэн залж сүүтэй цай, цагаан идээнийхээ дээжийг өргөн барьдаг уламжлалтай улс билээ. Хөх номин тэнгэрийг эзэгнэнхэн төрсөн монгол ижийн үр сад эхийн цагаан сүүг юунаас ч илүү хүндлэн дээдэлж дуу хуур, шүлэг найрагтаа магтан дуулсаар ирсэн билээ.

Монголчууд хэдийнээс л сүүтэй цай уухгүй бол гол нь харладаг сонин улс. Тиймдээ ч таван хошуу мал сүргээ шүтэж, сүү саалиа дээдэлж ирсэн ард түмэн юм. Сүү компанийн таних тэмдэг ч мөн үүнийг илтгэнэ. Монгол хүмүүний хувьд сүү, сүүн бүтээгдэхүүн бол амьсгалах агаар лугаа адил өдөр тутмын хэрэглээ болж байдаг. Харин энэ түгээмэл хэрэглээг хангахын төлөө хагас зуун жил шахам зүтгэж ирсэн брэнд бол яах аргагүй Сүү компани

билээ.

Үндэсний манлай үйлдвэр Сүү хувьцаат компани анх 1958 онд нийслэлийн хүн амыг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор ЗХУ-ын мэргэжлийн байгууллагын боловсруулсан зураг төслийн дагуу тухайн орны болон Европын бусад орнуудын техник хэрэгслээр тоноглогдсон, хоногт 30 тн сүү боловсруулах хүчин чадалтайгаар Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт ашиглалтад орсон гэдэг. Энэ нь Монгол улсын сүү боловсруулах үйлдвэрийн хөгжлийн шинэ үеийн эхлэл байлаа.

Сүү боловсруулах үйлдвэрийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад тухайн үеийн ЗХУ ихээхэн тусалж дэмжиж байсан агаад дээд боловсролтой олон тооны мэргэжилтнүүдээ ажиллуулж, шинэ шинэ тоног төхөөрөмжийг ашиглан олон нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх болсны зарим нэгийг дурдвал, бидний сайн мэдэх гурвалжин сүү, шилтэй сүү, тараг, аарц, ааруул зэргийг үйлдвэрлэдэг байв. 1971 оны зургаадугаар сард ЗХУ-ын тусламжтайгаар хүүхдийн тэжээлийн цехийг ашиглалтад оруулж хүүхдэд зориулсан нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн түүхтэй.

Харин 1985 оны долоодугаар сард техник, технологийн шинэчлэл хийж хоногт 200 тн сүү боловсруулах өндөр хүчин чадалтай шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. 1990-ээд онд хүнсний аж үйлдвэрийн салбар хувьчлагдаж эхлэх үед сүүний үйлдвэр бусад үйлдвэрийн адил төрийн өмчийн 51 хувийн оролцоотой хувьцаат компани болов.

Гэвч сүүний үйлдвэрлэл эрс буурч 1993 онд 1990 оныхоос 4,7 дахин, 1995 онд 34 дахин багасав. Саалийн механикжсан фермүүд зах зээлийн нөхцөлд зардлаа нөхөж бие даан ажиллаж чадахгүйд хүрч олон жижиг аж ахуйн нэгж болон задрав. Нэг хэсэг нь бүрмөсөн хаагдсанаар сүүний үйлдвэрлэл түүхий эдгүй болж 1996 оны эцэс гэхэд хүчин чадлынхаа дөнгөж хоёр хувийг ашиглах болтлоо зогсонги байдалд оржээ.

Энэ байдлаас гарахын тулд бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл хийж хорь гаруй нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсон байна.

Улмаар хүчин чадлынхаа 20 шахам хувийг ашиглан тухайн оны эхний 11 сард 820 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 34,4 хувийн борлуулалтын ашигтай ажиллав. Энэ үед Япон улсын буцалтгүй тусламжаар хөргөлтийн цехээ тэр чигээр нь бүрэн шинэчилж, тусгай тоноглол бүхий 20 автомашинаар сүү татах, борлуулах ажил үйлчилгээ явуулдаг болгож үйл ажиллагаагаа тасралтгүй явуулснаар эдүгээ үндэсний томоохон брэнд үйлдвэрлэгч болж чадав. Итали Чехийн хамтарсан үйлдвэрийн зайрмаг үйлдвэрлэх автомат шугамыг үйлдвэртээ суурилуулснаар одоогийн хүүхэд багачуудын идэх дуртай Мөрөөдлийн хэмээх нэртэй 15 гаруй нэр төрлийн брэнд бүхий зайрмагийг үйлдвэрлэн зах зээл дээр гаргах болжээ.

2006 онд Америк Тайванийн хамтарсан үйлдвэрийн өндөр хэмд /УНТ 140 хэмд/ ариутгах болон PURE PACK савлах шугам нэвтрүүлсэн нь Улаанбаатар хотын иргэдийг экологийн цэвэр сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах боломжийг нээв. Тетрапак савлагааг үйлдвэртээ нэвтрүүлж тетрапак сүү болон тетрапак жүүсийг үйлдвэрлэж эхлэв. Бидний нэрлэж заншсан "цэнхэр" сүү ийнхүү мэндэлсэн түүхтэй. Чухам яагаад бид "цэнхэр" сүү

хэмээн хөгшин, залуугүй уг брэндийг нэрлэх болсон нь цаанаа учиртай. Цагаан цэнхэр өнгөтэй сүүний сав нь угтаа бол Сүү брэндийн өөрийнх нь үндсэн логоноос үүдэлтэй өнгө агаад эхийн цагаан сүү, хөх номин тэнгэрийг хамтад нь бэлгэдсэн санааг илэрхийлдэг аж.

Тус компани дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад ашиглагдаж буй хамгийн сүүлийн үеийн Америк Тайванийн хамтарсан тоног төхөөрөмж болох ариутгалын хаалттай битүү системтэй /CIP/, хоногт 150 тн сүү боловсруулах шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулснаар хөгжлийнхээ шинэ шатанд гарчээ.

2010 онд хөгжингүй орнуудын стандартад нийцсэн йогурт савлах машиныг үйлдвэртээ нэвтрүүлж, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх болов. Мөн ондоо салбар үйлдвэрийн цехийг хөдөө орон нутагт өөрийн хөрөнгөөр бий болгож, сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан сүүгээр хэрэглэгчээ хангах цахилгаан саалтууртай фермерийн аж ахуй байгуулжээ.

Одоогийн зах зээл дээр Сүү компани нийт 70 гаруй нэр төрлийн сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж гаргадаг, зах зээлийн 60 гаруй хувийг эзэлсэн Үндэсний манлай үйлдвэр болж чадав.

Япон улсад үйлдвэрлэсэн йогурт савлах савлагааны шугамыг 2006 оноос суурилуулж сургуулийн хүүхдийн Үдийн цай хөтөлбөрт зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон нь ч цагаа олсон бизнесийн зөв сонголт байлаа.

Хамгийн сүүлд импортын сүүг орлох -30 - ( +30) хэмд зургаан сар хадгалах аюулгүйн баталгаатай сүү савлах Швед улсын Тетра Пак савалгааг амжилттай суурилуулж Аварга чанар сүүг зах зээлд нэвтрүүлэв. Ингэснээр зөвхөн нийслэлд бус хөдөө орон нутгийн хэрэглэгчдэд экологийн чанарын баталгаатай сүү хэрэглэх боломжийг бүрдүүлжээ.

Сүү хадгалах хамгийн төгс шийдэл бүхий технологи нь сүүг хуурайшуулан хатаах үйл явц юм. Эднийх Дани улсын Ан Хедро фирмийн сүү хатаах зориулалттай Монголдоо хамгийн томд тооцогдох хуурай сүүний үйлдвэртэй. Энэхүү үйлдвэр нь шингэн сүүг боловсруулан хатаадаг бөгөөд өвлийн улиралд дахин сэргээж үйлдвэрлэлд оруулдаг аж.

Сүү ХК нь 2000 онд чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлсний дүнд СХҮТ-ийн итгэмжлэлийн албаны шалгуурт тэнцэн хүнсний үйлдвэрийн итгэмжлэгдсэн хоёр дахь лаборатори болжээ. Улсын хэмжээнд итгэмжлэгдсэн хоёр лабораторийн нэг болохоор нийт хэрэглэгч, худалдан авагчдын гарт чанартай бүтээгдэхүүн очих хүртэл бүхий л чанарын шинжилгээг өдөр бүр хийж байна.

Мөн үйлдвэрлэлийн технологийн дамжлага дундын хяналтыг хийх, үйлдвэрлэлээс гарсан бэлэн бүтээгдэхүүнд эцсийн шинжилгээ хийж худалдаанд гаргах чанарын баталгааг олгодог аж.

Сүү брэнд нь олон жилийн туршлагадаа үндэслэн сүү бэлтгэлийн тогтсон системтэй болов. Урьд нь тэд малчин өрх бүрээр явж сүүгээ цуглуулдаг байсан бөгөөд СЦЦ /сүү

цуглуулах цэг/, СХТ / Сүүний хөргөлттэй тасаг/ байгуулагдаж, өнөөг хүртэл тасралтгүй ажиллаж байгаа юм. Сүүлийн жилүүдэд СЦЦ-ийг хэд хэдэн газар байршуулсан бөгөөд сүү бэлтгэн нийлүүлэлтийн энэ сүлжээ нь Төв, Сэлэнгэ аймгийн ихэнх нутаг дэвсгэрийг хамарч дэд бүтэц, зам харилцаанд түшиглэсэн нь тээвэрлэлтийн явцыг хурдасгах, сүүний чанарыг бууруулахгүй зөөвөрлөх, нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Сүү ХК нь Аварга чанар нэртэй эх орны сүүг шинээр үйлдвэрлэж эхэлснээр хүнсний ихэнх хэрэгцээгээ импортын бүтээгдэхүүнээр хангадаг манай улсын хувьд шинэчлэл болсон юм. Монголын дэвжээнээс Олимпын анхны аваргууд төрсөн баяртай үйл явдлыг угтан бэлгэшээж Аварга чанар хэмээх сүүг зах зээлд гаргасан нь цагаан сүү монгол хүний сэтгэлтэй ямар их нарийн холбогдсон байдгийг бэлээхэн харуулж буй мэт.

Харин йогуртны зах зээлийн одоогийн байдлыг авч үзвэл йогуртны ихэнхи хувийг импортын бүтээгдэхүүн эзэлж байв. Импортод автсан энэ орон зайн төлөө Сүү ХК стратеги боловсруулжээ. Сүү брэнд дэлхийн стандартад нийцсэн Жимстэй йогурт хэмээх шинэ брэндийг үйлдвэрлэснээр тэрхүү нөхцөл байдлыг өөрчилж йогуртны хэрэглээг хангах болов. Энэхүү жимстэй йогуртны онцлог гэвэл, монгол үнээний цэвэр сүүг исэлдүүлэн боловсруулж, байгалийн жимсээр баяжуулсан бөгөөд найрлагандаа химийн нэмэлт бодисгүй экологийн цэвэр брэнд бүтээгдэхүүн юм.

Импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад урт хугацааны тээвэрлэлт шаардагдахгүй учир тээвэрлэлтийн горим алдагдаж чанарт нөлөөлөхгүй, шив шинээрээ хэрэглэгчдийн гарт очих давуу талтай. Сүүлийн үеийн хамгийн шинэлэг дизайн бүхий савлагаатай зориулалтын аяга халбагатай бөгөөд ариутгалын өндөр түвшинд савлагддаг, хэрэглэхэд хялбар бүтээгдэхүүн юм.

Йогурт үүссэн түүхээс товчхон сонирхуулвал, МЭӨ 5-р зууны үед скифчүүд йогуртыг ихээр хэрэглэдэг байсан учир тэд эрүүл чийрэг, хүч чадалтай байсан талаар Геродот тэмдэглэн үлдээсэн байдаг. Улс үндэстэн, ард түмэн бүхэн тараг, йогурт, ацидофилин гэх зэрэг исгэлэн сүүн бүтээгдэхүүн боловсруулах өөр өөрийн уламжлалт аргатай. Тэдгээрийг бэлтгэх арга нь өөр боловч хүний биед үзүүлэх нөлөө, ашиг тус нь адилхан аж. Харин дэлхийд анх удаа исгэлэн бүтээгдэхүүнийг Оросын эрдэмтэн Илья Мечников судалсан бөгөөд тэрбээр 20 жилийн турш хүний бие махбодын хөгшрөлтийн шалтгааныг судалж, учрыг нь олохыг хичээсэн гэдэг. Гэтэл хөгшрөлт нь хүний биеийн бүдүүн гэдсэнд байдаг нянгууд бие махбодыг хордуулснаас ихээхэн шалтгаалдаг болохыг олж мэджээ.

Учир нь залуу насны төлөө тэмцэгч лактобацилл болон бифидо бактериуд нь йогуртын найрлагад их хэмжээгээр агуулагддаг. Мөн дур булаам байхын нууц болсон микрофлорыг хэвийн хэмжээнд байлгахын тулд исгэлэн сүүн бүтээгдэхүүнийг ихээр ууж байх хэрэгтэй аж.

Та үргэлж залуу сайхнаараа эрүүл чийрэг амьдрахыг хүсвэл йогуртыг тогтмол хэрэглэж хэвших хэрэгтэй юм. Ямар ч эм тангаас дутахгүй үйлчилж, хүний биеийг юугаар ч солимгүй аминдэмээр тэтгэж байдаг өвөрмөц ундаа бол сүүн исгэлэн бүтээгдэхүүнүүд байдаг билээ.

## Амжилтын нууц

- Хагас зуун жилийн турш сүү, сүүн бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн шинэчлэлтээрээ хүмүүсийн хүсэн хүлээсэн зүйлийг өгөхийн төлөө ажилладаг
- Хүнд хэцүү зах зээлийн шилжилтийн үеийг даван туулахын тулд зөв бодлого, менежмент хийж чадсан
- Хэрэглэгчдийн найдвартай түнш болсон
- Зах зээлийг зөв мэдэрсэн
- Уян хатан бодлого явуулахын зэрэгцээ импортын бүтээгдэхүүнийг эх орныхоо зах зээлээс шахах бодлогыг тун оновчтой авч хэрэгжүүлсэн

### Компанийн тухай товч мэдээлэл:

Цахим хаяг: [www.mongolmilk.mn](http://www.mongolmilk.mn) Байгуулагдсан он: 1958 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СХД Үйлдвэрчний гудамж-37

Үйл ажиллагааны чиглэл: Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл





**ТАЛХ ЧИХЭР ХК**

ЭРҮҮА ХҮНС **1984** ТАРЫ СОНГОЛТ  
ОНООС

**ORGANIC**

ЗОХИЦУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХҮНС





### Хүн амыг хүнсээр тэтгэгч брэнд

Хүн нэмбэл хүнс нэмэгдэнэ гэдэгчлэн Монголын хүн ам жил ирэх тутам өсөн нэмэгдсээр байна. Үүний нэгэн адил Талх Чихэр компанийн үйлдвэрлэл ч өдрөөс өдөрт нэмэгдэж эдүгээ орчин үеийн техник, технологийг иж бүрэн нэвтрүүлсэн дэлхийн стандартад нийцсэн үйлдвэр болж өргөжжээ.

Талх, Чихэрийн комбинат анх 1984 онд ЗХУ-ын техник, эдийн засгийн туслалцаатайгаар ашиглалтад орсон билээ. Тус комбинат хоногт 90 тн талх, жилд 5000 тн төрөл бүрийн чихэр, 6550 тн жигнэмэг, өрмөнцөр, бялуу, 800 тн жимсний чанамал үйлдвэрлэх хүчин чадалтай байгуулагджээ.

Өмч хувьчлалын комиссын 1991 оны 16-р тогтоолоор төрийн мэдлийн гучин хувийн

өмчлөл бүхий хувьцаат компани болов. 1999 онд Төрийн Өмчийн Хорооны 1238 тоот тогтоолоор төрийн өмчийн гучин хувийг хувьчилж, зуун хувь хувийн эзэмшилд шилжсэнээр хувийн өмчит компани болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн 27 дахь жилдээ ажиллаж байна.

Эдүгээ тус компани хоёр үйлдвэр. Арав гаруй албад нэгжийн таван зуу гаруй ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж, микро биологи болон химийн үндсэн хоёр лабораторид түүхий эд материалаас эхлэн шат дамжлага бүрт тогтмол шинжилгээ хийж чанарын шаардлага хангасан бэлэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэдэг.

Мөн үндсэн түүхий эд болох гурилыг Милл хаус гурил тэжээлийн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх стандартын шаардлага хангасан Атар гурилыг сонгон бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг.

Түүнчлэн үйлдвэрээс нь шуудайгүйгээр тээвэрлэх тусгай зориулалт бүхий 20 тн даацтай тээврийн хэрэгслийг Герман, Украин улсад захиалгаар хийлгэж, 480 тонн гурил хүлээн авах, хадгалах, түгээх зориулалт бүхий 16 силос болон тоног төхөөрөмжөө шинэчлэв.

Өнөөдөр ТАЛХ ЧИХЭР ХК нь арав гаруй нэр төрлийн талх, гучаад нэр төрлийн нарийн боов, төрөл бүрийн бялуу, арав гаруй нэр төрлийн жигнэмэг, зөөлөн чихэр, мармелад, зөөлөн чихрийн цуглуулга тус тус үйлдвэрлэдэг.

Бүтээгдэхүүний онцлог гэвэл Монгол хүний хоол, хүнсний суурь хэрэглээнд буудайн гурил, түүний бүтээгдэхүүн зонхилж буйг өөрчлөн бусад үр тарианы гурил, түүний дагавар бүтээгдэхүүнээр баяжуулах, орлуулах шаардлагатай байгааг тэд мэдэрч чаджээ. Тус компани орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглан хэрэглэгчдийн хүсэл сонирхол, амт чанарт нийцэхүйц цэвэр ургамлын гаралтай хүнсний нэмэлт түүхий эд болох хөх тарианы гурил, арвайн гурил, наранцэцгийн үр, гүнжидийн үр, овъёосны гурил, бүхэл үрийн гурил зэргийг ашиглан орц, хэмжээ, савлагаа, үнийн өргөн сонголттой арваад нэр төрлийн талх болон Хөх тарианы мөөхий, Тэжээллэг, Зөгийн балтай мөөхий, Бүхэл үрийн боов, Овьёосны жигнэмэг зэрэг гучаад нэр төрлийн брэндийг хэрэглэгчдэд хүргэж байна.

Мөн уламжлалт хэрэглээг тасралтгүй хангаж Атар брэндийн хэвийн боов, чанамал боорцог үйлдвэрлэх технологийг орчин үеийн тоног, төхөөрөмжтэй хослуулан илүү шинэлэг, чанартай байдлаар хэрэглэгчдэд хүргэдэг. Тус компанийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээс 38 бүтээгдэхүүн улсын Стандарт хэмжил зүйн газраас олгодог чанарын тохирлын тэмдэг, 50 бүтээгдэхүүн Монгол улсын Оюуны өмчийн газраас патентийн эрх авсан. Мөн Олон улсын болон дотоодын үзэсгэлэн худалдаануудад амжилттай оролцож олон арван шагнал авсан бөгөөд 2007 онд Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэгч үйлдвэрээр, 2009 онд Ургац хөх тарианы талх Экологийн цэвэр бүтээгдэхүүнээр, 2010 онд Мишээл хөх тарианы талх Эрүүл мэндэд ээлтэй бүтээгдэхүүнээр тус тус шалгарчээ.

Аливаа Брэндийн амжилт бүтээгдэхүүний баглаа боодлын дизайнаар тодорхойлогддог нь тохиолдлын хэрэг биш. Юутай ч брэндийн өөрийнх нь бүрэлдэн тогтох үйл явц хэрэглэгч түүнийг сэтгэл зүйн хувьд хэрхэн хүлээж авахаас ихээхэн хамаардаг. Зарим үед бүтээгдэхүүн ямар байх хийгээд түүнийг хэрхэн хүлээн авч буй нь чухал байдаг. Учир нь юуны өмнө

брэндийг сэтгэлийн хөдөлгөөнөөрөө хүлээн авдаг болоход нь хүмүүст бусад хүчин зүйлсээс илүү нөлөөлөх менежмент ч шаардагдах нь бий.

Тус компани техник, технологийн шинэчлэлийг 2004 оноос эхлэн шат дараатайгаар хийж ирсэн нь Монголын хүнсний үйлдвэрийн салбарт томоохон хөрөнгө оруулалт болж чаджээ. Тухайлбал, Тайвань улсын сахар болон хагуу төрлийн жигнэмэг хийх урсгал шугам, Голланд Чехийн хамтарсан Дворак фирмийн Атар талх үйлдвэрлэх иж бүрэн компьютерийн удирдлага бүхий шугамыг ашиглалтад оруулав. Мөн Европын холбооны улсад үйлдвэрлэсэн зууван болон дөрвөлжин хэлбэрийн төрөл бүрийн талх үйлдвэрлэх иж бүрэн компьютерийн удирдлага бүхий автомат хоёр шугамыг суурилуулсан бөгөөд энэхүү шугамаар талх үйлдвэрлэх технологи нь шингэн хөрөнгө бэлтгэх иж бүрэн автомат ажиллагаатай, орчин үеийн өндөр мэдрэмжтэй шат бүр нь хяналттай байдгаараа дэлхийд тэргүүлдэг юм.

Түүнчлэн Голланд улсад үйлдвэрлэсэн талх зүсэх, уутлах, боох бүрэн автомат ажиллагаатай шинэ тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулснаар шинээр Ургац, Мишээл, Зууван чех, Сүүтэй чех зэрэг арав гаруй нэр төрлийн брэндийг Монголд анх удаа зориулалтын машинаар зүсч, савлаж гаргасан нь хэрэглэгчдийн талархлыг хүлээв. Ийнхүү зүссэн талхны цоо шинэ хэрэглээг бий болгосноор Зүссэн талх хэмээх брэндийг амжилттай гаргаж чадсан бөгөөд хэрэглэгчдийн 60 орчим хувь нь зүссэн талх хэрэглэдэг болоод байна. 2010 онд Бялуу, нарийн боовны үйлдвэрийг иж бүрэн шинэчилж Европын холбооны Голланд, Чех, Итали улсаас хамгийн сүүлийн үеийн нарийн боов үйлдвэрлэх иж бүрэн автомат хоёр шугам авч суурилуулжээ. Энэ бүхнээс харахад тэд салбартаа шинийг санаачлагч, үргэлж анхдагч нь байж чаддаг.

Талх Чихэр бол худалдан авагчдад ямар ч эргэлзээгүй итгэл төрүүлдэг компани. Тэр ч бүү хэл улам бүр ээдрээтэй болж буй өнөө цагт ч уг брэндийг нэр хүндтэй байлгаж буй гол хүчин зүйл нь худалдан авагчдын итгэл юм. Монголын худалдан авагчид энэхүү брэндийг сонгодог. Итгэл хэмээх ойлголт худалдан авагч тухайн брэндийг сүслэн дагах хэмээх ойлголттой нягт уялдаатай байдаг билээ. Тиймээс Талх Чихэрийн удирдлага үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн нөхцөл бүтээгдэхүүний чанарт хэрхэн нөлөөлж буйг ямагт харгалзан үздэг. Тус компани эрчимтэй хөгжих замыг сонгож авсан Монголын ууган компаниудын нэг билээ. Үүний дүнд Талх Чихэр компани бизнесийн хүсэл тэмүүллээ биелүүлэхийг эрхэм зорилгоо болгож, Монголын хамгийн том хүнсний үйлдвэрлэгч хэвээрээ байсаар байна.

### **Амжилтын нууц**

- Инновацийн бодлого амжилттай хэрэгжүүлж, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг цаг алдалгүй судалж, нэвтрүүлж чаддаг тул салбартаа ямагт анхдагч, шинийг санаачлагч нь байж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, шинэ хэрэглээг бий болгож чадсан.

- Бүтээгдэхүүний чанарт эрс өөрчлөлт гарч бүтээгдэхүүний жор, орцыг цахим тоног төхөөрөмжөөр хянаж байгаа нь хувь хүнээс хамаарсан технологийн болон чанарын гологдол гаргахгүй болгов.

- Инженер техникийн ажилчид, технологийн ажилтнуудыг мэргэжлийн сургалтад

хамруулж, үе удам дамжин сурган ажиллуулдаг тул идэвхи санаачилга, өөрийгөө дайчлах чадвар нь дээшилж хамгийн сүүлийн үеийн дэлхийн шилдэг тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлсэн төдийгүй техник, технологийн дэвшилд сэтгэл ханамжтай, тогтвор суурьшилтай ажиллах болжээ.

- Хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээг судалсны үндсэн дээр талх, нарийн боовны нэр төрөл, хэлбэр хэмжээнээс гадна хэрэглээг өөрчлөн, жор, орц найрлагыг байгалийн гаралтай, амин дэмээр баялаг нэмэлт түүхий эдээр баяжуулан эрүүл мэндэд ашиг тустай, зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэх боломжтой болов.

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн горимд тавих хяналт нь компьютерийн хяналтад байдаг тул бүтээгдэхүүний гарц нь тогтмол байдгаараа давуу талтай.

- Үйлдвэртээ эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх Олон улсын GMP системийг нэвтрүүлж, душ, саун, бялдаржуулах танхимыг бий болгож, хөдөлмөрлөх нөхцөл, ажлын байрны тав тухтай таатай орчинг бүрдүүлснээр ажилчид эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэх урам зоригтой болсон.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.talkh-chikher.mn](http://www.talkh-chikher.mn) Байгуулагдсан он: 1984 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СХД, 18-р хороо, Талх Чихэр ХК-ийн байр.

Үйл ажиллагааны чиглэл: Талх, нарийн боовны үйлдвэрлэл, худалдаа

- уул уурхай
- газар тариалан
- мал аж ахуй
- хүнсний үйлдвэрлэл
- барилга, авто зам
- аялал жуулчлал
- техникийн худалдаа
- гадаад, дотоод худалдаа
- баталгаат агуулах
- бетон зуурмагийн үйлдвэр

- телевиз

- спорт сургууль



Gatsuurt

## ГАЦУУРТ ХХК



- УУЛ УУРХАЙ
- ГАЗАР ТАРИАЛАН
- МАЛ АЖ АХУЙ
- ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ
- БАРИЛГА, АВТО ЗАМ
- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- ТЕХНИКИЙН ХУДАЛДАА
- ГАДААД, ДОТООД ХУДАЛДАА
- БАТАЛГААТ АГУУЛАХ
- БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР
- ТЕЛЕВИЗ
- СПОРТ СУРГУУЛЬ





Gatsuurt

### Байгаль орчинд ээлтэй брэнд

Гацууртын үр суулгац 1993 онд Гурван гол ХК-ийн "хашаан доторх" хөрсөнд суужээ. Тус компани анх Сэлэнгэ аймгийн Мандал сумын Гацууртын аманд алт олборлолтын үйлдвэрлэл явуулж эхэлсэн ба үйл ажиллагаагаа өргөжүүлж Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт суманд алт олборлолтын үйлдвэрлэл явуулж ирэв. 2002 онд геологи, уул уурхайн салбартаа техникийн шинэчлэл хийж байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ус маш бага зарцуулдаг Шинэ Зеландын /скрин/ 60, 80 зэрэг алтны шороон ордын дэвшилтэд технологийг үйлдвэрлэлдээ ашигласнаар Монгол улсад анхны байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэн зардлыг хэмнэж, элс угаалтын хэмжээг дээшлүүлж, металл авалтыг нэмэгдүүлэх, хаягдлын хэмжээг багасгах, угаалгын технологийг боловсронгуй болгож, техникийн нөхөн сэргээлтийг байнга хийж байгаа цөөхөн компанийн нэг юм.



Гацуурт ХХК-ийн хамт олны хийсэн нөхөн сэргээлтийн ажилтай Мэргэжлийн хяналт, Байгаль орчны яам зэрэг байгууллагуудын мэргэжилтнүүд танилцаж Улсын тэргүүний нөхөн сэргээгч хамт олон гэсэн үнэлэлт өгч бусад уул уурхайн компани, аж ахуй нэгжүүдэд үлгэр жишээ үзүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг нийтэд таниулах зорилгоор 2006 онд улсын хэмжээний үзүүлэх сургалт, семинарыг анх удаа зохион байгуулав. Энэ үйл ажиллагаа нь "алтыг нь аваад авдрыг нь хаядаг" зарим нэг аж ахуйн нэгжүүдэд сайн үлгэр жишээ болсон юм.

Гацуурт гэдэг нэр тус компанийн ажлынх нь чанарыг тодорхойлох нэгэн үзүүлэлт мэт болжээ. Мөнх ногоон ойтой тэрхүү газар нутгийн нэрийг авсан тус компани 1998 онд Гурван голоосоо бие даан гарч, нэг гишүүнтэй компани болж 45 ажиллагсадтайгаар тэлэн "ургаж" эхэлсэн байна.

Нэг гишүүнтэй ХХК буюу ганц суулгацнаас олон салаа мөчиртэй саглагар том, мөнх ногоон мод болсон нь уг компанийн онцлог гэж болно. Амжилтад хурдан хүрье гэвэл ганц чиглэлийг барьж ажиллах нь чухал гэдэг. Нэг зүйлийг л төгс төгөлдөр, брэнд болго. Өөр юу хэрэгтэй юм бэ? гэсэн номлол ч бий. Гацуурт үүнийг сөрж ургасан юм. Геологи, уул уурхай, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, барилга, гадаад дотоод худалдаа, спорт сургууль, телевиз гэсэн 9 чиглэлд салаалж 25 салбар аж ахуйн нэгж болон мөчирлөж, 1000 гаруй хүнийг ажлын байраар хангажээ.

Салбар болгондоо техникийн шинэчлэл хийж ирсэн ба бусад ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад тусалж, техник технологийг хөнгөлөлттэй нөхцлөөр худалдаалж байна. Гацуурт компанийнхан анхнаасаа геологи хайгуулын ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, нөөцийг тогтоож, олборлолт явуулан, нөхөн сэргээлтийг чанартай хийдгээрээ уул уурхайн цогц үйл ажиллагаатайгаа харуулав.

Эх орныхоо байгальд эзний сэтгэлээр ханддаг Гацууртынхан Зөвхөн уул уурхайд төдийгүй чанартай үйл ажиллагаа технологийн дэвшилд анхаарч харьяа салбар болгондоо шинэчлэлийг нэвтрүүлдэг нь салбар бол гоныг тэгш анхаардгийг гэрчилнэ.

Баяндулаан уул ХХК нь Гацууртын газар тариалангийн компани юм. 1991 онд Найрамдал САА задарч 11 аж ахуйн нэгж болон зохион байгуулагдсаны нэг бөгөөд 2003 онд Гацууртын салбар болжээ. Тус компани одоогоор газар тариалан, мал аж ахуйн салбарт 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, эрчимжүүлсэн газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр ажилладаг. Энэ ажлаараа нутгийн 700 гаруй хүнийг байнгын ажлын байраар хангав. Тэр хэрээр тухайн орон нутгийн иргэдийн амьдрал дээшлэх нь тодорхой юм. Харин газар тариалан, мал аж ахуйг зэрэгцүүлэн эрхлэхэд төвөгтэй байдаг. Энэхүү төвөгтэй, бэрхшээлтэй асуудлыг Гацуурт эрчимжүүлсэн аж ахуйн хэлбэрээр шийджээ. Тус компанийнхан монгол үндэстэн оршин тогтнох гол үндэс, стратегийн чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн болох улаан буудайн хэрэгцээний 25 хувь, хүнсний ногоо, гурил, мах, сүүний 10 хувийг дангаар хангах зорилт тавин ажиллаж байна. Үүний тулд дэвшилтэт техник, технологийг иж бүрдлээр нь авч нэвтрүүлснээр богино хугацаанд амжилт олжээ.

АНУ-ын Valmont услалтын системийг 2003 онд 400 га газарт суурилуулснаар усалгаатай тариаланг эхлүүлэв. Одоо усалгаатай 2 мянган га, усалгаагүй 20000 га-д тариалалт

хийж, нийт эргэлтийн талбай 47000 га-д хүрчээ. 2003 онд усалгаатай талбайд Канадын Journey сортын хатуу улаан буудайг анх туршин тариалж га-аас 45 цн, Канадын CoreLand сортын шар айрагны арвайг тариалж га-аас 55 цн ургац авч эрчимжүүлсэн газар тариалангийн давуу талыг мэдэрч чадав. Гацууртын усалгаатай тариалан хэд хэдэн давуу талтай. Усалгааг 1 метр (нам)-аас талбайн гадаргад жигд хүргэж, усны ууршилт гаргадаггүй. Усалгааны ситемийн уртыг тохируулж 2.5 га-аас 200 га хүртэл усалгааны хэмжээг сонгох боломжтой. Сүүлийн үед Гацуурт дэлхий нийтийн сонгодог газар тариалангийн системийг нэвтрүүлэх бодлогыг барьж ажиллаж байгаа юм. Газар тариалангийн салбар гадаадын улс орнуудын дэвшилтэт техник, технологийг оруулж ирэн өөрийн хэрэгцээнд төдийгүй газар тариалангийн бусад компаниудад хөнгөлөлттэй хэлбэрээр худалдаалдаг. Үүнд нь худалдан авагчид нь ч ам сайтай байж Гацууртаас олгосон боломжийг сайн ашигладаг.

Гацуурт компани Сэлэнгэ аймаг болон ойролцоох сумдыг сайн чанарын үрийн улаан буудайгаар хангах зорилготой бөгөөд энэ зорилгоо ч биелүүлээд эхэлчихжээ. Үрийн будааны чанарыг хадгалах олон улсын стандартад нийцсэн үр хадгалах босоо сав болон хэвтээ ангарыг нийт 70 мянга гаруй тонн үр, тариа хадгалах багтаамжтай Канадын Behlen, Westeel компанийн үрийн савнуудыг 2005 оноос хойш жил бүр тасралтгүй нэмж суурилуулан ашиглалтад оруулж байна.

Хүнсний ногоо, ялангуяа төмсний үйлдвэрлэлд хамгийн чухал зүйл бол тэдгээрийг хадгалах агуулах зоорь байдаг. Тус компани нь нийтдээ 2000 тонн төмс хүнсний ногоог үрийн болон таваарын зориулалтаар хадгалах орчин үеийн зоорь барьж ашиглалтанд оруулав. Тэнд төмс хүнсний ногоог хайрцаглаж хадгалах ба температур, дотор дулаан, чийгийг тааруулах сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон аж. Зоорины бүх үйл ажиллагаа автоматжуулсан бөгөөд цаашдаа таваарын төмсөө зах зээлд гаргахдаа зоориндоо угааж цэвэрлэж уутлах боломжтой юм.

Гацууртын МАА-н салбар нь таван салбар нэгжээ түшиглэсэн 5400 гаруй үхэр, 10 мянга гаруй бог, 350 гаруй адуутайгаас хээлтэгч мал 40-өөд хувийг нь эзэлдэг аж. 2008 онд техникийн шинэчлэлтэд 2.5 тэрбум, махны үйлдвэрийн цогцолборт таван тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 3000 үхэр бордох цэг, 1000 тугал бойжуулах битүү дулаан байрыг ашиглалтад оруулав. Махны үйлдвэр нь сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд үйлдвэрийн арга хэрэглэн европ стандартаар мал нядлах хамгийн сүүлийн үеийн загсаах, сэврээх цехтэйгээрээ Монгол улсад анхных нь болж байгаа юм. Азидаа анх удаагаа махны чиглэлийн хонийг гаргаж авч нутагшуулж байна. Малынхаа тэжээлийг мэдээж өөрөө бэлтгэдэг. Жилд 100-500 га-д тэжээлийн ургамал тариалан 10 мянга гаруй тонн дарш, 20 мянга орчим тонн байгалийн хадлан базаадаг аж. Малын чанарыг сайжруулах талаар олон ажил хийж байгаа ба 2007 онд Канадаас махны чиглэлийн Хар ангусын үр хөврөл оруулж ирж 276 үнээнд хээлтүүлэг хийснээр Монголд анх удаа махны чиглэлд тэргүүлэгч Ангусын цөм эх сүрэг өсч байна. Энэ ажилд нэг тэрбум төгрөг зарцуулсан байх жишээтэй. Гацуурт хэмээх брэнд болсон нэрийн дор Баяндулаан уул, Монгол ногоо, Сэлэнгэ хүнс, Виго буудай, Сэлэнгэ мах, Сэлэнгэ тос, Шаргал тариа, Сайхан толгой, Халимаг, Монгол Ангус, Сэлэнгийн тариалан, Скрин зэрэг 17 охин компани ХАА-н салбарт ажиллаж байгаа билээ.

Зөвхөн ажилчиддаа анхаарал халамж тавиад зогсох бус "эзэлж" авсан, бас дайралт

хийх гэж буй өргөн уудам зах зээлдээ хүндэтгэлтэй хандах хэрэгтэй байдаг. Тийм компани өөрөө хүндэтгэл хүлээж, хэрэглэгчдийг татаж, тоог нь өсгөж чаддаг. Гацууртын хувьд гадна юу болоод байгааг чагнах маш олон чих, хөгжпийн хөдөлгөөнийг харах төчнөөн нүдтэй гэж болно. Энэ нь Гацууртын компани болгон хариуцлагыг дээдэлдэгтэй холбоотой. Зарим бизнес эрхлэгчид хариуцлага гэдэг зүгээр л үг яриан дотор байдаг зүйл гэж боддог байж мэдэх. Гэтэл хариуцлага бол амжилтын "суурийн блок" гэдгийг Гацуурт сайн ойлгодог юм.

Гацуурт брэндийн нэр доор хариуцлагатай уул уурхай, хариуцлагатай эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, хариуцлагатай аюулгүй эрүүл хүнсний үйлдвэрлэл, хариуцлагатай эх орныхоо байгалийн сайхныг сурталчилсан аялал жуулчлал хөгжиж байна. Энэ бүх хариуцлагатай үйл ажиллагаа нэгдэн нийлж Гацуурт болохоороо аль нэгнийхээ алдааг засч, ололттой зүйлийг нь өвөр хоорондоо солилцож шинэ үүлдэр сорт мэт болгодог гэж болно.

Гацууртынхан ургамлаас "нефть" гаргаж болно хэмээн үзэж байна. Усалгаатай тариалангийнхаа хөрсийг амраахдаа канола гэдэг тосны ургамал тариална. 2006 онд Германаас тос шахах үйлдвэр оруулж ирэв. Канолагийн үр нь тос ба шахагдас болж үйлдвэрээс гарна. Эдгээр нь үйлдвэрлэлд өргөн сонголттой, олон төрлөөр ашиглагдаж байна. Канола шахагдас мал, гахай, тахианд ч үнэт тэжээл болдог. Гацууртынхан канола тосны ургамлаас биодизель боловсруулан гаргахаар тоног төхөөрөмж суурилуулах шатандаа ажиллаж байгаа аж. Биодизель нь хөдөө аж ахуйн машин техник, тоног төхөөрөмжинд ашиглагддаг бөгөөд хамгийн хямд төсөр, байгаль орчинд хор бохирдол үүсгэдэггүй бүтээгдэхүүн юм. Тэрхүү Германаас оруулж ирсэн үйлдвэр хоногт 5 тн рапе боловсруулж, 2000 литр тос 3000 кг рапсын шавхдас үйлдвэрлэх хүчин чадалтай ба түүхий тосоо дахин боловсруулж ургамлын тос болон биодизель гаргах боломжтой аж.

Канола хэр цэвэр байхаас тосны гарц шалтгаалдаг байна. Тус компанийнхан 2008 онд 500-800 тн улаан буудай, үр тариа хатаах хүчин чадалтай үйлдвэрийг угсарсаар үтрэм дээр үр тариа хатаах гэж модон хүрзээр суганыхаа булчирхайг цочтол самардаг "технологи" нэгэнт хоцрогджээ..

Уг хатаагч нь оруулж буй таримлын чийгний хувиас шалтгаалж үлээх агаарын тохиргоог градусын хэмжилтээр тохируулдаг бөгөөд зуухны даралт, уур хэмжих самбар, уур хадгалагч суурь, будаа өргөгч босоо элеватор, халуун уураар хангах хоолой бүхий 32 метр өндөр байгууламж юм. Зуухыг 640687 хэмд галлаж халуун уураар үлээлгэдэг нь ёстой л манай орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон өндөр бүтээмжтэй төхөөрөмж болохыг нь харуулна. Газар тариалангийн үйлдвэрлэлийн нэг хэсэг нь үр цэвэрлэх болон тэжээлийн үйлдвэр болохоор бидний сайн мэдэх орос үтрэмийн тоног төхөөрөмжтэй ижил төстэй тийм үйлдвэрийг ч байгуулжээ.

Гацууртын гадаад, дотоод худалдааны Брикпанд ХХК нь Их Британийн CASTROL, BP брэндийн тос тосолгооны материал болон Дани улсын LeGo брэндийн тоглоомны Монгол дахь албан ёсны борлуулагчаар ажиллаж байна. Хүн төрөлхтний амьдралын ерөнхий чиг хандлага зугаа цэнгэл, амралтын хөгжөөнтэй байдал руу явж эхэлжээ. Өглөө ажилдаа очиж өдөржингөө юу хийж байгаагаа эс мэдэн ажиллаад орой үхтлээ ядарчихсан гэртээ харина.

Энэ дүр зураг 7 хоногт 5-аас доошгүй давтагддаг цаг үе ард хоцрох ойрхон болжээ. Тэр

цаг үеийн уур амьсгалыг Гацуурт компанийнхан мэдэрч, тэр шинэ агаараар амьсгалж чадсан учраас дэлхийд алдартай LeGo брэндийн тоглоомыг оруулж ирэв. Энэ брэндийн тоглоом ХХ зууны шилдэг тоглоомоор шалгарсан билээ. LeGo тоглоом Монголын хүүхэд багачуудын оюуныг хөгжүүлж, сэтгэн бодох, техник сэтгэлгээг хурцлах шидтэй юм. Монголчууд хөгжиж, амьдрал нь улам сайн сайхан болоод зугаа цэнгэлийн ертөнцийн хаалгыг бүгдээрээ л татах болно. Тэр хаалганы цаана Гацууртынхан анхны шангаа татаад хүлээж байна.

### **Амжилтын нууц**

- Гацууртынхан Монгол Улсын ХАА-н салбарт технологийн шинэчлэл авчирч, ингэснээрээ үргүй зардлыг багасгасны дээр уул уурхайн шилдэг технологийн нөхөн сэргээлтийг анхлан хийсэн юм.
- Монгол Улсад уналтад ороод байсан газар тариалан, мал аж ахуйн салбарыг сэргээх үйл ажиллагаанд үлэмж хувь нэмэр оруулсан.
- Монгол Улсын газар тариалангийн салбарын сүүлийн 10 жилийн хөгжлийн түүхийг бичилцэв.
- Салбар болгоныхоо бизнест тооцоо судалгаатай, дэлхийн стандартын түвшин, өндөрлөгөөс хандаж тэр бүхний хоорондын харилцан итгэлцлийг ч бизнес болгож чадсан.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.gatsuurt.net](http://www.gatsuurt.net) Байгуулагдсан он: 1993 он

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Гацуурт ХХК-ийн байр

Үйл ажиллагааны чиглэл: Геологи, уул уурхай, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, барилга, гадаад дотоод худалдаа, спорт сургууль, телевиз.



## Амт чанарыг дээдэлдэг брэнд

Брэнд гэхээр тодорхой бараа, бүтээгдэхүүн үйлчилгээ гэж манай хэрэглэгч нар төсөөлдөг боловч улс орнууд өөрсдийгөө брэндлэдгийн адил мал худалдан авах, мах боловсруулах, хадгалах, нэр бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлд хүргэх гэсэн бизнесийн цогц, тогтолцоот үйл ажиллагааг Монголын бизнесийн хөгжлийн явцад "Max Market" гэсэн нэрээр хоногшуулан бий болгожээ. "Max Market" буюу хөдөөгийн малчид, хотын иргэд, олон улсын түншүүд, засаг захиргааны байгууллагууд аль аль нь анддаггүй нэгэн брэнд нэр сүүлийн арван жилд хэрхэн бий болж төлөвшсөн талаар товчхон түүх өгүүлье.

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь монголчуудын эрт дээр үеэс хэдэн үеэрээ дамжуулан эрхэлж ирсэн уламжлалт, нүүдлийн мал аж ахуй гэдгээрээ онцлогтой юм. Энэ аж ахуй дахь мал арчилж өсгөх, үржүүлэх, нядлах бүхий л үйл ажиллагаа нь эрчимжсэн мал аж ахуйгаас эрс ялгаатай. Монгол оронд нүүдлийн мал аж ахуйг өрхийн аж ахуй хэлбэрээр 400 мянга гаруй малчин өрх эрхэлдэг бөгөөд тэдгээр нь 1,5 сая гаруй хавтгай дөрвөлжин өргөн уудам нутаг дэвсгэрт тархснаараа бүр онцлогтой.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед мал аж ахуйн салбарыг улсаас онцгойлон анхаарч, сум (засаг захиргааны хамгийн бага шатны нэгж) бүрт мал эмнэлгийг улсын төсвөөр ажиллуулан, мал тууврын улсын компани малчин өрхийн хотноос малыг шууд хүлээн авч, мах боловсруулах үйлдвэрт хүргэн өгч, улс өөрөө махны нөөцөө бэлтгэн, түүгээрээ хот, төв суурин газрын иргэдийн махны хэрэгцээг хангаад зогсохгүй, илүүдэл махаа ОХУ-д экспортлож ирсэн байна.





1990 оноос Монгол орон төвлөрлөөс зах зээлийн эдийн засагт шилжихтэй зэрэгцээ мал эмнэлэг, мал бэлтгэлийн тогтолцоо болон мах боловсруулах үйлдвэрүүд бүгд хувьчлагдсан билээ. Ийнхүү мал эмнэлэг, мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийг тус тусад нь задалж хувийн өмчид шилжүүлсэн явдал нь махны үйлдвэрлэл, борлуулалтын салбарт нилээдгүй сөрөг үр дагавруудыг бий болгосон. Юуны өмнө мал эмнэлгийн тогтолцоо үндсэндээ устаж үгүй болов.

Мал бэлтгэл ийн үйл ажиллагааг малчид бус, тэдгээрийг мах боловсруулах үйлдвэртэй холбосон дундын зуучлагч брокерууд гүйцэтгэх болжээ. Ингэснээр брокерууд мах боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эд болох амьд малын үнийг хиймлээр нэмэх хандлага гарч, мах боловсруулах үйлдвэрүүдийн ашгийн түвшин буурч, дөнгөж үйлдвэрлэлийн зардлаа хаасан борлуулалт хийх болж, үйлдвэрлэл, технологийг сайжруулах, боловсронгуй болгох, их засварт зарцуулах хуримтлалгүй болж, улмаар ихэнхи мах боловсруулах үйлдвэрүүд дампуурч хаалгаа барьсан билээ.

Брокерууд нь малыг эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд гар аргаар нядалж, бэлтгэсэн махаа хөргөлтийн шаардлага хангаагүй зооринд хадгалан, зориулалтын бус тээврээр зах зээлд нийлүүлж эхэлсэн нь цаашдаа нийтийг хамарсан өвчлөлийг тараах аюулыг ч авчирч мэдэхээр болов. Мал нядалгааны болон хадгалах, тээвэрлэх энэ арга нь монгол

малын махыг сонирхдогч гадаад хэрэглэгчдийг болгоомжтой хандахад хүргэж малын махыг гадаад руу гаргах зах зээл хумигдахад нөлөөлөв. Мал бэлтгэлийн брокерууд нь малын гарал үүслийг сонирхдоггүй, гар аргаар нядалсан махыг шууд худалдан авдгаас малчдаас малыг нь хулгайлж тэдэнд нийлүүлдэг малын хулгайн сүлжээ бүхий үйлдэл удалгүй бий болж, малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлж эхэлжээ.

Жаст группын хувьд мал бэлтгэл, махны экспортын үйл ажиллагааг 2000 оноос эрхлэн гүйцэтгэж ирсэн бөгөөд дээрхи олон шалтгааны улмаас нэг бол энэ үйл ажиллагаагаа зогсоох, эсвэл шинэ арга барилаар төгөлдөржүүлэн эрхлэх гэсэн хоёр сонголтын өмнө тулгараад байв.

Монголчуудын эрт дээр үеэс эрхэлж ирсэн, хэдэн үеэрээ туршлага хуримтлуулсан мал аж ахуйн салбарын ажил хэрэг, мөн гуч гаруй сая малтай Монгол орны хувьд махны үйлдвэрлэлийн түүхий эдийг бүрэн хангах нөөц бололцоотой болсноор зах зээлийн сонгодог утгаар энэхүү салбарыг өөд нь татан шинэ арга барилаар эрхлэх, хөгжүүлэх боломжтой гэсэн итгэл, үнэмшлийг бий болгож байлаа. Ийнхүү Жаст групп нь махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг мал бэлтгэлийн шатнаас эхлээд үйлдвэрлэл, борлуулалтын шат хүртэл цогц хэлбэрээр нь хөгжүүлэхээр зориглон "Мах Маркет" хөрөнгө оруулалтын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд энэхүү хөтөлбөр нь гурван үе шагтайгаар хэрэгжихээр төлөвлөгдсөн юм.

"Мах Маркет" хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нэг дэх шатны үйл ажиллагааг 2004 онд эхлүүлсэн бөгөөд энэ үе шатанд юуны өмнө орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, гучин мянган тонн махыг байнга хадгалах хүчин чадал бүхий мах боловсруулах төв үйлдэрийг нийслэл Улаанбаатар хотод барьж байгуулахаар санаачлан хөрөнгө оруулалт хийж БНСУ, Япон улсын технологи, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон "Мах Маркет" мах боловсруулах төв үйлдвэрийг байгуулан хувьцааны дийлэнхийг эзэмших болов. Тус үйлдвэр нь таван давхар бүхий хөргөх, хадгалах агуулахуудтай байхаар төлөвлөгдсөн хэдий ч үйлдвэрийн зөвхөн 1-2 давхрын хадгалах агуулахуудыг ашиглалтанд оруулсан нь нийтдээ зургаан мянган тонн махыг хадгалах хүчин чадалтай болсон юм.

Хөтөлбөрийн хоёр дахь шатны үйл ажиллагааг "Мах Маркет" мах боловсруулах сүлжээ үйлдвэрүүдийг хөдөө орон нутагт барьж байгуулахад чиглүүлэв. Уг төслийн эдийн засгийн үр ашигтай байдлыг хангуулах гол нөхцөл нь үйлдвэрийг хөдөө орон нутаг, малчидтай холбох, ойртуулах явдал гэдэг нь тодорхой байсан тул юуны өмнө Улаанбаатар хотоос алслагдсан, мал ихтэй орон нутагт мах боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулах ажлыг 2006 оноос эхлүүлж, тэдгээр үйлдвэрүүд дээрээ түшиглэн мал бэлтгэлийн цоо шинэ тогтолцоог банкны системтэй хамтран ажиллуулсан нь 2008 оны эхэн үе гэхэд бүрэн төлөвшин ажиллаж эхэлжээ. Өнөөгийн байдлаар "Мах Маркет"-ын сүлжээ 11 үйлдвэр орон нутагт ажиллаж байна.

Ийнхүү "Мах Маркет" сүлжээ нь хөтөлбөрийн хоёр дахь шатны ажлын дараа нийтдээ 17 мянган гаруй тонн мах, махан бүтээгдэхүүн хадгалах хүчин чадалтай, жилдээ 10-12 мянган тонн бүтээгдэхүүн борлуулж дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлдэг, Монголын мал бэлтгэлийн үйл ажиллагааны 90 гаруй хувийг хөдөө орон нутагт хийдэг бие даасан тогтолцоо болж өөрийн цаашдын хөгжлийн бат бэх суурийг тавьсан билээ.



Өнөөдөр "Мах Маркет" хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь өөрийн төлөвлөсөн гурав дахь шатандаа шилжин оржээ. Мах боловсруулах үйлдвэрүүдийн сүлжээгээ өртгөтгөн Монгол орны төв болон баруун төв бүсийн нутагт мал бэлтгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ингэснээр мал бэлтгэлийн үйл ажиллагааг улс даяар хамарч явуулах, махны үнийн огцом хөдөлгөөнийг сааруулан нийт эдийн засагт тогтвортой байдал бий болгоход нөлөөлөх, мах хадгалах хүчин чадлаа нэмэгдүүлэх, үүнтэй холбоотойгоор Улаанбаатар хот дахь төв үйлдвэрийн хадгалах агуулахын үлдсэн давхруудыг ашиглалтанд оруулж, хүчин чадлыг 30 мянган тоннд хүргэх, мах боловсруулах технологийг ястай мах бэлтгэх технологиос шулсан мах бэлтгэж, хадгалах технологид эхний ээлжинд шилжүүлэх, улмаар дэлхийн махны үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлж өөрийн "Мах Маркет" брэндийн мах, махан бүтээгдэхүүнийг дотоод болон гадаадын зах зээлд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болгоход энэ шат чиглэх аж.

Эрүүл мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь эрүүл мал үйлдвэртээ нийлүүлэхээс эхэлдэг. Үүний тулд амьд малд үзлэг хийж, серилогийн шинжилгээнд хамруулах болжээ. Мөн мах, махан бүтээгдэхүүнд, салбарын хэмжээнд 6,500 орчим үзүүлэлтээр хими, бактериологийн шинжилгээ явуулж байна. Сүүлийн гурван жилийн дотор үйлдвэрийн лабораторид "Махны чанар, аюулгүй байдлын зарим судалгаа" төсөл хэрэгжиж олон шинэ төхөөрөмжөөр тоноглогдов.

Мах Маркет үйл ажиллагаандаа олон улсын хүнсний аюулгүй байдлыг хангасан "Эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо" буюу HACCP системийг нэвтрүүлж эхэллээ. Үүний үр дүнд үйлдвэрийн бүх дамжлага, ажиллагсдад тавих эрүүл ахуйн шаардлага өндөрсөж, бүтээгдэхүүний ариун цэвэр, чанарын баталгаа дээшилж, дэлхийн стандартад өдрөөс өдөрт ойртох болжээ.

Мах Маркет үйлдвэрийн брэнд бүтээгдэхүүнүүд бусдаас өвөрмөц, шинэ технологи, туршилтын үр дүнд бий болсон байдаг. Барааны тэмдгийг хэрэглэгч нар танин мэдэж хэрэглэж байхын тулд бүтээгдэхүүнээ хөгжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог нэвтрүүлж, ISO 22002-1 болон үндэсний стандартад бүрэн нийцсэн, орчин үеийн технологиор боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг боллоо. Энэ нь уламжлалт ОХУ - аас гадна, өөр гуравдагч зах зээлд, тухайлбал араб болон бусад улс орнуудад Монголын махан бүтээгдэхүүнийг экспортлох өргөн болоцоог нээж байгаа билээ.

Энэхүү стандартыг мөрдсөнөөр мал эмнэлгийн хяналт, эрүүл ахуйн шинжилгээгүй амьд мал хотод нэвтрэх, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд нядалгаа хийх, мах, махан бүтээгдэхүүнийг ил задгай зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэх, лабораторийн шинжилгээгүй хүмүүс махны үйлдвэрлэл, борлуулалтад оролцох зэрэг сөрөг үзэгдлийг таслан зогсооход нөлөөлөв. Энэ нь зөвхөн Мах Маркет брэндийн бизнесийн асуудал төдийгүй монголын иргэдийг эрүүл хүнсээр хангах төрийн бодлогыг хэрэгжүүлж буй нэг хэлбэр юм.

Мах Маркет сүлжээ үйлдвэрүүд хоногт хоёр мянга орчим бод, есөн мянга гаруй бог мал төхөөрч, 260 тонн мах, дайвар бүтээгдэхүүн гүн хөлдөөж, хадгалах хүчин чадалтай болсноос гадна орчин үеийн техник, технологийн стандарт бүхий нэг ижил горимтой, төв үйлдвэр нь сүлжээ үйлдвэрүүдээ мэргэжлийн болон өдөр тутмын удирдлага, хүний нөөцөөр

хангаж ажилладаг. 2010 оны байдлаар Мах Маркет үйлдвэрүүдийн сүлжээ улсын хэмжээний мал бэлтгэлийн 32 хувь, мал нядлах хүчин чадлын 26 хувь, мах махан бүтээгдэхүүн хадгалах хүчин чадлын 30 хувь, тураг махны экспортын 23 хувийг эзэлсэн нь ажлынх нь цар хүрээ, далайцыг харуулж буй нэгээхэн үзүүлэлт юм.

Товчхон дүгнэхэд, Мах Маркет гэдэг маань монголын хөдөө талаас суурин газрын хэрэгцээг аюулгүй хүнсээр хангаж, олон улсын зах зээлд монгол бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа малчид, иргэд, үйлдвэрлэгч, бусад олон байгууллага оролцсон Монголын үндэсний бахархал болсон брэнд билээ.

### **Амжилтын нууц**

- Олон улсын стандартад нийцсэн үйлдвэрүүдийн сүлжээг бий болгож чадав. Үйлдвэрүүд нь орон нутагт байгуулагдсанаараа монгол малыг дасч зохицсон орчноос нь салгахгүйгээр мах бэлтгэл, үйлдвэрлэлд оруулдаг давуу талтай.
- Олон улсын хүнсний аюулгүй байдлыг хангасан HACCP систем бүхий үндэсний стандартад бүрэн нийцсэн орчин үеийн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.
- Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй нь хэрэглэгчдийн таашаалыг хүлээв.
- Малыг ченжийн гар дамжуулахгүй харьцангуй өндөр үнээр малчдаас худалдаж авдаг нь амжилтад шууд нөлөөлж, брэндийн чанар нэр хүндийг өсгөдөг.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.justgroup.mn](http://www.justgroup.mn) Байгуулагдсан он: 2000 он

Компанийн хаяг: Жаст Агро ХХК, Мах Маркет төв үйлдвэр, Монгол улс, Улаанбаатар-16102 Баянгол дүүрэг, 20-р хороо

Үйл ажиллагааны чиглэл: Мал худалдан авалт, мах, махан бүтээгдэхүүний сүлжээ дэлгүүр, махны үйлдвэрлэл



## **Хүнсний тусгаар тогтнолыг хамгаалагч брэнд**

Эрүүл чийрэг иргэн бол аль ч улс орны хамгийн үнэт баялаг нь юм. Энэ баялгийг чанартай, чадвартай байлгаж амжилтад хүргэхэд цэвэр, аюулгүй хүнс тэжээл чухал. 1990-ээд оны эхээр эдийн засаг хямарч, үүнээс шалтгаалан хүнсний салбарт мах, гурил, талх, будаа, цөцгийн тос, элсэн чихэр зэрэг гол нэрийн бараа хомсдож картын тогтолцоо ноёлсон байв. Лангуун дээр бор давснаас өөр бараагүй болжээ. Шинэчлэл, өөрчлөлт, дэвшил хэрэгтэй байлаа. Монгол улсын Засгийн газраас 1993 оныг "Хүнсний жил" болгож, 1994 онд "Монгол хүний хоол тэжээл" үндэсний хөтөлбөр, бас 1995 онд "Хүнсний тухай хууль" батлагдав. Гэхдээ энэ нь цаасан дээрх тунхаг төдий байлаа. Гадаадын чанартай, чанаргүй гурил будаа, чихэр жимс хүнсний зах зээлийг дүүргэчихсэн, хэрэглэгчид түүнд хүссэн хүсээгүй ч дасан зохицож байв.

Энэ нь зарим бизнесмэний нүдэнд хүнсний аюулгүй байдал, хүнсний тусгаар тогтнолын бодлого тусгаар тогтносон улс оронд заавал байх ёстой гэсэн байнгын сануулга болж харагдаж байв. Тийм холыг харсан хүмүүсийн дотор Таван

Богдын Ц.Баатарсайхан гэх биерхүү нэгэн багтжээ. Нэг удаа тэр дотоод сэтгэлээ нээж "Монголчууд хэзээ ч хэн нэгний өттэй гурил идэж явах учиргүй тэнгэр язгуурт үндэстэн юм шүү" гэж үг алдсан. Алдсан үг нь ажил хэрэг болов. Улаанбаатар гурил ХХК-ийн үйлдвэр 2001 онд ашиглалтад орлоо. Дэлхийн алдартай брэндүүд ихэнхдээ санамсаргүй байдлаар бий болж өргөжин тэлж, хувь заяаны ба зах зээлийн эргэлтэд орсон байдаг.

Харин Улаанбаатар гурил ХХК ухамсартай, бодлоготой, эх оронч сэтгэл дээр бий болсноороо азтай бус ухаантай үйлдлийн үр дүн байлаа. Жилийн дараа гэхэд л Түрэг Холландын SAS технологийн иж бүрэн дамжпага бүхий орчин үеийн өндөр бүтээмжтэй үйлдвэрээ ашиглалтад оруулав. Энэ нь том зай эзлэхгүй, цахилгаан, дулаан, уур ус болон бусад шугам сүлжээг хялбар, хямд төсөр болгосон, цахилгаан бага зарцуулдаг, ажиллах хүч ихээр шаардахгүйгээрээ алдартай. Мөн бүх тоног төхөөрөмж нь нэг давхарт суурилагдаж, механик болон агаарын дамжлага шугамаар холбогдсон байна. Хоногт тус бүр нь 110 тн буюу нийтдээ 330 тонн тариаг цэвэрлэж боловсруулан 75-78 хувийн гарцтай 245-260 тонн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай гурван бие даасан хэсэгтэй юм.

Энэ үеэс л Улаанбаатар гурил Монгол улсыг бүтээгдэхүүнийхээ борлуулалтын талбар гэж харж эхэлжээ. Энэ өргөн уудам бөгөөд сийрэг зах зээлд хүрэхэд түгээлт, сүлжээний менежментээс гадна бүтээгдэхүүний чанар гол байлаа. Төмөр зам болон авто тээврийн хэрэгслээс тариа хүлээн авч буулгах тоног төхөөрөмж бүхий найдвартай агуулах нь нөөцөлж хадгалахад толгой өвгөхгүй. Бас үр тариаг урьдчилсан цэвэрлэгээ хийх, угаах технологи нэвтрүүлснээрээ бусдаасаа хэдэн алхам түрүүлжээ. Өөр үйлдвэрүүд зөвхөн чийглэж

цэвэрлэдэг бол Улаанбаатар гурил нь буудайг усаар угааснаараа гадаргууд наалдсан нарийн тоос хогийг сайтар цэвэрлэж өнгө чанартай гурил гаргадаг болов. Мөн Швейцарь, Япон, Түрэгийн орчин үеийн лабораториор түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанарт хяналт шинжилгээ хийчихнэ. МҮХАҮТ, Нийслэлийн захирагчийн албанаас зохион явуулдаг Улаанбаатар түншлэл Био эко бүтээгдэхүүн үзэсгэлэнгээс энэ давуу талаараа Шилдэг технологитой бүтээгдэхүүн өргөмжлөлийг хоёр ч удаа авчээ.

Улаанбаатар гурилын бүтээгдэхүүний талаар захын хэрэглэгчээс асуухад цавуулаг сайтай, ус сайн даадаг, цагаан шаргал өнгөтэй гэж гурилын чанарт тавигдах үндсэн шаардлагыг хангасныг нь шуудхан л хэлнэ. "Шинэ цагийн шинэлэг технологи, шилдэг бүтээгдэхүүн, шинэ чанар гээд ямагт шинэ байж чаддаг, бидний дотны түнш, итгэлтэй анд". Энэ бол Улаанбаатар гурилын ямар ч рекпамгүй тодорхойлолт. Нэг амжилт гаргаад түүн дээрээ гишгээд таг зогсчихвол цааш хөгжихгүй. Улаанбаатар гурил үргэлж шинэ байхыг эрмэлзэж ирсэн. Энэ шинэчлэгч үзэл санаа нь тус брэндийн амжилтын үндэс юм. Гурилын чанарын цаана хүний чанар, улаан буудайны чанар, технологийн дэвшил баталгаа болон "зогсч" байна. Тарианы сорт, гурилын нэр төрлөөс хамаарч дээдийн дээд, ширхэгтэй дээд, дээд, нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар зэргийн гурил үйлдвэрлэдэг. Хэрэглэгчээ халамжлах нөхөрсөг уур амьсгал ч Улаанбаатар гурилын бүтээгдэхүүнд нэвчих боллоо. Нэгдүгээр гурилыг В-ийн төрлийн амин дэм, төмрийн бэлдмэлээр баяжуулах технологийг гаргаж ирэв.

ЭМЯ, Азийн хөгжлийн банкттай хамтарч "Ядуу эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах JFPR 9005" төслийг ийнхүү хэрэгжүүлж байгаа нь хоол хүнснээсээ өөрт хэрэгцээтэй аминдэм, эрдэс бодисыг авахад хэрэглэгчдээ тусалсан сайхан сэтгэл юм. Баяжуулсан гурилыг жирийн нэгдүгээр гурилын үнээр борлуулж байгаа билээ. Уг бүтээгдэхүүнийг хэрэглэснээр амин дэм, эрдэс бодисын дутагдлаас урьдчилан сэргийлэх сайн талтай. Үүнийг хэн, хэзээ, хэрхэн хэрэглэх ёстой вэ? Хүн болгонд тэгш хүрэх боломжтой "ялгаварлан гадуурхах" санаа өвөрлөөгүй баяжуулсан гурилыг бага насны хүүхэд, жирэмсэн болон төрөх насны эмэгтэйчүүд, настайчууд, ходоодны шархлаа, цагаан хорхойтой хүмүүс, шамбрам, цус алдалтын үед хэрэглэхэд хоол болохоос гадна эм болно. Цэвэр органик хүнс рүү дэлхий нийтээр ханарах болсон энэ үед Улаанбаатар гурил брэнд анагаах увидастай бүтээгдэхүүнээр нэр төрлөө нэмэгдүүлсэн нь цаг үеэ дэндүү сайн мэдэрдгийг нь харуулна. Мөн хэрэглэгчиддээ хүнсний хивгийг санал болгосон нь богино хугацаанд амжилт олжээ. Өмнө нь хивгийг мал, амьтан л иддэг гэсэн ойлголт байсан бол одоо өөрчлөгдөв. Энэ брэнд өөрийгөө өөрчилж шинэчлэхийн сацуу хэрэглэгчээ өөрчилдөг, өөрийнхөө араас дагуулах чадвартай юм.

Хивгийг төрөл бүрийн гурилан бүтээгдэхүүн, хоолны гурил, зуган шөл, агшаасан будаа, салатанд хольж хэрэглэнэ. Мөн түүхий байдлаар уудаг. Ингэж хэрэглэхэд гэдэс дотрыг цэвэрлэх, гэдсэн дэх хорт бодисыг шингээж, цус руу шимэгдэх шимэгдлийг нь сааруулах, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг идэвхжүүлэх, өтгөн хаталт, цөс чулуужихаас сэргийлэх зэрэг давуу талтай. Улаанбаатар Түншлэл Био Эко бүтээгдэхүүн Олон улсын намрын үзэсгэлэнгийн үеэр хүнсний хивэг хамгийн борлуулалттай бүтээгдэхүүн болж байв. Улаанбаатар гурил анагаагч чанартай болохоор айл бүхэнд хэрэглэгч болгонд өрхийн эмч шиг "очиж" байх учиртай.

Хүн ер нь юу идэж байгаага мэддэг байх нь чухал. Хаанаас авчирсан, юугаар хийснийг нь мэдэхгүй юмыг ам руугаа хийнэ гэдэг өнөөдөр боломжгүй зүйлийн нэг болжээ. Харин Улаанбаатар гурилын хувьд хэрэглэгчийг энэ эргэлзээтэй байдлаас гаргахын төлөө байна. Энэ брэнд нь 1кг, 5кг, 10 кг, 25 кг-аар савлагдсан бөгөөд эрүүл хүнсний лого сав, баглаа боодол дээр нь заавал бичигдсэн байдаг. Улаанбаатар гурилын гурван ширхэг түрүү хэрэглэгчийнхээ нүдэнд найзынх нь царай шиг харагддаг гэж болно. Сүүлийн үед Улаанбаатар хотын бүх хүнсний захууд, Миний дэлгүүр, Номин, БОСА, Сансар сүлжээ, Монфреш, САПУ-гийн сүлжээ дэлгүүр болон бүх супермаркет, хүнсний дэлгүүрүүдийг Улаанбаатар гурил хангах болов. Мөн Дархан, Эрдэнэт, Төв, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор аймагт гэрээт борлуулагчтайгаас гадна тус брэндийн очоогүй сум, баг, хэрэглээгүй хэрэглэгч гэж үгүй. "Цагаан сарын гурил" гэдэг нэртэй болсон нь түүний хэзээ ч нүүр улайлгахгүй чанартайг нь маш энгийнээр өгүүлсэн хэрэг юм. Улаанбаатар гурил бол халамжлагч сайхан зантайгаас гадна хандивлан туслагч брэнд юм.

Жил бүрийн Сар шинийн баяраар тус компани бүтээгдэхүүнийхээ дээжээс нийгмийн эмзэг, тусламж дэмжлэг шаардлагатай хэсгийнхэнд бэлэглэдэг. Улаанбаатар гурилаар үйлдвэрлэсэн Атар өргөөгийн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн хамгийн найдвартай хүнс юм. Эх нь ямар байна, унага нь тийм л байдаг гэсэн үгийг энд хэлж болмоор санагдана.

Эх орны шинэ ургацын улаан буудайнаас бүтээгдэхүүнээ гаргаж авдаг, чанарыг илүүд үздэг энэ компанийнхан 2004 оны шилдэг үйлдвэрлэгч, Эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүн, Эрүүл аюулгүй хүнсний үйлдвэрлэгч гэдгээрээ олны итгэлийг хүлээж, өөрөөр хэлбэл брэнд болж чаджээ. Брэнд болоход бэрхшээлийг ялах тэнхээ хэрэгтэй. Улаанбаатар гурил Цагаан сарын хүнс гэж алдаршсан. Энэ нь юу гэсэн үг болохыг монгол хүн бүхэн шууд ойлгоно доо. Бөөний болон жижиглэнгээр түгээхийн ялгааг арилгаж улс орныхоо зах зээлд тэгш хүрч чадсанаараа Улаанбаатар гурил дэлхийд өрсөлдөх Монгол брэнд болох шатаа алгуурхан тавьж байна гэсэн үг.

### **Амжилтын нууц**

- Аюулгүй цэвэр хүнсний эрэлт хэрэгцээ, нийгмийн цаг агаарт тохирсон байдлыг нь брэндийн гол хүч гэж үзэж, үйлдвэрлэл, түгээлт, борлуулалтандаа энэ зарчмыг "шингээж" ирсэн. Хүн өөрийгөө хэн болохыг илэн далангүй ярьж байж хэн нэгний итгэлийг хүлээдэг шиг Улаанбаатар гурил өөрийнхөө бий болсон үе шат бүхнийг хэрэглэгчийнхээ нүдэн дээр ил тод, ойр ойлгомжтойгоор харуулж чадсан.

- Хоол төдийгүй анагаагч чадалтай хүнсний бүтээгдэхүүн. Нийгмийн сайн сайхны төлөө бий болсон төдийгүй үйл ажиллагааныхаа зарим хэсгийг энэ үйлсэд хандивладаг. Ялангуяа монголчуудын уламжлалт Цагаан сарын баярын зоогийн гол хольц болгосон реклам нь зөвхөн сурталчилгаа төдийгүй үнэн амьдрал шиг харагдаж иржээ. Үе дамжсан хөөргөө машин гурилаар солих гэж байгаа хөдөөний панзчин эрийн царай бол магадгүй Цагаан сарын өмнөх монгол эрчүүдийн нийтлэг төрх ч байж болох юм. Дотно, дулаан байдал нь хэрэглэгчдийн дунд нэр хүндийг нь өсгөв.

- Улаанбаатар Түншлэл Био Эко бүтээгдэхүүн Олон улсын намрын үзэсгэлэнгүүдийг уг бүтээгдэхүүн байлдан дагуулав. Мөн хэрэглэгчдэдээ ямар ч хэмжээ, сав боодлоор хүргэх

асуудлыг шийдсэн нь олны таашаалд нийцжээ.


- Улаанбаатар гурилын гурилаар үйлдвэрлэгдсэн Атар өргөөгийн нэр хүнд тус брэндийн эргэсэн үнэлэлт болсон.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.tavanbogd.com](http://www.tavanbogd.com) Байгуулагдсан он: 2001 он

Компанийн хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө Улаанбаатар-36, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Гурилын үйлдвэрлэл.





CHINGGIS

## МОНГОЛЫН ШИЛДГЭЭР ДЭЛХИЙД ШАЛГАРСАН

Хагас зууны түүхтэй "Спирт Бал Бурам" компани Монголын зах зээлд премиум брэнд гэж тодотгосон Чингис бүтээгдэхүүнийг гаргаж, үндэсний үйлдвэрлэгчиддээ тансаг брэндийн жишгийг тогтоож өгсөн билээ.

- 2002 онд анх зах зээлд гарсан
- 2004 онд хамгийн анх экспортод гарсан
- 2010 онд

ЧИНГИС БРЭНД ТӨГС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

### **Түүхий эд:**

Шилмэл улаан буудайн тансаг спирт, цэвэршүүлэн боловсруулсан ус

### **Технологи:**

Дэлхийн стандартад нийцсэн уламжлалт технологи нарийн цэвэрлэгээний 11 давхар шүүлтүүрийг ашиглан, дээд зэргээр цэвэршүүлэн Платинум буюу цагаан алтан шүүлтүүрээр шүүж үйлдвэрлэдэг.

### **Хяналт, шинжилгээ:**

Эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртэл лабораторийн нийт 23 удаагийн хяналт, шинжилгээ, амтлах мэдрэхүйн тусгай сорилтоор баталгаажуулсан, эцэст нь хүнсний шингэн бүтээгдэхүүний бүхий л найрлагыг тодорхойлдог электрофорезийн аппаратаар хэмждэг. Үндэсний тохирлын баталгаатай бүтээгдэхүүн. ISO 9001, ISO 22000 олон улсын хүнсний аюулгүй байдлын хос стандартын дагуу үйлдвэрлэгддэг "Экспортын шилдэг бүтээгдэхүүн" билээ.

**Савлалт:** 50 мл, 0.5 л, 0.7 л, 0.75 л, 1.75л

**Хатуулаг:** 39%

**Төрөл:** Цагаан архи



## Эх орны хөрснөөс ургасан цэвэр брэнд

Зүүнхараагийн спиртийн үйлдвэр гэхээр хэний ч сэтгэлд дотно танил байдаг. Монгол улаан буудайн цэвэр спиртийг дал шахам жил нийлүүлсэн уг үйлдвэр нь эдүгээгийн Спирт Бал Бурам гэх арааны шүлс асгармаар нэртэй компани болж өөрчлөгдөн шинэчлэгджээ.

Брэндүүдийн өрсөлдөөн гэдэг улс төрийн сонгуультай нэлээн төсөөтэй болохыг зарим хүн тэмдэглэсэн байдаг. СББ-ын хувьд бусад нэр дэвшигчид шигээ овжин реклам урсгаж, өөрийгөө магтаж мандуулах шаардлага байхгүй. Тэр энэ салбартаа найдвартай, итгэж болох нэр дэвшигч гэдгээ мэддэг. Эх орны хөрсөнд ургасан улаан буудайн цэвэр спиртээр үйлдвэрлэгддэг нь СББ-ын брэндүүдийн хүч юм. Үйлдвэр ямар байна брэнд тийм л байдаг. Энэ хоёр эцэстээ нэг л зүйл. СББ аль 1990-ээд оноос хойш арав гаруй удаа техник, технологийн шинэчлэл хийж цаг үетэйгээ уралдаж шинэчлэгдэж ирсэн ба олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэгч анхны компанийн нэг болов. "Хар" Чингис хэмээн олноо өргөмжлөгдсөн Чингис, Хубилай, Гранд хаан, Хараа, нимбэгтэй Хараа, Ерөө, алимтай Хараа архины чанар, технологийн талаар олон үг нурших шаардлагагүй.

Эдгээр брэнд нууцлал сайтай. 2004 онд "Үндэсний шилдэг брэнд" Хараа архины шошгонд бүрэн шинэчлэл хийж, өндөр нууцлал шаарддаг мөнгө, үнэт цаас, цахим картад хэрэглэдэг голограм цаасыг анх удаа ашиглажээ. Бүтээгдэхүүний бөглөөнд неон гэрлийн мэдрэгч бүхий бичиглэлийн нууцлалтайгаас гадна 100 хувь баталгаат лацтай. Мөн лацны өнгийг тогтмол өөрчлөн, хуурамч бүтээгдэхүүн хажуугаар орж ирэхээс сэргийлдэг. Хэрэглэгч, брэнд хоёрын хоорондын итгэлцэл энэ бүхэн дээр тогтдог гэж болно.

Эзэн Чингисийн нэртэй сархадыг эдүгээ хэд хэдэн архины үйлдвэр янз бүрийн нэр, шошготойгоор гарган монголчууддаа хүргэж байгаагийн дотроос дотооддоо "Хар" Чингис, гадаадад бол Гранд Хаан нэртэй борлогдож байгаа энэхүү сархад нь СББ-ын шилдэг брэндийн нэг. Аливаа ёслол, Цагаан сар, Шинэ жилийн баяраар монголчууд бид идээ ундааныхаа дээдийг эрхэм зочиддоо өргөн барьдаг уламжлалтай. Тэгвэл "Хар" Чингисээр баярын ширээгээ чимээгүй айлыг зарим нэг нь муулахаас наагуур ярьж "найрка" уух аюулаас болгоомжилсондоо ч тэр үү, барьсан архийг нь тэгсхийгээд ёслоод өнгөрдөг болсон нь нууц биш.

Чанараа дагаад хэрэгцээ өсөх нь зах зээлийн бичигдээгүй хууль аваас СББ-ын борлуулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд асар хурдацтай өсч байна. Ийм хурдтай өсөлт нь согтууруулах ундаа үйлдвэрлэгч брэндийн хувьд санаанд багтамгүй хэрэг. Найдвартай бөглөө, сав баглаа боодлын өвөрмөц дизайныг СББ-ын хамт олон цаг ямагт шинийг эрэлхийлж үйлдвэрлэлдээ нэвтрүүлж ирснээр брэндийнхээ нэр хүнд, баталгаат чанарыг цаг, минут, өдөр, сараар нь хэмжин лонхон дээр нь баталгаажуулж өгдөг болсноор "Хар" Чингисийн нэр хүнд улам бүр өсөхөд нөлөөлөв. Энэ бүхнийг гүйцэлдүүлэхэд зовлон их бий ч дэлхий даяар тархсан Absolut Vodka, Smirnoff, Stolichnaya, Grey Goose-ын дайтай сархад



болгохын тулд СББ-ын хамт олон уйгагүй ажиллаж байна.

Хамгийн гол нь Эзэн Чингисийнхээ нэрийг брэнд бүтээгдэхүүнээрээ дамжуулж дэлхий даяар тархах боломжийг тэд өөрийн брэндэд бүрдүүлж өгсөн юм. Чингэснээр Чингисийн Монголыг сонирхох жуулчдын цуваа, Их хааны үүх түүхийг судлахыг хүссэн эрдэмтэн мэргэдийн хөл ч тасрахгүй байна.

Тус компани Монгол улсын хэрэглээний спиртийг олон жил дангаараа хангаж ирсэн. Энэ давуу талаа алдахгүй бүтээгдэхүүний чанар, борлуулалтаараа тэргүүлсээр байна. СББ зар сурталчилгаанд тэгтлээ дурлаад байдаггүй гэж өмнө өгүүлсэн. Түүний реклам нь хэн хүнд мэдлэг мэдээлэл өгсөн, хүнийг хөгжүүлж өрсөлдөөнд уриалсан өнгө аястай бүхэл бүтэн нэвтрүүлгүүд байдаг. Энэ нь нэг бодлын реклам бус хэрэглэгчдийнхээ оюун санаанд хөрөнгө оруулалт хийж мэдлэг мэдээлэл өгч байгаа хэрэг. СББ өгөөмөр зантай. Урлаг соёл, спорт, боловсрол, эрүүл мэндийн салбарт тогтмол хөрөнгө оруулж ирсэн. Ингэж нийгмийн хариуцлагаа өндөржүүлэхийн зэрэгцээ сүүлийн 10 жилийн турш газар тариаланд жил бүр нэг тэрбум төгрөгийн санхүүжилт хийж байна.

Үүндээ түшиглэн 2004 онд Түрэг улсын АНА группын Sas technology SC-1500 гурилын үйлдвэрийг ашиглалтад оруулав. Мөн энэ хугацаанд улсад нийт 160 тэрбум төгрөгийн татвар төлж, төрийн "алтан сан"-г арвижуулжээ. Үйлдвэрээс гарч буй бүх хаягдлыг дахин боловсруулж, байгаль орчинд хоргүй үйлдвэрлэлийг эрхлэх болов.

СББ архи спиртийн үйлдвэрээс гадна гурилын үйлдвэр, дулааны станцын үйл ажиллагааг явуулж нийгмийн зангараг, нөлөөгөө өргөжүүлэв. Тэдний брэндүүд дэлхийд чанараараа шалгарч, олон улсад нэр хүнд нь өсөх болсноор гадаад худалдаандаа анхаарч олон түншгэй болжээ. Тус компани өдгөө АНУ, Канад, Их Британи, Лихтенштейний вант улс, Солонгос, Герман, Швейцарь, Австри, Хятад, Сингапур, Болгар, Япон зэрэг хүнсний чанар, технологиороо дэлхийд тэргүүлж байгаа улс орнуудад Чингис, Хараа брэндүүдээ экспортлож байна. Нью-Йорк, Лондон, Токио хаана л бол хаана "Хар" Чингисийн дараалалд зогсч байгаа хүмүүсийг харсан нэгэн хүн "Absolut Vodka Оросын энэ төрлийн бүтээгдэхүүнийг Барууны зах зээл дээр өвдөг шороодуулж байсныг санахад хүргэв" гэж ярьсан байдаг. Ингэж улс орнууд Спирт Бал Бурамд хаалгаа нээж өгсөн нь тус компанийн манлайлагчийн тугийг өргөж, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх хүч тэнхээг нь улам бүр нэмэгдүүлж байгаа юм.

### **Амжилтын нууц**

- Амжилтын гол хүчин зүйл болсон технологийн шинэчлэлдээ байнга анхаарч ирсэн. Технологийн шинэчлэлийн он дарааллыг харахад энэ бүхэн тодорхой болно. 2002 онд Спиртийн үйлдвэрээ бүрэн автоматжуулсан. Мөн ондоо багтаж архины үйлдвэртээ мөнгөжүүлсэн шүүлтүүр ашиглаж эхэлсэн. Нэг жилийн дараа олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001 стандартыг Монгол улсын хүнсний үйлдвэрүүдээс анхлан тогтоосон. 2008 онд архины үйлдвэрийн шугамыг бүрэн шинэчилж, ХБНГУ, ОХУ, Тайвань улсын хамгийн сүүлийн үеийн технологиор тоноглогдов.

- 2009 онд Монголд анх удаа хүнсний шингэн бүтээгдэхүүнийг шинжлэх зориулалт бүхий электрофорезийн аппаратыг эцсийн бүтээгдэхүүн гаргахдаа хяналт шинжилгээнд

ашиглаж эхлэв. Үүнээс нэг жилийн дараа ISO 22000 олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэгч анхны компанийн нэгээр өргөмжлөгдөв.

- Мөн ондоо шүүлтийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч ОХУ-ын Технофильтр компанид үйлдвэрлэгдсэн Платинум буюу цагаан алт болон мөнгөжүүлсэн хосолмол шүүлтүүрийг архины үйлдвэрлэлд анхлан нэвтрүүлсэн.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.sbb.mn](http://www.sbb.mn) Байгуулагдсан он: 1945 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, СББ ХК-ийн байр

Үйл ажиллагааны чиглэл: Архи, спиртийн үйлдвэр, гурилын үйлдвэр, дулааны станц



## **«МОНОПОЛЬ»-оос Монголын нэрийг дэлхийд гаргах хүртлээ хөгжсөн брэнд**

2001 онд АПУ компанийн төрийн мэдэлд байсан 51 хувийг дуудлага худалдаагаар зарснаар тус компани хувийн өмчид бүрэн шилжив. Хувьчлалыг дагасан хэл ам, хэрүүл тэмцэл, атаа жөтөөг ч шинэ эзэд нь "хувьчилж авсан" байлаа. Тэр бүхэн үйлдвэрийн нэр хүндийг унагаж, хэрэглэгчийн итгэлийг алдагдуулан борлуулалтанд сөргөөр нөлөөлж байв. Төрийн мэдлээс хувьд шилжиж, төрөл арилжсан юм шиг "өөрчлөгдсөн" мэт харагдавч бүх юм хуучин хэвээрээ, хуучнаасаа ч дордох шинж тэмдэг мэдрэгдэж эхлэв.

Зоригтой шинэчлэл, шийдвэртэй давшилт хэрэгтэй болохыг тухайн үеийн гүйцэтгэх захирал Г.Батхүү сайн ойлгож байлаа. 1924 онд Улаанбаатар хотод Зүүн Сэлбийн баруун хөвөөнд таван монгол, есөн орос ажилчинтай үйл ажиллагаа эхэлсэн 77 жилийн түүхтэй компанийн "насаараа" цуглуулж, хоцрогдлын амьд музей болсон техник технологио төмрийн хогонд ачуулав. Шинэчлэлийг маш сайн тооцоо судалгаанд үндэслэн явуулж эхлэв. Хуучин АПУ-гаас сайн, бас муу зүйлийг ч өвлөж авснаа мэдэхийн дээдээр мэдэж байсан болохоор энэ хооронд зааг тогтоож мууг нь буланд хаших бодлого барилаа.





Малынхаа сүү шимээс нэрмэл гаргаж хэрэглэдэг байсан талын монголчууд европ маягийн амьдралд аажмаар шилжиж этилийн спиртээр найруулсан хатуу архитай танилцсан түүх нь шинэ шатанд гарах цаг болжээ. Архины онц эрхийг эрхлэх газар аль 1930-аад онд Хятад, Хайлаар, Харбин, Манжуур, Жанчхүү, Бээжин, Хөх хот, Буут, Шэньди, Альшаам, Тэньжин зэрэг газраас бэлэн янчаанаар Мартин, Мартели шарз, Нэриетта ром дарс, Луй Редвр, Рояль палас оргилуун дарсыг худалдан авч тэмээн жингээр тээж авчирдаг байж. Тэвдсэн үедээ Зөвлөлтийн худалдааны төлөөлөгчийн тусламжтай нууцаар оруулж ирнэ. Гэхдээ архины онцгой эрхийг улс мэдэлдээ авсан монополь эрхтэй байсан учраас ч юм уу, Монополь гэдэг архи дотооддоо үйлдвэрлэсэн нь энэ төрлийн бүтээгдэхүүний нийтлэг нэр болохоо шахаж байв. Гэхдээ Хар архи, Ганзай зэрэг арваад нэр төрлийн архи үйлдвэрлэдэг байжээ. АПУ-гийн бүтээгдэхүүн Гитлерийн нацизмыг нухчин дарахад ч бас үүрэг гүйцэтгэжээ. Аугаа их эх орны дайны үед монголчууд улаан армид 11 удаа бэлгийн цуваа илгээж байсны дотор арван хоёр мянган литр цагаан архи багтсан байдаг. 1974 онтой золгож байж жинхэнэ хууль номын дагуу Боргио, Нийслэл шар айргийг газрын ойрыг бодсон уу, хэрэглэгчдийн "онцлог"-ийг сонгосон уу ЗХУ-ЫН Эрхүү хот болон БМ-ын дагуух хотуудад анх гаргаж байгаад экспортын архийг БНАГУ, БНБАУ, БНУАУ зэрэг тухайн үеийн социалист тогтолцоо бүхий орнууд болон Итали, Франц улсад экспортлож эхэлжээ.

Энэ нь Монгол архи нэр хүнд, бүрэн эрхтэйгээр хил давсан анхны тохиолдол байлаа.

Экс цагаан архи ингэж эх орны нэрийн хуудас болж чадав. Тус брэнд нь одоо орц найрлага талаасаа шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спирт, зургаан давхар шүүлтүүрээр шүүсэн гүний цэнгэг ус, уламжлалт шүүлтийн технологийг орчин үеийн дэвшилтэт нүүрсэн, элсэн, мембранан болон дөрвөн давхар мөнгөжүүлсэн шүүлтүүртэй хослуулан гаргаж авдаг зөөлөн амт бүхий цэвэр цагаан архи юм.

Монгол хүн сансарт нисэх дуулиан орон даяар битүүхэн цуурайтаж салбар бүхнийг хөдөлгөөнд оруулав. Түүхэн нислэгт зориулсан шинэ бүтээгдэхүүн гаргах ажил хүнсний салбарыг ч хамрахад Архи, Пивоны комбинат чацарганы найрлагатай Сансар ундааг боловсруулж ундааны шошгыг Герман улсад захиалан хийлгүүлж байв. Мөн Болор архины технологийг боловсруулж, шошгыг нь ардын зураач Ж.Гомбосүрэн зохиож байжээ. АПУ компани сайн уламжлалыг улам сайжруулдаг болохоор Болор архийг 2008 онд технологи, өнгө дизайны шинэчлэл хийж "Сонголтоо шинэчилцгээе" уриатайгаар худалдаанд дахин гаргаж уулын болор мэт тунгалаг, тансаг идээг хэрэглэгчиддээ хүргэж чадав.

ЗХУ-д өөрчлөн байгуулалт өрнөж, архины эсрэг хатуу бодлого явуулсан М.С.Горбачевын Кремль дэх найтаалт манайд ханиад болж тусчээ. Архины үйлдвэрлэлийг эрс бууруулснаар хомсдол ихээр бий болж дэлгүүр хоршоо архины дараалалд зогссон олны хөлд дарагдав. Архи авах гэснээс болж зодоон цохион гарах, гэмт хэрэг үйлдэгдэх энүүхэнд байлаа. Дайны хажуугаар дажин гэгчээр Архангай аймгийн намын дарга нь бүрхээр, жалавч хэмхчих кампанит ажил зохион байгуулж байсан нь Кремлийн найтаалт ужгирсан ханиад болж манайд ирдгийн тодхон жишээ юм.

Нэгэнтээ хуучирч хоцрогдсон технологио төмрийн хаягдалд тушаачихсан болохоор шинэ эзэд нь үйлдвэрээ зуун хувь шинэчлэхийн төлөө бүтэн хоёр жил зүтгэв. Ингээд Итали, Австри, Герман улсын дэлхийд тэргүүлэгч фирмүүдийн тоног төхөөрөмжийг иж бүрэн суурилуулснаар зөвхөн шар айраг гэхэд жилдээ хорин сая литрийг үйлдвэрлэх болжээ. Цайвар, хар гэсэн хоёр төрлөөр нийт зургаан нэр төрлийн шар айраг үйлдвэрлэдэг ба Алтанговь, Хар хорум, Боргио шар айргийг Япон, Солонгос улсад экспортолж байна. Бүхий л технологийг бусдаас түрүүлж нэвтрүүлдэг АПУ Нийслэл шар айргийг шинэ өнгө төрхтэйгээр үйлдвэрлэж, залуусыг болон өөрчлөлтийг дагуулагч Fusion шар айргаа ч гаргаж ирлээ. Шинэ техник технологи нэвтрүүлж, хуучин брэндүүдийн шил, шошго зэргийг өвөрмөц шийдэлтэй өөрчилж ирсний дүнд амжилтаа дэлхийд үнэлүүлж олон улсын шагналуудыг удаа дараа хүртэх болов. Энэ нь зөвхөн архины асуудал бус улс орны нэр хүндийн асуудал юм. Олон улсад үнэлэгдсэн чанартай брэнд үйлдвэрлэдэг, хэрэглэдэг ард түмнийг хэн ч хүндэтгэх нь ойлгомжтой шүү дээ. Зөвхөн технологийн өөрчлөлт шинэчлэлтээр зогссонгүй. Тоног төхөөрөмжийн гагнаас, холбоос, эрэг боолтноос эхлээд үйлдвэрийн барилга байгууламжийн шал, хана, таазны будаг, плита зэргийг нян хадгалдаггүй, зэвэрдэггүй, урвал явагддаггүй эд зүйлээр технологийн өндөр түвшинд хийсэн байна.

Ажилчдын нийгмийн асуудал хаягдчихсан байв. "Ажиллавал ажилла, үгүй бол баяртай" гэсэн төрийн төмөрлөг нүүр тэнд цухалздаг байсныг эелдэг харилцаагаар сольж ажилчдынхаа цалинг хоёр дахин нэмэв. Тус байгууллагад ажиллаж байсан үе үеийн ахмадууд, тэтгэвэртээ гарсан хүмүүсийг ч байгууллагынхаа ажилчдын адил харж үзэж, дэмжиж туслах боллоо. Мөн МУ-ын хоёрдахь Ерөнхийлөгч Нацагийн Багабанди ажил амьдралынхаа гарааг

тус үйлдвэрээс эхэлж хөргөлтийн инженерээр ажиллаж байжээ. АПУ зөвхөн өөрийнхөө ажилчдад анхаарал тавиад зогсохгүй нийгмийн хариуцлагаа ухамсарласан компани юм. Эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн салбарт түүний гар оролцоогүй хандив тусламжийн аян гэж бараг байхгүй.

Цаг хором бүхэнтэй уралдаж шинэчлэгдэж өөрчлөгдөх нь жинхэнэ брэнд үйлдвэрлэгчийн мөн чанар. Өнгөрсөн жил гэхэд Германы Шмидт фирмийн техник технологиор тоноглогдсон тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх чадалтай Натур Агро спиртийн үйлдвэрийг ашиглалтанд оруулав.

АПУ ингэж шинэчлэгдсэнээр зөвхөн АПУ-даа ашиг олсонгүй. Үндэсний хэмжээнд хамгийн их татвар төлж, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ сайн биелүүлж байна. Дотоодынхоо хэрэгцээг хангаад зогсохгүй бүтээгдэхүүнээ гадаадад экспортлож, улс орондоо их хэмжээний валют оруулж ирэх бололцоо байна гэдгийг АПУ компани харуулж чадсан. Австри, Герман, Италийн тоног төхөөрөмжөөр шинэчилсэн архины үйлдвэр нь одоогийн байдлаар Соёмбо, Чингис хаан, Болор, Алтан түрүү, Экспортын цагаан архи, Ерөөл зэрэг өөрийн гэсэн имиж, нэр хүнд, чанар, амьдлаг шинжтэй 10 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Тус компани 179 метрийн гүнээс гаргасан усыг бүтээгдэхүүндээ хэрэглэдэг нь эрсдэлтэй гэхээсээ элгэмсэг алхам хийдгийг нь харуулдаг. Байнга шинэ санаа дэвшүүлж, шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн төлөө ажиллах нь компанийн хөгжлийг тогтмолжуулах ганц арга юм. Энэ зарчмыг АПУ компани бусдаас илүү хатуу баримталдаг.

2005 онд АПУ ХК олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO90001 стандартыг нэвтрүүлсэн гэрчилгээг гардан авчээ. Мөн компанийн хэмжээнд Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн удирдлагын тогтолцоо ISO-14001 олон улсын стандартыг нэвтрүүлэх төслийн хүрээнд үйл ажиллагаагаа үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Түүнчлэн өөрийн борлуулалтын сүлжээгээр дамжуулан 21 аймаг, нийслэлийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ хүргэж байна. Ер нь тус компани нь зөвхөн, архи, пиво, ус, ундаа үйлдвэрлээд зогсохгүй үндэсний хэмжээний шингэн хүнсний үйлдвэр болох ирээдүйгээ бүтээн байгуулсаар байна.

Сүү, жүүсний үйлдвэр 2006 онд байгуулагдаж, үйл ажиллагаагаараа хэдийнээ хэрэглэгчдийн танил болжээ. Тус үйлдвэр нь 3.2 хувийн тослогтой Цэвэр сүү, 100 хувийн Фругта алим, Фругта жүрж, Фругта олон жимст жүүс зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Үүнээс гадна Тэрэлж, Сэлэнгэ ундаа нэр шигээ сайхан таашаалыг хэрэглэгчиддээ өгсөөр байна. Энэ компани хүнснийхээ чанарт илүү анхаардаг. Тиймээс бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавих хими, микро биологийн лаборатори, хүнсний хуурай уур үүсгэх бойлер, хөргөлтийн иж бүрэн системтэй. Сүүний үйлдвэрийн бүтээгдэхүүний боловсруулалт савлагаа нь битүүмжилсэн нөхцөлд хийгддэг учраас түүнд агуулагддаг тос, уураг, амин дэм, эрдэс бодисын агууламж нь үндсэн чанараараа хадгалагдан үлддэг онцлогтой.

АПУ компани олсон ашгаараа бусад салбарт хөрөнгө оруулалт хийж, Хүнсний манлай үйлдвэрээс Үндэсний аж үйлдвэрийн манлай болох зорилго өвөрлөж байгаа. Бодлого төлөвлөлт гэдэг бодит ажлын хагас нь юм гэдэг.

- "Хамтдаа бүтээсэн бүхэн давгагдашгүй билээ" гэсэн үгтэй дуу "Зүүд биш л байгаа даа" нэвтрүүлгийн тусч дүр зураг АПУ брэндийн нэрийн хуудас шиг харагддаг. Ерөөл брэндийн мөнгөн аяга, хадаг дэлгэсэн зочломтгой байдал нь ч одоо хэрнээ хуучраагүй, хэрэглэгчийнхээ бодол санааг эзэмдсэн хэвээрээ байна.

- Брэндийнхээ чанар, сав баглаанд илүүтэй анхаардаг. Лонх, сав, бөглөө зэрэг нь урлагийн бүтээл мэт өвөрмөц шийдэл, үр дүнтэй байдаг нь АПУ компанийн амжилтад багагүй нөлөө үзүүлдэг.

- Брэндүүдийнх нь нэрс бүгдээрээ л цэвэр монгол үг бөгөөд утга санаа нь ямар нэгэн шижмээр бүтээгдэхүүнийхээ чанар чансаа, зориулалт зэрэгтэй очиж холбогддог. Өөрөөр хэлбэл АПУ компанийн бүтээгдэхүүн ба зар сурталчилгааны хооронд ямар нэгэн ялгаа байхгүй болохыг нотолж чаджээ.

- Төрийн өмчит компани 100 хувь хувийн өмчид очсоноор дэлхийн тэргүүлэгч техник технологийн шинэчлэлийг үе шатай авч хэрэгжүүлж ирэв.

- Зөвхөн архи, пиво, ус ундааны үйлдвэрлэлээр үйл ажиллагаагаа хязгаарлахгүй жүүс, цэвэр сүүний үйлдвэрлэл явуулж байна. Хамгийн гол нь АПУ компани бүтээгдэхүүнээ Монгол орны төдийгүй гадаадын арав гаруй орны зах зээлд хүргэдэг найдвартай сүлжээг бий болгосон. Дотооддоо үндэсний үйлдвэрлэл хөгжин дэвшихийн бэлгэдэл болж 21 аймаг, 50 гаруй сум, нийслэл дэх худалдаа үйлчилгээний 2000 гаруй цэгээр дамжин хэрэглэгчидтэй харьцаж байна.

- Монгол улсын анхны этилийн спиртээр найруулж үйлдвэрлэсэн хатуу архи учраас энэ төрлийн бараа бүтээгдэхүүний домог нь болдог. Энэ олон жилийн нэр хүнд нь түүнийг олон хүнийг шууд итгэхэд хүргэдэг гэж болно. Наад зах нь аль 1927 онд Чех улсын мэргэжилтний оролцоотойгоор эх орондоо анх удаа шар айраг үйлдвэрлэсэн түүхийг уншаад хэрэглэгч, үйлчлүүлэгчид АПУ-гийн талаар ямар төсөөлөл төрөхийг мэдэж ядах юмгүй.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.apu.mn](http://www.apu.mn) Байгуулагдсан он: 1924 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар-36, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-14, АПУ ХК-ийн байр

Үйл ажиллагааны чиглэл: Архи спирт, шар айраг, ус, ундаа, жүүс, сүүний үйлдвэрлэл





## Түүх амтагдаж сэтгэл сэргээсэн брэнд

Сүүлийн үед хэрэглэгчид аль болох градус багатай, зөөлөн амт бүхий шар айргийг сонгох болжээ. Энэ нь монголчуудын бие махбодын онцлогтой холбоотой гарч ирсэн хэрэгцээ. Хэрэглэгчийнхээ эл хэрэгцээг Сэнгүр шар айраг л хангадаг. Иймээс Сэнгүр шар айраг ахар богино хугацаанд хүлээн зөвшөөрөгдөж, залуусын дуртай брэнд болжээ. Хэрэглэгчийнхээ хүсэл зоригийг харгалзаж үзэхгүй байна гэдэг брэндийн зан төрх биш. Энэ байдлаараа Сэнгүр бусад шар айрагнаас ялгардаг билээ. Жил жилийн хөлбөмбөгийн тэмцээний үеэр Сэнгүр шар айраг асар их борлогдсон байдаг нь ч энэ зан төрхтэй нь холбоотой биз.

Ер нь сүүлийн үед хэрэглэгчид гаднаас тээвэрлэгдэж ирдэг импортын шар айргийг төдийлөн ойшоохгүй болжээ. Энэ нь тэдгээрийн хадгалалт хамгаалалт, тээвэрлэгдэж ирсэн байдал зэргийг харгалзахын сацуу хэрэглэгчид эрүүл, цэвэр хүнсийг сонгож хэрэглэх болсонтой холбоотой юм. Импортыг орлогч үндэсний шилдэг бүтээгдэхүүн Сэнгүр брэнд олон улсын шилдэг шар айраг шалгаруулах тэмцээнээс хоёр ч удаа мөнгөн медаль хүртсэн амжилтын эзэн болжээ.

Уг шар айрагны тэмцээн нь 1993 онд удаа Австралийн Мельбурн хотноо задгай шар айраг, шилтэй шар айраг гэсэн хоёр төрлөөр зохиогдсон байна. Сэнгүр брэндийн хувьд энэхүү тэмцээнээс 10 гаруй насаар дүү юм. Урд гарсан чихнээс хойно ургасан эвэр гэдэг шиг хурд, дэвшил, шинэ технологиор тэр гүйцэж түрүүлж явна. Шар айргийн тэмцээн бүтэн жилийн турш болдог. Маш нарийн шалгуур, сонжууртай ажил ажээ.





2009 оны шалгаруулалт л гэхэд 2008 оны 11 сараас эхэлж, 2009 оны 03 сарын 19-нд эцсийн дүнгээ гаргасан байдаг. Уг тэмцээнд дөч гаруй улсын 1074 шар айраг оролцоход манай Сэнгүр мөнгөн медаль хүртэв. MCS APB ХХК-ийн Сэнгүр шар айраг шилтэй шар айргийн төрөлд Амт, Үнэр, Өнгө гэсэн гол үзүүлэлтээрээ шалгарав. 2010 оны тэмцээнд шилтэй шар айрагны төрөлд алтан медаль авах шар айраг тодроогүй гэж үзсэнээс Сэнгүр брэнд хоёр дахь мөнгөн медалиа хүртсэн түүх ийм ажээ. Сэнгүрийн дэлхийд өрсөлдөх бяд чадал, ааг омог нь юундаа байдаг вэ?

М-Си-Эс Азиа Пэсифик Брюэри ХХК-ийн үйлдвэрлэж буй энэхүү брэнд дэлхийн хамгийн сүүлийн үеийн компьютер удирдлагатай үйлдвэрт, орчин үеийн шилдэг технологи бүхий 250 шүүлтүүрийг давж гардаг. Нэг үгээр хэлбэл, уруул чимчигнүүлсэн амт, хамар цоргисон тансаг үнэр, цэвэр тунгалаг өнгөтэй болох "бэлтгэл сургуулилтаа" маш өндөр түвшинд хийдэг тамирчин шиг ингэж элдүүрээ ханган байж дэлхийн дэвжээн дээр эх орныхоо нэрийг гаргаж, их түүхийнхээ халуун дурсамжийг омог бардам хүүрнэдэг брэнд юм.

Сэнгүр горхины сэнгэнэсэн зөөлөн амт, 4.8 хувийн хатуулагтай Сэнгүр шар айраг "Импортыг орлох шинэ бүтээгдэхүүн"-ээр ч мөн тодорч байжээ. Сэнгүрийг байхад өөр улс орны шар айраг руу гараа сунгах байтугай харцаа тогтоож харах шаардлага бий гэж үү? Сэнгүр бол Азиа Пэсифик Брюэрс Лимитэд компанийн шинэ тутам брэнд. Энэхүү компани

нь MCS группын нэг салбар бөгөөд Сингапурын хөрөнгийн зах зээлд албан ёсны бүртгэлтэй, шар айргийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалттай. Жилдээ нэг тэрбум гаруй ам.долларын борлуулалт хийж, НАССР, ISO 90018, ISO 22000 зэрэг дэлхийн хэмжээний чанар болон хүнсний аюулгүйн стандартыг мөрдөн ажилладаг байна. Бас дэлхийн 70 гаруй орны хэрэглэгчдэд танил болсон Тайгер шар айргийг үйлдвэрлэхийн зэрэгцээ өөрийн нэрийн брэнд болох Сэнгүр, Жалам хар брэндээ дэлхийд таниулж амжив.

Сэнгүр шар айрагны нэр хаанаас гаралтай, юунаас үүсэлтэйг товчхон тайлбарлая. Дэлхийн нүүдэлчдийн дотор байтугай өөрсдийгөө үлэмж соёлжин, үндэс тасрахгүй болж иргэншсэн гэж үздэг суурин соёл иргэншилтэй хүмүүсийн дотор ч "Монголын нууц товчоо" шиг суут бүтээлийг үлдээсэн нь үгүй гэдэг. Тэнд Сэнгүр горхины тухай хэдэнтээ өгүүлсэн байдаг. Тэр болгонд Сэнгүр горхи, Чингис хаан хоёр салшгүй нэгэн учгаар холбогддог ажээ. Дөнгө зүүлгэсэн Тэмүжин тайчуудаас зугтаж Сэнгүр горхиндоо хүрснээр тарвага зурам агнаж идэн басхүү Боорчитой нөхөрлөн найман шаргаа олж Сэнгүр горхины орчимд байгаа гэртээ ирдэг. Мөн 1178 онд буюу 17 настайдаа дүү Бэлгүдэйн хамт мордож, сүй тавьсан охин Бөртэ Үжинг Сэнгүр горхины дэргэдэх гэртээ авчирдаг тухай өгүүлсэн байдаг.

Эндээс Тэмүжин хар булган дахыг авч Ван ханы зүг мордсоноор түүний бүтээсэн их түүхийн омголон морьдын туураинд гал очис цахиж эхэлсэн билээ. Хожим бас нэгэн тохиол болж Тэмүжин 1181 онд нүүдлийн замдаа Жамухаас салж Сэнгүр горхины эцэс Хар зүрхний Хөх нуурт очиж буусан хэмээдэг. Чингис хааны ундаалдаг байсан энэхүү сэнхийсэн сэрүүн, сэтгэл уужруулсан уулын горхины онцгой чанарыг нэрнээс нь эхэлж эрдэмтэн мэргэд тайлж, тайлбарласан байдаг. Сэнгүр горхиноос ундаалж өссөн Тэмүжин дэлхийн талыг байлдан дагуулсан үнэн түүх бий. Түүх давтагддаг гэж ярьдаг. Тэрхүү түүхт гол горхиных нь нэрээр нэрлэгдсэн Сэнгүр шар айраг их далайг гаталж Австралийн Мельбурн хотын шар айрагны тэмцээнд тэргүүлж байгаа нь ч бас сонирхолтой. Дэлхийг эзлэх эрч хүч эндээс эхэлдэг юм биш байгаа.

### **Амжилтын нууц**

- Их түүхийн улбаа болсон нутагт Эзэн Чингис хааны ундаалж өссөн сэнхийсэн сэрүүн Сэнгүр горхины нэрээр нэрлэгдсэнээрээ ялангуяа монголчуудын хамгийн ойр дотны, уух дуртай шар айраг болж чадсан.
- Олон улсын шар айрагны тэмцээнээс хоёр удаа мөнгөн медаль хүртэж, амт чанар, өнгө үзэмж, үнэрийн дээдийг таниулж чадсан.
- "Монголын нууц товчоо"-нд Сэнгүр горхи нь таван удаа Чингис хааны амьдралын онцгой үе, бэрхшээлийг давсан эрч хүчтэй холбогддог нь монгол хүний эрч хүчийг сэлбэх, амжилтад хүрэх урам зоригийг хайрлагч болж харагддаг.
- Дэлхийн хамгийн сүүлийн үеийн технологиор 250 удаа шүүлтүүрт орж байж үйлдвэрлэгддэг импортыг орлох хэмжээний бүтээгдэхүүн болж чадсан.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.mcs.mn](http://www.mcs.mn) Байгуулагдсан он: 2006 он

Компанийн хаяг: М-Си-Эс Азиа Пасифик Брюэри ХХК, Гачууртын зам 102, Амгалан-1, БЗД, Улаанбаатар хот, Монгол улс.

Үйл ажиллагааны чиглэл: Шар айрагны үйлдвэрлэл



## Дэлхийд танигдсан монгол брэнд

Цаг үе бүхэн хүний өмнө, тэр бүү хэл бүхэл бүтэн улс орон, нийгмийн өмнө сонголт хийх хувилбаруудыг гаргаж тавьдаг. Япон улс манайд дайны төлбөрт 17 сая доллар (тухайн үеийн ханшаар) төлөх болжээ. Энэ нь 1972-1977 онд Монгол, Японы Засгийн газруудын хоорондох олон удаагийн уулзалт ярилцлага, ноот бичиг солилцооны үр дүнд социалист, капиталист нийгмийн сөргөлдөөнийг боломжийн байдлаар дуусгасан үйл явдал байлаа.

Нөгөө 17 сая доллараа яаж зарцуулах талаар хоёр янзын санал Засгийн газар дээр орж иржээ. Нэг нь Монголын малчин өрх бүрт 2-3 дээлийн торго, 18 аймаг, түүний сумдад хэрэглэж байгаа суудлын Газ-69 машинд 2-3 жил хэрэглэх резин дугуй авах санал байв. Нөгөөх нь ноолуурын том үйлдвэр барих тухай ХХҮЯ-ны санал байсан аж. Тухайн үеийн салбар хариуцсан яамны сайд П.Дамдины хичээл зүтгэлээр 1981 оны 9-р сарын 5-ны өдөр Говь комбинат албан ёсоор үүд хаалгаа нээжээ. Албан ёсоор гэсний учир нь тус үйлдвэр аль 1976 оны 6-р сарын 28-нд анхны туршилтын бүтээгдэхүүнээ гаргаж байв. Говь комбинат улс орондоо олон бахархах зүйлсийг дагуулж ирэв.

Манай улс тэр үед жилдээ 1200-1300 тн ноолуур бэлтгэж, ЗХУ болон ЭЗХТЗ-ийн орнуудад ердөө 8-9 сая рублиэр худалддаг байжээ. Гэтэл Говь комбинат туршилтын үедээ буюу 1980 оны байдлаар 60 шахам сая доллар, 24 сая рублийн бүтээгдэхүүн борлуулжээ.

Ер нь Говь эхнээсээ улс орны хөгжлийн чиг хандлагад эргэлт хийх цаг болсныг толь мэт харуулагч нь байлаа. Японы Иточу пүүстэй 1978 оны 5-р сард байгуулсан МН-78-01 тоот гэрээний дагуу ноолуурын үйлдвэрийн барилгыг гурван жилийн хугацаанд багтаан барихаар хэлэлцэн тохирч барилга угсралтын нарийн хуваарь гарган түүнийг хатуу мөрдөж ажиллах үүргийг хоёр тал авсан гэдэг. Барилгын ажил эхлээд зургаан сар болж байхад Японы талаас "Та нар иймэрхүү байдлаар ажиллаад байвал гурван жил байтугай, зургаан жил ч ажиллаад барахгүй. Хэрэв гурван жилээс хэтэрвэл Японы тал хөрөнгө хүч гаргаж чадахгүй, танайх өөрийн зардлаар хариуцах болно" гэсэн шаардлага тавьжээ. Капитализмын хатуу чанга араншинг үзэл суртлаас л "мэдэх" төдийхөн, үйл хэрэг дээр хүлээж авах ямар ч хөрсгүй байсан Монголын тал ихэд сандарчээ. Дээр дооргүй л хөдөлж, ажилчид өвлийн 25-30 хэмийн хүйтэнд ил задгай, хөлдүү газар өглөөний есөн цагаас шөнийн 1-2 цаг хүртэл ажиллаж байв. Ингэж ажилчин ангийн хөдөлмөрийг мөлжигч капитализмынхаа туршлагаар ажиллаж барилгыг хугацаанд нь дуусгажээ. Туршилтын үйлдвэрт ирээдүйн Говь комбинатын ажилчид япон багш нараасаа самнах, сүлжих, хялгас ялгах, будах, оёх технологид суралцаж байлаа.

Говь комбинат 1984-1985 онд үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг бүрэн ашиглаж эхэлжээ. Үүнээс хойш төлөвлөгөөт болон зах зээлийн эдийн засгийн үед үүргээ биелүүлсээр

ирэв. Гуч шахам жилийн өмнө сонгож оноосон Говь гэдэг нэр оновчтой болсон нь одоо ч нотлогддог. Gobi гэж латин үсгээр бичсэн Монголын нэр, шошготой бүтээгдэхүүн өөрийн эх оронд төдийгүй хилийн чанадад алдаршсаар байна. Энэ нь өчнөөн бэрхшээлийг давсан Говийн үе үеийн удирдлагуудын сүйхээ, ажилчдын хөдөлмөр зүтгэлтэй салшгүй холбоотой билээ. Тус үйлдвэр хүссэнээрээ ажиллаж, сэтгэж бүтээж, ашиг орлогоо нэмэгдүүлж болдоггүй тийм хэцүүхэн арваад жилийг ардаа орхив. Гэхдээ ноолуураа түүхийгээр нь гаргаад явуулчихсанаас хамаагүй дээр. Өмнө нь Монгол улс ноос, ноолуураа анхан шатны боловсруулалт хийсэн болж, түүхийгээр нь ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад рублиэр худалдаж, тэд цааш нь доллараар зардаг байлаа. Социализм дамын наймааг үздэггүй байсан ч Монголын ноолуур дээр бусад соц орнууд дамчин болдог байсан гэсэн үг л дээ.

1990-ээд оноос зах зээлд шилжсэнээр "Хэн чанар сайтай, өртөг багатай, хямд бүтээгдэхүүн хийж чадна тэр үйлдвэрлэгч амжилт олдог жамтай" гэсэн зарчмаар ажиллаж эхлэв. Говийн түүх бол Монгол улс зах зээлд шилжсэн түүхийн хамгийн цэвэрхэн хэсэг нь гэж болно. Олон улсын үзэсгэлэн яармагт тогтмол оролцдог болжээ. Бүтээгдэхүүнийг нь сонирхон таашаадаг түншүүд аажмаар бий болж эхлэв. Японы арваад пүүстэй холбоо тогтоож, тус оронд худалдаа эрхлэх хамтарсан Алтай компанийг байгууллаа. Мөн 50-100 мянган ам.доллар зарцуулж Америкт Gobi USA, Бельгид Gobi Europe пүүсийг байгуулснаар 1990 он гэхэд Европт гаргадаг бүтээгдэхүүний 70 шахам хувийг түншүүд нь өөрсдийн пүүсээр дамжуулан борлуулдаг болсон байдаг. Говийн танилууд, найз нөхөд, хамтран ажиллагсад олон улсад нэмэгдсээр байлаа.

Хамгийн сайн түүхий эдээр хамгийн сайхан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх нь ямар ч үйлдвэрлэлийн зорилго. Үүнд чанартай түүхий эд, орчин үеийн техник хангалттай биш. Бүтээгдэхүүний чанар, хийц загвар, өнгө үзэмж зэргийг зөв хослон нийцүүлэхэд хүний оюун ухаан, авьяас чадвар "ус шиг" хэрэгтэй. Ингэж байж л ноолуураа "дойлуур" болгоно.

1990-ээд оны дундуур Францын нэрт загвар зохион бүтээгч Пьер Карден Говь компанийн Загвар зохион бүтээх төвөөс эхлэн үйлдвэрийн бүх дамжпагаар орж танилцаад, дэлгүүрээс нь 1200 ширхэг бүтээгдэхүүн захиалж байв. Энэ нь ямар ч загварын шоунаас илүү сурталчилгаа болсон юм. Говь зах зээлийн шуурганд гудайлгүй тэсч үлдэж чадсан нь "Давшингуй", "Чөлөөт" хоёрын ач гэж болно. "Давшингуй" нь өөрийн гараар хийсэн бүтээгдэхүүнээ өөрсдөө "сууж хүлээх бус, явж гүйцэх" зорилгоор шинэ шинэ худалдан авагчдыг эрж хайж, уйгагүй хөөцөлдөн олох бодлого. "Чөлөөт" нь ганц хоёр худалдан авагчид "онцгой эрх, дарх" эдлүүлж түүний юу хэлж, хэзээ яахыг харж суулгүй, зах зээлийн өргөн боломжийг чөлөөтэй ашиглаж олон худалдан авагчтай болох гэсэн ойлголт.

Говийнхон энэ зорилгодоо хүрчээ. 1996 оноос эхлэн ашиг хуримтлалдаа тулгуурлан хүчин чадлыг нь нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрийн өргөтгөл хийв. Ингэснээр бэлэн бүтээгдэхүүний борлуулалтыг өсгөх замаар ээрмэлийн хоёр үйлдвэр байгуулж 28-60 номерийн утас буюу даавуу үйлдвэрлэх болжээ.

Энэ дэвшил нь энгийнээр ойлгуулбал монгол хүн ноолууран дээл өмсөх боломжтой болсон гэсэн үг л дээ. Мөн тухайн үеийнхээ технологийн түвшинд шинэчилсэн тоног төхөөрөмж ашиглан нарийн ээрэхийн системд оруулах ажлыг хэрэгжүүлэв. Энэ хоёр системд суурилсан нэхмэл эдлэл, даавуу цэмбэ, өргөн хөнжил нэхэх технологийг нэвтрүүлжээ. Өөрөө

өөртөө хөрөнгө оруулалт хийж Говь2 дагуул үйлдвэртэй болж чадлаа.

Энэ нь ямар ч цагт Говь голыг нь алдахгүй байж чадсаныг харуулдаг. Шинэ зуун, шинэ мянганаар овоглосон хөгжил дэвшлийн хурдтай цаг үе ирлээ. Төр, засаг бизнес хийх нь утгагүй, шаардлагагүй болжээ. Татвараа л авах нь "Таны эрх" гэмээр. Тус компанийн нийт хувьцааны 70 гаруй хувь нь төрийн мэдэлд байсан 2007 онд тус компани 700 сая төгрөгийн алдагдалд хүрсэн байв. Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар Эф Си Ай ХХК тус үйлдвэрийг хувьчилж авлаа. Компанийн засаглал нээлттэй болж, шинэ менежментээр ажилласнаар гурван жилийн хугацаанд багагүй ажил амжуулжээ. Японы Shi ma Seiki компаниас сүлжмэлийн 60 машин нэмж авснаар нийт 122 машинаар жилд хагас сая гаруй бүтээгдэхүүн хийж үйлдвэрлэлээ нэг дахин нэмэгдүүлэв.

Шинэчлэл үргэлжилсээр. Нэхмэлийн үйлдвэрээ Герман, Швейцарийн машинаар тоноглож, жилд 275 мянган метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай болгосон байна. Мөн хамгийн сүүлийн үеийн принт технологийг нэвтрүүлж, "Бусдаас дэгжин ноолуур" уриатай Принт загварын коллекци худалдаанд гаргаж, хэрэглэгчдээс өндөр үнэлгээ аваад байна.

Итали, австрали, орос, болгар, герман, америк, солонгос хэрэглэгчид Говийн бүтээгдэхүүнд дасах хандлагатай болжээ.

Тэд дэлхийн жишгээр жил бүр хоёр удаа коллеци гаргаж байгаа бөгөөд 2011 онд загварын ертөнцийн топуудын нэг, Италийн дизайнер Саверио Палателлитай хамтран ажиллаж байна. Үүний сацуу технологийн шинэчлэл, боловсон хүчний сургалт, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нийтдээ 17.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн аж.

Алдагдалтай байсан үйлдвэр ашигтай ажиллах болов. Хувьчлагдсанаас жилийн дараа буюу 2008 онд 689 сая төгрөгийн ашигтай ажилласан бол 2009 онд 20.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 1.5 тэрбум төгрөгийн ашиг олжээ. Харин 2010 онд 28.8 тэрбумын борлуулалт хийж, ашгаа хоёр дахин их буюу 3.8 тэрбум төгрөг болгов. Эдүгээ манай улсад ноос, ноолуурын анхан шатны боловсруулалт хийдэг 29, сүлжмэлийн 18, утас ээрдэг 30 үйлдвэр, үүнээс гадна 200 орчим хоршоолол бий. Урд хөршийн үйлдвэрүүд ч орж ирээд техникээ суурилуулчихсан байгаа.

Ноос, ноолуурын үйлдвэрүүдийн гол бэрхшээл нь түүхий эдийн хомсдол юм. Цаг цагийн салхинд гучин жилийн туршид ганхаагүй Говь ХК-ийн өмнө ч энэ бэрхшээл байна. 20 сая ямаатай байсан Монгол улсын үйлдвэрүүд ноолуургүйн зовлонг үздэг нь сонирхолтой. Нийт ноолуурын 20 хувийг л дотооддоо боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгож гаргадаг байна. Харин үлдсэн 80 хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн нэрээр ямар ч татваргүйгээр урд хөрш рүү ачигдаж Made in China шошготой бүтээгдэхүүн болж бусад орны хэрэглэгчдэд хүрдэг аж. Төгрөгөөр аваад доллараар зардаг нь ЭЗХТЗ-ийн үеийг санагдуулдаг. Хятадууд зүгээр ч нэг импортлоод авдаггүй, бодлоготойгоор муу чанарын ноолуураа гарал үүслийг үл харгалзан "Монгол ноолуур" гэж зах зээлд гаргадаг болоод уджээ.

Энэ нь бүтээгдэхүүний чанар болоод бизнесийн нэр хүндэд халдсан хэрэг юм. Ингэж



нэмүү өртөг нь ч, нэр хүнд нь ч Хятадад шилжсэн монгол ноолуурын хувь тавиланг нааш эргүүлэх шаардлага байна. Үүнд төр, засгийн бодлого хэрэгтэй. Монгол улс дотооддоо ноолуураа боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгон гаргавал 500 тэрбум төгрөг олно. Түүхийгээр нь гаргаад үүнээс хоёр дахин багыг олж байгаа юм. Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн түүчээ болсон Говь ХК өдгөө гадаадын 30 оронд 150 гаруй гэрээт борлуулагчтай.

Одоо дотооддоо 14, Токио, Софи, Москва зэрэг том хотуудад 26 дэлгүүрээрээ борлуулалт хийдэг. 2011-2012 онд гадаад улс оронд нэрийн бүтээгдэхүүний 100 дэлгүүртэй болох зорилт тавиад байна.

2011 онд бүтээмж өндөртэй боловсронгуй тоног төхөөрөмж авч, хөрөнгө оруулалт хийснээр борлуулалтаа 50 тэрбум төгрөгт хүргэх юм. 100 хувийн цэвэр, нарийн ноолууран утсаар хөнгөн, дулаан, загварлаг бүтээгдэхүүнээрээ хэрэглэгчдийнхээ таашаалыг улам татсаар байгаа тус компани ирэх 4-5 жилдээ нэг сая ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулалтаа 100 тэрбум төгрөгт хүргэх стратегитэй. Тус үйлдвэрт Монголын 1000 эмэгтэй ажиллаж 1000 гэр бүл, айл өрхийн амьдралын баталгаа болж байна. Амьдралын төлөө л ийнхүү зүтгэдэг эмэгтэйчүүдийг ажилтай байлгаж буй учраас Говь буянтай. Үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлснээр энэ оноос 300 ажлын байр шинээр нэмэгдүүлэх боломж бүрдэх юм. Gobi-ийн илч дулааныг дэлхий ертөнц өмсч мэдэрсээр л байна. Дэлхийд танигдаад зогсохгүй дэлхийг байлдан дагуулагч монгол брэнд бол Gobi.

### **Амжилтын нууц**

- Хаалттай нийгмийн үед Говь комбинатыг байгуулах ХХҮЯ-ны санал "ялж" үндэсний ноос, ноолуурын анхны үйлдвэр бий болсон нь өөрөө амжилт байлаа. Тэгээгүй бол 2-3 жилийн дараа дээл нь гандаж сэмрээд, машиных нь дугуй элэгдэж хагарсан Монгол орон ийм үйлдвэргүй үлдэх байв.

- Анхнаасаа л дэлхийн шилдэг технологи болох Японы техник, тоног өхөөрөмжөөр тоноглогдож, ажилчид мэргэжилтнүүдээ тухайн оронд суралцуулж, үйлдвэр дээр нь япон багш нарыг дагалдуулсан нь Монголын хөнгөн үйлдвэрийн салбарт цоо шинэ үзэгдэл болов. "Ноолуур бол цагаан алт" гэж тухайн үйлдвэрийн түүхий эдийг үнэлж байв. Хамгийн гол нь энэ бүхэн ноолуурыг алт болгох увидас шид нь Говь гэдгийг цаагуураа сурталчилж байсан хэрэг.

- 1996 оноос үйлдвэрийн хоёр дахь шинэчлэл хийгдэж ноолууран даавуу үйлдвэрлэх технологи нэвтрүүлснээр бүтээгдэхүүнээ өргөн олонд хүргэх бодлого баримталжээ.

- Төрийн мэдэлд байсан 70 хувийг хувьчилж тус компани 100 хувь хувийн өмч болсноор техник, технологи, удирдлага менежментийн арга барил шинэчлэгдэж, олон улсад бараа бүтээгдэхүүнээ хүргэх боломж гарцуудыг нээж байна.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.gobi.mn](http://www.gobi.mn) Байгуулагдсан он: 1981 он

Компанийн хаяг: Хан-Уул дүүрэг 3-р хороо, Говь компанийн байр, Улаанбаатар-17062,  
Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл




## **Монгол ноолуураар дэлхийг гоёсон брэнд**

Бид чихрийн нишинг, цагаан будаа тариалдаггүйтэй адил цаас үйлдвэрлэдэггүй, торго нэхдэггүй... Гэхдээ тэдгээрээс дутахгүй тансаг нандин эдийг монголчууд ХХ зууны хоёрдугаар хагасаас үйлдвэрлэж, дэлхийн зах зээлд нийлүүлж эхэлсэн нь ноолуур юм.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай Монгол орны хөрс шороо, цаг агаарт кофений ургамал идээшүүлж, гадил жимс тариалах боломжгүй ч монгол ямааных шиг гайхамшигтай ноолуур бүхий ямаан сүргийг өөр бүс нутгийн хаанаас ч хайгаад олохгүй. Үүний учир Төв Азийн өндөрлөгт орших Монгол орны байгаль, цаг уур монгол ямааны ноолуурыг тийм гайхалтай шинж чанартай болгосных билээ. Энгийнээр хэлбэл, ноолуурын ширхэг нарийн, урт байх нь сайн чанарыг илтгэдэг бол монгол ямааны ноолуур дэлхийд хамгийн нарийн ширхэгтэйд тооцогддог байна. Тэгвэл монгол ямааны ноолуурыг түүхий эдээс бүтээгдэхүүн болгож, малчны хотноос дэлхийн загварын тайз хүртэлх гайхамшигийг бүтээж буй хүмүүс бол үндэсний үйлдвэрлэгчид. Улс орон чөлөөт эдийн засаг, зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойшхи он жилүүдэд үндэсний үйлдвэрлэгчдийн хөл дээр нь босгож буй олон салбарт дэлхийн тэргүүлэх техник, технологи нэвтэрч, тэр хэрээр бид дэлхийн жишигт ойртох болжээ. Үүнийг бид Монголын ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүний хөгжлөөр жишээлэн хэмжих бүрэн боломжтой.

Дэлхийд монгол ямааны ноолуур чанараараа тэргүүлдэг ч ноолуур боловсруулах, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн хувьд Итали, Япон, Америк, Их Британи зэрэг суурин иргэншлийн хөгжлөөр нүүдэлчдээс хавьгүй урд алхаж яваа хүчирхэг эдийн засагтай орнууд ноолуур боловсруулалтын салбарт бидний өрсөлдөгчид гээд бодохоор олон улсын зах зээлд нэгэнт танигдсан монгол ноолуурын үнэ цэнэ, монгол брэндийн нэр хүнд илүүтэй тодорч харагддаг. Тэр дундаа дэлхийн ноос, ноолууран бүтээгдэхүүний зах зээлд монгол ноолуурын ид шидийг хувцас загварын үйлдвэрлэлтэй хослуулан амжилтад хүрээд буй Гоёо брэндийн чансаа, бүтээгдэхүүний чанар эдүгээ Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар дэлхийн төвшинд явааг бүрэн илэрхийлж чадах болсон. Товчхондоо бол, дэлхийн зах зээлд өрсөлдөж буй Монголын ноолууран бүтээгдэхүүний нүүр царайг "Гоёо" тодорхойлдог болсноор багагүй хугацааг үджээ. Энэ үгийг зүгээр нэг тэмдэглэсэнгүй тэдний хийж бүтээсэн ажил, гавьяа шагнал, дэлхийн бусад улс оронд монгол брэнд гэсэн нэр хүндийг бий болгосноор нь ийнхүү үнэлж буй хэрэг. Учир нь Гоёо брэнд нь техник, технологийн шинэчлэл хийхийн хирээр сүлжмэл эдлэлийн загварыг улам баяжуулан хэрэглэгчдийн хүсэл таашаалд нийцүүлэхийн зэрэгцээ хувцас загварын чиг хандлагыг ч тодорхойлох болсон байна.



CASHMERE FASHION COMPANY

[www.goyo-cashmere.com](http://www.goyo-cashmere.com)



Дотоодын төдийгүй гадаад зах зээлд үйлдвэрлэгч гэх нэрийг халж брэнд бүтээсэн гэж мэргэжилтнүүдэд үнэлэгдэж буй Гоёо брэндийн түүхээс сөхвөл, 1993 онд Монголын Засгийн газар, АНУ-ын Амикал Индастри компанийн хамтын үйл ажиллагааны хүрээнд Монгол Амикал ХХК байгуулагдсан нь Гоёо брэндийн үндэс болсон бөгөөд 2005 оноос МСиЭс группын харъяанд шилжсэнээр Гоёо брэндийн өсөн дэвшихийн эхлэл тавигджээ.

Савангийн хөөс шиг нимгэн, хөнгөн сэвсгэр ноолуурыг дизайнер, зохион бүтээгч зэрэг уран бүтээлчдийн ургуулан сэдсэн 1000 гаруй өнгөөр будаж, дараа нь түүгээр мяндас зөөлөн утас ээрч утсаараа ганган, чамин хувцас, эдлэл сүлжин дэлхийг гоёсон монгол брэндийн ноолууран хувцас, эдлэлийг өдгөө Гоёочууд мянга, мянган хэрэглэгчдийнхээ өдөр тутмын хэрэглээнд зориулан үйлдвэрлэж байна.

Монгол ямааны ноолуурын өөрийн чанар гайхалтай байж чаддагийн хирээр ноолуураар сүлжсэн хувцас, эдлэл дэлхийн хэрэглэгчдэд таалагдах хийц загвартай байх нь олон улсын өрсөлдөөнд ялах нэг үндэс гэдгийг Гоёо брэнд олж харж чадсан нь тэдний амжилтын эхлэл болсон юм. Бүтээгдэхүүн бүрээ хэрэглэгчдийнхээ тав тух, тайван амьдрал, хүсэл шаардлагад нийцүүлэхийг эрмэлзэж ноолуурын халуунд дулаан тэнцвэржүүлэх амьд чанартайг ашиглан зуны хувцасны загварт оруулж ирснээр Гоёо брэнд ноолууран хувцсанд хувьсал хийсэн билээ. Гоёо брэнд хүүхдийн хувцасны зах зээлд орон зай буйг гярхай

ажиглаж, хүүхдийн арьсанд хөнгөн, зөөлөн мэдрэгдэх, 100 хувь байгалийн түүхий эдээр хийсэн хүүхдэд ээлтэй брэнд бүтээсэн нь Cashmere KIDS хүүхдийн ноолууран хувцасны брэнд юм. Брэнд өөртөө брэндийг багтаана гэдэг тухайн брэндийг хир өргөн цар хүрээтэй, хүчирхэг болохыг харуулдаг билээ.

Ноолуур бол "амьд" түүхий эд. Түүнийг зөв арга, зөв технологиор боловсруулж. Эцсийн бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн гоо зүйн болоод эрүүл ахуйн хэрэгцээнд нийцсэн байх нь Гоёо брэндийн нэр хүнд, чанар юм. Гоёочууд компанийн үнэт хөрөнгө болсон хүний хөгжилд гол анхаарлаа хандуулж, ажилтан, ажиллагсдынхаа мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэх үүднээс ноос, ноолуурын үйлдвэрлэлийн уламжлалт төвүүд болох Итали, Герман, Японоос мэргэжилтнүүд урьж хамтран ажиллаж, туршлага солилцдог. Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, чанарыг эрхэмлэн дэлхийн загварын чиг хандлагыг тодорхойлсон, ноос ноолуурын зах зээлд Монголыг төлөөлөх нэр хүндтэй олон улсын брэнд болох нь Гоёо брэндийн хэтийн зорилго аж. Зах зээлийн өрсөлдөөнд хэн хамгийн ухаантай хөдөлж, хэн хамгийн ихийг хийж, шинийг сэдэн брэнд бүтээж буй нь ялдаг жамтай. Өөрөөр хэлбэл брэнд бүтээсэн бизнес амжилттай бас урт настай байдаг.

Мөн "Гоёо" нэрийн брэнд хэрэглэгчдийнхээ олон талт хэрэгцээ, харилцан адилгүй хүсэл, сонирхол бүрт нийцүүлэн бүтээгдэхүүнээ гаргах зорилгоор Монголын загварын ертөнцөд нэгэн шинэ хуудас нээсэн нь хэв маяг, донж имиджээрээ бусдаас ялгарах дуучид, урлагийнхантай хамтарсан оддын нэрийн коллекцийг зах зээлд гаргасан явдал байлаа. Гоёо брэндийн эхний сонголт нь Монголын шилдэг R&B дуучин Д. Болд байсан нь нүдээ олсон сонголт байсан хэмээн олон нийт онцолдог.

Ноолуурын салбарт загварыг тодорхойлж, монгол ноолуураар дэлхийг гоёсон Гоёо брэнд өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэлдээ зориулсан хөрөнгө оруулалт технологийн шинэчлэлийн үр дүнг бүтээгдэхүүнийхээ чанараар илэрхийлж буй бөгөөд дэлхийн ISO 9001 стандартыг ноолуурын үйлдвэрлэлдээ нэвтрүүлж салбартаа ISO 9001:2010 батламжийг хүртжээ.

Байгалийн шижир түүхий эдээр бүтээгдэж буй Гоёо брэнд өдгөө Европ, Хойд Америк, Азийн 30 гаруй оронд худалдаалагдаж байна.

### **Амжилтын нууц**

- Хүүхдийн хувцасны зах зээл дээр орон зай буйг гярхай ажиглаж Cashmere KIDS брэнд гаргасан нь Монголд төдийгүй Ази тивд үнэлэгдэв
- Үйлдвэрлэлийн шилдэг технологиос гадна загварын "байлдан дагуулалтыг" өдөр тутам явуулж буй явдал орчин цагийн хэрэглэгчдийн таашаалыг хүртэх болов.
- Монголд төдийгүй олон улсад шилдэг технологи болон өнгө үзэмж, орчин үеийн загвар бүхий бүтээгдэхүүнээ экспортлож гадаадын хэрэглэгчдийг өөртөө татах бодлогыг ухаалгаар хэрэгжүүлж байна.

**Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.goyo-cashmere.com](http://www.goyo-cashmere.com) Байгуулагдсан он: 1993 он

Компанийн хаяг: Гоёо ХХК, УБ-36, Хан-Уул дүүрэг, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Ноос, ноолууран бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл



## МОНХИЙН ҮСЭГ ГРУПП

Хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ



*Бид ЭНГИЙГ удирдана*



### Үндсэн үйл ажиллагаа:

- Офсет хэвлэл
- Торгон хэвлэл
- Хатуу хавтас үйлдвэрлэл
- Үнэг цаас үйлдвэрлэл
- Хайрцаг сав, баглаа боодол үйлдвэрлэл
- Хаяг, шошго үйлдвэрлэл
- Түргэн хэвлэл



**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дунд, 3-р хороо,  
Төвдөррийн гудамж, Нарны зам

**Утас:** 976-11-320450  
976-11-379008  
**Факс:** 976-11-320376

**E-mail:** info@munkhin-usag.mn  
**Web:** www.munkhin-usag.mn





The infographic is a grid of 18 cells, each representing a different brand or service. The top row includes 'Munkhin Usag' (with a photo of a person working at a desk), 'Хэвлэлийн цахь, компьютерийн үйлчилгээний төв' (with a photo of a computer monitor), and 'Бид Хэвлэлийн цахь, компьютерийн үйлчилгээний төв, цахь, компьютерийн үйлчилгээний төв' (with a photo of a person working at a desk). The second row includes 'Мөнх сүлжээ' (with a photo of a person working at a desk), 'Болор судар' (with a photo of a person reading a book), and 'Урсгал' (with a photo of a person working at a desk). The third row includes 'VEM' (with a photo of three people in business suits), 'Эко Пак' (with a photo of a person working at a desk), and 'Эко Пак' (with a photo of a person working at a desk). The bottom row includes 'Эко Пак' (with a photo of a person working at a desk), 'Эко Пак' (with a photo of a person working at a desk), and 'Эко Пак' (with a photo of a person working at a desk).

 **МӨНХИЙН ҮСЭГ ГРУПП**

**Хэвлэлийн салбарын манлайлагч брэнд**

Хүн амьдралдаа гурван сайн үйлийг гүйцэлдүүлсэн байх ёстой гэдэг. Энэ нь үр удмаа үлдээх, мод тарих, ном бүтээх явдал. Тэгвэл энэ гурвыг зэрэг шахам гүйцэлдүүлсэн хүний нэг бол яах аргагүй Мөнхийн үсэг группыг үүсгэн байгуулагч Г.Батмөнх агсан юм. Тэрбээр ном бүтээх хамгийн буянтай гэмээр амаргүй энэ ажлыг нэг л өдөр барьж авч эхлүүлсэн бөгөөд өдгөө түүний үр хүүхэд нь эцгийнхээ зааж чиглүүлсэн замаар урам зоригтой алхаж яваа билээ. Өдгөө Мөнхийн үсэг, Аз хур, Болор судар хэвлэлийн газар, Ви Эс Эм, Эко Пак Монгол зэрэг салбар компаниуд төрөн гарсан байна. Мөн тэртээ 1996 онд Улаанбаатар хотноо хэвлэлийн салбар компаниа байгуулж асан үеэ бодвол эдүгээ Монголын хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт техник, технологийн шинэчлэл, хүчин чадал, дадлага туршлага, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ тэргүүлэгч болтлоо хөгжжээ.

Мөнхийн үсэг группын үүссэн түүх гайхалтай, тэмүүлэлтэй гэж болно. Учир нь Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн эдийн засагч Г.Батмөнх гэх шавилхан залуу ном хэвлэх замыг сонгож хувийн хоршоо байгуулан Хөтөл хотхонд Сэргэлэн нэртэй пүүс нээлээ. Ном,

бичгийн маягт энэ тэрхэн хэвлэнэ. Ингэхийн тулд тугалган үсэг өрнө. Мөн үүнийгээ хуудас цаасан дээр барладаг ганц машин, мөн ганц ажилчинтай. Үндсэн хөрөнгө нь ердөө 14 мянган төгрөг байв. Энэ мөнгө бол "Өрхийн төсөв" гэсэн авсаархан ном бичиж хэвлүүлээд олсон ашиг нь байв. Харин хар багын шүлэг, яруу найрагт дуртай, мөн зураг зурахын зэрэгцээ ном, сонин, сэтгүүл, төрөл бүрийн ил захидал, баярын бичиг, урилга, үзвэрийн тасалбар зэргийг цуглуулдаг байсан нь үйлдвэрлэл эрхлэхэд нь нэг ёсны бэлээхэн загвар болжээ.

Ийм байдлаар галаа асаасан айлын амьдрал өдгөө хорь дахь жилдээ бадарч байна. Анх хоёрхон хүнтэй гал голомтоо асааж асан бол эдүгээ 350 гаруй ажилтан, албан хаагчтай, хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээс гадна ном, хэвлэмэл бүтээгдэхүүний худалдаа, хэвлэн нийтлэлийн газар, хайрцаг, сав баглаа боодлын үйлдвэрлэл, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа өргөтгөн Монголын Шилдэг Аж Ахуйн нэгжийн нэг болжээ.

Мөнхийн үсэг групп 2003, 2009, 2010 онуудад ТОП-100 аж ахуйн нэгжийн нэг, 2000,2001,2004,2008 онуудад шилдэг арван аж ахуйн нэгжийн нэгээр шалгарч байсан төдийгүй брэндүүд нь шилдэг бэлэг дурсгалын зүйлс, Үлэмжийн чанар Монголын үндэсний шилдэг 99 бүтээгдэхүүний нэгээр тодорчээ.

Үндсэн үйл ажиллагаа нь ном, сонин, сэтгүүл, хуанли, зурагт хуудас гээд бүхий л төрлийн хэвлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэнэ. Түүнээс гадна хэвлэлийн дизайн, эх бэлтгэл, хавтан шарах, торгон хэвлэл, сав, баглаа боодлын үйлдвэрлэл, үнэт цаасны үйлдвэрлэл зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Тус компани Монголд анх удаа таван өнгөөр А1 форматаар хэвлэх шинэ технологийг нэвтрүүлснээр хэвлэлийн зах зээлд бусдаас ялгарч чадсан бөгөөд шинээр түргэн хэвлэлийн дижитал машин ашиглаж эхэлснээр ганц ширхэг ном, сэтгүүл хэвлэх бололцоог бүрдүүлсэн нь тухайн хамт олны хамгийн сүүлийн үеийн ололт юм.

Ер нь энэ компани дэлхийн дэвшилтэт технологи, сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдийг нэн тэргүүнд нэвтрүүлсний дээр өдгөө Монголын хэвлэлийн салбарын хөгжлийг тодорхойлж буй үйлдвэрийн нэг болжээ.

Хамгийн гол нь өнгөрсөн хугацаанд тэд өөрийн гэсэн брэндтэй болж чадав. Тийм шүү. Брэндтэй. Тэд Монголын болон дэлхийн ховордсон шилдэг номыг дахин хэвлэж нийтийн хүртээл болгож эхлэв. Цагаан морин жилийн төвөргөөний чимээ, ганзагын наймаа, мөнгөний ханш уналт гээд манайхан олз омгийн төлөө жинхэнэ орондоо орох завгүй оволзон бужигнаж байх үед ном хэвлэнэ гээд нөхдийн нүдийг орой дээр нь гаргаж байсан үе бий. Гэвч тэд ном хэмээх оюуны бүтээгдэхүүнээ мартаж шахаад байсан ард түмнийхээ оюун тархийг сэргээхээр ном хэвлэл, сурталчилгаа, судалгааны чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн байдаг. Өвгөд дээдэс, өв уламжлалаа дээдлэхээр шийдсэн тэд зүгээр ч нэг захын номыг барьж аваад хэвлээд байсангүй. Харин үеийн үе, хойчийн хойчдоо дурсагдан үлдэхээр жинхэнэ брэнд гэхээр номуудыг хэвлэн гаргаж байлаа. Брэнд бүтээгдэхүүнүүдээс нь цухасхан дурдвал: Монголын нууц товчоо, Монгол ардын уртын дуу, Монгол ардын богино дуу, Хөх судар I, II, III дэвтэр,

Овгийн шастир, В.Яны гурамсан роман, Бурхантай хуанли зэрэг олон бүтээлүүдийг нэрлэж болно.

Мөнхийн үсэг хэвлэлийн үйлдвэрлэлээс гадна өөрийн брэнд болгосон гэмээр хүмүүнлэгийн үйлс болох Монголын оюуны хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц уншигч олон, уран бүтээлчдээ дээдэлсэн маш олон арга хэмжээ зохиосон байдаг. Уран зохиолын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах нь тэдний гол зорилгын нэг болжээ. Тэд өнгөрсөн жилүүдэд Төрийн шагналт зохиолчид, Д.Нацагдоржийн шагналтнууд, "Болор цом"-ын эзэд, дууны яруу найрагч, хүүхдийн зохиолчид, шог хошин зохиолчид, Монголын нууц товчооны сонгомол эхийн зохиогчид, ахмад зохиолчид, зохиолч, орчуулагчдын чөлөөт уулзалт, цугларалт зэргийг жил дараалан амжилттай зохион байгуулжээ.

МөнхийнҮсэг компани нь хэвлэлийн салбарт анхдагч байж, дэлхийн дэвшилтэт техник, технологиудыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж ирэв.

Мөнхийн Үсэг Групп хэвлэлийн салбартаа тэргүүлэгч болохыг баталсан бас нэгэн үзүүлэлт нь 2010 онд тэд Хэвлэл ийн үйлдвэрлэлийн салбарт анх удаа ISO 9001:2008 Олон улсын Чанарын Удирдлагын Тогтолцоог нэвтрүүлэн тус стандартыг нэвтрүүлэгч Монголын 31 дэх байгууллага болжээ.

### **Амжилтын нууц**

- Тугалган үсэг өрөх технологийг халж компьютерийн аргаар хэвлэлийн эх бэлтгэж эхэлсэн.
- Торгон хэвлэлийн орчин үеийн тоног төхөөрөмжийг анх суурилуулж, арьс ширэн эдлэл бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэж эхэлсэн.
- 2005 онд Монголд анх удаа дөрвөн өнгийн офсет хэвлэлийн машиныг суурилуулсан нь хоёр өнгийн машинаар хэвлэдэг байсан манай улсад дэвшилтэт технологи болж чадсан.
- 2007 онд таван өнгийн хамгийн том форматын сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, дотооддоо богино хугацаанд хамгийн том форматаар, чанартай бүтээгдэхүүн хэрэглэх боломжийг нээсэн.
- 2008 онд хальс боловсруулах технологийг халж, компьютерээс шууд хавтанд буулгах СТР технологийг ашиглаж эхлэв.
- 2009 онд лентикүляр хэвлэл, пластик хэвлэл, 5С, 6С лакны үйлчилгээг зах зээлд анх нэвтрүүлсэн нь урд хөршид ч хөгжөөгүй үйлдвэрлэл байлаа.
- 2010 онд цаасан хайрцаг, сав баглаа боодлын үндэсний үйлдвэрийг байгуулав.
- 2011 онд В1 формат буюу Монголд хамгийн том форматын тоног төхөөрөмжийг суурилуулаад байгаа нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх хугацааг 2-3 дахин богиносгоод байна.

## **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.munkhiin-useg.mn](http://www.munkhiin-useg.mn) Байгуулагдсан он: 1991 он

Компанийн хаяг: Сүхбаатар дүүрэг, Тээвэрчдийн гудамж, 3-р хороо Улаанбаатар-28

Үйл ажиллагааны чиглэл: Хэвлэлийн бүх төрлийн үйлчилгээ



## **Амьдрах орчин, ая тухыг хангасан брэнд**

Ямар ч хүний амьдрах орчинг санаанд нь тохирсон байдлаар бий болгож, монголчуудын хэлж заншсанаар шинэ гэрийг нь барьж өгнө гэдэг амар зүйл биш билээ. Цаг үе, нийгмээ дагаад хүмүүсийн сэтгэлгээ, сонирхол нь дэндүү өөрчлөгдчихсөн өнөө цагт таалагдсан орон сууц, супермаркет гээд амьдрах орчных нь цогц байдлыг бий болгоно гэдэг бараг л боломжгүй зүйл. Тэр боломжгүйг болгож, бүтээж яваа таны хамгийн дотны, танд таалагдсан брэнд бол Жигүүр Гранд гэдэгтэй хэн ч маргахгүй.

Энэ нэрийг сонсоод их хотын бүтээн байгуулалт, аварга хоёр далавчаараа тэнгэрт сэлүүрдэж яваа ихэмсэг оршихуй мэт өргөгч цамхаг санаанд буух нь гарцаагүй. Тус групп 1989 онд байгуулагдаж өнөөг хүртэл Монгол улсын барилга, үйлдвэр, үйлчилгээний салбарт тэргүүлэх байгууллагын нэг болж өөрийгөө тод томруун харуулж байна. Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд 30 гаруй орон сууц, үйлдвэр, үйлчилгээ, офисын зориулалт бүхий томоохон цогцолборуудыг иж бүрнээр нь барьж 100 орчим байгууллага, аж ахуйн нэгжийн засал чимэглэл, угсралтын ажлыг сайнаас онц үнэлгээтэй хийж гүйцэтгэсэн билээ.

Жигүүр Грандын брэндүүд маш тансаг байгууламж, утга төгөлдөр нэр, өвөрмөц шийдлийг олсон байдгаараа онцлог юм. Хос жүрж гэдэг нэр ямархан исгэлэн, амьдралын амт шимтийг агуулсан, залуухан хосуудын амраг сэтгэлийн өнгө төрхийг санагдуулсан болохыг хэн ч гэсэн төвөггүйхэн мэдэрч чадна. Энэ орон сууц, үйлчилгээ, офисын зориулалттай 961 м2 ашигтай талбай бүхий цогцолборыг Барилга Хот Байгуулалт, Нийтийн аж ахуйн газраас 2003 оны шилдэг 10 бүтээн байгуулалтын нэгээр шалгаруулсан байдаг. Нэрнээсээ эхлээд эрүүл саруул орчин, цэвэр тунгалаг байдлыг үйлчлүүлэгчийнхээ тархи зүрхэнд зоож зүүж өгдөг нь Жигүүр Грандын жигүүртэй брэндийн онцлог юм. Хунгийн хотхон хэмээх цогцолбор л гэхэд нэрнээсээ аваад утга төгс, уран яруу байдлыг илтгэдэг юм. Байгалийн төгс үзэсгэлэн бүрдсэн газар хун шувуу цуглардгийн адил Хунгийн хотхонд айл бүр аз жаргалаар дүүрэн байхыг бэлгэдэж уг нэрийг өгсөн байх жишээтэй.

Энэхүү брэндийн төслийг хоёр жилийн өмнөөс төлөвлөж Монгол орны уур амьсгал, монгол хүний бие махбодийн онцлог зэрэгтэй нарийн уялдуулж, хүний эрүүл, аюулгүй амьдрах нөхцлийг дээд зэргээр тооцсоны үндсэн дээр хэрэгжүүлж эхэлжээ. Зайсан толгойн зүүн урд байрлах уг хороолол 64 айлын амины орон сууцнаас бүрдэх агаад хотын төвөөс холгүй боловч үзэсгэлэнт байгальтай, дуу чимээнээс хол, нам гүм, агаарын цэвэр цэнгэг орчинд байрладаг давуу талтай. Ер нь Жигүүр Грандын жигүүртэй брэндүүдийн нэг болох Хунгийн хотхоноор жишээлэн тэдгээрийн мөн чанар, мөс ясыг нь тайлбарлан таниулбал хэрэглэгчдэд л хэрэгтэй юм.

Хунгийн хотхоны хашаан дотор бут сөөг, төрөл бүрийн жимсний мод суулгаж, Кремлийн хөх гацуур, байгалийн чулуун жим зэрэг эрхэм тансаг эрүүл орчинг тал бүрээс нь бүрдүүлж байна. Энэ бүхнийг зүгээр нэг санамсаргүй байдлаар сонгочихоогүй юм. Богд хан уулын хормой, Их тэнгэрийн ам болон Зайсангийн ам нь уул ус, ургамал модтой ойр, агаарын солилцоо сайтай, чийглэг зөөлөн уур амьсгалтай, тоосжилт багатай учир харшил болон амьсгалын замын бусад өвчнөөс гэр бүлээрээ ангид байж, эрүүл амьдрах баталгаагаар хангагдана. Бүр бие чилээрхсэн тохиолдолд Гранд Мед эмнэлгийн 24 цагийн түргэн тусламжаар үйлчилж бусад үйлчилгээг түргэн шуурхай хүргэдэг гэж байгаа.

Хотхоны эргэн тойронд үерийн хамгаалалт бүхий гоёмсог хашаагаар хүрээлэгдсэн 24 цагийн харуул хамгаалалт, камерын хяналт ч бий. Дохиоллын системээр галын аюулаас бүрэн хамгаалагдсан, гадна фасад хамгийн орчин үеийн шийдэлтэй, дээвэр нь цутгамал бетоноор хийгдсэн нь галын аюулгүй, маш урт удаан эдэлгээтэй байх аж. Герман улсын тохилог 24 цагийн лифттэй, Косом high end Home Network Solution системтэй ба өөрийн гэрийг алсын зайнаас гар утас, интернэтийн тусламжтайгаар удирдан хянах боломжтой аж.

Жигүүр грандын нэг шилдэг брэнд нь Luxury Zaisan ViLLage цогцолбор юм. Энэ нь таван одтой зочид буудал мэт орон сууцны дээд зэрэглэлийн үйлчилгээний иж бүрэн цогцолбор. Орон сууц нь гурван янзын зохион байгуулалттай бөгөөд давхартаа нэг айлын элит апартамент, давхартаа хоёр айлтай опейшл апартамент, давхартаа гурван айлтай стандарт апартаментуудаас бүрдэнэ.

Энэ бүхэн монгол хүнд л зориулагдаж байгаа болохоор бар жилийн шилдэг архитектуртай барилгаар шалгарсан юм. Өнөөдөр гадны томоохон хөрөнгө оруулагчид Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж, түүнийг дагаад манайд ажиллаж амьдрах гадаадын иргэд ихсэх боллоо. Люкс зэрэглэлийн 3-4 өрөө байрны нэг сарын түрээсийн төлбөр 2000-5000 долларын хооронд хэлбэлздэг. Жишээ нь, та байраа сарын 3000 доллараар түрээслэвэл гурван жил гаруйн хугацаанд байрныхаа үнийг хуримтлахуйц ашигтай түрээслэгч байх боломжтой. Ашгаас ашиг унагах, байраараа бизнес хийх боломжийг үйлчлүүлэгчээ мартдаггүй Жигүүр Гранд нээж өгч байгаа нь энэ.

Жигүүр Грандын сүндэрлүүлсэн байр урлагийн бүтээл шиг сэтгэлгээ, оюун мэдрэхүйн таашаал эдлүүлдэг онцлогтой. ГХЯ-ны баруун талд 6700 м2 талбай бүхий Гранд офис центр офис үйлчилгээ, орон сууцны цогцолборыг Монголын Архитекторуудын Эвлэлээс 2008 оны шилдэг барилгаар шалгаруулжээ. Энхтайваны гүүрний баруун урд 9100 м2 ашигтай талбай бүхий орон сууц, үйлчилгээний цогцолбор бүхий Наран хотхоныг шалгаруулж байв. Жигүүр Гранд олон төсөл, цогцолборуудыг амжилттай барьж ашиглалтад оруулжээ. Үүнд, Континенталь зочид буудлын зүүн талд 7432 м2 талбай бүхий 49 айлын орон сууцны барилга, Жигүүр Грандын 2100 м2 талбай бүхий үйлдвэр баазын барилга, мөн тус компанийн офисын 7050 м2 талбайтай офис үйлчилгээний барилгуудыг чанарын өндөр түвшинд хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн байдлаар хийж бүтээжээ.

Энхтайваны өргөн чөлөөнд 41375 м2 талбай бүхий Гранд Плаза худалдаа, үйлчилгээ, офисын зориулалттай цогцолбор, 13-р хороололд 225 айлын орон сууцны 24500 м2 ашигтай талбай бүхий Шинэ зуун хотхон, Цэцэг зочид буудлын хойд талд 4678 м2 талбай бүхий 54 айлын орон сууц зэрэг цогцолбор байгууламжууд үнэхээр төгс шийдлээр барьж байгуулсан

урлагийн бүтээлүүд юм.

Жигүүр Грандын бүх салбарууд хүний ая тух, амьдрах орчинд анхаарал тавьсан үйл ажиллагааг явуулж ирэв. Энэ бүхнийг Grand Club төлөөлж чадна. Grand Club-ын бассейн нь хөдөлгөөний дутагдал болон элдэв химийн бодисноос үүдсэн өвчлөлтэй тэмцэх сайн арга болдог. Grand Club нь дээд зэрэглэлийн бассейнаар үйлчилж, массаж хийж, алжаал тайлна.

Жигүүр Грандын жигүүртэй брэнд зөвхөн Монголдоо төдийгүй дэлхийд гайхагдаж, бишрүүлэх болов. Гранд Плаза цогцолбор нь 2008 онд Монгол улсаас анх удаа дэлхийн топ барилгын жагсаалтад орсон агаад архитекторын шилдэг дизайн, шийдэлтэй байгууламжаар шалгарсан нь Жигүүр Гранд группын төдийгүй монгол хүний оюун ухааны бахархал болж байна. Монголдоо хамгийн томд тооцогдох уг цогцолбор нь олон улсын худалдаа, үйлчилгээний стандартын шаардлагыг бүрэн хангасан барилга болж чадсан бөгөөд цогцолбор ашиглалтад орсноор 3000 гаруй хүний ажлын байр шинээр бий болж, нийгмийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулав.

Бас эх орны байгаль орчны тэнцвэрт байдлын төлөө Эрүүл орчин сэдэвт төсөл боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Ажилчдаа чанартай эрүүл хүнсээр хангах, улмаар улс орныхоо хүнсний хэрэгцээний хэсэгхэн зайг ч гэсэн өөрсдийн хүчээр хангах зорилгоор Булган аймгийн Хутаг Өндөр суманд өндөр ашиг шим бүхий мал аж ахуй эрхэлж, 2000 га талбайд үр тариа, хүнсний ногоо, жимс, чацаргана тариалжээ.

Хүн болж төрсний дараа эхийн хэвлийг орлож байдаг орон байрыг хүний биед харш нөлөөгүй, олон улсын стандартын шаардлага хангасан барилгын материалаар хийх зорилгоор энэ чиглэлийн худалдааг эрхэлж байна.

Цаашид 120000 м2 талбайд иж бүрэн хороолол барих бөгөөд үүнд орон сууцны бичил хороолол, эмнэлэг, цэцэрлэг, сургууль, супермаркет, спорт цогцолбор, кино театр, банк, санхүү үйлчилгээний иж бүрэн цогц төв багтах юм. Гадаад харилцаагаа өргөжүүлж, өөрийн ажилчид болон хойч үеэ гадаадад мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах нь Жигүүр Грандын эрхэм зорилгын нэг билээ.

Энэхүү их бүтээн байгуулалт, уран тансаг барилга байгууламжийг сүндэрлүүлэгч Жигүүр грандыг Дашбалжирын Баттөр хэмээх Монголдоо хайртай, урлагт авьяастай эрхэм үүсгэн байгуулж ийм өндөрлөгт хүргэжээ. Д.Баттөр Сэлэнгэ аймагт төрсөн нэгэн. Түүний барьж байгуулсан бүхэн нь уран барилгын шийдэл, үгийн яруу сайхнаар ирлэгдэж нэрлэгдэж, хэрэглэгчдийн сэтгэлд нийцтэй, гэгээн сайхан мэдрэмж төрүүлдэг нь учиртай. Тэр зөвхөн их барилгын салбарт хүч үзээд зогсохгүй урлагт зүрх сэтгэлээ өгсөн хөгжмийн зохиолч, яруу үгийн мастер юм. Түүний зохиосон аялгуу, дууны үгс бас нэгэн жигүүр үүсгэн хүмүүний оюун санаан дунд дэвж байгаа нь гайхалтай. Энэ ч гэсэн Жигүүр Грандын жигүүртэй брэнд юм. Д.Баттөрийн дэмжлэгээр олон хүн урлагийн алтан тайзнаа тодхон гялалзах болсон билээ. Тэрбээр монгол хүн эх орондоо эзэн байж Монголоо хөгжүүлж босгох ёстой гэж үздэг. Монголын төлөө цохилох зүрх, ажиллах тархийг Жигүүр Грандын бас нэгэн жигүүр ч гэж болох юм даа.

**Амжилтын нууц**

- Орон сууц үйлчилгээ офисын зориулалттай цогцолборын дагалдах асуудлыг нь сайтар тооцоолж, сайн шийдвэрлэж байдаг нь хэрэглэгчдийн талархлыг хүлээдэг.
- Барилга байгууламжаа барих газрыг эрүүл ахуй, цэвэр цэмцгэр орчинтой байхаар сонгож, ая тохитой, амгалан сайхан амьдрах боломжийг хэрэглэгчиддээ олгодгоороо давуу талтай.
- Нийгэм, улс орны хөгжлийн чиг хандлагыг сайтар мэдэрч гадаадаас Монгол руу чиглэж байгаа хөрөнгө оруулагчдын мөнгөний урсгалыг ашиглахад Жигүүр Грандын тансаг барилга, орон сууцнууд эзэндээ бизнесийн давхар боломж олгож, амьдралын баталгааг нь хангаж байдаг.
- Хэзээнээс нааш хэрэглэгчдийнхээ ая тух, эрүүл мэндэд анхаарал тавьж ирсэн нь Жигүүр Грандын имиж төдийгүй ажлынх нь чанар, брэндийнх нь онцлог шинж болоод байна.
- Жигүүр Грандын барьж байгуулсан барилгууд зүгээр нэг байшин барилга төдийгүй архитектурын өвөрмөц шийдэлтэй урлагийн бүтээлийн хэмжээнд дүйж очдог нь гайхалтай.
- 20 жилийн туршлага дээр үндэслэн Монголд баригдсан барилгын алдаа эндэгдлийг нарийн тооцож, европ стандартад нийцсэн, ISO шаардлага хангасан дэлхийн брэнд болон барилгын эрүүл материалыг ашиглах болсон.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.jiguurgrand.mn](http://www.jiguurgrand.mn) Байгуулагдсан он: 1989 он

Компанийн хаяг: Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж, Улаанбаатар-210628, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Барилга, байгууламж, эмнэлэг, гэр ахуй болон зочид буудлын зориулалт бүхий тавилгын худалдаа





## **Монос групп эрүүл мэнд, гоо сайхныг бэлэглэгч брэнд**

Гоц гойд зүйлийг зохион бүтээж, хэрэглэгчдийнхээ төлөө анхаарал тавьж амжилт гаргасан хүн олон байдаг. Тийм топуудын нэг бол Монос групп юм. Одоо арав гаруй салбар компанитай тус групп 1990 онд гуравхан хүнтэйгээр эмийн ургамлын зэхмэл, тос тосон түрхлэг, гоо сайхны тос үйлдвэрлэж үйл ажиллагаагаа эхлүүлсэн ч ирээдүйдээ дэндүү итгэлтэй байж чадав. Ингэснээрээ Монос гэдэг нэр одоо хүн болгоны сайн мэдэх үг болжээ. Зөвхөн үг төдийгүй хорь гаруй жилийн нөр их хөдөлмөр, эрдэм шинжилгээний ажлын эрэл хайгуул, шилдэг, шинэ брэнд бүтээгдэхүүн зэрэг олон талт үйл ажиллагаа нь хэрэглэгчдийнхээ талархлыг хүлээж байна.

Монос гэдэг нь Монгол оюун санаа гэсэн үгийн товчлол гэдэг. Бас цаг үргэлжид урган цэцэглэж, өсөн дэвжихийг бэлгэдсэн биз. Байгуулагдсанаасаа хойш жил шахмын дараа гэхэд л өөрийн шошготой өвөрмөц бараа бүтээгдэхүүнээ зах зээлд гаргаж, төдөлгүй шахмал болон ургамлын хандаар эм бэлдмэл үйлдвэрлэж, үйлдвэрлэлээ өргөжүүлж эхлэв. Ингэж эрүүл мэндийн баталгаатай эм бүтээгдэхүүн үйлдвэрлэх өрсөлдөөний талбарт Монос компани хүчтэйхэн орж ирлээ.

**МОНГОЛЫН №1**  
БАЙГАЛЫН ГАРААТАЙ ШИНЭЧИЛСЭН **ГОО САЙХНЫ ЦУВРАЛ**

Барагшуунтай органик ханд нь олон төрлийн эрдэс бодисоор таны арьсыг хангаж, чийгшүүлнэ.

Гүүний саамны органик ханд нь арьсанд тэжээл өгч, уургаар тэтгэнэ.



**МОНОС**  
FOOD CARES

# САЛИМОН



*Дархлаагаа  
тэтгэе*

**ЯДАРГААНД ЯЛАГДАШГҮЙ**



# ЧИТАМОН

- ✓ Ханиалга дарах
- ✓ Үрэвсэл намдаах
- ✓ Цэр ховхлох

Тэр үеэс л судалгаа шинжилгээний ажилд анхаарч эхэлсэн бөгөөд өдгөө Монос эм судлалын эрдэм шинжилгээний төв нь уламжлалт анагаах ухааны онолын суурь судалгаа, эм судлал, биотехнологи, фитохими эмийн технологи, хими стандартын чиглэлээр судалгаа шинжилгээний ажлуудыг хийдэг байна. Жилд дунджаар 700 орчим сая төгрөгийг эрдэм шинжилгээ, судалгааныхаа ажилд зарцуулж байгаагаас харахад монгол ухаанаар бүтсэн эм, эмийн бүтээгдэхүүнийг дэлхийн брэнд болгох зорилготойг нь хялбархан ойлгож болно. Энэ бүхэнд тус группын удирдлагын шинжлэх ухаанч алсын хараа, эх орныхоо нэрийг тив дэлхийд дуурсгах гэсэн хүсэл тэмүүлэл ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Ялангуяа Моносоор овоглож, Монгол оюун санаагаар жигүүрлэсэн эрдэмтэн, мэргэжилтнүүд нь Монгол, Төвдийн уламжлалт эмнэлгийн нууцад нэвтэрч, уламжлалт болон орчин үеийн технологийг хослуулан байгалийн гаралтай эм бэлдмэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүн олныг зохион бүтээж, үйлдвэрлэж байгаа билээ.

Эрдэмтэн М.Амбага, Л.Хүрэлбаатар нар хэдэн жилийн өмнө дархлаа сэргээх Салимон, шүдний тулгуур эд, буйл, амны салстын үрэвсэл намдаах, эмчлэх Дентамон бэлдмэлээрээ төрийн соёрхол хүртсэн нь энэ ажлын үр дүнг бэлээхэн харуулдаг. Монос үйлдвэр 60 гаруй төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэдгээс 10 гаруй нь шинэ эм юм. Эдгээр нь өөр өөрийн үүрэг, зориулалт, өнгө төрхтэй. Ургамлын гаралтай энэ эм бэлдмэлүүдийг дагалдагч урианаас нь хараад л хэрэглэгчид хялбархан таних боломжтой. Тухайлбал, Салимон

ядаргаанд ялагдашгүй, Читамон ханиадны эсрэг хамтдаа, Дентамон шүд эрүүл бол бие эрүүл, Эрвалкор айсан зүрх тайвширч, түгшсэн зүрх тайтгарна гэх зэрэг. Ойлгомжтой бөгөөд ийм ойр дотно бүтээгдэхүүн гэвэл Моносын эмнүүд. Одоогийн байдлаар тэд Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон 20 гаруй нэр төрлийн эм мөн дотоодын нийт эмийн үйлдвэрлэлийн 30 хувийг эзэлж байгаа юм.

Түүхий эд бэлтгэлээс эцсийн бүтээгдэхүүн гарч хэрэглэгчид очих хүртэлх шат дамжлагуудад хяналт тавьж баталгаажуулдаг. Мөн эм бэлдмэлийн сорилын лабораторидоо хими, микро биологийн шинжилгээг үндэсний стандарт болон олон улсын норматив, техникийн баримт бичигт үндэслэн хийдэг байна. Дэлхийн чанарт дүйцэх бүтээгдэхүүн нэгэнт үйлдвэрлээд эхэлчихсэн болохоор эм бэлдмэлээ экспортлохыг зорино. Шаардлага хангасан эмийг зөрүүлээд оруулж ирнэ. Ингэж эм мэддэг байгууллага нь эмийн бүтээгдэхүүн оруулж ирснээр хэрэглэгчдийн дотор ямар нэгэн болгоомжлол, хардлага сэрдлэг бий болохгүй. Итгэж болох импортлогч байж чаджээ. Одоо Монос фарм компани Монголд эмийн үйлдвэрээ өргөтгөж, ОХУ-ын Санкт Петербург хотод салбар үйлдвэрээ байгуулахаар ажиллаж байна.

Гоо сайхны бараа бүтээгдэхүүний хамгийн том үйлдвэрлэгч байж чадсанаараа Моносынхон бахархдаг. Хүнийг гоё сайхан харагдуулж, амьдралын эрч хүч, баяр баясгалан бэлэглэхээс илүү буянтай ажил гэж юу байх билээ.

Монос косметик ХХК нь бас л 1990 онд байгуулагдсан бөгөөд төрөл бүрийн аминдэм, уураг, амин хүчил, эрдэс бодис зэрэг биологийн идэвхит бодис агуулсан 30-аад нэр төрлийн байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна. Биомон, Биоген цуврал нь арьсанд бүх төрлийн арчилгаа, цэвэрлэгээ үзүүлж уураг, аминдэм, эрдэс бодисоор баялаг тул зөвхөн Моносын төдийгүй Монголын нэрийг олон улсад гаргаж байна.

Мөнөөрийн нэрийн гоо сайхны салоона нээж арьс арчилгаа, эмчилгээний олон төрлийн үйлчилгээ үзүүлж Солонгос, Словени зэрэг улсаас гоо сайхны бараа импортлодог.

Монос группын Моносфарм трейд ХХК нь дотоодын арав гаруй, Франц, Герман, Швейцарь зэрэг гучаад орны Санофи Авентис, Шеринг, Новартис зэрэг 80 гаруй томоохон пүүстэй харилцаж 3000 орчим нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, вакцин, оношлуур, эмчилгээний гоо сайхан, биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотын тав, хөдөө орон нутгийн 19 эм ханган нийлүүлэх төвөөр дамжуулан Монгол улсын нийт эмийн сан, сум, аймаг, дүүрэг, хотын клиникийн эмнэлгүүд, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд зэрэг 800 гаруй байгууллагад нийлүүлж байна. Одоогийн байдлаар манай улсын эмийн бүртгэлд 1600 гаруй бүтээгдэхүүн бүртгэгдсэн байдаг гэнэ. Үүний 60 гаруй хувийг Моносфарм трейд зуучлан бүртгүүлжээ. Мөн Монгол улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон нийт эмийн 80 гаруй хувийг хангаж байна.

Зөвхөн эмийн бүтээгдэхүүнээр эдний үйл ажиллагаа хязгаарлагдахгүй. 2006 оноос эмнэлгийн техник, технологийн газар шинээр байгуулжээ. Эндээ эмнэлэг, лабораторийн техник хэрэгслийн байнгын үзэсгэлэнгийн танхим нээн ажиллуулж, компьютер томограф,

суурин рентген аппарат, лабораторийн тоноглол зэрэг төрөл бүрийн багаж төхөөрөмж нийлүүлж, засварлаж байна.

2004 онд Монголдоо анхны Фарм маркетийн үйлчилгээг бий болгосноор ариун цэвэр, гоо сайхан зэрэг эрүүл мэндийн барааг нэг дороос авах боломж нээгдсэн агаад жортой эмийн тасаг нь тусдаа байж стандартын дагуу үйлчилгээ үзүүлж эхэлсэн юм. Гэхдээ эдгээр эмийн сангийн сүлжээн дээр "худалдагч" зогсдог юм биш. Мэргэжлийн эмч нар үйлчлүүлэгчидтэй шууд харьцаж, өөрийн биеэр очиж чадахгүй хүнд 1883 дугаарын лавлах утсаар улс орны хаана ч, өдөр шөнийн аль ч цагт эмийн лавлагаа болон эрүүл мэндийн зөвлөгөө өгдгөөрөө үйлчлүүлэгчийн эргэлзээг төрүүлэхгүй байж чаддаг. Ингэснээрээ орчин үеийн чиг хандлагыг нэвтрүүлэн эмийн зохистой хэрэглээг бий болгохоос гадна хэрэглэгчийн үнэт цагийг хэмнэх, соёлтой боловсон үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлж байна.

Монос дээд сургууль нь хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн сургууль бөгөөд 2000 онд анх тулгын чулуугаа тавьснаас хойш 11 дэх хичээлийн жилтэйгээ золгож байна. Одоо тус сургууль 500 гаруй оюутан, 30 шахам профессор багш, гурван тэнхимтэй бөгөөд сургалтын материаллаг орчин нь хоёр хичээлийн байр, 12 лаборатори, кабинет, 20 шахам анги, 15 мянган ном бүхий номын сан, өндөр хүчин чадал бүхий компьютерийн лаборатори болон бусад хэсгээс бүрдэж байна.

Тус сургууль зургаан удаагийн төгсөлтөөрөө 400 гаруй эм зүйч, 20 гаруй магистр бэлтгэсэн нь бүгд ажлын байраар хангагдаж мэргэжлээрээ үр бүтээлтэй ажиллаж байгаа аж. Моносын төгсөгчид "эм барих" эрхийн шалгалтад жил бүр 95-100%-ийн амжилт үзүүлдэг билээ. Монос дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн гурвалсан холбоонд суурилж нэгдмэл тогтолцоог бүрдүүлснээр бэлтгэн гаргаж буй мэргэжилтнийхээ чанарыг сайжруулах урьдчилсан нөхцөл болжээ. Сүүлийн үед сургуулийн гадаад харилцаа улам өргөжин тэлж ОХУ-ын Пятигорскийн Эм зүйн академи, Буриадын их сургууль, Санкт Петербург хотын Эм зүйн академи, БНСУ-ын Олон улсын их сургуулийн Эм зүйн сургууль, Жунсоны их сургууль, Чунбукийн үндэсний их сургуулийн Эм зүйн коллежтэй хамтран ажиллах гэрээ шинээр байгуулав. Монос Дээд сургууль нь сургалтандаа кредит цагийн системийг иж бүрэн нэвтрүүлэх замаар багшийн хөдөлмөрийг оновчтой үнэлж, дүгнэх, оюутны суралцах идэвхи чармайлтыг нэмэгдүүлэх, мэдээллийн системийг боловсронгуй болгох талаар томоохон зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа юм.

Монос Хаус холд ХХК нь дэлхийд алдартай компаниудын гэр ахуй, өргөн хэрэглээний барааны импортын худалдаа эрхэлдэг. Одоогоор Японы КАО, LION корпораци, Малайзын IFFCO, Индонезийн PacificInter Link, Английн Glaxo Smith Kline зэрэг компанийн албан ёсны дистрибьютерээр ажиллаж шүдний оо, шампунь, угаалгын нунтаг, саван зэрэг олон төрлийн бараа импортлон нийлүүлж байна.

Монос групп нь салбарынхаа бүтээгдэхүүний зохиогч, шинийг санаачлагч, үйлдвэрлэгч, чанарынх нь баталгааг хангагч, хэрэглэгчиддээ хүргэгч бас өөрөө өөрийнхөө найдвартай хэрэглэгч байж олон нийтэд итгэл төрүүлэгч юм. Мөн дэлхийн стандартыг Монголын эм, гоо сайхны барааны зах зээлд нэвтрүүлэгч, салбартаа чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж, тэднийг ажлын байраар хангагч юм. Үүнээс илүүтэй нийгмийн сайн

сайхны төлөө ажиллана гэж юу байх билээ. Монос буюу Монгол оюун санаа тун удахгүй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн брэнд болоход хэн ч гайхахгүй биз ээ.

## **Амжилтын нууц**

Эх орны хөрсөнд ургадаг ургамлын гаралтай эм

бэлдмэлийг гаргаж, уламжпалт анагаах ухааны мэдлэг, эм барих аргыг орчин үеийн техник технологитой хослуулан шинжлэх ухааны нээлтийн чанартай үйл ажиллагааг тогтмолжуулж чадсан.

- Эмийн болон гоо сайхны бүтээгдэхүүнийхээ чанарт түүхий эд бэлтгэлээс эцсийн бүтээгдэхүүн болж үйлдвэрлэгдэх хүртэл нь хяналт шинжилгээ хийж, Монгол улсын төдийгүй гадаадын зах зээлд нэр хүндтэй брэнд болгож чадсан.

- Монголдоо эмийн болон гоо сайхны барааны хамгийн том үйлдвэрлэгчийн хувьд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн чанартай эм бэлдмэл, эмийн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирдэг. Моносын бараа бүтээгдэхүүнд эргэлзэх шаардлагагүй гэж хэрэглэгчид нь үзэх болсон.

- Олон улсын чанарын удирдлагын ISO-9000 стандарт болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Үйлдвэрлэлийн сайн дадал (Good Manufacturing Practice/GMP)-bm стандартыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг амжилттай хийж байна.

## **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.monos.mn](http://www.monos.mn) Байгуулагдсан он: 1990 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар 211137, Сонгинохайрхан дүүрэг-20, Сонсголонгийн тойруу-5

Үйл ажиллагааны чиглэл: Эм, гоо сайхан, эрүүл мэндийн барааны үйлдвэрлэл, импорт, экспорт, бөөний худалдаа, эмийн сан.



## Эрүүл амьдралын баталгаа болсон брэнд

Энэ хорвоод хүн болж төрсний мөн чанар нь эрүүл саруул, аз жаргалтай утга учиртай амьдрахын зэрэгцээ бусдад ч тийм боломжийг бэлэглэх явдал билээ. Тэгвэл "Эрүүл, аз жаргалтай амьдралд хамтдаа" гэсэн уриан дор Дорнодын тэгш талаас Ховдын хязгаар, Өмнийн өргөн говиос Хөвсгөлийн шигүү тайга хүртэлх Монгол орны бүхий л нутаг дэвсгэрт өвчин эмгэгийг эмчлэх өндөр идэвх бүхий чанарын баталгаатай эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслээр 88 жил тасралтгүй, найдвартай, хүртээмжтэй үйлчилсээр ирсэн нэг байгууллага байдаг нь Монголэмимпекс концерн ХК юм. Тус концерн анх 1923 онд "Нэгдүгээр эмийн сан" нэртэйгээр байгуулагдаж, өнөөг хүртэл төв, орон нутгийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй ханган нийлүүлж иржээ.

1990 оноос Монгол Улсын нийгмийн хөгжлийн хандлага бүхэлдээ өөрчлөгдөн зах зээлийн эдийн засагт шилжсэнээр энэ салбарт хувийн хэвшлийнхэн олноороо орж ирэн, өрсөлдөөн буй болов. Гэсэн ч тус концерн төрийн өмч хэвээр байж, төрийн зохицуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байлаа. 1991 онд Монгол улсад "Эмийн үндэсний бодлого", 1998 онд "Эмийн тухай хууль" батлагдсанаар хууль эрх зүйн орчин, цаг үетэйгээ зохицон бүрдэх болсон байна. Харамсалтай нь төр өөрөө сайн менежер байж чаддаггүйн жишээ онцгой, эмзэг салбар болсон эмийн бүтээгдэхүүний салбарт давтагдаж тус байгууллагын ажил уналтад орж, тэр хэрээр ард иргэд найдвартай, баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдах явдал дээсэн дөрөөн дээр ирсэн билээ. Үүнээс үүдэж тус байгууллагыг хувьчлах шийдвэр гарч, ийнхүү төрийн мэдэлд байсан 85 жилийн түүхтэй тус компани хувьчлагдаж 2007 онд Бишрэлт холдингийн мэдэлд зуун хувь шилжсэн билээ.

Аливаа бизнес зөвхөн хувь эзэмшигчдэд ашгаа өгөхөөс гадна оршин буй нийгэмдээ үр ашгаа өгч, урт удаан хугацаанд амжилт гаргах чадвартай болдог гэдэгт итгэж ирсэн шинэ эзэд нь халаа сэлгээ хийлгүй хуучин боловсон хүчний нөөцдөө тулгуурлаж, чадварлаг, туршлагатай мэргэшсэн баг бүрдүүлэн нэн тэргүүнд компанийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, зах зээлд эзэлсэн байр сууриа бэхжүүлэх тогтвортой өсөлтийн стратегийг барьж ажиллав. Эрүүл мэндийн байгууллагын тулгын гурван чулууны нэг нь эм хангамжийн салбар байдаг билээ. Тэгвэл Монголэмимпекс концерн бусад эм ханган нийлүүлэгчдээс ялгарах онцлог нь хот, орон нутгийн эмнэлгүүдийг хорт мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, мэс заслын хагалгааны мэдээгүйжүүлэх бэлдмэл, хорт хавдрын болон яаралтай тусламжийн эм тариагаар хангах энэ амаргүй ажлыг дангаараа идэвхитэй хийж ирсэн.

Мөн ондоо анхны өөрөө өөртөө үйлчлэх Pharm Market - E BERES

 BÉRES

# БЕРЕС

*Дархлааг  
сэргээх!*



- Дархлаа сулрал
- Эдфат
- Өмс сульдат
- Шамирдат
- Нойрзүүдэг
- Хоолны дуршил буурах
- Зэрлэг тэргэлтэ.

- Эд мэйн нэгэн шалжмал
- Хүнд татагвааны дарга
- Хавдрын өвчтэй хүмүүст
- илүү тэргэлтэ.

**MEIC** Since 1923  
МОНГОЛ ЭМНЭГЭЭС КОНЦЕРН

Монгол улс, Улаанбаатар-28, Т. Уулзур 2000, т. дугаар-39  
Утас: Төв утасны гэрээ 323917, 36 хэлтэсний гэрээ 310-323961,  
Факс: 338897, 70179997, Факс: 323877,  
Вэб сайт: www.meic.mn, И-мэйл: info@meic.mn



**МЭС**  
MONGOL EMIMPEKS CONCEPT

# БЕВИПЛЕКС

В бүлгийн витаминууд агуулсан нийлмэл найрлагатай бэлдмэл. Мэдрэлийн үрэвсэл витаминь дутагдал, тамирдах зэрэгт хэрэглэнэ.

Таны гэр бүлийн сонголт

Beviplex®  
Beviplex H  
Beviplex

**Galenika**

Монгол улс, Улаанбаатар-28, Тээвэрчний гудамж-39  
Утас: Төв эмийн сан-323917, Эм ханган нийлүүлэх төв-323961,  
Фарммаркет 330897, 70179997, Факс: 323877,  
Вэб сайт: www.mesc.mn, И-мэйл: info@mesc.mn

аа нээжээ. Хуучин үеийн эмчилгээний стандартыг өөрчлөн орчин үеийн чанартай, дэлхийн стандартад тохирсон эм, эмийн бэлдмэлийг нэвтрүүлэх шаардлага урган гарч иржээ. Тиймээс клиникийн эмнэлгүүдэд ерөнхий мэдээ алдуулах бэлдмэл болох Изофлураныг нэвтрүүлсэн байна. Энэ тариа нь эмчлэгч болон өвчтөнд үзүүлэх хор хөнөөл багатайгаараа алдартай билээ. Ер нь эднийхэн ашиг олохоо урьтал болгохгүй чанартай, найдвартай, хамгийн гол нь дэлхийн өндөр хөгжилтэй улс орны эмийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх болжээ. Уламжлалт түгээлтийн системээ орчин үеийн жишигт нийцүүлсэн нь томоохон ахиц юм. Мөн ондоо багтааж Pharm Market-ийн тоогоо гурваар нэмэв. Ингэж дүүрэг болгонд өөрөө өөртөө үйлчлэх Pharm Market байгуулснаар хэрэглэгчдэд илүү ойртсон, тэдний хэрэгцээ шаардлагад суурилсан орчин үеийн шинэлэг үйлчилгээг бий болгож, тохь тухтай орчинд өргөн сонголттой, чанарын баталгаатай бүтээгдэхүүнээр үйлчлэх болсон нь бусаддаа үлгэр дууриал болж буй аж. Энэ онцлогоороо Монголэмимпексийн үйл ажиллагаа брэндийн түвшинд хүрч очив.

Өнөөдөр тус концерны Улаанбаатар дахь төв эмийн сан болон PharmMarket эмийн сангийн сүлжээ, Эм ханган нийлүүлэх төв, 21 аймаг, орон нутаг дахь харьяа компаниуд нь ард иргэдийг баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хурдан шуурхай, тасралтгүй хангаж байна. Тус концерн нь дэлхийн эмийн зах зээлд тэргүүлэгч 50 гаруй пүүс, компанийн албан ёсны дистрибьютерийн болон импортын гэрээгээр чанарын баталгаатай, өндөр идэвхтэй

эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг импортлон, холбогдох байгууллагуудын шинжилгээ, дүгнэлт, зөвшөөрлийн үндсэн дээр хэрэглэгчиддээ хүргэхээр ажиллаж буй юм. Үүнийг дагаад дэлхийн хэмжээний стандарт үйлчилгээ, менежмент манай орны хөрсөн дээр буух таатай нөхцөл бүрэлдэж, Монголэмимпексийн брэнд хөгжиж, өөрчлөгдөн шинэчлэгдэж ирэв. Тус концерны удирдлага дэлхийн эм үйлдвэрлэлийн болон анагаах ухааны салбарын тэргүүлэгч эрдэмтэн, профессоруудыг урьж Олон улсын эрдэм шинжилгээний онол практикийн хурал, сургалтыг зохион байгуулах ажлыг хийж ирсэн нь манай мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролд оруулсан томоохон хөрөнгө оруулалт болж байна.

Улаанбаатар дахь Pharm Market эмийн сангууд нь нөөц, найрлага, шинжилгээ, шил угаалгын гэх мэт эмийн сангийн стандартын шаардлага хангасан талбай бүхий өрөөнүүдтэйгээс гадна шинэлэг өнгө, загвартай тохилог орчинд соёлтой, орчин үеийн үйлчилгээг цогцоор нь бүрдүүлж, чанартай бүтээгдэхүүнээр хангах болов. Цаашид ч Улаанбаатар дахь эмийн сангийн болон Бөөний худалдааны төвийн борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн хэрэглэгч бүрт хүрч үйлчлэх зорилго тавин ажиллаж буй аж. Тус компанийнхан борлуулалтын бодлогоо зөв үнийн бодлоготой хослуулснаар ихээхэн амжилт олов. Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хэрэглэгчиддээ очих чадвар бол энэ салбарынхны гол шалгуур болдог.

Тиймээс Монголэмимпекс нь онцгой байдлын үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, хурдан шуурхай хангах үүргээ нэр төртэй биелүүлсээр ирсэн. Тухайлбал, Багануур дүүрэгт гарсан метилийн спиртийн хордлогын үеэр тус концерны ажилтнууд яаралтай дуудлагаар ажлын байрандаа ирж хордлого тайлах антидотыг эмнэлгийн байгууллагуудад хурдан шуурхай нийлүүлж ажилласны хүчинд олон иргэний амь насыг аварсан юм. Мөн Баян-Өлгий аймагт таван зуу гаруй хүн хоолны хордлогод өртлөө гэсэн мэдээллийг авч тэр даруй яаралтай эм тариаг өөрсдийн хөрөнгөөр онгоцонд ачуулан хүргүүлж, газар дээр нь мэргэжилтнүүдээ очуулж ажиллуулснаар олон хүний эрүүл мэндэд хор хохирол учруулалгүй шаардлагатай арга хэмжээг авч чадсан байдаг. Түүнчлэн 7 дугаар сарын 1-ний үймээний дараа Төрийн тусгай хамгаалалттай эмнэлгүүдэд тендерийн эм барааг яаралтай хүргэж байв.

Энэ чиглэлийн үйл ажиллагааны дагуу МУ-ын Засгийн газартай гэрээ байгуулан онцгой болон гамшгийн үед хэрэглэх зайлшгүй шаардлагатай эмийн улсын нөөцийг бэлэн байдалд байлгаж, стандартын нөхцөлд хадгалж байна. Ийнхүү нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлаж, салбарынхаа хэмжээнд үлгэр жишээ болохуйц үйл ажиллагаа явуулж буй Монголэмимпекс концерн дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй брэнд компаниудтай хамтарч ажиллаж байгаа билээ.

### **Амжилтын нууц**

- Хүний нөөцийн хувьд ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсан, өндөр хөгжилтэй улс орнуудад боловсрол эзэмшсэн чадварлаг багийг бүрдүүлсэн.

- Хүн амын эрүүл мэндийн манаанд найдвартай зогсч, харьяа эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагууд нь бүгд стандарт, чанарын шаардлагад нийцсэн тоноглол бүхий

төрөлжсөн агуулах, эм барааг тээвэрлэн хүргэх зориулалтын тээврийн хэрэгслээр хангагдсан.

- Алс хэтийг харж, чанартай бүтээгдэхүүн нийлүүлж үйлдвэрлэх зорилт тавьснаар нэр хүндээ өсгөж чадсан.
- Олон улсын худалдааны "Incoterms 1990" гэрээний нөхцлөөр гадаад худалдаагаа хийдэг.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.meic.mn](http://www.meic.mn)

Байгуулагдсан он: 1923 он

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот-28, Тээвэрчдийн гудамж-39.

Үйл ажиллагааны чиглэл: Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн импорт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, хадгалалт, тээвэрлэлт, ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаа, эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагын үйлчилгээ, өөртөө үйлчлэх PharmMarket эмийн сангийн сүлжээ, эрүүл мэндийн сургалт семинар, зөвлөгөө.



ДЭЛХИЙН ЖИШГИЙГ  
МОНГОЛД  
ТОГТООСОН БРЭНДҮҮД



**Дэлхийн хөгжлийг монголд авчрагч брэнд**

Эрчим хүчний зөвлөгөө өгөх үйл ажиллагаанаас гараагаа эхэлсэн М-Си-Эс компани өнөөдөр олон салбарт тэргүүлэх үүрэг рольтой гуч гаруй компанийг төрүүлсэн групп болтлоо өргөжин хөгжжээ.

Нэг салбараас өөр салбарт орж ирэхдээ М-Си-Эс төд удалгүй тэрхүү салбарынхаа тэргүүлэх байр сууринд ямагт хүрч чаддаг. Энэ чадварыг үнэлсэн М-Си-Эс-ийн менежмент гэх хэлц үг хүртэл гарсан билээ. М-Си-Эс-ийн менежмент хүрсэн газарт шинэ санаа, даацтай шийдвэр, уйгагүй нөр их хөдөлмөр, өндөр стандарт үргэлж мэдрэгддэг. Түүнийг Монголын бизнесийн ертөнцөд шударга өрсөлдөөний зөв хандлага, барууны сонгодог бизнесийн дүр төрхийг оруулж ирсэн гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ. М-Си-Эс брэнд шударга өрсөлдөөнийг гаргаж ирсэн бөгөөд түүнтэй өрсөлдөнө гэдэг бусад компанийн хувьд өөрийгөө хөгжүүлэх боломж юм. Харин энэ нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүний өргөн сонголт хийх боломжийг бас бий болгодог. Нөгөөтэйгүүр тэд өөрсдөө бүхнийг хийх зорилт

тавьдаггүй, бусдад бизнесийн боломжуудыг нь тавьж өгч, стандартад нь нийцвэл харилцан ашигтай хамтран ажилладаг тул хамтрагчид нь гар нийлж үйл ажиллагаа явуулахдаа дуртай байдаг.

М-Си-Эс өнөөдрийн амжилтаар үйл ажиллагаагаа хязгаарладаггүй, цаг ямагт урагш давшиж байдаг. Тус компани нийгэмд олон шинэлэг зүйлийг нэвтрүүлж, санаачилж хийж бүтээсэн. Мэргэшсэн өндөр чадавхи, манлайлал, шинэлэг санал санаачлага, компаниа гэсэн өөриймсөг хандлага, үнэнч шударга зарчим, багаар гар нийлж ажиллах чадвар нь яван явсаар компанийн хорь шахам жилийн түүхийн хугацаанд бүрэлдэн бий болж өдөр тутмын үйл ажиллагаанд нь хэвшиж чаджээ. Үнэт зүйлээ дээдлэх нь бий болгосон брэндийнхээ дархлааг хамгаалж, хадгалж чадаж байгаа хэрэг. Нэгдмэл байдлыг оюуны шинэчлэл, үзэл бодлын нягтралаар бий болгох ёстой гэж М-Си-Эс үздэг. Энэ үзэл ч гэсэн тухайн брэндийг бий болгоход хүчтэй нөлөөлж иржээ. М-Си-Эс бол эрүүл саруул, өөдрөг, шинэлэг үзлийн цэнэг хуримтлуулсан залуучууд ажиллахыг хүсч мөрөөддөг компани юм.

М-Си-Эс групп нь уул уурхай, мэдээлэл, харилцаа холбоо, инженеринг дэд бүтэц, боловсрол, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбарт ажиллаж байна. Салбар бүртээ нэр хүндтэй гадаад түншүүдийнхээ хүрээг тэлж тэдэнтэй мөр зэрэгцэн итгэл төгс алхалдаг. Үйл ажиллагааны явцад тасралтгүй төгөлдөржих менежментээр олон компани ажиллаж, олон төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг талст бүхий брэнд М-Си-Эс хэрэглэгчдэд хүчтэй нөлөөлөхийн зэрэгцээ нийгмийн зүгээс ихээхэн дэмжлэг хүлээдэг. Үүний нууц бол хэрэглэгч, үйлчлүүлэгч, түншүүд нь хүлээн зөвшөөрсөн, хүндлэлийг нь хүлээсэн, итгэлийг нь ямагт дааж чаддаг брэндийнх нь мөн чанар юм. М-Си-Эс олон нийтэд таашаагдсан чанартай, шинэ шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг тооцоо судалгааны үндсэн дээр гаргасаар, тэр нь зах зээлд тэргүүлэгч байр сууриа багтай эзэлсээр байна. Үргэлж хөгжлийн хандлага руу чиглэсэн үйл ажиллагааг тууштай явуулж ирсэн М-Си-Эс нь тодорхой хэмжээнд аз туршиж байдаг гэж хэлж болно. Учир нь хэрэглэгчийн нийгмийн ухамсар хэт шинэлэг зүйлийг хүлээж авахад бэлэн бус байдаг явдал бий. Гэхдээ М-Си-Эс манай нөхцөлд эрсдэлтэй байж болох дэлхийн хөгжлийн энэ чиг хандлагаасаа хэзээ ч, ямар ч нөхцөлд буцаж няцаж байгаагүй юм.

Монгол улсын зах зээлийн багтаамж хязгаарлагдмал, нутаг дэвсгэрийн хувьд өргөн уудам энэхүү өвөрмөц байдалд дэлхийн хөгжлийг нутагшуулах амаргүй ажлыг М-Си-Эс групп амжилттай хэрэгжүүлж байна.

### **Амжилтын нууц**

- Оюуны баялгаар амьдрах саналыг нийгэмд тавьж, цаг үеийнхээ манлайлагч байх бодлогыг баримталж ажилласан.
- Дэлхийн шилдэг технологийг Монгол оронд нутагшуулах, Монголыг тэр жишигт хүргэх тал дээр дандаа анхдагч байж шударга өрсөлдөөнийг бий болгож, хэрэглэгчдэд сонголт олгосон.
- Уул уурхай, мэдээлэл, харилцаа холбоо, инженеринг дэд бүтэц, боловсрол, хүнс болон хөнгөн үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө зэрэг эдийн засаг, нийгмийн чухал салбарт

манлайлж, улс орныхоо хэмжээнд шинэлэг, тэргүүлэгч үйл ажиллагаа явуулж байна.

- Менежментийн шинэ дэвшил бүхнийг өөрсдийн арга барилаар баяжуулж, хувь хүний хөгжилд түлхүү анхаарч ирсэн. Багаар ажиллах чадварыг голлож хардаг. Шинэлэг, өвөрмөц давтагдашгүй арга барилаа бусдад хүлээн зөвшөөрүүлж чадсан.

- М-Си-Эс шиг гэсэн бахархлыг бий болгож, залууст эрч хүч, хийж бүтээх урам зориг өгсөн. Бэрхшээлийг давж туулах, сайн ажиллаж сайхан амьдрах, өөрийгөө хөгжүүлэх, манлайлах арга замыг тэдэнд сайтар эзэмшүүлж чаддаг.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.mcs.mn](http://www.mcs.mn)

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 210620 а, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Central Tower 15 давхар

Байгуулагдсан он: 1993 он

Үйл ажиллагааны чиглэл: Уул уурхай, мэдээлэл, харилцаа холбоо, инженеринг дэд бүтэц, боловсрол, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө зэрэг.

# BISHRELT HOLDING

## Шинэчлэлт өөрчлөлтийн брэнд

1994 оны тэр нэгэн өдөр Бишрэлт ББХК-ийг үүсгэн байгуулагчид худалдаа, үйлчилгээний бяцхан компаниа хожим нь үйлчилгээний соёл, зах зээлийн нийгмийн мөн чанар, утга учрыг үйлчлүүлэгчиддээ мэдрүүлж, үйл ажиллагаа болгондоо шинэчлэлт өөрчлөлтийг дагуулсан том брэнд компани болно гэж тесөөлж байгаагүй гэдэг. Шударга өрсөлдөөн, менежментийн оновчтой бодлогыг барьж ажиллан хүний нөөцийг хөгжүүлж, чадавхиа бүрэн ашиглан, шинэ техник технологийг нэвтрүүлсний хүчээр ийм амжилтад хүрчээ. Ингэж нэгдсэн удирдлагатай олон компанийг төрүүлэв.

Бишрэлтийн гэсэн нэр шошготой брэндийг бий болгохын зэрэгцээ дэлхийн стандартад нийцсэн ахуйн хэрэглээний Blue Touch, Blue Kung нэрийн бараа бүтээгдэхүүнийг оруулж ирэв. Брэнд болсон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, оруулж ирээд зогсохгүй хэрэглэгчдэд хүргэх менежментийг хийхгүй бол ажил үр дүнгүй болно. Тиймээс Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт худалдааны гурван шинэ төв нээлээ. Ингэснээр бөөний болон жижиглэнгийн худалдааг нэг дороос хэрэглэгчиддээ хүргэх болжээ. Ийнхүү стандартад нийцсэн, соёлтой, түргэн шуурхай үйлчилгээ бүхий Well-Mart сүлжээний үйл ажил тогтмолжив. Нарны замын дагуух Well-Mart Supercenter-ийг өргөжүүлснээр нэг дороос олон нэр төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулах боломжтой болжээ. Мөн хөргөгчтэй агуулахыг ашиглалтад оруулснаар мах, сүү, хүнсний ногоо, жимс зэрэг хүнсний аюулгүй байдлыг хангасан үйлчилгээг гаргаж ирэв.

Импорт бол хэн нэгний багтааж ядсан илүүдэл зүйлийг оруулж ирэх явдал биш гэдгийг Бишрэлтийнхэн маш сайн мэддэг. Зарим алдартай брэндүүд ололт амжилтынхаа золиос болж, жаргалдаа ташууран сүйрдэг тохиолдол ч бий. Тиймээс амжилт ганцхан гарцтай байх ёсгүй гэж Бишрэлт Холдинг үздэг байна. Иймээс импорт төдийгүй экспортыг ч сайн хийдэг. Уламжлалт зэс, ноолууран бүтээгдэхүүний хажуугаар экспортын мах, махан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж чадсан нь бас нэг амжилт байлаа. Бишрэлт Холдингийн салбар компани Мах Экспо нь шинэ техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэлээ өргөжүүлэн, борлуулалтаа нэмж, Монголын махны нэр хүндийг дэлхийн зах зээлд өргөн сурталчилж байна. Тус компани 2008 онд л гэхэд 500 тонн махыг ОХУ-д, 28 тонн бордсон адууны махыг туршилтын журмаар Японд экспортлосон аж.

Мөн банш бууз болон хоногт 500-1000 кг хиам үйлдвэрлэх хүчин чадалтай цехүүдийг ашиглалтад оруулж Зочин, Өег, Монгол салями, Улаанбаатар, Баянтал зэрэг чанамал, хагас болон бүтэн утлагат хиам зэргийг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна.

Мах экспортлох шинэ гарц гаргаж, БНХАУ-ын мал эмнэлэг, эрүүл ахуйн хяналтын байгууллагаас эрх авав. Мах Экспогийн хиамыг ОХУ-ын хүнсний технологийн мэргэжилтнүүд "... Колбаса для богатых..." (баячуудад зориулсан хиам) гэж тодорхойлсон нь

химийн ямар нэгэн нэмэлт бодис ороогүй, экологийн цэвэр бүтээгдэхүүн болохыг нотолсон, хүлээн зөвшөөрсөн хэрэг. Түүгээр зогсохгүй богийн гэдэс, адуу үхрийн хар гэдсийг зуун хувь боловсруулдаг болсноор экспортын барааныхаа нэр төрлийг нэмжээ. Мөн Капитал банк, Бишрэлт Косметикс, Монголэмимпекс концерн зэрэг компаниуд өөр өөрийн чиглэлдээ шинэчлэлт хийж, нийгмийн хөгжилд зүтгүүрийн үүрэг гүйцэтгэж байна. Бизнес амжилт олохдоо түүний баримталсан гол чиг шугам нь хэрэглэгчдээ зүй зохистой хандах хэлбэрэлтгүй байр суурь баримталж байсан явдал юм. Тийнхүү бизнесээ босгож ирэхдээ өөрийг нь хүндэтгэдэг болохоо хэрэглэгчдэд ойлгуулж чаджээ.

Барилгын салбарт өөрийн орон зайтай болсон Юнико Констракшн ХХК нь дэлхийн стандартад нийцсэн төдийгүй хэрэглэгч, оршин суугчдын хүсэл сонирхол, хэрэгцээг бүрэн хангаж, шинэ технологийн ололт дэвшлийг ашиглан орчин үеийн загвар хийцтэй офис, орон сууцны барилгыг барьж байна. Энэ нь Бишрэлт Холдингоос салбар компаниуддаа оновчтой хөрөнгө оруулалтыг хийж ирсний илрэл юм.

Мөн барилгын салбарт хэрэглэгддэг бүх төрлийн мод, шилэн эдлэлийн бүтээгдэхүүний сонголтод томоохон өөрчлөлт гарч, эрэлт хэрэгцээ өсч, орчин үеийн стандартыг хангасан үйлдвэрлэл, бүтээгдэхүүн шаардлагатай болсныг гярхай ажиглаж мэдэрсэн Бишрэлт Холдинг том санаа дэвшүүлэгчдийн алдаа болсон жижиг зүйлсийг ч үйлдвэрлэж, тэрхүү онгойж үлдсэн орон зайг нөхөж байна. Ингээд зогсохгүй жирийн хэрэглэгч гэр орноо тохижуулахдаа үүднээс хоймор хүртэлх бүхий л засал чимэглэлийн зүйлсийг эндээс авах боломжтой боллоо.

Бишрэлт Холдингийн гурван одтой Бишрэлт Плаза зочид буудал 1996 онд үүд хаалгаа нээжээ. Зан сайтай айлд хүн цугладаг гэдэгчлэн тус буудалд Швейцарь, АНУ, Канад, Япон, Солонгос, Хятад зэрэг орны зочид бууж тухалдаг аж. Зочдынхоо төлбөр тооцоог Голомт, Худалдаа Хөгжлийн банкны Master болон Visa карт, American Express, JCB картаар хийж, хөнгөлөлтийн карт гаргажээ. Энэ нь үйлчлүүлэгчиддээ төлбөр тооцоо хийхэд хүндрэл гаргахгүй, бас тэднийг "байнгын" зочин болгох нэг арга байлаа. Тус буудлын Royal ресторанд зуу гаруй нэр төрлийн халуун хоолоор үйлчилдэг агаад тогооч нар нь Улаанбаатартаа шилдэг нь болохоор таны ширээн дээр ямар зоог тавихаа тэд дэндүү сайн мэддэг.

Харин АНУ-ын Revlon фирмийн гоо сайхны бүтээгдэхүүнийг худалдаалах эрх авч Бишрэлт Косметикс дэлхийд танигдсан Burberry, Versace, Salvatore Ferragamo, Lanvin, Dupont, Bourjois, Moschino, Antonio Banderas зэрэг гоо сайхан, сүрчигний нэр хүнд бүхий брэндийг оруулж ирж, гоо сайхны Beauty Gallery төвийг ашиглалтад оруулснаар үйл ажиллагаагаа эрчимтэй явуулах болов. Охид бүсгүйчүүдийг ингэж өөртөө итгүүлсэн тус компани Японы гоо сайхны Shiseido брэндийг оруулж ирэн жил бүрийн Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар Японы гоо сайханч, худалдааны зөвлөхүүдийг урьж зөвлөгөө, сургалт явуулан нүүр будалтын үзүүлбэр хийдэг. Ийм ажлыг орон нутагт ч хүргэж Дархан, Эрдэнэт зэрэг хотод гэрээт борлуулагч ажиллуулах болжээ. Мөн загварын чиг хандлагыг тодорхойлогч Италийн United Colors of Benetton-ы албан ёсны дистрибьютер болсноор ямар ч нас, хүйсний хүмүүст зориулсан бэлэн хувцсыг оруулж ирэн моод Монголоор дуусдаг гэсэн хэвшмэл ойлголтыг үгүйсгэж чадав.

Дэлхийд алдартай брэнд бүтээгдэхүүнийг Монголын хэрэглэгчдэд хүргэх явцдаа



Европын томоохон ноён оргилын нэрээр нэрлэгдсэн Германы алдарт брэнд Montblanc-ийн Монгол дахь албан ёсны борлуулагч болжээ. Ингэснээр хэрэглэгчиддээ 2010 оны Montblanc-ийн шинэ загварын цаг болох Nicolas Rieusses, 2010 онд дөнгөж гарч ирсэн шинэ загварын үзэг John Lennon-ыг оруулж ирж танилцуулсан билээ. Үйлдвэрлэсэн болон импортлосон бүтээгдэхүүнээрээ бус тавьсан зорилгоороо бахархах нь брэнд бүтээгчийн онцлог гэдэг.

Аялал жуулчлал Монголд хүчтэй хөгжиж байгаад оролцох явдлыг эрхэм зорилгоо болгосон Мондискавери Туре ХХК нь Франц, Швейцарь, Бельги, Итали, Холланд, Финланд, Дани, Австри, Япон, БНХАУ, БНСУ, Сингапур, Тайланд, Австрали, АНУ-ын 60 гаруй компанитай хамтран ажиллаж гадаадын 18 мянга гаруй, дотоодын 2500 орчим хүнд үйлчилжээ.

Бусдын өмнөөс сайн дураараа хариуцлага хүлээх нь Бишрэлт Холдинг компанийн нэг имиж юм. Улс орон санхүү, эдийн засгийн хямралд өртөж, хөрөнгө оруулалт, ажлын байр багассан үед ч эднийхэн ажилгүйдэл, ядуурлын эсрэг санаачлагатай ажиллаж, шинээр зуу гаруй хүнийг сургалтад хамруулж ажлын байраар хангав. Мөн боловсролыг дэмжин Ууган сургууль гэдэг ТББ-ыг байгуулж нийслэлийн гуравдугаар сургуульд найман сая төгрөг хандивлаж, Ахмадын өдөр, Цагаан сараар 500 өндөр настанд бэлэг гардуулдаг уламжлал тогтоож, Сонгинохайрхан дүүргийн Өнөр хороололд ус түгээх гурван цэг ашиглалтад оруулж, авто болон явган хүний зам засчээ.

Эдгээрээс гадна импортын шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан БНСУ-д үйлдвэрлэгддэг OKF брэндийн эрүүл мэндийн ундааны борлуулалтыг дэмжин "Солонгос улсад аялцгаая" сугалаат худалдааг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг аж.

Бишрэлт Холдинг ганцхан импорт, экспортыг шүтэж үйл ажиллагаа явуулдаггүй. Сүлжээ дэлгүүрээрээ дотоодын үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулж, 1300 орчим харилцагчтай болсноос мянга гаруй нь жижиг бизнес эрхлэгчид байдаг. Ингэж бусдыг дэмжиж ажилласнаараа аварга том үйл ажиллагааныхаа хөдөлгүүрийг улам эрч хүчтэй болгодог байна. Үүний нэгээхэн жишээ бол Капитал банкнаас зөвхөн 2009 онд 40 гаруй тэрбум төгрөгийн зээлийг 25 мянган бичил бизнес эрхлэгчдэд олгосон явдал юм. Мөн аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг болон гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хот, хөдөөгийн 50 гаруй компани, хувь хүнтэй хамтардаг аж.

Бишрэлт Холдинг компани цаг үеэ маш сайн мэдэрч маркетингийн стратегиэ боловсруулж иржээ. Тэдний оруулж ирсэн бараа бүтээгдэхүүн зах зээл дээр хамгийн хямд үнэ, чанарын баталгааг бий болгох зорилготой. Тухайлбал, угаалгын хэрэглэл нь гэхэд зах зээлд хамгийн хямд байгаагаараа хэрэглэгчийн таашаалыг хүлээдэг бол Италийн Luxootusa фирмийн нүдний шил нарны хэт ягаан туяанаас 100 хувь хамгаалдгаараа алдартай билээ. Бишрэлт Холдинг ажилтнуудаа сургаж, хөгжүүлэхэд түлхүү анхаардаг. Үүнийг компаниа хөгжихөд ихээхэн ач холбогдолтой гэж үздэг. Хүний хүчин зүйлийг илүүд үзэж, түүнийгээ маркетингийн шинэ технологиор бататгасан бөөний болон жижиглэнгийн худалдааны алдарт брэнд WalMart-ын зарим шинж тэмдэг Бишрэлт Холдингоос үе үе цухалзах шиг санагдана.

**Амжилтын нууц**

- Импортыг маш өргөн сонголттой хийж, хэрэглэгч бүртээ хүргэх зорилго нь компанийн үйл ажиллагааг тодорхойлогч юм.
- Олон талт үйл ажиллагаа. Бизнесийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж, тэдгээрийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажиллагсдынхаа хөгжиж боловсрох тал дээр илүүтэй анхаардаг. Энэ чиглэлээр байнгын сургалт явуулж, гадаад орнуудаас мэргэжилтэн урьж ажиллуулдаг.
- Салбар компани болгондоо орчин үеийн технологи нэвтрүүлж, шинэчлэлт өөрчлөлтийг брэндийнхээ имиж болгож чадсан.
- Нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, олон нийтийн дунд хандивын болон урамшуулалт худалдаа, амьдрах орчных нь тав тухтай байдалд нөлөөлсөн олон үйл ажиллагаа явуулдаг.
- Өөрөө аварга том бүтэцтэй болоод зогсохгүй хот хөдөөд үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажилладаг. Энэ нь Бишрэлт Холдингийн нийгмийн цар хүрээг улам тодотгож өгдөг.
- Бөөний болон жижиглэнгийн худалдааг зэрэг явуулах боломжтой сүлжээ дэлгүүрүүд нь тус компанийн нэр хүндийг өргөж, хэрэглэгч үйлчлүүлэгчдийг ихээр татах болжээ.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.bishreлт.mn](http://www.bishreлт.mn) Байгуулагдсан он: 1994 он

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж-43

Үйл ажиллагааны чиглэл: Худалдаа үйлчилгээ, махны үйлдвэрлэл, банк санхүү, гоо сайхан, аялал жуулчлал, барилга, эмийн худалдаа, үйлдвэрлэл



## Гэр бүлийн дүр төрхтэй брэнд

Үйлчлүүлэгчийг зочинд өргөмжилсөн Номин Холдинг компани 1992 оны Улсын наадмын эхний өдөр Номин-5 ХЭАА нэртэй байгуулагдсан түүхтэй. Учир ерөөл, бэлгэ дэмбэрэлд дуртай монгол хүний ёсоор Ш.Баярсайхан энэ өдөр аж ахуйн нэгжийнхээ нэрийг сонгосон гэдэг.

Мэндлээд хэдхэн сар болж буй хүү Номин-Эрдэнийнхээ нэрний эхний Номин дээр халуун ам бүлийнхээ тоог нэмж ийнхүү нэрлэжээ. Тэр анхнаасаа л бизнесээ гэр бүл гэж харан, тийм дүр төрхөөр бодож, зүтгэж эхэлсэн байдаг. Бизнес дүр төрх л байхад бусад нь яахав гэсэн үг бий. Гэр бүлийнхээ үйл ажиллагааг брэнд болгох ийм зөөлөн, найрсаг дүр төрхийг тэр сонгож аваад 19 жилийг үджээ. Ш.Баярсайхан одоо ч гэсэн компаниа гэр бүл мэт харж сэтгэж явдаг гэхэд хилсдэхгүй. Олон улсад аль хэдийнэ нэрд гарч, улс орныхоо хэмжээнд бүхэл бүтэн сүлжээ бий болгосон аварга биетийг санагдуулам, тив алгассан энэ компанийг гэр бүл гэсэн дүр төрхөөр төсөөлөхөд зарим хүн гайхаж, сэтгэлд нь буухгүй мэт боловч тэд үнэндээ үүнийг хийж чадсан нь гайхамшигтай. Энгийн зүйл агуу байдаг.

Дэлхий ертөнц бол бидний гэр бүл гэхэд хэн ч дургүйцдэггүй. Ийм бодолтой хүн Номин Холдингийн гэр бүлийн дүр төрхөд эргэлзэх гэж үү? Эндээс ургуулж бодвол Номин Холдинг улам зөв сэтгэж, улам холыг харж байгаа гэлтэй. Тэднийх өнөөдөр худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 3200 гаруй ажилтан бүхий 20 орчим компанийг өөртөө нэгтгэсэн нүсэр бүтэцтэй ч бүхнийг залгигч мангас шиг харагддаггүй. Хамгийн гол нь эелдэг зантай, эгэлхэн дүр төрх нь хэрэглэгчээ айлгахгүй байж чаддаг.

Дүр төрхөө илэрхийлсэн мэт худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлж байгаа нь ч сонирхол төрүүлдэг. Энэ нь зорьсон замаасаа хазайх юм уу өөр машинд суугаад нөгөө тийшээ давхичихаагүйг нь харуулна. Хэн ч гэсэн өнөөдөр гэртээ ороод хаашаа ч харсан Номингийн бараа бүтээгдэхүүн дүүрэн байгааг анзаардаг. Энэ бас л Номин Холдингийн бизнесийн нүүр царай, гэр бүлсэг дүр төрхийнх нь илрэл юм. Бөөний болон жижиглэн худалдааны дэлгүүрүүдийн Номин сүлжээ нь хэрэглэгчдийн дунд асар их амжилт олж Монголын зах зээлд импортын барааны агуулах болж хувирахад хүрэв.

Ийм аварга үйлчилгээгээрээ 2010 онд л гэхэд улсын төсвийн 0.52 хувьтай тэнцэх татвар төлсөн нь дөчин сумын жилийн төсөвтэй тэнцэх аж. Үүнийг өөр талаас харвал 2010 оны ДНБ-ийн 2.4 хувьтай тэнцэх борлуулалт бөгөөд хувийн секторын ажил эрхлэлтийн таван хувь нь гэсэн үг юм. Номингийнхон үйлчлүүлэгчээ "Зочин" хэмээн хүндэтгэн үздэг. Энэ компанийн ажилтнууд монголчуудыг хэрэгтэй бараа бүтээгдэхүүнээр нь хангаад зогсохгүй харилцааны соёл зэргээрээ баярлуулдаг. Асар том дэлгүүрт орсон үйлчлүүлэгч өөртэй нь хэн ч дуугарахгүй, тоож харахгүй бол төдөлгүй гарч зугтахаас өөр замгүй болно. Номин

үйлчлүүлэгч бүртээ хүрч, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч сонголт хийхэд нь тусалдаг. Энэ бол тэдний худалдаа, үйлчилгээндээ анхлан нэвтрүүлсэн стратеги. Номингийн туслагчдад итгэж болно гэж хэрэглэгчид үзэх болжээ. Ингэж дэлхийн болон эх орны шилдэг брэндийн борлуулалт Номингоор дамжин явагддаг.

Эдний дэлгүүрүүд бусад ижил төстэй газраас хамаагүй том. Ийм болохоор бөөний болон урамшуулалт худалдаа явуулахад тохиромжтой байдаг. Бөөний худалдааг тогтмол хийх нь барааны үнийг өдөр бүр хямд, бусад дэлгүүрийг өөрөөсөө ганц ч цаг хямд байлгахгүй тийм "хэцүү" байдалд оруулдаг. Тэд өөрийн маркетингийн стратегийг тун өвөрмөц байдлаар хийж иржээ.

Номингийн хэрэглэгчдээ өгдөг таван баталгаа бол үүний нэг жишээ. Худалдан авсан бараа нь бусад дэлгүүрт хямд байгааг 72 цагийн дотор мэдэгдсэн эхний үйлчлүүлэгчид үнийн зөрүүг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц мөнгийг буцаан олгодог.

Хямд үнийн давхар баталгаа. Худалдан авахыг хүссэн бараа нь өөр газар хямд байгааг мэдэгдэхэд барааны үнийг мөнөөх өрсөлдөгчийнхөө хамгийн бага хямдралаас гурван хувь бага байхаар бууруулна.

Карт эзэмшигчийн бонусын урамшуулал. Сүүлийн гурван жилд хийсэн худалдан авалтын дүнгээс хамаарч 10 хүртэл хувьтай тэнцэхүйц бонусыг жижиглэнгийн үнээр авсан бараанд тооцон картаар үйлчлүүлэгчид олгоно.

Үйлчлүүлэгчийн худалдан авсан бараа сэтгэлд нь нийцэхгүй бол 72 цагийн дотор дуртай бараагаар нь буцаан сольж өгдөг. Мөн эзлэхүүн нь 0.8 м3 бөгөөд 200 мянган төгрөгөөр дээш үнэтэй барааг хот дотор үнэгүй хүргэж өгдөг билээ.

Ингэснээр Номингоор үйлчлүүлэгчдийн ТОО ч өсч, бөөнөөр худалдаалах бараа бүтээгдэхүүн нь ч олширч байна. Эднийх хэрэглэгчдээ очих, хамтрах, дуудах гээд найз нөхрийн журмаар хандаж ирсэн. Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт өөрийн найман супермаркет, гурван хайпермаркет, хоёр их дэлгүүр, агуулах худалдааны төв болон Улаанбаатар хивсний байранд байрлах шинэхэн бөөний төв, Дархан, Эрдэнэт, Хөвсгөл, Дорнод аймагт өөрийн салбар худалдааны төв, 18 аймагт даатгалын салбартайгаас гадна Монгол улсын бүх аймаг, сумдад явуулын худалдаагаар хүрч очдог нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа нь түгэж хэрэглэгчиддээ ойр ажилладагийн жишээ юм.

Үүнийг худалдагч болон худалдан авагчийг үргэлж хамт байлгах маркетингийн стратеги боловсруулан хэрэгжүүлж байна гэж хэлж болно. Юу гэвэл үйлчлүүлэгч буюу зочноо нэгэн жигд хувцастай тосч, хүндлэл үзүүлж, үүдээ нээж өгөх зэргээр угтана. Үйлчлүүлэгчээ тэд манайд заавал айлчлах ёстой эрхэм хүн гэж үздэг. 313232 гэсэн дугаарыг мэдэхгүй хүн ховор байх. Энэ бол Номингийн Хэрэглэгчийн үйлчилгээний төвийн утас. Үүгээр тэд хэрэглэгчээ байнга сонсч, ярьж, зөвлөж, тухай бүрт асуудлыг шийдэх, эсвэл шийдвэрлэж чадах албан тушаалтантай ямар ч хүнд сурталгүй холбож өгдөг. Өөрийнхөө хэрэглэгчийн юу бодож хүсч байгааг мэдэхгүй байна гэдэг залуургүй хөлөг онгоцоор их далайд хөвж яваатай адил.

Тиймээс худалдааны төвүүддээ саналын хайрцаг ажиллуулж долоон хоног тутамд тэр нь нэгтгэгдэн удирдлагын гар дээр очно. Эндээс үндэслэн дараачийн маркетингийн стратеги боловсрогддог аж.

Реклам сурталчилгаа гэдэг аливааг магтах хэрэгсэл бус үйлчилгээ, бүтээгдэхүүнээ үнэн зөв таниулан тайлбарлах явдал билээ. Харин ямар аргаар вэ гэдэг л тухайн компанийн шийдэх асуудал. Энэ алтан дүрмийг Номин чанд хатуу баримталж ирсэн. Арван жилийн турш өглөө бүр Номингийн цаг нэвтрүүлэг үндэсний радиогоор явж хэрэглэгчиддээ шинэ үйл ажиллагаа, худалдаа урамшуулал, мэдээ мэдээллийг хүргэж иржээ. Мөн хэрэглээний боловсрол хэрэглэгчдэдээ олгох нэвтрүүлгийг Боловсрол телевизтэй хамтран хийдэг боллоо. Энэ нь аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг арилжааны талаас нь сурталчлах бус жинхэнэ хэрэглээ талаас нь танин мэдүүлснээрээ хүнийг татаж чангааж чадаж байгаа хэрэг юм.

Тухайлбал, Номин Косметиксийн оруулж ирдэг DUNI брэндийн лааны талаар юу гэж өгүүлдэг вэ гэхээр бүтээгдэхүүнийг гоёчлон магтахгүйгээр орчин үеийн лаа хэрэглээний чиг хандлага, түүнийг хэзээ яаж хэрэглэвэл зохилтой хийгээд үүнтэй холбоотой сонирхолтой мэдээ мэдээллийг өгдөг байна.

Ийнхүү хэрэглэгчээ сэрээж сэнхрүүлж ажилласнаар сар тутам дунджаар зургаан зуу гаруй мянган худалдан авагч, хэрэглэгч нарт үйлчилгээгээ хүргэдэг нь Монголын айл өрх бүр Номингоор овоглосон байгууллагуудаар үйлчлүүлдэг гэсэн үг. Номин брэнд үүсэн байгуулагдсанаас хойшхи хориод жилд бизнесийн хүрээгээ улам өргөжүүлэн тэлж импортын чиглэлээр Номин Электроникс, Номин Фүүдс, Номин Фэйшн, Номин Хоум Стайл, Номин Стандарт, Номин Моторс, Номин Косметикс, худалдаа үйлчилгээний чиглэлээр Улсын Их Дэлгүүр, Номин их дэлгүүр, Хайпермаркет болон Супермаркетийн сүлжээ, Бөөний болон Агуулах худалдаа, Улаанбаатар Импекс, үйлдвэрлэлийн чиглэлээр Эрдэнэт Хивс, Номин Констракшн, Улаанбаатар хивс, электрон барааны Монел үйлдвэр, санхүү, хөрөнгийн зуучлалын чиглэлээр Номин Даатгал, Номин Юнион ХЗХ, Номин Картс, Номин Зууч болон аялал жуулчлал, зочид буудлын чиглэлээр Хөвсгөл усан зам, Номин тэнгэр цогцолбор зэрэг олон чиглэлээр салбар, салбартаа тэргүүлэн ажиллаж байна.

Номингийн эдгээр салбарууд дэлхийд алдартай 2500 гаруй брэндийн албан ёсны онцгой эрхт төлөөлөгч болж дэлхийн жишигтэй хөл нийлүүлэн алхах боломжийг Монголын хэрэглэгчдэд олгодог юм. Номин гэсэн итгэлт нэрийн дор жагсагчдын нэг болох Номин даатгал нь 2001 оны сүүлчээр байгуулагдан богино хугацаанд даатгалын зах зээлд тэргүүлэгчдийн нэг болов. Энэхүү амжилт бол хэрэглэгчид нь Номинд итгэлтэйгээс итгэлтэй ханддагийн нэгэн жишээ юм. Улмаар тэдэнд санаснаас нь хол давсан бүтээгдэхүүн, үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэхээр зорьж буй.

Харин Номин Констракшн нь 1997 онд "Барилга анги" нэртэйгээр тус компанийн харьяа нэгжүүдийн барилгын урсгал засварыг хийхээр байгуулагдсан бөгөөд бас л өргөжин тэлж Номин Констракшн ХХК болж 2010 онд "Өнөр хотхон" нэгдүгээр ээлжийн 250 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгуудыг барьж тэр ондоо "Golden Tower" шилдэг барилгын шагнал хүртсэн юм.

Ийнхүү эгэл жирийн замналаар бизнесээ эхэлсэн Номингийнхон зорилго, тэмүүлэл,

зүтгэлийг уриа болгон дээдэлж, дэлхийн хэмжээнд сэтгэж, мэлхийн хэмжээний ч алдаа гаргахгүй гэсэн зорилготой явна.

## **Амжилтын нууц**

- Хэрэглэгчийг зочин гэж үздэг. Харин бусад худалдаа, үйлчилгээний газрууд "хаан" гэж үздэг ч тэрхүү хаанаа хүндэлдэггүй талтай. Тиймээс Номингийн энэ хандлага нь бусдаасаа ялгарч хэрэглэгчийн эгдүүг хүргэсэн хааны худал "титэм"-ийг үгүйсгэдэг. Энэ имиж нь хэрэглэгчдээ үнэнчээр ханддаг байдлынх нь наад захын жишээ болдог.

- Маркетингийн стратеги дахь хүний хүчин зүйлийг өндөрт тавьдаг. Хэрэглэгчийн өмнө үнэ бичсэн цаас байвал ямар сэтгэгдэл төрөх билээ. Тиймээс зочноо орж ирэхээс аваад угтан авч хүндэтгэн мэндчилж, бараа бүтээгдэхүүнээ сонгож авахад нь тусалж, мэдлэг мэдээллээр хангаж хэрэглэгчид туслах үйл ажиллагааг нэвтрүүлсэн

- Дэлхийн шилдэг 2500 гаруй брэндийн онцгой эрхт төлөөлөгч болж бүтээгдэхүүнийг оруулж ирэн өрсөлдөгчдөөсөө хямд үнээр (энэ нь зарим тохиолдолд бөөний худалдаа шиг санагдах нь бий) худалдаалж, хэрэглэгч үйлчлүүлэгчдийнхээ санал хүсэлтийг байнга судалж, эрэлт хэрэгцээг нь харгалзан үздэг. Энэ нь цахилгаан барааны хэрэгцээг Монгол улсын хэмжээнд хангах зорилготой компанийн хувьд бас нэг стратеги юм. Янз бүрийн хэрэглэгчийн сонголт төрөл бүрийн бараа бүтээгдэхүүнээр хангагдах магадгүй ганц боломжийг Номин олгодог.

- Импортын худалдаанаас гадна Эрдэнэт хивсний экспортын худалдааг явуулдаг. Мөн дотооддоо банк бус санхүүгийн болон даатгал, барилгын салбар, аялал жуулчлалын үйл ажиллагааг амжилттай явуулж, гадаад болон дотооддоо хүчирхэгжиж тив алгассан үйл ажиллагаанд шилжсэн.

- Хямдрал. Дэлгүүрүүд нь асар том бөгөөд улс орны хэмжээнд хэрэглэгчиддээ хүрч очиж тэгснээр компани бараа бүтээгдэхүүнээ хэрэглэгчийн санаанд нийцсэн хямд үнээр борлуулах боломжтой болсон байна.

- Компанийнхаа дүр төрх (имиж)-ийг гэр бүлийн халуун дулаан, ажил хэрэгч, тав тухтай, амьдралыг дээдлэгч байдлаар бүрдүүлж ямар ч хүн Номингүйгээр гэртээ сайхан амьдрахгүй байгааг эелдгээр ойлгуулж чадсан. Хүнд маш энгийн ойлгомжтой замаар хүрч очсон.

## **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.nomin.net](http://www.nomin.net) Байгуулагдсан он: 1992 он

Компанийн хаяг: Энхтайваны Өргөн Чөлөө- 23, УИД, 7-р давхар,

Улаанбаатар - 15172, 210644, Ш.Х - 688, Монгол Улс

Үйл ажиллагааны чиглэл: Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, даатгал, барилга,



## **Дэлхийн шилдэг технологийг импортлогч брэнд**

Юуг ч брэнд болгож болдгийг Моннис Интернэшнл ХХК харуулсан юм. Энэхүү импортлогч брэндийн онцлог нь машин механизм, уул уурхайн тоног төхөөрөмжийг дагнан оруулж ирдэгт оршино. Аливаа брэндэд түүнийг бүтээгчийнх нь зан араншин нэвт шингэсэн байдаг. Моннисын хэмээн овоглогдох болсон Базын Чулуунбаатар бизнестээ тийм ч олон хаалга нээж, өчнөөн төчнөөн туулай хөөхийг хүсдэггүй нэгэн. Ерөөсөө л дэлхийн алдартай брэндүүдийн бүтээгдэхүүнийг Монголдоо оруулж ирсээр буй бизнесийн замнал нь эдүгээ Моннис Интернэшнлийг олны танил болгожээ.

Бусдаас хол ялгарч, хэрэглэгч үйлчлүүлэгчээ төөрөлдүүлэхгүй байх нь брэндийн гол чанар. Энэ чанар Моннис Интернэшнлд хангалттай байгаагаас импортлогч брэндийн орон зайг ийнхүү эзэлж байгаа юм. 1999 онд Nissan Motors компанийнхан дистрибьютер компани шалгаруулахаар Монголд ирэв. Уг шалгаруулалтад Моннис оролцож, Таван Богд болоод бусад компаниудтай шударга өрсөлдөн дистрибьютерийн эрх авчээ. Ингэснээр засварын газар байгуулах, баталгаат



SHIFT\_the way you move



# PATROL Y62

Шинэ үеийн БАРТААТ ЗАМЫН ХААН



**MONNIS**  
МОННИС МОТОРС

Утас: 9911-0014, 9911-3831  
[www.patrol.mn](http://www.patrol.mn)

# LIEBHERR

Ажлын бүтээмжийг зөвхөн LIEBHERR-с



**MONNIS**  
MONNIS INTERNATIONAL

[www.monnis.com](http://www.monnis.com)

засварын хугацааг урамшуулал болгох гээд ажил ундарч эхэлжээ. Энэ нь Моннис Интернэшнл ХХК-ийн хувьд дэлхийн шилдэг технологийг импортлогч болох замын эхлэл байлаа.

Тухайн үед Nissan Motors компани санхүүгийн хямралд орсон байсан бөгөөд одоогийн удирдагч Карлос Гон компанийг хүндрэлтэй байдлаас нь гаргахаар арга саам эрж байв. Чингээд 2001 он гэхэд тус компани ашигтай ажиллаж чадсан юм. Өнөөдрийн байдлаар Моннис компани хурд хүч, тав тух, аюулгүй байдал, загвар төрхөөрөө дэлхийн олон сая хүнийг байлдан дагуулсан 5000 гаруй Nissan брэндийн болон люкс ангиллын Infiniti загварын автомашинуудыг хэрэглэгчиддээ хүргэв. Моннис эхлээд дунд зэргийн хэрэглэгчдээ "унаатай болгох" зорилго тавьжээ. Гэхдээ Nissan-ыг зарим хүн тансаг хэрэглээний машин гэж үздэг нь бэрхшээл дагуулдаг байлаа. "Эксел"-ээр амьсгалсан Монгол улсын тэрхүү бүгчимдсэн сэтгэлгээний цонхыг нээж, "Nissan бол зүгээр л хэрэглээ. Та жолооныхоо ард суу" гэсэн урилгыг хэрэглэгчиддээ хүргэж чадсан нь Моннис Интернэшнлийн амжилтын үндэс болжээ. Харин Infiniti бол өөр л дөө. Үүнийг сонгосон хүмүүс өөрийгөө бусдаас илүү болохыг харуулах гэсэндээ бус техникийн үзүүлэлт, ая тух сайтайг нь бодсон хэрэг гэж ярьдаг.

Тэднийг ингэж ярихад хүргэсэн борлуулалтын менежментийг Моннис л хийж чадсан юм. Гэхдээ ийм стратеги дангаараа хол явахгүй гэдэг нь тодорхой байсан болохоор сүүлдээ

уул уурхай, зам, барилгын хүнд механизм, машин техник рүү хандах болов. Энэ нь улс оронд өрнөж байгаа уул уурхай, зам, барилга зэрэг бодит бүтээн байгуулалтын хөгжлийг соргоогоор харж гаргасан шийдвэр аж. Бизнес зорилт бүхэн шинийг олж харсан мэдрэмжээр хөглөгдөж амжилтад хүрдэг.

Моннис Интернэшнл ХХК-ийн Уул уурхайн тоног төхөөрөмжийн газар нь 2002 онд Liebherr брэндийн албан ёсны дистрибьютер болов. Liebherr бол дэлхийн хамгийн алдартай брэндийн нэг бөгөөд 1949 онд Швейцарь улсад анх байгуулагджээ. Одоо Германы шилдэг 100 брэндийн 53-т бичигддэг аж. Үндэслэн байгуулагч нь Ханс Либхэрт байсан агаад өдгөө түүний гэр бүлийн гишүүд болох Вилли Либхэрт болон Изольда Либхэрт нар группыг үргэлжлүүлэн удирдаж байна.

Liebherr брэнд бүх төрлийн өргөгч кран, хүнд даацын машин, машин механизм, онгоцны эд анги, хөргөгч зэргийг уул уурхай, барилга, аж ахуйн салбарт нийлүүлдэг. Тиймээс Моннис 300 гаруй техник оруулж ирэн томоохон уул уурхайн компаниудад нийлүүлээд байна. Импортлогч компанийн онцлог бол аль ч талдаа найдвартай, итгэлтэй үйл ажиллагаа явуулах явдал. Хэрэглэгчийнхээ сонгох учиртай тэр л зүйлийг авчрах ёстой. Эс бөгөөс хоёр талаасаа галд шаруулж нүүрс болтлоо шатна гэсэн үг. Liebherr-ийн техникүүд ажлын бүтээмжийн хувьд маш өндөр үзүүлэлттэй, түлш зарцуулалт болон ашиглалтын зардал бага, эдийн засгийн талаасаа ч өндөр ач холбогдолтой бүтээгдэхүүн юм. Мөн ажиллах тав тухтай нөхцлөөр бүрэн хангасан, ялангуяа манай орны нөхцөлд хамгийн тохиромжтой техникүүдийг зөвхөн тэнд үйлдвэрлэдэг аж.

Моннисын сонгож хэрэглэгчиддээ хүргэдэг бас нэг брэнд болох Тегех корпораци нь хэрэглэгчдийнхээ одоо болон ирээдүйн хэрэгцээг хангахаар бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг өргөжүүлж, чанар, үзүүлэлтэд онцгой анхаарал тавьж ажиллахын зэрэгцээ компанийнхаа тоог нэмэгдүүлж, Тегех-ийн чанарыг түгээхийн төлөө эрчимтэй ажиллаж байна. Ийм зорилго өвөрлөсөн компанитай Моннис 2007 онд гэрээ байгуулж албан ёсны дистрибьютерээр ажиллаж эхэлжээ. Тус компанийн ачааны аварга машинууд TR ЮОС-ээс зургаа, МТ4400-өөс долоог оруулж ирсэн нь цаашдаа эрэлттэй болох нь мэдрэгдэв.

Чингээд тэдний ажил зогссонгүй. Харин ч улам өргөжиж LeTourneau Technologies, Inc компанитай холбоо тогтоов. Тус компани нь 1923 онд АНУ-д байгуулагдсан бөгөөд өндөр бүтээмж бүхий хуурай газрын болон задгай тэнгист зориулагдсан газрын тосны өрөмдөгч, ойн аж ахуй, уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэдэг. LeTourneau нь ялангуяа уул уурхайн салбарт зориулагдсан хамгийн олон сонголт бүхий төрөл бүрийн хүчин чадал, хэмжээтэй аварга том дугуйт ачигч болон бульдозерыг үйлдвэрлэдэг.

Моннис компани 2007 оноос хойш эдгээр дугуйт ачигчийг Монголын уул уурхайн компаниудад борлуулж байна. Уул уурхай хөгжихийн хэрээр улс орны амьдрал сэргэн мандах нь тодорхой. Бас зам дагаад хөгжил гэдэг үг ч бий. Тиймээс авто зам тавих ажил ундарч л таарна. Тэдний дараачийн сонголт бол Bomag компани байлаа.

Авто зам тавих, засварлах техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэлээрээ дэлхийн зах зээлд тэргүүлэгч Bomag компанийн техник, тоног төхөөрөмжүүд газар шорооны ажил болон бүх төрлийн замын ажилд зориулагдсан байдаг. Моннисын энэ сонголт ч бусдаасаа дутахгүй

хэрэглэгчээ татаж байгаа юм. Bomag-ийн шинэ шийдэл бүхий орчин үеийн технологиуд, чанартай, аюулгүй байдал, өндөр хүчин чадал, урт хугацааны хэрэглээ, зардал багатай зэргээрээ дэд бүтэц, авто зам, галт тэрэг, онгоцны замыг барьж байгуулах гээд Монгол шиг хөгжлийн гараан дээр байгаа орны хувьд чухал хэрэглээ юм.

Bomag-ийн бүх төрлийн бүтээгдэхүүн 2006 оноос Монголын зах зээлд орж ирэв. Мөн 2008 оноос хойш Kawasaki компанийн дугуйт ачигчтай хэрэглэгчээ танилцуулж эхлэв. Kawasaki брэндийн хувьд: 13 загварын, бүх төрлийн хэрэглээнд зориулагдсан, 96-720 морины хүчин чадалтай, Cummins болон Isuzu дизель хөдөлгүүрээр тоноглогдсон, Z-холбоот загварын хурд хүчтэй, өндөр бүтээмжтэй, шанаганы хэмжээ нь 1.8-13 куб ярдын хэмжээний сонголттой, тохилог, аюулгүй, найдвартай байдлыг хангасан бүхээгтэй, сэлбэг болон засвар үйлчилгээг үзүүлэх дистрибьютерийн өргөн тархалттай аж.

Харин Striker бол уул уурхайн буталгааны тоног төхөөрөмж үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч Австралийн компани юм. Striker-ийн бүтээгдэхүүнүүд нь аварга тээрэм шиг учраас уул уурхай өндөр хөгжсөн Австрали, Чили, Бразил, Канад зэрэг оронд өргөнөөр ашиглагддаг юм. Striker нь мобайл (хөдөлгөөнт) бутлагч механизмын иж бүрдэл болох конус хэлбэрийн хацарт болон босоо бутлагч зэргийг шигшигч, дамжлагын замын хамт үйлдвэрлэдэг. Striker-ийн том оврын машин механизмууд нь ганцхан цагийн дотор 500 тонн чулууг "гурил" болгочихдог аж.

Харилцагчаа хүндэтгэсэн дээд зэргийн харилцаа болон борлуулалтын дараахь засвар үйлчилгээ зэрэг нь Striker-ийн цаашдын бизнесийн чадамжийг тодорхойлогч гол хүчин зүйл нь болдог. Striker-ийн гол үйлдвэр Малайзид байрлаж буй нь Монголын харилцагчдад давуу тал болдог бөгөөд Моннис компани дистрибьютер болсноор Монголын уул уурхайн салбарт шинэ хөгжлийг авчирч байна.

Тэднийхэн дэлхийн номер нэг дугуйг ч мөн Монголдоо оруулж ирэхээ мартсангүй. Goodyear нь Хойд Америк болон Латин Америкийн номер нэг, Европт хоёрт орох томоохон дугуй үйлдвэрлэгч. 1898 онд Хойд Америкт мэндэлсэн тус компани нь бүтээгдэхүүнийхээ цар хүрээг нэмэгдүүлж бүх төрлийн машин, онгоцны дугуй үйлдвэрлэдэг юм.

Одоогоор Goodyear нь дэлхийн 23 оронд 57 үйлдвэртэй, 69 мянган ажилтантай бөгөөд тухайн брэндийн дугуйнууд дэлхийн олон сая хэрэглэгчдийг чанар, хийцээрээ байлдан дагуулсаар байна. 2009 онд Goodyear компанийн борлуулалт 16.3 тэрбум долларт хүрчээ. Моннис Интернэшнл компани нь 2004 оноос хойш Goodyear-ийн төрөл бүрийн дугуйг Монголын хэрэглэгчиддээ өргөнөөр нийлүүлж байна.

Дэлхийд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээрээ манлайлагч Cummins-ын дистрибьютер болсноор тэд тухайн брэндийн түлшний систем, удирдлага, агаар тохируулга, шүүлтүүр, цахилгаан үүсгүүр, хөдөлгүүр болон бусад холбогдох техник технологийг ч мөн Монголдоо нэвтрүүлжээ.

Энгийн жижиг хөдөлгүүрт механизмаас 18 дугуйт хүнд даацын ачааны машин, 360 тонны уурхайн аварга эксковатор гээд дэлхий дээрх бараг бүх төрлийн машин механизмуудад Cummins хөдөлгүүр суурилагдсан байдаг. Энэ нь бүх том брэндийн алдааг засварласан тийм

үйл ажиллагаа юм. Ажиллагааныхаа тогтолцоог зөвхөн өөрийнхөө үйлдвэрлэж буй компьютерт л ашиглаж болохуйцаар бүтээх болсон нэгэн компани зөвхөн өөрийнхөө брэндийг боддог нийтлэг алдааны жишээ билээ. Харин Cummins-ийн зарчим үүнээс тэс өөр. Моннисийн хувьд ийм шинж төрхтэй брэндүүдийг импортлох сонирхолтой. Үүний нэг болох Ansul брэнд нь бүх төрлийн гал унтраагч бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна ресторан, автомашин, үйлдвэрийн системд гал унтраагуур суурилуулдаг. Мөн гал мэдрэгч боловсронгуй систем болон хуурай хими, хийн болоод хөөсөн гал унтраагуур үйлдвэрлэдэг аж.

Үүнээс уул уурхайн машин механизмд гал унтраагч суурилуулахдаа механизмын аль нэг хэсэгт гал гарах, утаа мэдрэх төдийд гал унтраагч нь хүний оролцоогүйгээр галыг аюулгүй болгодог юм байна.

Моннисынхон машин механизмд хэрэгтэй бүхнийг оруулж ирэхийг боддог. Тиймдээ ч тэдний ажил урагштай яваа юм. СЪАР-COR-ыг тэд зүгээр ч нэг сонгоогүй гэдэг нь тодорхой. CLARCOR компанийн брэнд болох Baldwin шүүлтүүр нь автомашин болон уул уурхайн хүнд машин механизмын хөдөлгүүрийн шүүлтүүр үйлдвэрлэгч билээ. Анх 1936 онд Ж.А.Балдвини гаргаж ирсэн брэнд өдгөө хамгийн олон загварын машины шүүлтүүр болон тэдгээрийн эд ангийг үйлдвэрлэж байна. Baldwin нь чанартай, тэргүүн зэргийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг эрхэмлэж ажилладаг.

Харин Scania-гийн хувьд анх 1891 онд байгуулагдсан цагаасаа хойш автобус, уул уурхай болон ачаа тээвэрлэлтийн машин механизм, усан онгоцны хөдөлгүүр үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч компаниудын нэг болсон юм. Scania нь дэлхийн 100 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг нийт 34 мянган ажилтантай. Өнгөрсөн хугацаанд нийт нэг сая 400 мянга гаруй хүнд даацын машин болон автобус үйлдвэрлээд байна.

Scania-гийн бүтээгдэхүүнүүд нь сүүлийн жилүүдэд Европ, Латин Америкийн зах зээлд хүч түрэн нэвтэрч байгаа бөгөөд Моннис Интернэшнл ХХК нь 2011 оноос албан ёсны дистрибьютер болж, тус брэндийн уул уурхайн хүнд даацын машиныг Монголын зах зээлд нийлүүлж эхэлжээ.

Олборлолтын дараа боловсруулалт хийхдээ гартаа барих зэвсэг бол Outotec-ийн брэндүүд юм. Үүнийг ч мөн Моннис оруулж ирдэг. Outotec нь ашигт малтмал боловсруулалт, металл хайлуулалтын технологиороо дэлхийд тэргүүлэгч компани билээ. Ашигт малтмал боловсруулалтад зориулж Outotec компани нь бутлагч, металл баяжуулах болон хайлуулах тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэдэг. Ашигт малтмал баяжуулах үйлдвэрийн хамгийн том хэмжээтэй 300 метр куб багтаамжтай танкийг гагцхүү Outotec л үйлдвэрлэсэн гэдэг.

Моннис компани машин механизмаас гадна компьютерийн зах зээлд ч мөн хүчээ үзэх болов. Монниском ХХК нь 2008 оноос микро процессор үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч Intel корпорацийн Монгол дахь албан ёсны дистрибьютер болжээ.

Тус компани Intel корпорацийн бүтээгдэхүүнийг Монголд компьютерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, хувь хүмүүст давхар дамжлагагүйгээр, оригинал, дэвшилтэт цувралуудыг үйлдвэрээс нь шууд, цаг алдалгүй нийлүүлж эхлээд байна.

Тэд Intel® Core™ процессор, Intel® эх хавтан, Intel® серверүүдийг дотоодын зах зээлд нийлүүлж MCS электроникс, Мигма электроникс, Саммит электроникс, Компьютер Ланд, Компьютер маркет зэрэг 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж иржээ.

Моннискомынхон өөрийн харилцагч болох компьютерийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж, 2009 оны байдлаар Монголын компьютерийн зах зээлд микро процессорын хэрэглээний 51%-ийг дангаараа нийлүүлж, Зүүн Өмнөд Азийн орнуудын дунд борлуулалтаараа Сингапурын дараа хоёрдугаарт орсон байна.

Эх орныхоо хөгжил цэцэглэлтэд хэрэг болох зүйлийг Моннис л оруулж ирдэг. Тэрхүү брэндүүд нь бүтээн байгуулалтад зориулагдсан байдаг болохоор үндэсний шилдэг импортлогч (ийм нэр Моннист л тохирно) энэ компанийн бүтээгдэхүүний борлуулалт нөгөө утгаараа улс орны хөгжлийн, бүтээн байгуулалтын нүүр царай болдог билээ.

### **Амжилтын нууц**

- Дагнах чадвар. Юм юм руу үсчин орсон тохиолдол болгон брэнд бий болгох бус амжилттай явж байсан бизнесийг орвонгоор нь эргүүлж орхидог. Моннисын бодлого нь бизнесээ хамгаалж, улс орныхоо хөгжлийн гол салбар болсон зам, барилга, уул уурхайд шинэ технологи нэвтрүүлдгээрээ онцлог шинж болон ач холбогдлоо тодорхойлж чадсан.
- Бусдын сайн зүйлийг хүлээн зөвшөөрөх чадвар. Энэхүү импортлогч брэндийг үүсгэн байгуулагч Б.Чулуунбаатарын зан төрх бол ийм юм. Тийм ч учраас дэлхийн тэргүүлэгч брэндүүдийг "хүлээн зөвшөөрч" Монголын хэрэглэгчдэд өргөн сонголттой хүргэх болсон.
- Итгэл. Моннис Интернэшнлийн оруулж ирсэн бүтээгдэхүүн хэзээ ч завсрын байдаггүй. Олон улсад тарж, үйл ажиллагаагаар чанар нь батлагдсан зүйлс байдаг.
- Уялдаа холбоо. Явцуурлыг арилгасан, нийтлэг гэж болох брэндүүдийг Моннис сонгосноороо брэндүүдийнхээ хоорондын "найрсаг" байдлыг бий болгосон. Тухайлбал, Ap-sul брэнд нь бүх төрлийн гал унтраагч бүтээгдэхүүн юм. Энэ нь галын аюултай тэмцэхэд зориулагдахаас гадна ресторан, автомашин, үйлдвэрийн системд ч гал унтраах зорилгоор суурилуулж болдог билээ.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.monnis.com](http://www.monnis.com) Байгуулагдсан он: 1998 он

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот-14240, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг, 14 давхар

Үйл ажиллагааны чиглэл: Машин техник, уул уурхай, зам, барилгын хүнд механизм, компьютерийн сэлбэг хэрэгслийн импорт



## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД ЦАХИУР ХАГАЛСАН БРЭНДҮҮД



### **Ази, европыг холбосон амьдрал тэтгэгч брэнд**

Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-ээд он ганзагын наймааны "алтан" үе байлаа. Гадаад улс оронд тэр бүр зорчих боломжгүй байсан монголчуудын хувьд ардчиллын буянаар гадаад ертөнцтэй харьцах үүд хаалга нээгдэж улмаар Москва-Бээжингийн хооронд холхих наймаачдын цуваа тасрахгүй өдийг хүрчээ. Үүнийг дагаад хүмүүсийн амьдрал ч дэгжин дээшилж, өдгөө ганзагачид дундаас төрсөн үндэсний хэмжээний бизнесмэнүүдийн амжилтын хуудас тэр л үеэс эхтэй. Энэ бүхнийг гүйцэлдүүлж "Алтан" Москваг алсын Бээжинтэй холбосон гүүр нь Улаанбаатар Төмөр Зам болсон юм. УБТЗ-аар үйлчлүүлж, аялж үзээгүй, ачаа бараагаа тээвэрлүүлж байгаагүй монгол хүн цөөхөн биз ээ. Хүмүүний амьдралыг тэтгэгч энэ их айлыг Монголын томоохон брэнд бүхий байгууллага гэдэгтэй маргах хүн үгүй гэдэг нь ойлгомжтой. Манай улсын бүхий л эдийн засгийн хөгжлийн урьд өмнөх хийгээд ирээдүйн төлөв байдал гагцхүү УБТЗ-ын нуруун дээр л оршин

тогтнож байна. Тиймээс Ази, Европыг холбосон тэр л ган "гүүр" үгүй бол өнөөдрийн энэ амьдралыг, улс орны хөгжлийг төсөөлөхөд бэрх санагдана.

Монгол оронд механикжсан тээврийн төрөл үүсч хөгжсөн түүх бол бүр 1920 оноос эхтэй билээ. Энэ хугацаанд авто тээвэр, усан ба агаарын тээвэр үүсч хөгжих замаа олсон түүхтэй.

Тэгвэл үүнээс бүр өмнө Хаант Оросын үеэс эхлэн Монголын зарим сэхээтнүүд Сибирийн төмөр замын гол шугамаас салаалан Байгаль нуураар дамжин нийслэлдээ хүргэх саналыг 1910, 1911 онуудад тавьж байжээ.

Хаант Орос оронд 1836-1837 онд Петербургээс Хааны тосгон хүртэл 24,37 бээр /26км/ урттай нийтийн ашиглалтын анхны төмөр зам байгуулагдаж байсан бол Монгол оронд үүнээс нэг зуун жилийн дараа буюу 1938 онд Улаанбаатар-Налайхын хооронд 43км, Чойбалсан-Баянтүмэний хооронд 237км урттай анхны төмөр зам тавигдаж, аж үйлдвэр хөгжүүлэх, эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт ихээхэн ач холбогдолтой болов. Тухайлбал, Улаанбаатар-Налайхын нарийн төмөр замаар дөрвөн сая гаруй тн нүүрс тээвэрлэж Улаанбаатар хотын анхны цахилгаан станц, нийслэлийн айл өрх, албан байгууллагуудыг нүүрсээр хангаж байжээ.

Монголын төмөр замын түүхэнд гарсан томоохон үйл явдал бол 1949-1956 онд Сүхбаатар-Упаанбаатар-Замын-Үүдийн чиглэлд 100 км урттай өргөн царигийн төмөр зам байгуулагдсан явдал юм.

Энэ зам тавигдсанаар алс Европыг Төв Азитай 1025 км дөт төмөр замаар холбосон нь зөвхөн Монголд төдийгүй бусад орнуудын хувьд ч асар их ач холбогдолтой болжээ. Манай улсад ийм төмөр зам тавигдаагүй бол Дархан, Эрдэнэт, Шарын гол, Багануур гэх мэт аж үйлдвэрийн томоохон суурин газрууд баригдах боломжгүй байв. Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр замын гол шугамаас салбарласан Дархан-Шарын гол, Салхит-Эрдэнэт, Багахангай-Багануур, Сайншанд-Зүүнбаян зэрэг салаа замууд тавигдсанаар төмөр замын нийт урт 1810 км болж нэмэгдэн түүний дагуу олон арван хот, суурин баригдсанаар үйлдвэрлэх хүчний байршил өргөжин тэлж Монголын төмөр замын дэд бүтэц хөгжсөн түүхтэй. Монголын төмөр замчид жилдээ 14 гаруй сая тн ачаа тээвэрлэж байгаа ба цаашид төмөр замын тээврийн тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 2010 онд УБТЗ-ын хамт олон 3.5 сая зорчигч тээж, 16.8 сая тонн ачаа тээвэрлэж төлөвлөгөөгөө 11.5 хувиар давуулан биелүүлсэн амжилт гаргажээ. Төмөр замын түүхэнд анх удаа жилд 12.7 сая тонн ачаа ачсанаас аравдугаар сард 1.3 сая тонн ачаа ачиж түүхэн амжилт тогтоосон бол мөн анх удаагаа 6800 тн жинтэй, 320 гол бүхий 80 вагонтой галт тэргийг 2010 оны зун найруулж тээвэрлэлт зохион байгуулсан зэрэг олон амжилтыг гаргасан жил болжээ. Дээр нь Монгол Улсын Их Хурал "Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого"-ыг баталж, төмөр замын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсноор улс орны төмөр замын тээврийн цаашдын хөгжлийн шинэ хуудсыг нээж өгөв.

Монголын төмөр замын тээвэрт эдүгээ 16 мянга гаруй хүн ажиллаж байна. УБТЗ нь Монгол улсын түүхэн туршлагатай, өөрийн гэсэн ололт амжилттай томоохон байгууллага болж өдгөө 60 гаруй жилийн туршид манай нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол хүч нь



болон зүтгэж байгаа билээ.

Өнөөдөр УБТЗ нь Монгол улсын ачаа тээврийн 60 гаруй хувь, зорчигч тээврийн 30 гаруй хувийг дангаараа тээвэрлэж байна.

### **Амжилтын нууц**

- Ачаа ба зорчигчдыг их хэмжээгээр тээвэрлэх төмөр замын шугамын тээх, нэвтрүүлэх чадамжийн өндөр боломж, аль ч чиглэлд жилийн турш хэдэн арван сая тн ачаа, зорчигч тээвэрлэх боломжтой

- Цаг уурын нөхцөл, цаг хугацаанаас үл хамааран тээвэрлэлтийг тасралтгүй зохицуулах чадвартай

- Төмөр зам нь ачаа, барааг усан замыг бодвол илүү өндөр хурдаар хүргэх боломжтой байдаг

- Их хэмжээний ачааг дунд ба алс замд ялангуяа замналаар хүргэх үр ашигтай байдал

- Тээврийн бусад төрөлтэй харьцуулахад (хоолойн тээврээс гадна) харьцангуй хямд өртөгтэй

- Хөдөлгөөний аюулгүй байдал өндөр, хүрээлэн байгаа орчинд хүргэх хор хохирол бага

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.mtz.mn](http://www.mtz.mn) Байгуулагдсан он: 1949 он

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Магсаржавын гудамж-2

Үйл ажиллагааны чиглэл: Төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт



  
**AERO MONGOLIA**  
OFFICIAL PARTNER OF  
MONGOLIAN NATIONAL OLYMPIC COMMITTEE



Тийз борлуулах төв:  
"Моннис" цамхаг  
Утас: 976-11-330373  
Факс: 976-11-330374  
И-мэйл: reservation@aeromongolia.mn

[www.aeromongolia.mn](http://www.aeromongolia.mn)



## Агаар тэнгэрт амгалан зорчүүлэгч брэнд

1925 оны тавдугаар сарын 25-ны өдөр Нийслэл хотын Консулын дэнжид Зөвлөлтийн "Ю-13" хэмээх сонотой төсөөтэй онгоц газардлаа. Москва-Улаанбаатар гэсэн чиглэлээр их тайгыг туулж ниссэн аэроплануудыг тосч Ерөнхий сайд Б.Цэрэндорж гэзгээ хийсгэн очиж нисэгчдийг тэвэрч байснаас хойш олон арван жил өнгөрчээ. Энэ өдрийг Монголд нисэх хүчин байгуулагдсан өдөр гэж зүй ёсоор үзэх болжээ. Өнөөдөр дэлхийд хүчирхэг онгоц, хөгжлийн загвараараа гайхуулж буй Австралийн нисэхийн компаниас манай нисэх хүчин яг зургаан насаар дүү юм. Австралийнх шиг агаарын үзүүлбэр үзүүлэх хэмжээнд хөгжиж чадаагүй ч шинэлэг зүйлс нэвтэрч, хуримтлагдсан олон асуудлаа шийдвэрлэж чадаж байна. Тухайн үед "Ю-13"-ын чимээнээр чихээ таглан зугтаж, эргэж харан харан "соёлыг гайхаж" байсан монголчууд өнөөдөр дэлхийгээр нэг хэрэн хэссэн аялагчид болжээ.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, эрс тэс хатуу ширүүн уур амьсгалтай, тээврийн дэд

бүтэц муу хөгжсөн манай оронд алслагдмал нутаг руугаа тухтай, түргэн шуурхай, аюулгүй зорчих хүсэлтэй хүн олон билээ. Бас эртний түүхт Монгол улсыг сонирхон үзэхээр ирж байгаа гадаадын зочин, жуулчдын баталгаатай, тохилог, биед амар тээврийн хэрэгслийн асуудлыг шийдэх нь улс орны нэр хүндтэй ч бас холбогдох зүйл. Энэ асуудлыг шийдэх хүсэл одоогийн Аэромонголиа нисэхийн компанийн үүсгэн байгуулагчдад төржээ. Тухайн үед Агаарын тээвэр улсаас л хариуцдаг зүйл, түүнд хувийн хэвшил хумсын төдий ч хамааралгүй гэсэн бодол олон нийтийн дунд байсаар байсан юм. Энэ бол хэн нэг том даргын чанга дуугаар явах салбар мэт ойлгогдож иржээ. Үүнийг хариуцлага, айдас гэж харж байснаас бус ашиг, бизнес гэж харсан хүн байгаагүй юм.

Хувийн хэвшлийн нисэхийн компанид найдна гэдэг хүн өөрийгөө доош нь хийж пиццаг гэрт хүргэж өгдөг үйлчилгээ шиг болгосон мэт санагдаж мэднэ. Ер нь пиццаг гэрт нь хүргэж өгсөн үйлчилгээний юу нь муу гэж? Тэр үйлчилгээ дэлхийн шилдэг 100 брэндийн нэг болж чадсан.

Нисэхийн түүхэнд төрсөн анхны хувийн Аэромонголиа компани нь 2001 онд байгуулагдаж, жилийн дараа агаарын тээвэр хийх эрхээ авав. Анх орон нутаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ын нийслэл Хөх хот чиглэлийн нислэгийг хийж эхэлжээ. Дараа нь ОХУ-ын Эрхүү хот руу олон улсын шууд нислэгээ эхэлж, удалгүй Тяньжин, Чеонжу руу нислэг хийх болсноор олон улсын чиглэлийнхээ тоог нэмэгдүүлэв. 2007 оны 6-р сард тус компани төдийгүй агаарын тээвэрлэгчдийн хувьд онцгой үйл явдал тохиолджээ. Аэромонголиад Моннис Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалт, менежмент хэрэгжиж, удирдлага менежементийг бүрэн шинэчилснээр санхүүг нэмэгдүүлж ашигтай ажилладаг болгов. Хамгийн гол нь нислэгийн аюулгүй ажиллагааг хангах, боловсон хүчнийхээ мэдлэг чадварыг дээшлүүлэх талд илүү анхаарсан байдаг. Үндэсний шилдэг агаарын тээвэрлэгч Аэромонголиа ХХК-д Монгол улсын хөгжлийн бас нэг гарц болж харагдаж буй Энержи Ресурс болон Айвэнхоу Майнз Монголиа Инк ХХК-ийн захиалгаар Канадын Hard Ariaion аудитын компанийн хяналт шалгалтыг тогтмол хийгддэг. Эндээс өндөр үнэлгээ авч дотооддоо болон олон улсад өндөр зэрэглэлийн нисэхийн компани болохоо Аэромонголиа харуулж байна. Мөн Английн Лойдсын даатгалын биржид гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалыг 250 сая ам.доллараар хийж, зорчигчоо дээдэлж, тэдний аюулгүй байдлыг баталгаажуулдаг дэлхийн шилдэг нисэхийн компаниудын жишигт хүрчээ.

Өнөөдөр Монголд ирж, буцагсдын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. Энэхүү боломжийг тус компани эхнээсээ бодитойгоор мэдэрч, зөв менежмент хийж, олон улсын стандартад нийцсэн ажил, үйлчилгээ явуулснаар олон улсын байгууллагууд, уул уурхайн компаниуд, төрийн болон төрийн бус байгууллагууд, аялал жуулчлалын компаниудын дотно түнш нь болжээ. Түүнчлэн олон нийтэд найдвартай итгэл хүлээсэн агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч болохоо харуулж чадлаа.

Ялангуяа Оюу толгой, Овоот, Таван толгойн чиглэлд нислэгийн давтамжийг нэмэгдүүлж, аялал жуулчлалын компаниудтай хамтран Аэро Тур аяллыг гадаад зах зээлтэйгээ холбож эхэлжээ. Ингэж нэг цэг дээр уулзсан эрх ашиг хэн хэндээ ач тустай байдаг. Үүнийг бизнесийнхээ хүч чадлыг хялбархаан нэмэгдүүлж байгаа менежмент ч гэж болно.

Ямар ч брэнд өөрийн гэсэн онцлог шинж тэмдэг, хэрэглэгчиддээ хүрэх замгүй бол

хөгжиж дэвшиж, зүрх сэтгэлд хоногшиж чадахгүй. Аэромонголиа түгээлтийг онцгойлон анхаардаг.

Тус компанийн орон нутаг болон олон улсын нислэгийн тийзийг онлайнаар олон улсын бүх төрлийн виза картаар, дотоодод ХХБ, Хадгаламж, Хас банкны төлбөрийн картаар төвөггүйхэн худалдан авч болно.

Өнөөдрийн байдлаар Аэромонголиа ХХК олон улсын гурав, орон нутгийн найм, захиалгат гурван чиглэлд хамгийн өндөр давтамжтайгаар тогтмол нислэг үйлдэж байна. Шинэ зууны шинэ торгоны зам болох Улаанбаатар-Ховд-Үрүмчи чиглэлийн тогтмол нислэг Төв Азийн бүс нутгаар дамжин манай улсыг Европын орнуудтай холбох гүүр болжээ. Тэдний үйлчлүүлэгчид зөвхөн Аэромонголиагийн үйл ажиллагааны найдвартайд итгэдэг. Харин ямар хөлгөөр зорчиж байгаагаа хэт найдсандаа ч тэр үү төдийлөн анзаардаггүй. Тэгвэл тус компани Холланд улсад үйлдвэрлэсэн Fokker-50 загварын 50 хүний суудалтай агаарын гурван хөлгөөр зорчигч тээврийн үйлчилгээ явуулж ирлээ.

Fokker-50 агаарын хөлөг нь хөөрөх, буухдаа гүйлтийн урт харьцангуй бага, шороон зурвас дээр бууж хөөрөх боломжтой тул манай орны нөхцөлд бүрэн тохирдог аж. Дуу шуугиан, чичиргээ доргилт багатай уг агаарын хөлөг нь зорчигчдын тав тухыг бүрэн хангадгаас гадна дэлхийд алдартай пүүсийн хөдөлгүүр, хөл анги, нислэгийн автомат удирдлага, хяналт навигацийн цахим системтэй тул орчин үеийн стандартад бүрэн нийцсэн, дэлхийн 42 оронд түгээмэл хэрэглэгдэж байгаа агаарын хөлөг юм.

Тус компани ИНЕГ-ын жил тутмын болон Аюулгүй ажиллагааны хөндлөнгийн аудитын агентлагийн шалгалтад байнга амжилттай үнэлгээ авдаг билээ. Гадаадын олон нэр хүндтэй зочид тус компанийг сонгож VIP зорчигч нь болсоор байна.

Мөн олон орны ЭСЯ өөрийн ажилтнууд болон иргэдээ Аэромонголиа компаниар үйлчлүүлэх нь их болжээ. Өмнө нь тэд Монголд орон нутгийн нислэгээр иргэдээ зорчихыг хязгаарладаг байлаа. Үнэнийг хэлэхэд Монголын орон нутгийн агаарын тээврийг тэд найдваргүй гэж үздэг байв. Хүний эрхийг дээдэлж, өөрийн ажилтнууд хийгээд иргэдийнхээ төлөө анхаарал тавьдаг тэдгээр улс орон, олон улсын байгууллагууд "Гайгүй байх аа" гэсэн байдлаар асуудалд хандахгүй нь тодорхой. Эндээс Аэромонголиа аюулгүй байдлыг хэрхэн хангаж, үйлчлүүлэгчдээ ямар сэтгэгдэл төрүүлдгийг харж болно.

Тус компанийн нисэх бүрэлдэхүүнд Монголын Иргэний агаарын тээврийн салбарт олон жил ажилласан, агаарт 800030000 км/цаг туулсан, Швед улсын Oxford Aviation Academy (ОАА) нислэгийн академид суралцаж мэдлэг чадвараа байнга дээшлүүлдэг дадлага туршлагатай нисгэгчид байдаг.

Бүхээгний ажилтнууд нь ч гэсэн Малайз улсын Malaysia Airlines Academy, БНСУ-ын Asian Airlines Training Center, БНХАУ-ын Air China Training Center сургалтын төвүүдэд авран хамгаалах сургалтанд амжилттай хамрагдаж, Fokker -50 болон Airbus-A320 агаарын хөлөгт ажиллах эрхийг авсан байдаг. Энэ сургалт жил болгон давтагддаг аж.

Компани инженер, техникийн ажилчдынхаа ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх,

багагтах зорилгоор бүх инженер болон ажилчдаа Франц, Малайз, Сингапур улсад мэргэжлийн чиглэлийн сургалтад хамруулж агаарын хөлөг, шугамын техник үйлчилгээ хийх эрхийг авсан байна.

Аэромонголиа бол шинэчлэгч брэнд. 2011 онд томоохон бүтээн байгуулалт болох Ангар байгууламжаа ашиглалтад орууллаа. Энэ байгууламж нь Fokker-50 агаарын гурван хөлөг, Airbus-A320 агаарын нэг хөлгийн багтаамжтай бөгөөд Аэромонголиагийн ажилчдын офисоос бүрдэнэ. Сааль бэлдэхийн өмнө сав бэлддэг. Байгууламжид Airbus-A320 загварын агаарын хөлгийн байрыг урьдчилаад барьчихсан байсан нь учиртай. Тус компани Airbus-A320 агаарын хөлгийг үйлчилгээнд ашиглаж эхэлсэн бөгөөд 150 хүний суудалтай уг агаарын хөлгөөр Тяньжин, Шанхай, Хонконг, Сингапур, Бангкок, Астана, Чезжү, Дэли зэрэг Азийн том хотууд руу нислэг үйлдэхээс гадна Бээжин, Сөүлийн чиглэлд захиалгат нислэг хийж байна.

Мөн олон улсын стандартад нийцсэн, зорчигчдын тав тухыг хангасан үйлчилгээний том оврын аэропорт автобусыг үйлчилгээнд ашиглаж зорчигчдоо үдэх, угтах соёлыг шинэ шатанд гаргав.

Нисэх нэг хэрэг, газарт бууж амьдрал дунд "алхах" өөр хэрэг. Тус компани Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага, Оюуны чадвар хүний хөгжлийн төвтэй хамтран хүүхэд багачуудад ажил мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилгоор Сити Тур аяллыг жил бүр өөрийн компани дээр зохион байгуулдаг.

Бас жил бүрийн Мисс Монголиа тэмцээн, MONGOLIAN MUSIC VIDEO AWARDS хөгжмийн наадмын ивээн тэтгэгч.

Үүгээр зогсохгүй Монгол улс, БНХАУ-ын кино театруудад нэгэн зэрэг нээлтээ хийсэн Монгол Фильм студийн уран бүтээл Аравт хэмээх түүхэн киногоор дамжуулан эх орон, түүх соёл, өвөг дээдсээрээ бахархах үзлийг төлөвшүүлж, нөхөрлөл, эв нэгдэл, багаар ажиллах чадварын үнэ цэнийг мэдрүүлсэн тайз дэлгэцийн уран бүтээлийг мөн ивээн тэтгэж хамтран ажиллажээ.

Лондонгийн олимпод оролцох баг тамирчдаа дэмжих зорилгоор тэд 2012 оныг хүртэл МҮОХороотой албан ёсны Түншлэлийн гэрээг байгуулсан билээ. Тэнгэрээр дүүлэн нисэгч энэхүү даль жигүүртэй компани Монгол улсынхаа нэрийг дэлхийд цуурайтуулахад ийнхүү гар бие оролцож байна.

### **Амжилтын нууц**

- Дэлхийн стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах зорилго тавьсан. Энэ асуудлаа асар богино хугацаанд шийдвэрлэж, аюул осолгүй, хурдан шуурхай, тав тухтай, найрсаг үйлчилгээг бий болгож чадсан.
- Орон нутгийн нислэгийн нэр хүнд өмнө нь уначихсан байсан бол Аэромонголиа сэргээж чадсан. Ингэснээр монголчууд төдийгүй ОУ-ын байгууллага, гадаадын зарим улс орны ЭСЯ өөрийн ажилтнууд болон иргэдээ тус компаниар үйлчлүүлэхийг зөвшөөрсөн.

- Агаарын хөлгийн засвар үйлчилгээ, нислэгийн аюулгүй байдлыг анхаарч, дэлхийн хэмжээний мэргэжилтнүүдийг урьж ажиллуулж арга туршлагаас нь ажилчиддаа сургах боломж олгосон. Нисэгч, инженер техникийн ажилтнуудаа Франц, Малайз, Сингапур зэрэг улс орнуудын сургалтын төвд байнга сургаж ур чадвар, мэдлэгийг нь дээшлүүлдэг.

- Өндөр хөгжилтэй орны техник Монголын нөхцөлд тохирохгүй гэсэн болгоомжлол олны дунд байдгийг үгүйсгэж чадсан. Шороон болон хатуу хучилттай зурваст нислэг үйлдэхэд зориулагдсан төхөөрөмжтэй Fokker-50 монголчуудад морь шиг нь л дотно санагдах болсон.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.aeromongolia.mn](http://www.aeromongolia.mn) Байгуулагдсан он: 2001 он

Компанийн хаяг: Чингис хаан ОУ нисэх буудал, Улаанбаатар-34, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Агаарын тээврийн нислэг, үйлчилгээ



## Холыг ойргүүлэгч холбооны анхдагч брэнд

Хүмүүс өөр хоорондоо харьцахыг хүсч эрмэлзэж ирсэнтэй өнөөгийн харилцаа холбооны салбарын түүх салшгүй холбоотой. Эртний хүмүүс янз бүрийн дуу авиа гаргаж "Энд ан байна, тэндээс аюул заналхийлж эхэллээ" гэх мэтээр хоорондоо холбоо барьж байсан тухай түүх судлаачид бичсэн байдаг. Хожим ямар нэг зүйлээр дохио өгдөг болов. Тухайлбал, "Цогт тайж" кинон дээр л гэхэд уулын орой дахь харуулын цонж дээр гишүү мөчир овоолон ихээхэн хэмжээний угаа май тавьж, дайрах дохио өгч байгаа хэсэг гардаг. Энэ бол нэг ёсондоо "телефон"-оор л харилцаж байсныг тодхон жишээ юм.

Тийм ч учраас МЦХ хувьцаат компанийн нэртэй юу юунаас илүүтэйгээр телефон хэмээх гадаад үг яахын аргагүй холбогддог. Тэгэхээс ч аргагүй. Үндэс суурь, түүхийн эхлэл нь ерөөсөө л энэ үгнээс үүдэлтэй.

Анх телефон хэмээх үг хүн төрөлхтөний чихэнд сонсдож, амьдралд хэрэглэгдэх болсноос хойш 150 жил өнгөрчээ. Өөрөөр хэлбэл, энэ үг 1861 онд англи хэлний үгсийн санд орж ирсэн аж. Уг нь Иоганн Филипп Рэйс гэдэг эр анх телефон аппарат маягийн юм зохиосон байна. Гэсэн хэдий ч түүнийгээ ажиллуулж чадалгүй орхижээ. Гэтэл үүнээс хойш 15 жилийн дараа Александр Грэхем Белл хэмээх нөхөр нөгөө аппаратыг нэлээд боловсронгуй болгож, улмаар патентыг нь өөрийнхөө нэр дээр авсан байдаг. Рэйсийн хувьд үнэхээр азгүй хэрэг боловч бүх хүн төрөлхтөнд аз тохиосон гэж хэлж болно.

Харин монголчууд бие биетэйгээ холбоо барих болсон түүх Өгөдэй хаан морин өртөө байгуулсан үеэс эхтэй хэмээн үздэг. Харин утсан холбооны хувьд зуу гаруй жилийн өмнө бий болсон байдаг. 1898 оноос Оросын Хиагтаас Их хүрээ, дараа нь Улиастай, Ховдын хооронд телеграфын шугам тавигдаж, монгол, орос, хятад хэлээр мэдээ дамжуулж эхэлжээ. Улмаар энэхүү үйлчилгээ хүрээгээ тэлж, Их хүрээ, Чуулалт хаалганы хооронд телеграфын холбоо тавигдаж, одоогийн Хиагт, Улаанбаатар, Чойр, Замын-Үүдэд цахилгаан мэдээний газар байгуулагдсан байдаг.

Их хүрээнд цөөн тооны хэрэглэгчтэй гар ажиллагаатай телефон станц ашиглалтад орж жил ирэх бүр хэрэглэгчийн тоо өсөн нэмэгдсээр байлаа.

Ардын хувьсгал ялахаас нэг жилийн өмнө Их хүрээнд жижиг радио станц суурилуулж, Бээжинтэй холбоо барьдаг болсноор радио холбооны эхлэл тавигдав. Чухамхүү Хүрээг эзэлж, Богдыг баривчилсан Сюй Шүжан генерал ар талтайгаа энэхүү радио холбоогоор харьцаж байсан баримт бий.

Хувьсгалын дараахан Монгол Улсын Түр Засгийн газрын МОНТА агентлаг, мөн Шуудан цахилгаан холбооны ерөнхий газар байгуулагдав. Цэцэн хан аймаг буюу одоогийн



Өндөрхаан, Хүрээний хооронд анхны телефон, телеграфын шугам тавигджээ. Мөн одоогийн Сэлэнгэд 60, Улиастайд 10 цэгийн багтаамж бүхий гар ажиллагаатай станцууд байгуулагдаж жилээс жилд цэгийн тоо нь нэмэгдсээр хожим тусгай яам байгуулах хэмжээнд хүрсэн байна. Холбооны яам байгуулагдсан түүх ийм ажээ.

1928 онд кабелийн анхны сүлжээ байгуулагдсан бол хэдхэн жилийн дараа түүний тоо 2000 хол давж гучин жилийн дараа энэ бүгдийг станцаар солив. Аймгуудын хооронд агаарын шугам тавигдаж, үйлчилгээний төв барилга Улаанбаатар хотноо сүндэрлээд зогсохгүй 1967 онд анхны телевизийн нэвтрүүлэг цацагдав.

Энэ үеэс хойш Монголын цахилгаан холбоо маш эрчимтэй хөгжиж таксофоны үйлчилгээ, хот хоорондын хагас автомат станц зэрэг байгуулагдсанаас гадна бүх сум, сууринг аймгийн төвтэй нь холбов. Мөн ихэнх аймаг аналог системийн радио релейний шугамаар нийслэлтэй холбогдоод байлаа. 1990 онд Холбооны яамыг Холбооны ерөнхий газар болгож өөрчлөн байгуулав. Дараа жил нь Улаанбаатар, Хонконгийн хооронд улс хоорондын цахилгаан холбооны үйлчилгээ явуулах зорилгоор хиймэл дагуулын газрын станц, мөн телевизийн үндэсний нэвтрүүлэг дамжуулах хиймэл дагуулын газрын станц байгуулагдсан зэрэг нь мэдээж цахилгаан холбооны хөгжлийг улам түргэтгэсэн нь тодорхой.

1992 он тус компанийн хувьд алтан үсгээр бичигдэх үйл явдлаар дүүрэн байв. Ингээд л технологийн шинэчлэл шил шилээ даран хөвөрсөн байдаг. E-10 тоон станцыг суурилуулж 1994 он гэхэд энэ станц 11 мянган цэгээр нэмэгдсэн байлаа. Мөн Улаанбаатар хотын станцууд хоорондоо шилэн кабелиар холбогдов.

1994 онд сансрын холбооны Интел сатын газрын станцыг байгууллаа. Улс хоорондын NEAX-61 станц ч ашиглалтад орлоо. 1995 онд Монголын Харилцаа Холбоо компанийг Монголын Холбооны Хөрөнгийн компани, Монголын Цахилгаан Холбоо компани гэсэн хоёр аж ахуйн нэгж болгон салгаж улмаар наймдугаар сард ашиглалтын компанийг нь хувьчлахад Кореа Телеком компани уг компанийн 40 хувийг нь эзэмшихээр болсон юм.

Техник, технологийн хувьд МЦХ ХК өдрөөс өдөрт шинэчлэгдэж, эх орон төдийгүй гадаад талдаа олон арван анд нөхөдтэй болов. Улаанбаатарын телефон станцын багтаамжийг 16 мянган цэгээр нэмэгдүүллээ.

Монголын анхны олон улсын ярианы шууд гарц 001 үйлчилгээг нэвтрүүлсэн энэ хамт олонд "Байнга урагшаа" гэсэн уриа нь хөтлөгч хүч болдог билээ. Тэр нь мэдээж техник, технологийн асар хурдацтай хөгжил дэвшил. Нөгөө талаас хэрэглэгч. Тиймээс энэ их айл E-10 станцаа 4500 гаруй хэрэглэгчийн шугам, процессорынхоо хүчин чадлыг дөрөв дахин нэмэгдүүлж, программ хангамжаа хамгийн сүүлийн үеийн хувилбараар шинэчлэв.

Суурин холбооны дараачийн үе болох NGN-ийг Улаанбаатарын дүүргүүдэд, утасгүй холбооны F-zone үйлчилгээг Улаанбаатар хот, 21 аймаг, зарим сумдад хүргэв. NGN үйлчилгээ нь дүрсээ харж ярих, хэрэглээндээ зохицуулж урьдчилсан төлбөрт карт ашиглах, 33 төрлийн нэмэлт үйлчилгээ авах, улс хоорондод дотоодын үнийн тарифаар ярих зэрэг олон талын боломжтой суурин утасны шинэ үеийн технологи юм. Хэрэв та уламжлалт суурин утасны хэрэглэгч бол NGN үйлчилгээнд үнэ төлбөргүй шилжих боломжтой. Мөн дээр нь NGN

үйлчилгээний хувь хэрэглэгчид амралтын өдрүүдэд сүлжээндээ үнэгүй ярих боломжтой ажээ. 2007 он гэхэд энэ айл Улаанбаатар хотын бүх дүүрэгт нэг цэгийн үйлчилгээний төвүүдтэй болсон байлаа. Мөн утасгүй холбооны F-zone үйлчилгээ нь иргэдэд нэгэн зэрэг мэдээлэл хүргэдэг болов. Мөн ХААН банкны бүх салбараар МЦХ хувьцаат компанийн бүх төрлийн урьдчилсан төлбөрт картыг борлуулж эхлэв. Түүний зэрэгцээ Улаанбаатар хотод ашиглалтад орсон болон орж байгаа томоохон хороолол, барилгуудын холбоожилтын асуудлыг шилэн кабель MSAN станцаар шийдэж эхэлсэн билээ.

МЦХ компанийнхан ер нь зүгээр суудаггүй хамт олон. Тиймээс бас нэгэн шинэ ажил өрнүүлэв. Тэр нь интернэтийн үйлчилгээ үзүүлэх. Энэ зорилгоор 100 хувийн хөрөнгө оруулж, МИКОМ охин компанийг байгуулав. Үүгээрээ дамжуулан VoIP үйлчилгээний анхдагч болов. ADSL-ийн үйлчилгээ ч эднийхээс эхтэй. Ердийн телефон утас болон модем ашиглан интернэтийн сүлжээнд холбогдох боломжийг олгож буй Микомд нэлээд хэдэн давуу тал бий. Микомын интернэтийн хувь хэрэглэгчид Улаанбаатар хотын дотор суурин утасны бүх хэрэглэгчид рүү үнэгүй ярина. Та интернэтэд холбогдсон ч телефон утсаа давхар ашиглах боломжтой юм. Интернэтийн сүлжээнд холбогдох үйлчилгээний тусгай дугаар 1633. Таны нэр, мэйл хаягийг үнэгүй олгоно. Хэрэв та хүсвэл гурав хүртэл мэйл хаягтай ч байж болно. Харин байнгын хэрэглэгч бол урьдчилсан төлбөрт картаар интернэтийг үнэгүй ашиглах боломж бий. Мөн Микомын интернэтийн цагийн төлбөр цаг ямагт бусдаас хямд байдаг юм.

Хэзээ ч, хаанаас ч, гэрээт борлуулагчдаар дамжуулан карт худалдан авах боломжтой. Ингэхдээ телефон утсаа давхар ашигласны нэмэлт төлбөр төлөхгүй. Хэдэн ч компьютерээр интернэтэд нэгэн зэрэг холбогдож болно. ADSL-ийн энэхүү үйлчилгээнд хамрагдсанаар цагийн хязгааргүй интернэтийг хэрэглэнэ. Уг үйлчилгээг хот, аймгийн төвийн хэрэглэгчид авах боломжтойгоороо онцлог билээ.

Энэжил МЦХ компанийн үе үеийн ажилтан.албан хаагчдын хувьд түүхт 90 жилийн ойтойгоо золгож буйгаараа онцлогтой. Хоёрыг уулзуулах төдийхнөөр үйл ажиллагаагаа эхэлж байсан МЦХ ХК хорвоо ертөнцийн бүхий л мэдлэг мэдээлэл, харилцаа холбооны шинэ үүд хаалгыг хэрэглэгчийнхээ өмнө нээгээд байна.

### **Амжилтын нууц**

- Ярианы зах зээл дэлхийн жишигт үнэгүй болж байгаатай холбогдуулан NGN үйлчилгээний хэрэглэгчид амралтын өдрүүдэд сүлжээндээ үнэгүй ярьдаг нь хэрэглэгчдэд маш том боломжийг олгодог.

- МЦХ компани нь суурин утас, интернэт, кабелийн телевиз, утасгүй холбоо, Олон улсын яриагны цогц үйлчилгээнүүдтэй. Хэрэглэгчид олон компаниас тус тусын үйлчилгээг авахгүй нэг компаниас найдвартай, шуурхай авч мөн төлбөрийг нэг дор төлдөг нь давуу талтай. Мөн энэхүү давуу талд суурилан суурин утастай хэрэглэгчид интернэт авсан тохиолдолд суурин утасны бүх сүлжээнд хязгааргүй ярьдаг нь бодит хэмнэлийг өгдөг.

- Олон улсын ярианы 001 гарц болон олон улсын ярианы картын үйлчилгээнүүд нь зах зээл дээр хамгийн анхдагч, чанартай, хямд юм. Суурин утас болон F-zone үйлчилгээнээс картаар ярьсан тохиолдолд нэмэлт төлбөр унадаггүй гэх мэт бие биенээ дэмжсэн

үйлчилгээнүүд байдаг.

- Интернэтийн зах зээлд байнга шинийг эрэлхийлж өөрсдийн интернэт хэрэглэгчдэд олон давуу талыг үзүүлдэг. Тухайлбайл, Миком интернэттэй хэрэглэгчид өөрсдийн контентийн үйлчилгээнүүд авч хүссэн программ, дуу, киног өндөр хурдаар татаж,үзнэ. Өндөр хэмжээтэй файл байршуулах, 24 цагийн турш дотоодын сүлжээнд өндөр хурдаар хандах боломжийг бас олгодог.

- Хэрэглэгчид утсаар бүх мэдээллийг авах, үйлчилгээний захиалга өгөх боломжтойгоос гадна, компанийн мэргэжилтнүүд гэрт нь очиж үйлчилгээ үзүүлдэг.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.mtcone.net](http://www.mtcone.net) Байгуулагдсан он: 1921 он

Компанийн хаяг: Сүхбаатарын талбай-1, Улаанбаатар-211213, Монгол улс,

Үйл ажиллагааны чиглэл: Миком интернэт, Dial-Up, ADSL, байгууллагын э-шуудан, домэйн нэр, түрээсийн шугам, уламжлалт суурин холбоо, F-Zone, National KATB, улс хоорондын холбоо, мэдээллийн лавлах 1109 үйлчилгээ.



## Үргэлж шинийг эрэлхийлэгч брэнд

Содон хурц ногоон өнгө, исгэлэн шинэ амтыг мэдрүүлэгч мэт Юнител брэнд Монголын үүрэн холбооны зах зээлд салхи татуулан орж ирэв. Тухайн үед Монгол улсад Мобиком, Скайтел гэсэн GSM, CDMA системийн монополь эрх бүхий гадны хөрөнгө оруулалттай хоёрхон оператор ноёлж байв. Үүнээс өөр сонголт үгүй байсан тэр л цаг үед Юнителийнхэн шударга өрсөлдөөнийг бий болгох, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, улмаар хэрэглэгчдийн хэтэвчинд хал багатай үнэ бүхий гуравдагч оператор болохын төлөө чамгүй өрсөлдөж ихээхэн хөрөнгө, хүч зарцуулж байж сая нэг үйл ажиллагаагаа эхэлж байсан билээ.

Юнителийнхэн эрхэмсэг залуустаа зориулж олон янзын үйлчилгээ гаргах болсон нь цагаа олсон ажил болж Сонгодог багц, Dorin зэрэг брэнд олны анхаарлыг өөрийн эрхгүй татах болов. Сонгодог брэндийн хувьд шинэ үеийн ажил хэрэгч залууст зориулсан үүрэн холбооны дараа төлбөрт үйлчилгээ юм.

Анх 2009 онд Сонгодог багц нэртэйгээр зах зээлд гарч ирэхдээ хэрэглэгч хэрэглээний онцлогтоо тохируулан үүрэн

**СОНГОДОГ**  
ensured by *Unitel*





холбооны бүх төрлийн үйлчилгээний багцуудаас сонгож авч ашигладаг олон улсын аргачлалыг нэвтрүүлснээрээ онцлог юм. Брэндингийн үйл ажиллагаа нь мөн ажил хэрэгч, эрхэмсэг дүр төрхийг бий болгохыг зорьж байлаа.

Тиймээс ч Сонгодог багц гэдэг нэр нь нэг талаас хэрэглэгч өөрийн хүссэн багцаа сонгох боломжтой, олон сонголттой, нөгөө утгаараа энэхүү дараа төлбөрт үйлчилгээ нь дэлхийн жишигт нийцсэн багц буюу сонгодог хувилбар гэсэн утгыг агуулж байгаа юм.

Харин зах зээлд танилцуулж хэрэглэгчдэд сурталчлахдаа хүн бүр өөр, хэрэглээ ч бас өөр өөр гэдгийг заавал бодолцох ёстой. Тиймээс тэдний хэрэглээнд тохирохуйц дэлхийн жишиг болсон дараа төлбөрт үйлчилгээний Сонгодог багцыг танилцуулж байна гэсэн утга агуулгатай байсан бөгөөд рекламны зохиол, хэрэглэгчийн гарын авлага гэх мэт бүх зүйлсэд тухайн сегментийн хэрэглэгчдийн сонирхдог зүйлсээр нь төлөөлүүлэн харуулахыг зорьжээ. Жишээ нь: Каппучино, Гольф, Зангиа гэх мэт.

2010 онд Сонгодог багцын зах зээлд нэвтэрсэн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр брэндингийн зарчимд зарим өөрчлөлт шинэчлэл ийг хийснээр ихээхэн амжилт олжээ. Энэ үед үйлчилгээний нэрийг Сонгодог үйлчилгээ болгож логог хөгжүүлсний дээр хэрэглээний нөхцлүүдийг шинэчлэв. Эдгээрийг "Сонгодог үйлчилгээг сонгох 10 шалтгаан"

хэмээн томъёолж бодит хэрэглэгчдийн жишээн дээр тайлбарлаж өгчээ.

Амжилтаараа ялгар! гэсэн шинэ уриа нь зорилтот сегментийн бодол, хүслийг оновчтой илэрхийлсэн тул гарсан даруйдаа сайн байршсан бөгөөд ийм нэртэй мэдээллийн булан тогтмол ажиллуулах зэргээр багтай хоногшуулсан байна.

Хэдийгээр брэнд гэдэг ойлголт урт хугацаанд бий болдог ч гэлээ Сонгодог үйлчилгээ нь богино хугацааны дотор хэрэглэгчдийнхээ хүндлэл, таашаалыг хүртэж зах зээлд эзлэх хувь нь эрс нэмэгдэв. 2009 онд Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны технологийн газраас зохион байгуулдаг ICT EXPO-гоос Харилцаа холбооны шилдэг бүтээгдэхүүн, 2010 онд Вэбстор ХХК болон Like IT.mn вэб сайтаас зохион байгуулсан Мэдээлэл, Холбооны Технологийн шилдгүүдийг шалгаруулах Like IT Awards 2010 уралдаант шалгаруулалтад Мэдээлэл Холбооны Технологийн Шилдэг брэнд бүтээгдэхүүн үйлчилгээгээр шалгарчээ.

Харин DOPIN брэндийн хувьд бол ярианы хэрэгцээ их боловч зардлаа хянах сонирхолтой идэвхтэй хэрэглээтэй хэрэглэгчдэд зориулсан үүрэн холбооны урьдчилсан төлбөрт үйлчилгээ юм.

Сегментчиллийн судалгаанаас үзэхэд нэгж хэрэглэгчийн үүрэн холбооны дундаж зардал нь дараа төлбөрт хэрэглэгчдээс дутахааргүй бөгөөд төлбөрийн чадвартай боловч урьдчилсан төлбөрөөр цэнэглэж ашиглах сонирхолтой хэрэглэгчийн тоо нэлээд их байгаа нь харагддаг. Тиймээс 2008 онд хэрэглэгчийн зан төлөвийн энэхүү онцлогт суурилсан DOPIN брэндийг зах зээлд нэвтрүүлсэн нь тэр даруйдаа ихээхэн амжилт олов.

Анх удаа сүлжээ харгалзахгүй ижил үнэ, бага зардлаар их ярих боломжийг урьдчилсан төлбөрт хэрэглэгчдэд олгосон бүтээгдэхүүний шинж чанарын зэрэгцээ "Бодит амьдралд тулгуурлав" гэсэн мессеж бүхий сурталчилгааны кампанит ажил нь зорилтот сегментдээ сайн хүрсэн нь DOPIN брэнд богино хугацаанд их амжилт олох үндэс болжээ.

2010 онд DOPIN брэндийн тогтвортой хөгжүүлэлтийн хүрээнд Хязгааргүй ярианы багц, Миний гэр бүл, Бэлэг зэрэг зөвхөн тухайн брэндийн хэрэглэгчдэд онцгой давуу тал олгосон нэмэлт үйлчилгээнүүдийг бий болгож сурталчилгааны агуулга нь гэр бүлээ хайрлах сэтгэлзүйд чиглэжээ. Мөн 2011 оны нэгдүгээр сараас DOPIN брэндийн гар утсыг зах зээлд танилцуулаад байна.

### **Амжилтын нууц**

- Орчин үеийн дэвшилтэт технологийн ололт амжилтад суурилсан хамгийн найдвартай, чанартай, ухаалаг тогтолцоо бүхий үйлчилгээг санал болгодог.
- Сүлжээ ялгаварлалгүй бүх сүлжээ рүү зөвхөн нэг үнээр холбогдох боломжийг хангадаг.
- Хэрэглэгчдээ сонсч, тэдний хэрэгцээ шаардлагыг үйл ажиллагаандаа байнга тусган ажилладаг.

## **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.unitel.mn](http://www.unitel.mn) Байгуулагдсан он: 2005 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 210620 а, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Central Tower 2, 8 давхар

Үйл ажиллагааны чиглэл: Үүрэн холбооны үйлчилгээ





## Өртөө шуудан монголчуудын брэнд

Эдүгээ шуудангүйгээр улс орон битгий хэл хувь хүн хүртэл нэг ч өдрийг өнгөрөөхөд тун бэрх. Хүн төрөлхтөн бичиг үсэгтэй болсноос эхлэн шуудангийн үйлчилгээ жинхэнэ утгаараа үүсч хөгжсөн гэж үздэг. Үнэн байх. Хашгираад дуу сонсогдохгүй, дохио өглөө гэхэд нүдний хараа хүрэхгүй орчин хязгаарт байгаа нэгэндээ мэдээлэл дамжуулахын тулд мэдээж өгөх гэсэн мэдээллээ бичээд хэн нэгнээр яаралтай хүргүүлэх шаардлага гарч таарна. Энэ бол ерөнхийдөө захидал үүссэний нэг шалтгаан. Мөн энэхүү бичгийг хүргэж өгдөг нөхрийг шилж сонгож таараа. Хамгийн хурдан гүйдэг нэгнээ сонгодог байсан тухай түүхийн бичиглэл, домог үлгэрт зөндөө гардаг билээ. Өөрөөр хэлбэл шуудан үүссэн гэсэн үг.

Бичсэн мэдээллийг эхлээд явган гүйгчид хүргэж өгдөг байлаа. Дараа нь морь зэрэг ердийн хөсөг ашигладаг болов. Буухиална. Буухиа уралдаан шиг л гэсэн үг. Ялангуяа дайн байлдаан шуудангийн хөгжилд ихээхэн тус нэмэр болов. Ялалт, ялагдлынхаа тухай мэдээг аль болох хурдан хүргэхийн тулд хамгийн шилдэг гүйгчээ шууданч болгодог байлаа. Хожим шуудан хэмээх зүйл хөгжлийнхөө жамаар морь, тагтаа, машин, онгоц зэрэг тээврийн хэрэгсэл, эдүгээ цахим хэлбэрт хүртэл шилжсэнийг дурдах нь илүүц биз.

Тэгвэл шууданг бид монголчуудын брэнд гэж хэлэх эрхтэй. Яагаад гэхээр Их эзэн Чингисийн гуравдугаар хөвүүн Өгөдэй 1228-1241 оны хооронд хаан ширээнд суухдаа дөрвөн сайн зүйл хийж бүтээсний нэг нь морин өртөө. Тухайн үедээ Монголын нийслэл Хархорин хотоос Францын хаанд илгээсэн өдтэй бичиг 10 000 километр замыг ердөө тавхан хоногийн дотор туулан хаягласан эзэндээ очсон байдаг.

Ингэхэд тагтааны хүзүүнээс захидлаа зүүгээд нисгэх ухаан европчуудын толгойд ороогүй байхад өдтэй бичиг өвөртөлсөн хөрслөг монголчууд морин дэл дээр бөгтийсхийн суучихаад хэдэн мянган бээр газрыг өртөөлөн туулдаг байжээ. Тэгэхээр шуудан Монголын брэнд хэмээн дуугарах эрх бидэнд яах аргагүй байгаа биз.

Өртөө шуудан түүхийнхээ явцад улам боловсронгуй болсоор ирэв. Хувьсгалаас өмнө л гэхэд Монголын нутагт 37 суурь өртөө, нэг мянгат бүрээс нэг улаач, унааны морь, шүүсний хонь, саалийн гүү, хөллөх үхэр зэргийг гаргадаг байлаа. Ингээд 1921 онтой золгож, шуудан өөрийнхөө түүхийн бас нэгэн шинэ хуудсын зурвас үеийг нээсэн гэж болно.

Ардын хувьсгалын жилүүдэд шуудан улам эрчимтэй хөгжсөн юм. Тухайлбал, хувьсгал дөнгөж ялаад байсан тэр жил Ардын Засгийн газрын тэргүүлэгчдийн VI хурлын тогтоолоор МУ-ын Шуудан бичиг, Цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан бөгөөд шуудан нь харилцаа холбооны харьяа байж байгаад 1994 оны эцсээр Цахилгаан холбоо компаниас салж Монгол шуудан ТӨУҮГ, тун удалгүй бие дааж Монгол шуудан төрийн өмчит компани болсон билээ. Ийнхүү өрх гэрээ тусгаарлаж, үүд хаалгаа дэлгэн, нэгэн их айлын арван зууны тэртээд асаасан галыг унтраалгүй залгамжлах эрхэм үүргийг дангаараа үүрэх боллоо.

Шуудангийн үйлчилгээний салбар тухайн улсынхаа тэргүүлэх чиглэлийнх байдаг нь бичигдээгүй хууль. Өнөөдөр манайд шуудангийн үйлчилгээ явуулах тусгай эрх бүхий гуч орчим байгууллага байдгийн хамгийн ахмад нь Монгол шуудан компани юм. Тэд 21 аймаг, 334 сум, Улаанбаатар хотын 40 салбараар дамжуулан үйлчилгээ үзүүлж байна. Нийт 800 гаруй ажиллагсадтай.

Гадаад харилцаа нь тогтмол хөгжиж Дэлхийн шуудан холбооны байгууллага, Ази, Номхон далайн бүсийн байгууллагын бүрэн эрхт гишүүн болоод зогсохгүй дэлхийн 200 гаруй оронтой шуудан солилцдог. Мөн шуудангийн хамгийн шуурхай хэлбэр болох буухиа шууданг 34 оронтой солилцож байна.

Тэд бичиг захидлын гадаад болоод дотоод зах зээл дээр жинхэнэ ноёрхдог юм. Хаанчлалаа бүрэн тогтоосон гэсэн үг. Ингэж хаанчлах эрхийг нь түүнд үйлчилгээ, хэрэглэгч нар нь олгожээ. Дотоод илгээлтийн зах зээл дээр ч ноёлдог. Харин гадаад илгээлт, улс хоорондын буухиа шуудангийн зах зээлийг өрсөлдөгч нартайгаа хуваалцдаг. Мөн хэвлэл захиалга, хүргэлтийн зах зээл дээр жинхэнэ халуун тулаан өрнөдөг байна. Гэхдээ л тэд давамгайлдаг.

Шуудангийн үйлчилгээний онцлог, бас давуу талуудыг ашиглан шуудангийн хайрцаг болон хэвлэлтэй хамт бизнесийн байгууллагуудын сурталчилгааны материалыг нийтэд хүргэдгээрээ онцлогтой.

Хамгийн хямд сурталчилгааны хэлбэр бол директ шуудан. Үйлчлүүлэгчдийн хувьд ч ашигтай. Монгол шуудан компани 40 мянган шуудангийн хайрцагтай. Хүртээмжтэй байгаа биз. Дээр нь 200 мянган сонин, сэтгүүл захиалагчийг нэм. Хэрэглэгчийн шууд гарт нь очно. Боловсрол, орлогын түвшин өндөртэй иргэд л шуудангийн хайрцаг эзэмшиж, хэвлэл захиална гэдгийг бас анхаарлынхаа гадна орхиж боломгүй. Тэрчлэн орон даяар аалзны тор шиг хэрсэн сүлжээтэй гэдгийг бүү мартаарай.

Шуудан холбооны салшгүй нэг хэсэг болсон марк үүссэн түүх их сонин билээ. Марк гэдэг нь Англиас эхтэй. Эдүгээ Лондонгийн хуучин хөрөнгийн биржийн өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн байшингийн замын эсрэг талд нэг нөхрийн хөшөө байдаг. Энэ бол Английн парламентын гишүүн агсан Ролланд Хиллд зориулсан хөшөө юм. Түүнд ийм нэгэн явдал тохиолджээ. Тэрбээр хот хоорондын захидал, энэ тэрхэн зөөж, амьжиргааныхаа хэдэн бор юмыг олдог залуу байж. Хилл нэгэн ирланд бүсгүйтэй удаан ярьж байгаад уйлуулан салав гэнэ. Уйлсан бүсгүйгээс учрыг лавлавал, цэрэгт алба хааж байгаа сүйт хархүүгээс нь ирсэн захидлын оронд өгөх юм үнэхээр байгаагүй тул түүнийг надад уншуулалгүй буцаагаад аваад явчихлаа гэжээ. Тэр үед түүний толгойд нэгэн бодол сэрдхийн буув. Зүгээр нэг нугалсан цаас бус захидал энэ тэрийг нууцалсан дугтуйтай болгохын зэрэгцээ түүнийг зохих хэмжээний төлбөртэйгээр зөөдөг болгох хуулийн төсөл санаачлан батлуулах нь зүйтэй юм байна хэмээн боджээ.

Хилл ч санасандаа хүрч хууль батлагдав. 14 грамм захидал нэг пенни байх үнэ тогтжээ. Ийнхүү хожмын нэгэн өдөр хөшөөгөө босгуулах гавьяаг Хилл байгуулсан байна. Харин нэг пенни төлсний баримт болгон тасалбар өгдөг байв. Түүнийг нь номын худалдаачин Чалмерс хэмээх нөхөр хөнгөвчилж дугтуйн дээр наадаг болгосноор марк үүссэн

түүхтэй.

1840 оны тавдугаар сарын нэгэнд анхны марк бий болж, тавны өдрөөс шуудангийн үйлчилгээнд хэрэглэгдэж эхэлжээ. Энэхүү маркийг Хар пенни хэмээн нэрлэсэн агаад эдүгээ дэлхийн марк цуглуулагчдын гарт тун цөөхөн байдаг аж.

Монгол Улсын хувьд 1924 онд анх удаа шуудангийн маркийг гаргасан байдаг. Марк гарсан өдрөөс өдийг хүртэл дэлхийн шуудангийн маркны цуглуулагчид монгол маркийг хүлээн зөвшөөрч, олон ч удаагийн уралдаан тэмцээнээс манай маркнууд алт, мөнгөн медаль, тусгай шагналыг нь түүж иржээ. Одоо ч энэ уламжлалаа алдаагүйд дэлхий гайхдаг л юм.

Анх Шанхай хотод чулуун бараар Элдэв-Очир гэсэн нэртэйгээр хэвлэн гаргаж байсан бол эдүгээ манай улс 1924 дэх багц маркаа өнгөрсөн жил Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид зориулан гаргалаа. Ерөнхийлөгч маань алдарт уяач Х.Наранхүүгийн домогт шарга азаргатай хамт энэ маркан дээр мөнхөрчээ.

Ер нь Монгол шуудангийнхан үе үеийн Ерөнхийлөгчөө марканд мөнхөлдөг уламжлалтай. Анхны Ерөнхийлөгч П.Очирбат, дараа нь Н.Багабанди, Н.Энхбаяр нар ч нэг тусдаа багцыг эзэлж байсан. Ингэхэд марк нь зөвхөн төлбөр хийсний баталгаа бус улс орон, байгаль орчин, ёс заншил, ан амьтан гээд сурталчилгааны маш сайн хэрэгсэл болдог. Үр дүнгээ ч өгдөг. Саяхнаас үнэт цаас болсон тухай зарлалаа. Марк цуглуулагчдын хувьд энэ бол өдрийн бодол, шөнийн зүүд. Бизнес ч болдог. Монгол марк бол дэлхийн хэмжээнд нэрээ дуурсгаж, намба төрхөө олсон манай гайхамшигтай брэндүүдийн нэг билээ.

Элдэв-Очир нь бат бэх, салж сарнишгүйн бэлгэ тэмдэг. 1924 онд энэ тэмдгийн зохиомж бүхий долоон нэрээр гүйлгээнд гаргаж байжээ. Хожим нь зөвхөн Соёмбо үсгийн зурагтайгаар хэвлэгдэж байснаа Монгол орны социалист амьдралын хөгжил дэвшлийг тусгаж эхэлсэн түүхтэй.

Өнгөрсөн хугацаанд 3600 гаруй нэр төрлийн марк гүйлгээнд гаргасан байна. Ер нь шуудангийн маркийг цааснаас гадна алтан, алт мөнгөн фольга, холограмм, торгоор хэвлэдэг. Хойч үедээ энэхүү үнэт цаасыг өвлүүлэн үлдээхийн тулд тодорхой тооны маркийг Монгол Улсын сан хөмрөгт хадгалдаг болов. Тухайлбал, 1924 оноос хойш марк бүрээс 20 ширхэг, 1958 оноос хойш гарсан марк бүрээс 30 мянган ширхэгийг Монгол банкинд хадгалж байсан бол одоо Монгол шуудан ТӨҮГ-т хадгалагдаж байгаа аж.

1924 оноос хойш маркийг ЗХУ-д хэвлүүлж байсан бол дараа нь Унгарын зураачдаар зуруулж тухайн оронд хэвлүүлдэг байлаа. Унгар нь хэвлэсэн маркныхаа гуравны нэгийг манайд өгч бусдыг нь дэлхийн зах зээл дээр борлуулдаг байлаа. Харин 1983 оноос монгол зураачид эх зургийг бэлтгэн БНАГУ-ын ЦИМЕКС үйлдвэрт хэвлүүлж байв.

Эдүгээ Английн Куэста, Унгарын Филатели хунгарика, Хятадын үнэт цаасны үйлдвэр, Францын Картор зэрэг үйлдвэрт хэвлүүлж байна. Харин тусгай маркийг АНУ-ын Ситихолл пүүсийн санал болгосон зураг дизайнаар хэвлэдэг аж.

**Амжилтын нууц**

- Шуудангийн үйлчилгээний технологи нь чанартай, шуурхай, хамгийн гол нь найдвартай.
- Гадаад болон дотоод шууданг интернэтийн сүлжээнд суурилсан олон улсын IPS Light, дотоод шуудангийн Postnet зэрэг программаар дамжуулан бүртгэж, хянадаг.
- Цаг үеэ олсон сэдвээр гайхамшигтай маркуудыг гаргадаг. Үйлчилгээнийхээ сурталчилгааг маш сайн хийдэг. Шуудангийн бичиг, захидлын дугтуй, маркийн альбом, анхан шатны хүснэгт маягтыг үйлдвэрлэн худалдаалдаг.
- Гадаад, дотоодын зах зээл дээр маркаа өөрөө борлуулдаг нь энэ компанийн маш сайн сурталчилгаа болж чаддаг.
- Олон улсын үзэсгэлэн яармаг, интернэт шопоор худалдаа наймаа хийдэг нь ч амжилт авчирдаг бас нэгэн эх сурвалж. Америк, Франц, Шинэ Зеланд улсад марк борлуулдаг өөрийн гэсэн дилертэй.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn) Байгуулагдсан он: 1921 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай, Монгол шуудан ТӨҮГ-ын байр.

Үйл ажиллагааны чиглэл: Шуудангийн үйлчилгээ, Монгол маркийн үйлдвэрлэл, худалдаа, директ шуудан, шуудангийн хайрцаг, хэвлэл захиалга, хүргэлт, ил захидал, мэндчилгээ, дугтуйны үйлдвэрлэл.



## Даатгалын салбарт цахиур хагалсан брэнд

МЭӨ 1760 онд Вавилоны Хаммурапи хааны гаргасан хуульд харилцан бие биедээ туслах, хамтын санаан дээр суурилсан харилцан туслалцах даатгалын хэлбэр байсан нь хамгийн эртний даатгалын хэлбэрийн нэг билээ. Үүнээс хойш эртний Герег болон Ромын эзэнт гүрний үеийн түүхээс харилцан туслалцах даатгалын зарчим дээр суурилсан даатгалын жишээнүүдийг олж харж болох юм.

Өнөөдрийг хүртэл даатгалын олон хэлбэр бий болж төлөвших хүртэл энэхүү салбар ихээхэн "зовлон" туулж бидний үетэй золгосон гэж хэлж болно. Газарзүйн аугаа нээлтийн эрин үед хөлөг онгоцны хөгжлийн явцад шинэ тутам аюул заналхийлэл буй болсон юм. Далайн эрсдлээс хамгаалахын тулд хөлөг онгоцны эзэд болон худалдаачид аялж явахдаа хэн нэгний эд зүйл гэмтэж үгүй болсон тохиолдолд түүний хохирлыг бүгд хуваалцах талаар ярьж тохирдог байжээ. Бидэнд үлдсэн түүхэн баримтаас харахад далайн даатгалын анхны гэрээ 1347 онд Генуягаас Майорка арал руу ачаа тээвэрлэх үед хийгдсэн байдаг. Үүнээс харахад тээвэрлэлтийн үед худалдааны даатгал хөгжиж байсан бөгөөд даатгалын хамгаалалтыг тодорхой төлбөртэйгээр хийдэг байсныг үүнээс харж болно. Тэгвэл 1468 онд Венецийн далайн даатгалын кодекс бий болов. XVIII зууны эхээр далайн даатгалын салбарт анхны даатгалын нийгэмлэгүүд бий болж эхэлсэн гэдэг. Чингэснээр даатгалын салбар нь далайтай холбоогүй бусад эрсдлийг ч мөн хамарч эхэлсэн юм. Харин 1666 онд Лондон хотын төвд байрлах 13200 орчим барилга байгууламжийг үнс болгосон томоохон гал түймэр гарсны дараа галын аюулаас эд хогшлыг хамгаалах даатгалыг бий болгосон гэдэг. Чухам энэхүү эмгэнэлт үйл явдлын дараа галын аюулаас даатгах дэлхийн анхны даатгалын компани бий болсон билээ.

Харин амь даатгалын хувьд Их Британид анх үүссэн гэж тооцдог. Тухайн улсад 1762 онд Equitable Life Assurance Society хэмээх даатгалын компани бий болсон бөгөөд өнөөг хүртэл амьдралын даатгалын асуудлыг эрхэлсээр байна. Харин XVIII зууны сүүлчээр Баруун Европт ойролцоогоор 100 орчим төрлийн янз бүрийн даатгал бий болсон байлаа.

Манай улсын хувьд даатгалын анхны байгууллага Дэлхийн II дайны өмнөхөн 1934 онд төрийн байгууллагуудыг галын аюулаас хамгаалах зорилготойгоор байгуулагдаж байжээ. Тухайн цаг үед ихэнх албан байгууллагууд 24 цагаар гал түлж байшингаа халаадаг байсан нь гал түймэр гарч улсын эд хөрөнгө ихээр сүйдэх шалтгаан болдог байв. Тэр үед Бөмбөгөр ногооны барилгын ихэнх хэсэг шатсан байна. Тэгэхэд жүжгийн галтай хэсгийн тоглолт дээр паяльникаар гал гаргах үеэр хөшигт гал авалцсанаас болж анхны хохирол үүсч байсан аж.

Ийнхүү улс орны эдийн засаг, соёлыг хөгжүүлэх ач холбогдол бүхий улс нийгэм, ард олны ашиг сонирхлыг хангаж чадахуйц өөрийн даатгалын төвлөрсөн байгууллага 500 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр Улсын Аюулаас хамгаалах газар нэртэйгээр байгуулагдаж байсан түүхтэй. Энэ нь өнөөгийн Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэх байр эзлэж буй

Монгол Даатгал компанийн эхлэл болсон юм. Монгол Даатгал компани өдгөө манай улсын даатгалын зах зээлийн 60 гаруй хувийг дангаар зохицуулж байгаа билээ.

Анхандаа галын аюулаас сэргийлэх зорилготой байгуулагдаж байсан даатгалын компани өнөөдрийн байдлаар 62 нэр төрлийн үйлчилгээг даатгуулагчиддаа хүргэж байна. Мэдээж энэ брэндүүд нэг дор үүсээгүй, тухайн үеийн нийгмийн байдал, хүмүүсийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан амьдралаас урган гарч 77 жилийн турш боловсронгуй болсоор ирсэн юм.

Эхний үед зөвхөн байгууллагын хөрөнгийг даатгадаг байсан бол 1946 оноос ард иргэдийн амь насны даатгалыг хийж, иргэдийн амины байшинг даатгаж эхэлсэн байна. Энэ үеэс иргэдэд зориулсан даатгалын бүтээгдэхүүнийг бий болгох үндэс тавигджээ. Газар тариалан, төмс, хүнсний ногооны тариалалтад улс орноороо эрвийх дэрвийхээрээ оролцож байсан 1960-аад оны үед мал, газар тариалан, таримлын даатгал үүсч бий болов.

Чингээд 1997 онд Монгол Улсын Даатгалын хууль батлагдсан энэ үеэс даатгалын салбар хөгжлийн шинэ шатанд гарчээ. Хувийн даатгалын компаниуд үүд хаалгаа нээж, даатгалын зах зээл дээрх өрсөлдөөн ширүүсэв.

Эдүгээ Монгол Даатгал компани даатгалын зах зээлд шударга өрсөлдөөнийг баримталж, даатгуулагчиддаа шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг байнга санал болгосоор байна.

Монгол Даатгал компани нь салбартаа манлайлагчийн хувьд даатгалын шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлж, тус салбарын хөгжилд жинтэй хувь нэмрээ оруулсаар иржээ. Тухайлбал, Монголд анх удаа 2005 онд санхүүгийн эрсдлийн даатгал, 2006 онд шуурхай албаны үйлчилгээ, 2009 онд интернэт даатгал болон ухаалаг даатгалын үйлчилгээг тус тус нэвтрүүлжээ.

2006 онд шуурхай албыг анхлан нээв. Хохирол гарсан газар дээр нь үйлчилгээ үзүүлэх шуурхай албыг ч Монголд анх удаа нээн ажиллуулжээ. Өнөөдрийн байдлаар шуурхай албаны газар дээрх үзлэгийн маягтыг үндэслэн 222 мянган төгрөгнөөс доош хохирлыг өдөрт нь олгож буй аж. Мөн шуурхай албаны машинууд GPS системтэй болсноор байршил тодорхойгүй, хаягжилт байхгүй газруудаас ирсэн ослын дуудлагын байршлыг тогтоон, хамгийн ойр дөт замыг сонгон очиж даатгуулагчийн цагийг хэмнэдэг болов.

Түүнчлэн тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалыг хүмүүсийн худалдан авах түвшинд тааруулж дотор нь зургаан төрөл болгон ангилжээ.

Тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалыг тухайн хүний машин барих ур чадвар, тухайн байгууллагын нөхцөл байдалд тохируулан зургаан төрөл болгон зах зээлд борлуулсан нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн бүтээгдэхүүн болж чадав. Төд удалгүй Монгол Даатгал Мишээл сан ТББ-ыг санаачлан байгуулжээ. Тус сан нь Монгол Даатгал компанийн дэргэд үүсэн байгуулагдсан нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага бөгөөд үйлдвэрлэлийн болон гэнэтийн ослоос үүдсэн, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгагдаагүй иргэдэд мөнгөн болон эд материалын тусламж, тэтгэлгийг үзүүлж тэднийг сэтгэл санааны хувьд дэмжих зорилгоор байгуулагдсан сайн санааны байгууллага юм. Ингэснээр

даатгуулагчийн даатгалын хураамжийн тодорхой хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралд тус дэм болж эхлэв.

Тус байгууллагын бас нэг шинэ үйлчилгээ бол даатгалыг интернэтээр анх удаа борлуулж эхэлсэн явдал юм.

Е-ДААТГАЛ нь даатгуулагчид гэр, ажлын байр, хөдөө орон нутаг, дэлхийн аль ч өнцгөөс тус компанийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ зэргийг шууд худалдан авах боломжийг Монголд анх удаа нэвтрүүлжээ. 2010 он гэхэд Монгол Даатгал компанийн бүх харилцагчид Ханноверре компанид давхар даатгалтай болов.

2010 онд ХБНГУ-ын Ханновер хотод байрлах олон улсын Ханноверре даатгалын компанитай Монгол Даатгал компани өөрийнхөө даатгалын нийт багцыг давхар даатгалд хамруулжээ. Энэ нь Монгол Даатгал компанид даатгуулсан даатгалын бүх гэрээ олон улсын давхар даатгалын зах зээлийн томоохон давхар даатгагч болох Hannover re компанид давхар даатгагдсан гэсэн үг билээ. Тус компани нь 1960 оноос давхар даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулж эхэлсэн түүхтэй. Ингэхээр та бидэнд учирсан эрсдэлтэй тохиолдол, хохирол бүрийн цаана дэлхийн хэмжээнд даатгагдсан даатгалын байгууллага Монгол Даатгал компанийн ард найдвартай хамгаалалт болон зогсч байгаа гэсэн үг юм.

Монгол Даатгал компанийн үйл ажиллагаа өргөжин тэлсээр байгаа нь гадны хөрөнгө оруулалт бүхий бусад төслүүдтэй хамтран ажиллаж малчид болон бага, дунд орлоготой иргэдэд зориулсан шинэ бүтээгдэхүүнийг борлуулж буйгаас нь харагдаж байна. Тус компани Дэлхийн банкны төслийн хүрээнд Малын индексжүүлсэн даатгал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн нэг хэсэг болох Эрүүл мэндийн бичил даатгалын борлуулагчаар амжилттай ажиллаж байгаа аж.

Монгол улсын даатгалын салбар харьцангуй бага боловч жил ирэх тутам тогтвортой өсч байна. 1998 оны байдлаар салбарын жилийн орлогын нийт хэмжээ ердөө гурван тэрбум төгрөг байсан бол 2010 оны 2-р улирлын байдлаар хураамжийн цэвэр орлого 11,5 тэрбум төгрөгт хүрсэн нь энэ салбар эрчимтэй хөгжих хөгжлийн шат руугаа нэгэнт орсныг тодорхой харуулж байгаа юм.

Тэд зөвхөн орлогынхоо хувьд Монголдоо тэргүүлэгч бус даатгуулагч нарт эрсдэл тохиолдсон хүнд үед олгосон нөхөн төлбөр төлөлтөөрөө ч мөн улсдаа тэргүүлэгч даатгалын компани гэдэг нь 2009 онд 2,5 тэрбум төгрөгийн хохирлыг төлсөн байдлаас нь илхэн харагдана.

Даатгуулагчдын хохиролд төлсөн нөхөн төлбөр ч жил болгон өссөөр байна. Монгол Даатгал ХХК нь даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, даатгалын талаарх мэдлэгийг олон түмэнд цаг алдалгүй хүргэсээр байгаа билээ.

Монгол даатгал компанийн ойрын ирээдүйд зах зээлд нэвтрүүлэхээр зорьж буй хөгжлийн тулгуур салбар болох уул уурхай, боловсруулах үйлдвэр, дэд бүтцэд зориулсан багц үйлчилгээ, мэдээллийн технологи, хөрөнгийн зах зээлийг эрсдлээс хамгаалсан шинэлэг даатгалын бүтээгдэхүүн, нөхөн төлбөрийг хурдан шуурхай, чирэгдэлгүй барагдуулахүйл

ажиллагааны шинэчлэл, давхар даатгал, эрсдлийн удирдлагын олон улсын стандартад нийцсэн бодлогууд, уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл зэрэг нь Монгол улсын даатгалын салбарын хөгжлийг тодорхойлохуйц ажил бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн төлөө хоёргүй сэтгэлээр ажиллаж байгаагийн илрэл мөн.

### **Амжилтын нууц**

- Компанийн имиж бүрдүүлэлтийг хийж өөрийн гэсэн өнгө төрхтэй болж чадсан.
- Даатгалын зах зээл дэх бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч байж чадсан.
- Бүх аймагт салбартай, сумдад төлөөлөгчтэй бөгөөд улс орны хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулах сүлжээ бий болгосон.
- Даатгуулах болон даатгуулсны дараахь сэтгэл ханамжийг бүрдүүлэв.
- Хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд шаардагдаж буй бүтээгдэхүүнийг бий болгодог.
- Олон улсад үйлчлэх нэрийн бүтээгдэхүүнтэй.
- Даатгуулагчдад учирсан хохирлыг нөхөн төлөх баталгаа болсон нөөцийн хангалттай сан бүрдүүлж санхүү, төлбөрийн чадвар бэхэжсэн.
- Даатгалын мэргэшсэн боловсон хүчнээр бүрэн хангагдаж олон улсын даатгалын зах зээлийн туршлага хуримтлуулсан.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.mongoldaatgal.mn](http://www.mongoldaatgal.mn) Байгуулагдсан он: 1934

Компанийн хаяг: Монгол Даатгал ХХК-ийн байр, Энхтайваны өргөн чөлөө-13, Улаанбаатар-48, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Арилжааны даатгал монгол





## Телевизийн түүхэнд шинэчлэл хийсэн брэнд

Олон зууныг харанхуй байдлаар аж төрж үдсэн хүмүүн төрөлхтөн XIX зуунд шинжлэх ухаан, техникийн олон нээлт хийгдсэний ачаар утсан холбоо, телевиз, радио, автомашин зэрэг бидний өнөөгийн өдөр тутмын зайлшгүй хэрэглээ болсон зүйлүүдийг бүтээсэн билээ. 1870-аад оны үед орчин цагийн телевизийн үндэс суурь тавигдсан түүхтэй. Харин манай улсад 1960-аад оны дундуур энэ ажил хийгдэж, 1967 онд Монголын ууган телевиз анхны нэвтрүүлгээ цацсанаас хойш өдгөө 40 гаруй жил болж байна. Өнөөдөр Монгол улсад 20 гаруй телевиз үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Тэгвэл Монгол улсын телевизийн түүхэнд цоо шинэ хуудсыг нээсэн Монгол телевизийн үүх түүхийг хамтдаа сонирхоцгооё.

2007 оны аравдугаар сарын 2-нд Харилцаа Холбооны Зохицуулах Хороон дээр радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (ХХЗХ-ны тусгай зөвшөөрлийн дугаар: 331/Б/ TV54/ олгох дуудлага худалдаа болсон билээ.

ХХЗХ-ноос ийм төрлийн эрх олгохдоо өмнө нь өөр журмаар явдаг байсан бол энэ удаа тендер шалгаруулалтын зарчмаа өөрчилж, нээлттэй дуудлага худалдаа явуулахаар шийдвэрлэсэн байлаа.

Шинэ зарчмаар явагдсан анхны дуудлага худалдаанд таван компани материалаа ирүүлж, радио телевизийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах сонирхлоо илэрхийлэн өрсөлдсөнөөс иргэн Л. Чинбат өөрийн үүсгэн байгуулсан Монгол телевиз ХХК-ийн нэр дээр уг эрхийг 812 сая төгрөгөөр худалдан авчээ.

Иргэн Л.Чинбатын худалдан авсан дээрх эрхэд үндэслэж, Монгол телевиз 2007 оны арванхоёрдугаар сарын 10-ны өдөр Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос Улаанбаатар хотод телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн тусгай зөвшөөрөл, Улаанбаатар хотод телевизийн нэвтрүүлгийг нэвтрүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн зохих ёсоор нь авсан гэдэг.

Үүнээс нэг жил орчмын дараа буюу 2008 оны арваннэгдүгээр сард туршилтын нэвтрүүлгээ үзэгчдэд анх хүргэж, 2009 оны намар анхны HD (дуу, дүрсний өндөр тодролттой) телевиз албан ёсны нээлтээ хийж, Монголын телевизийн салбарын түүхэнд шинэхэн хуудсыг эхлүүлсэн билээ.

Тус телевизийг үүсгэн байгуулагчид Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, нэн ялангуяа Оюуны өмчийн хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг эрхэм үүргээ гэж үздэг агаад олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд энэ зарчмыг нэвтрүүлэх, цаашлаад өргөн нэвтрүүлгийн хуультай байхын ач холбогдлыг эрх баригчдад ойлгуулах, Монголын телевизүүдэд олон улсын жишигт нийцэхүйц мэргэжлийн стандарт

ТОГТООХЫН ТӨЛӨӨ ХИЧЭЭН АЖИЛЛАЖ БАЙГАА ЮМ.

Үүний сацуу нийгмийн амьдралын амин чухал асуудлыг хөндсөн, олон нийтийн эрх ашиг, хэрэгцээ сонирхлыг хангасан, улс орны хөгжлийн ололт амжилтуудыг сурталчилсан, хувь хүний хөгжлийг дэмжсэн нэвтрүүлгүүдийг олон нийтэд хүргэх зэрэг томоохон зорилгуудыг өмнөө тавьж, өнөөдрийг хүртэл энэ чиглэлд анхаарлаа хандуулсаар иржээ.

Монгол телевизийн мэдээний алба нь улс эх оронд болоод дэлхий дахинд болж буй үйл явдлыг олон талын эх сурвалжтай, тэнцвэртэй, аливаа нэг нам, хүчний сонирхлоос ангид, сэтгүүлчийн хувийн дүгнэлтгүй, мэргэжлийн стандартын түвшинд бодитойгоор хүргэдгээрээ бусдаас ялгаатай билээ. Тодруулбал, бүгдийг бус, чухлыг ч биш, үзэгчдийн заавал мэдэж байвал зохих мэдээ, мэдээллийг түгээдэг гэсэн үг.

"Үзэгчээ хүндэлж хуулиа дээдэлнэ" гэсэн уриатай Монгол телевиз нь байгуулагдсан цагаасаа эхлэн зохиогчийн эрхтэй гадаад нэвтрүүлэг, контентуудыг үзэгчдийн хүртээл болгохыг зорьж иржээ. Үүнд гадаадын мэдээллийн агентлаг, телевизүүд таатайгаар хандаж, өөрсдийн контентуудаа Монгол улсад гаргах онцгой эрхтэйгээр худалдахад бэлэн байгаагаа илэрхийлж, хамтран ажиллах болсон нь нэгийг хэлэх буй за. Монголын телевизийг сонирхсон эдгээр саналууд дээр үндэслэн Австралийн ABC корпораци болон Солонгосын EBS 2009 онд, KBS телевиз, Их Британийн Associated Press, спортын SNTV агентлаг, Бразилийн Globo телевизтэй тус тус гэрээ байгуулж, хамтын ажиллагаагаа эхлүүлжээ. Худалдан авсан нийт контентуудаас Монгол телевиз сонголт хийж, 2010 онд телевизийн олон ангит болон баримтат кино 30, телевизийн шоу, баримтат нэвтрүүлэг, хүүхэлдэйн кино олныг орчуулж, мэргэжлийн өндөр түвшинд дуу оруулан үзэгчдэд толилуулав. Маркетингийн зүгээс гадаад, дотоод хэмээн ялгалгүй аливаа контентийн үнэлэмжийг өсгөх тал дээр онцгой анхааран ажиллаж байгаа нь Монголдоо шинэлэг зүйл болж буй юм. Монгол телевиз хэдийгээр арилжааны телевиз боловч танин мэдэхүй, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хөгжилд хувь нэмрээ оруулахад голлон анхаарч ирснийг дурдахгүй өнгөрч болохгүй.

Үүний дотроос хүүхдийн нэвтрүүлгээрээ бусдаа онцгойрдог. Жишээлбэл, "Тог тог" хүүхдийн нэвтрүүлэг цэвэр танин мэдэхүйн шинж чанартай бөгөөд амьд хөгжим, дуу, бүжиг, мэргэжлийн жүжигчдийн тоглолтыг багтааж чадсан төдийгүй Монгол улсын Оюуны өмчийн газраар баталгаажсан хүүхэд бүрийн хүсэн хүлээдэг нэвтрүүлэг болсон билээ. Монгол телевиз өөрийн нэвтрүүлгээ үзэгчдэд хүргэхдээ хамгийн сүүлийн үеийн JVC фирмийн видео камерийг ашиглаж, дүрсний хувьд SMPTE 292M стандартын дагуу HD 720p50-1280x720 pixel /гадуур сурвалжлага/, HD 1080i-1920x1980 pixel /студийн бичлэг/ нягтралшилттайгаар агаарт цацдаг. Хэрэглэгчдийн хүлээж авах хүчин чадлаас шалтгаалж 720x576 нягтралшилттай PAL системээр, дууны гаралтын хувьд AES/ EBU стандартын дагуу PAL системээр нэвтрүүлдэг бөгөөд эвлүүлгийг Final Cut Pro, GV Edius программ дээр хийж байгаа нь мөн л манайдаа анхдагч юм.

Олон улсын стандартын дагуу тоногдсон шууд нэвтрүүлгийн хоёр студи, 600 цагийн багтаамжтай хоёр сервер, дуу оруулалтын хоёр студи, эвлүүлгийн найман цэг бүхий өөрийн байрнаасаа Чингэлтэй дэх 58 метр өндөр цамхагт байрлах 10 киловаттын хүчин чадалтай нэвтрүүлэх станцаар дамжуулан нэвтрүүлгүүдээ Улаанбаатар хотод цацаж байна. Одоогоор

ямар ч энэ технологийг нэвтрүүлээгүй байна. Үүний сацуу 2010 оны намар АРТ Satellite Holding компанийн гурван хиймэл дагуулын нэг болох АРЗТАКЛ/ өндөр хүчин чадал бүхий сүүлийн үеийн технологиор тоноглогдсон хиймэл дагуулаар үндэсний сувгуудыг дахин дамжуулж буй DDish TV-д нэгдсэнээр орон нутагт төдийгүй Солонгос, Хятад, Орос, Казахстан, Энэтхэг зэрэг Азийн 20 гаруй оронд эфирээ дамжуулж эхэлсэн байна.

Түүнчлэн 2010 оны эхээр дэлхий дахинаа хурдацтай хөгжиж буй хамгийн сүүлийн үеийн технологи болох IPTV буюу кабелийн телевизийн дараагийн үе болох 1920x1080 нягтаршилттай FULL HD телевизийн үйлчилгээг шилэн кабелийн тусламжтайгаар өрх бүрт хүргэх үйлчилгээнд нэгдэн орсноор үндсэн зорилго болох HD технологийн гайхамшгийг үзэгчдэд жинхэнэ ёсоор мэдрүүлэх боломжтой боллоо. Тэгэхээр удахгүй та бид HD телевизийн давуу талыг мэдэрч эхэлнэ гэсэн үг. HD телевиз нь олон талын давуу талыг бидэнд олгох болно. Ганцхан жишээ дурдахад л HD форматаар хийгдсэн мэдээ, нэвтрүүлгүүд нь 100 жилээр ч хадгалагдах боломжтой байгаа нь нэг ёсны архивын үүргийг давхар гүйцэтгэж байгаа хэрэг билээ.

Монгол телевизийг үзэхээр сонголт хийсэн хэн боловч дэлгэцийнхээ баруун доод буланд буй бичгийг нэг ажаарай. Та HD-г сонгож байна.

### **Амжилтын нууц**

- Монгол улсад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг өдгөө 20 гаруй компани, хувь хүн аваад байгаа билээ. Түүний дотроос уг зөвшөөрлийг зөвхөн Монгол телевиз хууль ёсны дагуу авчээ.
- Тус телевиз нь нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа бүрэн ухамсарлаж элдэв хууль бус сурталчилгаа, нэвтрүүлгийг эфиртээ гаргадаггүй.
- Монгол телевиз үйл явдлыг олон талын эх сурвалжтай, тэнцвэртэй, аливаа улс төрийн нам, хэсэг бүлгийн ашиг сонирхлоос ангид, сэтгүүлчийн хувийн дүгнэлтгүй, мэргэжлийн түвшинд хүргэдэг.
- Оюуны өмчийн хууль, тогтоомжийг дээдлэн мөрдөж ажилладаг ёс зүйтэй телевиз.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [mongol.tv/mn](http://mongol.tv/mn)

Байгуулагдсан он: 2009 оны 09 сарын 10-ны өдөр. Компанийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Үйл ажиллагааны чиглэл: Дуу, дүрсний өндөр тодролт, нягтралшилттай HD форматын манай ууган телевиз.



## УУЛ УУРХАЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙСЭН БРЭНДҮҮД



### Монгол брэнд - Ухаа худаг

Одоогоос гурав, дөрөвхөн жилийн өмнө эл хуль оргисон тал байсан Ухаа Худагийн хөндийд өнөөдөр дэд бүтцийн олон төсөл зэрэг хэрэгжиж, их бүтээн байгуулалтын талбар болоод байна. Ажлын эрч хүч жинхэнэ утгаараа мэдрэгдсэн энэ хөндийд MCS групп, Петровис ХХК, Шунхлай групп зэрэг үндэсний хэмжээний томоохон компаниудын хамтын хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан Энержи Ресурс ХХК үйл ажиллагаа явуулдаг юм.

Харьцангуй маш богино хугацаанд дэлхийн түвшний уурхайн үйл ажиллагааг нэвтрүүлж чадсан Ухаа Худаг уурхай болон түүнийг бүрдүүлэгч дэд бүтцийн шинэлэг төслүүдийн талаар юуны өмнө өгүүлье.

Жилд таван сая тонн нүүрс угааж баяжуулах хүчин чадал бүхий Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний модуль 2011 оны эхний хагаст ашиглалтанд орлоо. Ингэснээр монголчууд байгалийн баялгаа түүхийгээр нь гадагш нийлүүлэх биш дотооддоо нэмүү өртөг шингэсэн

бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болж байгаа юм.

Энэ мэтчилэн нийт гурван модуль үе шаттайгаар ашиглалтанд орсноор энэхүү үйлдвэр жилдээ 15 сая хүртэлх тонн нүүрс угааж, боловсруулах хүчин чадалтай болох юм. Тус үйлдвэр Австралийн Сежмен компанийн зураг төслөөр баригдаж байгаа бөгөөд бүтээмж өндөртэй, иж бүрэн автомат удирдлагын системтэй байх аж. Нүүрс баяжуулалтын технологи нь дэлхийн сонгодог жишигт хүрсэн байхаар төлөвлөсөн байна. Энэ нь хүндийн хүчний арга, төвөөс зугтах болон хөвүүлэн баяжуулах гэсэн гурван аргачлалыг хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Ингэснээр нүүрсний гадаад зах зээл дээр өрсөлдөх чадвар нэмэгдэж, эдийн засгийн үр ашигтай, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн экспортлох боломж бүрдэнэ. Мөн 18 мегаваттын цахилгаан станцыг Монгол инженерүүдийн мэдлэг, ур ухааныг шингээж дотоодын гүйцэтгэгч компаниудын хамтын хүчээр босгосон бөгөөд энэ нь бас л тухайн салбартаа монголчуудын гараар хийгдсэн анхдагч бүтээн байгуулалт боллоо. Станц нь уурхайн цахилгааны нийт хэрэгцээг хангаад зогсохгүй Цогтцэций сумыг эрчим хүчээр хангах юм.

Түүний бас нэг давуу тал нь орчиндоо зохицсон байдал. Усаар хомс говь нутгийн байгалийн онцлогт тохирсон хуурай хөргөлтийн систем, усны "О" хэрэглээ гээд олон шинэ шилдэг технологийг агуулсан байна. Говь нутагт усны асуудлыг эхэлж харж, хангах асуудлыг шийдэх зан заншил, уламжлал малчдад хүртэл суусан байдаг. Энержи Ресурс энэхүү асуудлаа хэрхэн шийдсэнийг нь сонирхоё.

Усан хангамжийн томоохон төсөл хэрэгжсэнээр уурхайн бүх усны хэрэгцээг хангаад зогсохгүй Цогтцэций сумыг ч усаар найдвартай хангана. Системийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох усан сан л гэхэд Монголд хамгийн томд тооцогдох 56 мянган шоо метрийн багтаамжтай бөгөөд одоо бүрэн хүчин чадлаараа ажиллахад бэлэн болжээ.

Говь нутгийнхан усыг алтнаас дутуугүй үнэлдэг. Энержи Ресурс ч гэсэн усыг гамнаж, шинэ технологийн хүчээр үйлдвэрлэлийн зориулалтын усыг 96 хувь хүртэл эргүүлэн ашиглах юм. Энэ тал дээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Aquaterra компанитай хамтарч ажилласан байна. Үйлдвэрийнхээ эхний модулийг барьж байгуулж, усныхаа асуудлыг шийдчихсэн Энержи Ресурс бүтээгдэхүүнээ тээвэрлэх зам хэрэгтэй болов.

Энэ шаардлагын үүднээс Ухаа Худаг уурхайг Гашуун сухайт боомттой холбосон 245 км хатуу хучилттай авто замыг барьж эхлэв. Дотоодын зам барилгын салбарт тэргүүлэгч долоон компани уг ажлын гүйцэтгэгч бөгөөд 2011 оны 2-р хагаст ашиглалтанд орохоор төлөвлөгдсөн байна. Энэ нь Монголын хувьд анхны хүнд даацын зам гэж болно. Өмнө нь 100 тонноос дээш даацтай автомашин зорчих үйлдвэрлэлийн зориулалттай авто замыг цэвэр дотоодын нөөц бололцоон дээр тулгуурлан барьж байгаагүй билээ. Шинэ зам ашиглалтанд орсноор уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэлт нэмэгдэж, тээвэрлэлтийн зардал буурах төдийгүй тоосжилт багасч, нутгийн байгаль орчны тэнцвэрийг хадгалахад чухал нөлөө үзүүлэх юм.

Нүүрсний уурхайн дэд бүтцийн хамгийн чухал хэсэг нь мэдээж төмөр зам. Энэ үүднээс уурхайг Гашуун сухайттай холбосон төмөр зам барьж байгуулахаар их хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхэлсэн төдийгүй техник, эдийн засгийн үндэслэл, суурь судалгаан дээр нь Германы Төмөр Замын Концернтай хамтран ажиллажээ. Үүний үр дүнд

ойролцоогоор 240 орчим км төмөр зам тавигдах бөгөөд жилд 15 сая хүртэлх тонн нүүрс тээвэрлэх боломж бүрдэх аж. Энэ ажил эхэлснээр Монгол дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай анхны төмөр зам гэж тооцогдоно. Мөн уурхайн ажиллагсдын төдийгүй орон нутгийн иргэдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн Таван Толгой нисэх онгоцны буудлыг Энержи Ресурс компани барьж, 2009 онд ашиглалтад оруулсан бөгөөд одоогийн байдлаар тус буудал 7 хоногт таван удаагийн тогтмол нислэгийг хүлээн авч байна.

Энержи Ресурс нүүрс олборлолт, хөрс хуулалт, мэргэжлийн ажилчдын сургалт дадлагажуулалтыг Австралийн дэлхийд алдартай Лейтон Ази компаниар гүйцэтгүүлдэг. Ер нь Ухаа Худаг уурхайн дэд бүтцийн төслүүдийг Parsons, Brinck erhoff, Wilbur Smith Associates, Aquaterra зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компаниудтай хамтран хийж байгаа нь уг бүтээн байгуулалтын цар хүрээг илтгэж байна. Энэ бол дэлхийн стандартыг дэргэдээ авчран харж, түүнээс суралцаж байна гэсэн үг. Нөгөө талаас Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниудаас Энержи Ресурс цэвэр үндэсний хөрөнгө оруулалттай гэдгээрээ ял гардаг бөгөөд 2010 оны 10-р сард Хонконгийн хөрөнгийн бирж дээр Mongolian Mining Corporation нэрээр амжилттай гарч чадсан юм.

Цэвэр дотоодын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан компани ийнхүү олон улсын хөрөнгийн зах зээлийн шалгуурыг давж, дэлхийн хөрөнгө оруулагчдад хувьцаагаа санал болгосон гэдэг утгаараа Энержи Ресурсын хувьд төдийгүй Монгол улсын түүхэнд онцлох үйл явдал болсон билээ. Тус компани хэмжигдэхүйц, бодитой бөгөөд ухаалаг бизнесийн загварт үндэслэн Ухаа Худаг уурхайг хөгжүүлж, төслийг бүхэлд нь тухайн салбарын хөгжлийн түүчээ, загвар болгож байна. Хэдэн арван сая жилийн өмнө үлэг гүрвэл нутаглаж байсны ор мөр эдүгээ хүртэл хадгалагдан үлдсэн энэ нутагт дэлхийд ховорхон аварга техник, хүнд даацын машин механизмууд үлэг гүрвэл "бэлчих" мэт сүрдэм харагдана. 2010 онд байгуулагдсан уурхайн засварын төв л гэхэд нэг дор 4-6 ширхэг CAT 793 авто самосвалыг засварлах боломжтой юм.

Энержи Ресурс бол нийгмийн хариуцлагаа бүрэн ухамсарласан компани. Энэ ч утгаараа нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлэх, тэдний ирээдүйн тогтвортой хөгжлийг хангахад тус дэм үзүүлэх чиглэлд байнгын анхаарал хандуулдаг. Төсөл бодит утгаараа хэрэгжиж эхлээгүй байхад ч орон нутгийн иргэдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний санаа бодлыг төслийн хэрэгжилтэд тусгахаас аваад уурхайн ашиглалтын дараах нөхөн сэргээлтийн бодлогыг ч ярилцан зөвлөлдөж байв. Эндээс тус компанийн засаглалын шинэлэг дүр төрхийг харж болох билээ.

2006 оноос хойш нийт таван удаагийн нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг Өмнөговь аймгийн зарим сумдыг хамран зохион байгуулжээ. Энержи Ресурс зөвхөн өөрийн уурхайн төсөлд анхаарах төдийгүй сум орон нутгийн иргэдийг чадавхижуулах төсөл, хөтөлбөрийг ч хэрэгжүүлдэг. Энэ нь эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, бизнесийн чиглэлийг хамардаг. Одоогийн байдлаар мянга гаруй ажлын байрыг шинээр бий болгосон бөгөөд тэдний ихэнх хувийг Өмнөговь аймгийн иргэд эзэлж байгаа аж.

Дэлхийн зах зээлд "Монгол" хэмээгч нэрийг дуурсгаж, Монголыг олон улсад таниулах, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чиглэлд томоохон алхам хийж чадсан Энержи Ресурс олж авсан амжилтаа улам бүр бататган, төслүүдийнхээ цар хүрээг нэмэгдүүлсээр

байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, тэргүүлэгч зэргийн менежмент болон технологийг Монголд нутагшуулж, монголчууд өөрсдийн хүчээр юу хийж чаддагийг харуулж чадсанд энэ компанийн амжилтын хөшүүрэг оршдог болов уу.

### **Амжилтын нууц**

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, тухайн салбартаа дэлхийд тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллаж, Монголд анхдагч технологийн шийдлүүдийг нэвтрүүлсэн.

- Компанийн засаглалыг бодит утгаар хэрэгжүүлж, дотоодын тэргүүн туршлагыг олон улсын стандартад нийцсэн, жишиг үйл ажиллагаатай хослуулж чадсан.

- Үндэсний хөрөнгө оруулалттай компаниудаас анх удаа олон улсын хөрөнгийн биржид амжилттай гарч чадсан. Монголоор овоглосон тэргүүлэгч зэргийн коксжих нүүрсний брэндийг бий болгож, бүс нутагт төдийгүй дэлхийд өрсөлдөх зорилготойгоор менежментийн цогц бодлогыг хэрэгжүүлж байгаа.

- Үйл ажиллагааныхаа бүтэц бүрэлдэхүүн болсон эрчим хүч, усан хангамж, хүнд даацын авто зам болон төмөр зам, нисэх буудал зэрэг дэд бүтцийн асуудлуудыг өөрийн хүчээр дэлхийн стандартад нийцэхүйц түвшинд шийдвэрлэсэн.

- Үйл ажиллагаагаараа дамжуулан Монгол улсын эдийн засаг, төсвийн орлогод бодитой хувь нэмэр оруулж чадахуйц хэмжээнд хөгжсөн төдийгүй шинэ ажлын байрыг олноор бий болгож, төслүүдийн хэрэгжилтэнд дотоодын компаниудыг олноор татан оролцуулах замаар орон нутгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд дорвитой үүрэг гүйцэтгэж байна.

Уурхайн одоогийн үйл ажиллагаанд анхаарахаас гадна орон нутгийн ирээдүйн хөгжил, байгаль орчны чиглэлд хэтийг харсан бодлого баримталж, дэлхийн стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулдаг.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.energyresources.mn](http://www.energyresources.mn) Байгуулагдсан он: 2005 он

Компанийн хаяг: Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс 8 км, Аймгийн төв Даланзадгад хотоос зүүн тийш 90 км, УБ хотоос өмнө зүгт 540 км, Монгол-Хятадын хилээс 245 км, Оюутолгой зэс алтны ордоос 150 км

Үйл ажиллагааны чиглэл: Коксжих нүүрсний үйлдвэрлэл ба экспорт



## Бие сэтгэл дүлаацуулсан брэнд

Хүнд нэг удаа хэрэглэгдэх бус очсон газар, орсон барилга байгууламж, гэр оронд нь төдийгүй хаана л бол хаана хэрэглэгчээ тосч, хүлээж, уулзаж, сайхан сэтгэгдэл төрүүлж байдаг ийм брэндийн нэг бол Шарын голын уурхайн брэнд юм. Аль Богд хаант Монгол улсын үед Хүдэр харуулын сав газар гэж ерөнхийд нь нэрлэдэг байсан нутагт 1958 оноос Монгол, Зөвлөлтийн геологчид нарийвчилсан хайгуулаар нүүрсний томоохон орд байгааг тогтоожээ. Тухайн үеийн хэрэгцээ шаардлага, хөгжилд голлох нөлөө үзүүлж, улс орны гал голомтыг бадрааж "Өөрийгөө шатааж өрөөлийг дулаацуулсан" Шарын голын хар алт гарч ирсэн цагаасаа Монголд нэгэн томоохон суурин газрыг байгуулах суурь болсон юм. Уурхайн анхны барилгын суурь 1961 оны 10 дугаар сард тавигдаж, 1965 оны 4-р сард улсын комисст хүлээлгэн өгчээ. Анхны нүүрсийг арав гаруй вагонд ачиж "Шарын голын нүүрс эх орны хэрэгцээнд" гэсэн лоозон хадсан цуваа Дархан хотын зүг хөдөлсөн байна. Ингэж Дархан, Сэлэнгийн бүс нутаг, төвийн бүсийн түлш эрчим хүчний системийн хэрэгцээг хангах Шарын голын хар алт үнэ цэнээ мэдрүүлж эхэлжээ. Өнгөрсөн зууны 80-аад оны дунд үеэс үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хийж 60 тоннын даацтай думпкарыг 100 тонныхоор, Белаз 540-г Белаз 548-аар сольж байв. Жилдээ 2.5 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай уурхайн өргөтгөл хийгдэж уурхайчдын орон сууц, эмнэлэг, сургууль зэрэг олон барилга байгууламж нэмэгдэж баригдсан байдаг.

Жилдээ арван сая шоо метр хөрс хуулж, хоёр сая гаруй тонн нүүрс олборлож, төвийн бүсийн эрчим хүчний системийн 60 гаруй хувийг нүүрсээр хангаж байв. Шарын голын уурхай аль ч нийгмийн үед Монгол улсын түлш эрчим хүчний судсан дээр суусаар иржээ. Энэхүү амин чухал хэрэгцээтэй чанар нь түүнийг яах аргагүй брэнд болгосон юм. Энэ бүхэн маш нарийн эмх журам, ажпын ур дүй, эрэмбэ дараалал, уялдаа холбоо, шинэчлэлт өөрчлөлттэй нийлж байж нэг цогц болдог нүсэр бөгөөд нүргээнтэй ажил. Уламжлал, туршлага, баатарлаг үйлс, бахархах сэтгэл энэ брэндэд шингэсэн байдаг. "Гэрлэж амжаагүй явна" кинон дээрх шахмал түлш үйлдвэрлэх санаачлага хүртэл тус уурхайгаас гарч байсан талаар өгүүлдэг. Тэр үед олон шинэ содон зүйл санаачилж уурхайн ажилд нэвтрүүлж байсан нь Шарын голын уурхайн уламжлалт онцлог юм.

Уурын зуухны түлш дамжуулах систем, думпкарыг алсын удирдлагаар буулгах автомат систем, автомашины хөдөлгүүрийн гэмтлийг шалгах стенд, илчит тэрэгний тохируулгыг шалгах хэрэгсэл, илчит тэрэгний рестаг буюу туршуур төхөөрөмж, мөрөгцөгийн галыг унтраах машин зэрэг олон шинэ зүйлийг санаачилж зохион бүтээсэн нь ажлын бүтээмжид нөлөөлж байв. 1987 онд хар алтныхаа хажуугаар шар алт олборлож эхлэв. Шарын голын уурхайгаас ингэж Бурхантын алтны орд газарт үйлдвэр байгуулах ажлыг зохион байгуулж эхэлсэн явдал ашиг орлогыг нь нэмэгдүүлж байжээ.

Тус уурхай тавь шахам жил үүрэг хариуцлагаа хором ч тасалдуулахгүй ажиллаж ирсэн



нь брэндээ дайчин, баатарлаг төрхтэй болгосон юм. 1992 оноос Японы Комацу фирмийн бульдозер, Англи-Хятадын хамтарсан үйлдвэрийн Терекс, дэлхийн хүнд механизмын тэргүүлэгч брэнд болох Кат загварын техникүүдийг оруулж ирэв.

Олон жил хөрс хуулалтын төлөвлөгөө таслагдаж энэ нь хураагдсаар байгаад маш том бэрхшээлийн хар уул боссон байлаа. Энэ нь явж явж механикжуулалтын төсөлд саад тотгор болов. Тиймээс түүнийг орлох шийдлүүдийг гаргаж ирэх шаардлага тулгарчээ. Үнэндээ бизнесийн цоо шинэ орчин руу хуучин байдлаараа яваад орчихсон болохоор энэ зэргийн бэрхшээл хүндрэл гарах нь тодорхой юм. Хамгийн гол нь зөв гарцыг олох нь чухал байлаа. Ингээд уурхайн инженер, эдийн засагчид цаг наргүй сууж байж "Шарын голын уурхайн үйлдвэрлэлийн 1997-2010 оны үндсэн чиглэл" нэртэй хөтөлбөр боловсруулжээ. Уурхайн өмчийн хэлбэрийн хувьд алгуур замыг туулж, аажим аажмаар зах зээл рүү явж байлаа. 1995 оны 2-р сарын 21-нд 20 ба 80 гэсэн харьцаагаар төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болов. Дараа нь 2003 оны арваннэгдүгээр сард зуун хувь хувийн өмчлөлд шилжсэн билээ. Энэ нь уурхайн түүхийн цоо шинэ үеийг эхлүүлсэн юм. Төрийн өмчит компани болон хувийн өмчид тулгуурласан компани хоёрын ялгааг ажиллагсад болон харилцагчдад ойлгуулах, мэдрүүлэх нь төвөгтэй байлаа. Үүнд цаг хугацаа болон ажиллагаа хэрэгтэй болохоор уг брэнд гэгээрүүлэх шинж чанарыг өөртөө шингээж шинэчлэгдсэн дүр төрхөө харуулж эхлэв.

Хувьчлагдсан жилээ буюу 2004 онд 2703.0 мянган шоо метр хөрс хуулсан нь уурхайн түүхэнд авто тээврээр хөрс хуулсан хамгийн дээд үзүүлэлт байлаа. Найдвартай, итгэлтэй, өөриймсөг сэтгэлтэй Б.Батмөнх нарын өмчлөгч нь уурхайн ирээдүйг өөдрөгөөр харж, тооцоолж байв.

Хамгийн гол нь бэрхшээлийг олж харах, түүнээс гарах арга замыг зөв тодорхойлох хэрэгтэй боллоо. Ер нь нүүрсний салбар зах зээлд шилжиж чадаагүй, тэнд ашгийн тухай ойлголт байсангүй. Зах зээлийн нийгэмд зах зээлийн бус зарчмаар ажиллаж, торгуулийн суман шиг үүрэг гүйцэтгэж сөхрөхдөө хүрч байсан энэ брэндийг сэргээх, хөгжүүлэх шаардлагатай болов. Орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулах чиглэлээр олон ажил санаачилж, бүтцийн өөрчлөлт хийлээ. Компанийн стратегийг тодорхой болгож менежментийн шинэчлэл явуулав. Хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийн хөгжлийн үндсэн чиглэлийг баталлаа.

Үүнд нүүрс олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг бүрэн хангах, нүүрс экспортлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нүүрсний чанарыг сайжруулж боловсруулах, дагалдах бүтээгдэхүүн болох өнгөлгөөний болон даацын тоосго үйлдвэрлэх ажлуудыг богино хугацаанд хийхээр тусгажээ. Эдгээрийг хийх хугацаанд технологи, үйл ажиллагааны шинэчлэл ч хамт явагдаж байв. Далд уурхайн нэвтрэлтийн аргаар нүүрс олборлох, комплексээр нүүрс олборлох хагас үйлдвэрлэлийн туршлагыг амжилттай эхлүүлж ажил хэрэг болголоо. Хятадын ЕВ маркийн комбайнаар хийсэн энэхүү туршилтын олборлолт Монголдоо анхны тохиолдол байв. Ингэснээр нүүрсний тээврийн зардлыг эрс бууруулж жил тутам 700 гаруй сая төгрөгийн түлш хэмнэх болжээ. Өмнө нь ор тас орхигдож ирсэн нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн чиглэлээр хийж эхлэв.

Уурхайнхаа спортын ордон, уурхайчдын амралтыг сэргээн засварлаж шинэчлэв. Ном уншлагын газар нээж, офисийн барилгаа ч засч цэмцийлгэлээ. Ажиллагсдынхаа цалинг жил

бүр тодорхой хувиар нэмж, тэдний тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүллээ. Тус уурхайг Австралийн Australian Xstrata company сонирхож эхэлснээр хамтран ажиллах ажлын хэсэг байгуулсан төдийгүй олборлолтын стратегийн иж бүрэн судалгааг Германы ДВТ компаниар хийлгэжээ. Мөн 10 мянган тн нүүрсийг БНХАУ руу экспортлож, тэр нь Хятадын Далайн боомт буюу Порт-Артурт хүргэгдэв.

Шинэчлэлийн хүрээнд ОХУ-ын Кемерово мужийн Междуречинскт туршлага судалж, АНУ-ын Superior Highwall Mining технологийг нэвтрүүлэхээр судалгаа тооцоо хийжээ. Энэ нь хүн орохгүйгээр гаднаас нь шууд комбайнаар нэвтрэлт хийж нүүрс олборлох технологи юм. Нүүрсний давхаргын зузаан нь дөрвөн метр байх ёстой учраас Шарын голын нүүрсний зузаан давхаргад тохируулах аргачлалыг судалж байгаа аж. Мөн ОХУ-д нүүрс экспортлох хэлэлцээр хийж 80 мянган тонныг гаргах болсон ч энэ хэмжээг нэмэх саналыг нөгөө талаас тавив. Бас жилдээ 50 мянган тонн утаагүй түлш буюу хагас кокс болон шатдаг хий үйлдвэрлэх хүчин чадалтай нүүрс хийжүүлэх үйлдвэрийг 2009 онд Дархан хотод барьж дуусгажээ. Тус уурхайн нүүрсний нөөцийг баталгаажуулж, улмаар нөөц өсгөх олон улсын Жорк стандартаар шинэчлэл тогтоох 17900 тууш метр өрөмдлөгийн ажил хийгдэж, таван сая ам.долларыг хайгуул судалгаанд зарцуулжээ. Ингэснээр 374 сая тн нөөц тогтоож, нэмэлт хувьцаа гаргаж шаардлагатай хөрөнгийг босгох ажилдаа оров.

Нэгэнт тогтоогдсон нөөц болон хайгуулын үр дүнд тулгуурлан шинээр ил уурхай байгуулах боломжтой учраас түүний техник, эдийн засгийн үндэслэлийг эхлүүлэв. Мөн гадаад зах зээлийн худалдан авагчдын хэрэгцээ шаардлагын дагуу нүүрс угаах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл тавигдаж экспортод гарах бэлтгэл ажил хийгдэж байна. Шарын голын уурхай нь Монголын хөрөнгийн зах зээл дээрх хамгийн нээлттэй компани бөгөөд цаашдаа туулж өнгөрүүлсэн дөчин таван жилтэйгээ цаг хугацааны хувьд тэнцэх ирээдүйг бий болгохоор зорьж байгаа юм. Тэрхүү ирээдүй нь уул уурхайн анхдагч, уламжлалт брэндийг цаг үеийн шаардлага хэрэгцээнд нийцүүлэн олон улсын стандартыг хангах орчин үеийн шинэчлэгдсэн уул уурхайн компани болгох их өрнөлтэй давхцаж байна.

Брэндүүд өөрийнхөө ирээдүйг маш сайн харж, явах замаа товчилж тодорхойлж, боломжийг алхах тоолондоо олж авч байдаг. Шарын гол хүнийг ажилд сургадаг хөдөлмөрийн том талбар, амьдралын их сургууль байсаар ирлээ. Эндээс уул уурхайн салбарын төдийгүй улс орныг удирдагчид хүртэл амьдралын гараагаа эхэлж байсан болохоор авьяаслаг менежерүүдийг төрүүлж гаргадаг боловсон хүчний уурхай ч гэж хэлж болно. Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат тус уурхайн Ерөнхий инженерээр ажил амьдралынхаа гарааг эхэлж байсан гэдэг. Шарын голын уурхай шинэ стратеги, менежментийг барьж ажиллан, уламжлалт компаниас орчин үеийн брэнд бүхий компани болгохоор ажил ид ундарч байна.

### **Амжилтын нууц**

- Төвийн болон хойд бүсийн эрчим хүчний хэрэгцээнд 46 жил брэндээ нийлүүлж, ашиг олохыг урьтал болгохгүй ард түмний ая тохьтой амьдрах орчин, эх орны хөгжлийн нүүр царайг харуулж ирсэн түүхэн гавьяатай. Нэгэн цагт төвийн эрчим хүч, Дархан, Сэлэнгийн бүс нутгийн нүүрсний хэрэгцээний 60 хувийг хангаж байсан эх оронч брэнд.

- Зөвхөн гадаадын технологийг ашигласангүй. Инженер, техникийн ажилчид нь шинэ

бүтээл, оновчтой санаачлага гаргаж ажлын бүтээмжийг нэмэгдүүлж ирсэн. Томоохон хэрэглэгчиддээ төдийгүй айл өрхийн хэрэгцээнд зориулж шахмал түлш үйлдвэрлэх технологийг аль 80-аад оны үед боловсруулж байжээ.

- 2003 онд зуун хувь хувийн өмчид шилжсэнээр шинэ менежмент, оновчтой шийдэл, найдвартай үйлчилгээг гол болгож ажилласан. Хувьчлагдсан жил буюу 2004 онд авто тээврээр 2703.0 мянган шоо метр хөрс хуулсан нь уурхайн түүхэнд гарсан амжилтын хамгийн дээд үзүүлэлт юм.

- Шинэ технологи. Монголдоо анх удаа Хятадын ЕВ маркийн комбайнаар хийсэн нэвтрэлтийн олборлолт нь нүүрс олборлох зардлыг хэмнэх болов.

- Гадаад түншлэл. Гадаадад нүүрс экспортлох гарц олж, цаашид энэ үйл ажиллагаагаа идэвхижүүлэн, жилдээ 50 мянган тонн утаагүй түлш буюу хагас кокс, шатдаг хий үйлдвэрлэх хүчин чадалтай нүүрс хийжүүлэх үйлдвэр Дархан хотод барьж ашиглалтад оруулав. Мөн Australian Xstrata Company-тай хамтран ажиллах болж, Германы ДВТ компаниар уурхайн олборлолтын стратегийн иж бүрэн судалгааг хийлгэсэн. ОХУ-ын Кемерово мужийн Междуречинскт туршлага судалж, АНУ-ын Superior Highwall Mining технологийг нэвтрүүлэх судалгаа явуулав.

- Шинээр нарийвчилсан хайгуул хийхэд таван сая ам.доллар зарцуулж, 374 сая тонн нүүрсний нөөцийг тогтоов. Үүнд түшиглэж, шинээр ил уурхай байгуулах болон нүүрс угаах үйлдвэр барих ажлыг эхлүүлжээ.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.sharyngol.com](http://www.sharyngol.com) Байгуулагдсан он: 1965 он

Компанийн хаяг: Чингисийн өргөн чөлөө-13, I хороо, СБДүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, Натур Тур компанийн байр, 4 давхар

Үйл ажиллагааны чиглэл: Уул уурхай, нүүрс олборлолт

**PETRO MATAD**



## Эрсдэлийг даван туулсан брэнд

Монгол оронд газрын тосны судалгааны ажил дөнгөж эхэлж байсан үе буюу 2004 оны арванхоёрдугаар сарын 31-нд Шинэ жилийн баярын салют буудах мөч дөхөж байхад Петровис ХХК-ийн бүрэлдэхүүнд Петроматад мэндлэв. Газрын тосны талаар 1990 оноос хойш багагүй ярьдаг болоод байсан ч төрийн тэргүүний дээлийн энгэрийг мялаахаас цааш хэтрээгүй байв. Мэдээж улсын төсвөөр судалгаа, шинжилгээний ажил хийх нь эрс хумигдаж, хувийн хэвшлийнхэн хөл дээрээ тогтож чадаагүй байв. Энэ салбарын хайгуул нь аз туршсан зүйл юм. Асар их зардал гаргаж, эрсдэл амсах нь их. Ийм юм руу зориглоод явж орчих зүрхтэй үндэсний компани олдохгүй байлаа. Чухам энэ үед Петровис компани тухайн салбар луу оржээ. "Энэ Оюунгэрэл чинь юу л хийж байна даа" гэх хүн ч олон байв. Түүний шийдэмгий, тооцоотой үйл ажиллагаанд зарим нь итгэж ч байсан биз.

Ямартаа ч Петроматад хэмээх үндэсний газрын тосны судалгааны компанийг тэрээр анхлан байгуулав. Петровис НИК компаниуд газрын тосны бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх боломжийг хайж байгаа нь сайхан хэрэг. Үүний цаана хатагтай Ж.Оюунгэрэл импортлогчдын шантаажийг эсэргүүцэж, ийм зоримог эрсдэлтэй алхам хийсэн гэдгийг олон хүн мэдэхгүй. Манай газрын тосны хэтийн төлөв гэдэг угаасаа ээдрээтэй, улс төр, бизнес сурталчилгаа холилдсон "хярамцаг" шиг зүйл байлаа. 1990 оноос өмнө Зөвлөлт, Монголын томоохон эрдэмтэн, мэргэжилтнүүд Монголд эдийн засгийн үр ашигтай олборлох тос байхгүй гэж үздэг, бичдэг байв. Петроматад компанийн судалгаа хийхээр сонгож авсан Матад ХХ хэмээх талбай нь Монгол орны зүүн хэсэгт орших Тамсагийн сав газарт багтах бөгөөд газрын тос илрүүлэх хамгийн өндөр магадлалтай газарт тооцогдож ирсэн юм. Тиймээс энэ нутаг харьцангуй сайн судлагдсан байв.

1979-1983 онд хуучин ЗХУ-ын газрын тосны асуудлаар мэргэшсэн ВНИГН Институт Монгол оронд төрөлжсөн судалгаа хийгээд энэ нутгийн тосны геологийн нөөцийг 4.6-6.0 сая тонн, үүнээс олборлож болох тос 0.46-0.6 сая тонн гэсэн тооцоо гаргажээ. Энэ нь манай орны нэг жилийн хэрэглээний хагастай тэнцэх хэмжээ гэсэн үг. Яагаад ч юм нөхцөл байдал өөрчлөгджээ.

Үүнээс долоон жилийн дараа ЗХУ-ын өөр нэг ВНШЗГ Институт тус талбайн геологийн нөөцийг 75 сая тонн буюу түрүүчийнхээс даруй 12.5 дахин өсгөж гаргасан байлаа. Тэгвэл 2002 онд Соко компанийн захиалгаар Тамсагийн сав газрыг судалсан газрын тосны нөөцийн үнэлгээ хийх олон улсын эрх бүхий Канадын Фекете компани уг талбайн геологийн нөөцийг 1.26 тэрбум тонн буюу дээр өгүүлснээс даруй 2100 дахин их гэж гаргасан байдаг. Ийм олон толгой эргэм тоонуудын учрыг олж, хужрыг нь тунгаагаад хамгийн оновчтой замыг сонгож, өндөр эрсдэлтэй шийдвэр гаргана гэдэг түүнээс өмнө хэн ч хийгээгүй алхам байсан

ЮМ.

Ойлгоход төвөгтэй өөр нэг зүйл гэвэл дээр өгүүлсэн газрын доорхи "нөөц"-ийг гаргаж авах эдийн засгийн үр ашиг нь хэр байх вэ гэдэг асуудал юм. Монгол, Хятад зэрэг эх газрын тунамал хурдаст сав газруудтай орнуудын геологийн онцлогоос хамаарч газрын тос байгааг нотлоход хэцүү, гаргаж авахад удаан бөгөөд зардал ихтэй. Саудын Арабт гэхэд л нэг барель газрын тос олборлоход дөрвөн доллар хүрэхгүй зардал гардаг байна. Гэтэл манайд 40 америк доллартай тэнцэх зардал гардаг гэсэн тооцоо бий. Газрын тосны үнэ 40 ам.доллараас бага байх үед Монголд газрын тос олборлоно гэдэг амиа хорлож байгаатай адилхан санагдаж болох. Гэхдээ аливаа бизнес эрсдлийг давж гарах ёстой.

Петроматад Лимитэд компанийн өөр нэгэн хариуцлагатай шийдвэр гэвэл 2006 оны долоодугаар сард Монгол орны баруун урд талын томоохон нутгийг хамарч байгаа Богд-IV, Онги-V талбайд хайгуул хийхээр Засгийн газартай шинэ бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан явдал байлаа. Эдгээр нь Матад XX талбайгаас эрс ялгаатай.

Баруун аймгуудын нутгаар тос үүсгэгч хурдас байхгүй гэж судлаачид үздэг байжээ. Тиймээс энэ нутагт хэзээ ч тосны чиглэлийн судалгаа хийгдээгүй юм. Талбайн хэмжээгээр Матад XX-аас зургаа дахин том, нийт таван аймгийн 32 сумын нутагт тархаж байрласан гээд онцлог ихтэй.

Тиймээс Петроматад Лимитэдийн охин компани болох Капкорн компани нь баруун зүгийн нутгаар судалгааны дорвитой ажлыг эхлүүлэхээр зориглож, тэнд хөл тавьсан анхны компани боллоо. Үүнд Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар их дэм үзүүлж байгаа аж. Аливаа томоохон төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт олох, нэгэнт орсон хөрөнгийг үр ашигтай зарцуулах мэргэжлийн боловсон хүчинтэй байх зэрэг нь чухал байдаг. Энэ хүндхэн ажлыг гардан зохион байгуулах үүргийг Петроматад компанийн гүйцэтгэх захирал, Австрали улсын иргэн Дуглас МакГей хүлээж авлаа. Геологийн гал тогоонд 40 гаруй жил чанагдсанаас 14 жилийг нь Монголын тал нутгаар аялж, монгол болохоо дөхсөн энэ эрхэм уг асуудлыг шийдвэрлэхдээ Лондонгийн хөрөнгийг биржийг сонгож авсан нь үр дүнгээ өглөө.

Мөнгө босгож эхэллээ. Петроматад нь 2008 оны тавдугаар сарын 1-нд Лондонгийн хөрөнгийн биржийн хоёр дахь зах зээл дээр бүртгэгдэж, хувьцаагаа гаргаж эхэлсэн нь Монголын үндэсний компаниудаас бас л анхдагч нь болсон юм. Энэ нь хариуцлага, хяналтыг өөр дээрээ овоолж байгаа хэрэг. Олон улсын хөрөнгийн бирж нь хөрөнгө оруулагчдаа төлөөлж оруулсан төгрөг бүрийнхээ төлөө хяналт тавина. Петроматад зөвхөн газрын тос олж, олборлолт явуулснаар л хөрөнгө оруулагчдаасаа сайн гэсэн үнэлгээ авах учиртай. Өөр юм хийж ашиг олох ч хориотой. Тиймээс Петроматад ХХК газрын тосны салбарт хэрэглэгдэж байгаа хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглаж Монголын тал нутагт хийгдсэн геологи, геофизикийн судалгааны мэдээллийг эхлээд Австралид аваачин томоохон мэдээллийн төвүүдэд боловсруулж, шинжлүүлж, дүгнэлт гаргуулж байна. Үндэснийхээ залуу мэргэжилтнүүдийг ч сургах хэтийн томоохон хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв. Зах зээл өндөр хөгжсөн орнуудын туулсан олон жилийн сургалтын замыг товчлох зорилтыг тавьж байна.

2005 оноос хоёрхон хүнтэй эхэлж байсан тус компани зөвхөн 2010 оны төлөвлөгөөт

зорилтоо биелүүлэхийн тулд 5-6 байгууллагын 230 шахам хүнийг ажиллууллаа. Эдгээрийн 70 гаруй хувь нь Монголын ажилчин, мэргэжилтнүүд байв. Өнөөдрийг хүртэлх гүн өрмийн ажлыг хятадууд л хийж гүйцэтгэж ирсэн билээ. Петроматад энэ жилээс өөрийн өрөмдлөгийн тоног төхөөрөмж, боловсон хүчинтэй болох зорилт тавиад ажиллаж байна. Мөн дутагдалтай байгаа нарийн мэргэжлийн хүмүүсийг сургаж бэлтгэх тал руу анхаарал хандуулж эхэлжээ. Петроматад компанийг үйлдвэрлэл талаас нь геологийн салбарт 30 жил, үүнээс Монголд 10 жил ажилласан туршлагатай геологич, АНУ-ын иргэн Родны Грахэм удирдаж байна. Харин хайгуул шинжилгээний чиглэлийг тодорхойлох өндөр хариуцлагатай ажлыг энэ салбарт 29 жил ажилласан туршлагатай эрдэмтэн, АНУ-ын иргэн доктор Жаймэс Кууген хариуцдаг аж.

Эдгээр туршлагатай ноёдоос юм сурч авах гэж Петро матадын монгол ажилчид хичээдэг нь ойлгомжтой. Газрын тосны судалгаа нь хажуугаараа байгаль экологи, орон нутгийн уугуул иргэдийн тав тухыг алдагдуулахгүй гэх зэрэг олон асуудлыг дагуулдаг. Петроматад энэ асуудлыг ч судалж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишгийг дагаж мөрдөн ажиллаж байна. Объектоо олз ашгийн талбар бус олон хүнийг амьдруулах эх булаг гэж Петроматадынхан үздэг. Тиймээс 2010 онд байгаль, цаг уурын хүндрэл, малын өвчин, томуу гээд цаг зуурын бэрхшээл тохиолдсон орон нутгийн 37 сум, нэгжид нийт 93.8 сая төгрөгийн тусламж дэмжлэгийг үзүүлжээ. Петроматад компани Матадын талбайн хайгуулын ажлыг 2006 оноос, Богд, Онгийн талбайн хээрийн ажлыг 2010 оноос тус тус эхлүүлсэн нь энэ салбарын ажил хичнээн бэрх, чимхлүүр болохыг харуулдаг.

Матадын талбайн зарим хэсэгт геофизикийн иж бүрэн судалгааны ажил хийж, газрын тосны нөөцтэй байх 14 талбайг шинээр илрүүлж баримжаа нөөцийг ч гаргасан аж. Өнгөрсөн 2010 онд эдгээр талбайн нэг болох Давсан толгой хэмээх газар 1000 м-ээс дээш гүнтэй хайгуулын гурван цооног өрөмдсөнөөс бүгдэд нь газрын тосны илрэл тогтоогдсон нь Петроматадынхан хэзээ ч аз туршаагүйн илрэл юм. Петроматад хэн болохоо хөрөнгө оруулагчдадаа харуулах гэж хичээж байна.

Юуны түрүүнд газрын тос баруун бүс нутагт Тамсаг булагийн сав газраас дутахааргүй байгааг тогтоосон нь том амжилт юм. Петровис ХХК болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк тэргүүтэй бусад олон хувь нийлүүлэгчид нь Петроматадын судалгааны ар талд баталгаа болж зогсдог.

2004 оны эцсээр хоёр сая төгрөгийн дүрмийн сантайгаар ажлаа эхлүүлж байсан бол 4-5 жилийн дотор нийт хайгуулын гурван талбайд 21.5 тэрбум төгрөгийн газрын тосны судалгаа хийгээд байна. Хөрөнгийн бирж дээр 300 гаруй сая ам доллар босгосон Петроматадынхан гадаад, дотоодын олон арван компанид үлгэр дууриалал болж, газрын тосны судалгаа хийхээр ялгасан 26 талбай сүүлийн тавхан жилийн дотор бараг бүгдээрээ эзэнтэй болжээ.

Ингэж богино хугацаанд Петроматад компанийн хийж бүтээсэн бүхэн тус компанийн дуудах нэр, дуурсах брэнд болж байна. Петроматад цаашдаа хайгуул, судалгааны ажлаа улам томруулна. Яагаад гэвэл түүнийг дэлхий харж байгаа. Хөрөнгө оруулагчид нь Лондонгийн биржээс Монголын тал руу "дурандаж" байгаа шүү дээ.

- Асуудалд ямар нэгэн үзэл суртал, сурталчилгааны өнцгөөс хандаагүй. Бодитой хандаж, эрсдэлээс айлгүйгээр зоригтой алхам хийсэн нь Монголын тал нутагт газрын тосны брэндийг гаргах анхдагч болсон юм.

- Дэлхийн стандартыг Монгол нутагт суурьшуулж, газрын тосны салбарт олон жил ажиллаж туршлагажсан мэргэжилтэн, эрдэмтэдтэй хамтарч ажиллав.

- Үйл ажиллагааны эрсдэлээс айлгүй баруун бүс нутагт хайгуул судалгаа хийсэн нь санамсаргүй мэт газрын тосны нөөц илэрч, олон улсын хөрөнгө оруулагчдад хандах боломжийг бүрдүүлжээ. Лондонгийн бирж дээр асар богино хугацаанд 300 гаруй сая долларын хөрөнгө босгов.

- Хайгуул судалгаа, өрөмдлөг хийсэн газар болгоноос газрын тосны илэрц гарсан бөгөөд энэ нь цаашдаа маш том төсөл хэрэгжүүлэхэд үндэс суурь нь болох юм.

- Импортоор оруулж ирдэг нефть бүтээгдэхүүний хараат байхгүй гэсэн сэтгэлийн үүднээс хийсэн эрсдэлтэй алхам нь ажил хэрэг болж, жилээс жилд боломж харагдах боллоо.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.petromatad.com](http://www.petromatad.com) Байгуулагдсан он: 2004 он

Компанийн хаяг: НИК-ийн байр, Ерөнхий сайд Амарын гудамж-8, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 210646, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Газрын тосны хайгуул, судалгаа

بصریتع مر  
تیسسیرسوسو  
وحطف مر

**MONGOLIAN BRAND ROYALTY**



**БАНК САНХҮҮГИЙН  
ТЭРГҮҮЛЭГЧ БРЭНДҮҮД**





Харилцааг эрхэмлэсэн  
таны БАНК

1940-өөд оноос хойш  
үйл ажиллагааг зөвүүлж  
буй Иргэдийн ууган банк



Та хаанаас ч банкны  
үйшлэлээг авч болно.



Өөрчлөн шинэчлэгдэж,  
Өсөн дэвжиж буй банк

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Холбогчдын гудамж - 4


Утас: +976-11 310 103  
Факс: +976-11 327 467

Цахим шуудан: [contact@savingsbank.mn](mailto:contact@savingsbank.mn)  
Цахим хуудас: [www.savingsbank.mn](http://www.savingsbank.mn)

 **Хадгаламж Банк**

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ БАНКНЫ СҮЛЖЭЭ**

- Монгол Улсын Шилдэг 4 банкны нэг
- 100% Монголчуудын хөрөнгө оруулалттай банк
- 400 орчим салбар нэгжтэй, 100% онлайн банк



 **ХасBank**  
Зөв Банк

### Харилцааг эрхэмлэгч хадгаламж брэнд

Зах зээлийн эдийн засаг дахь арилжааны банкууд нь нийгэмд санхүүгийн зуучлал хийж, ашиг олох үйл ажиллагааг явуулдаг. Өөрөөр хэлбэл банкуудын үйл ажиллагааг нийгмийн илүүдэл мөнгөтэй хэсгийн илүүдэл мөнгийг хүү төлөн авч, нийгмийн мөнгөний дутагдалтай хэсэгт илүү үнээр хүүлэн ашиг олдог гэж энгийнээр тайлбарлахад болно. Монгол орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжин орсноор арилжааны банкууд олноор бий болж, тэдгээр нь өөрсдийн мөн чанар, зорилгоо төрөл бүрээр тодорхойлсон байдаг хэдий ч эцсийн дүндээ бүгд л дээр энгийнээр тайлбарласан санхүүгийн зуучлалыг л явуулж, ашиг олохын тулд үүсгэн байгуулагдсаныг харж болно.

Харин Хадгаламж банкны хувьд түүний үүсэн байгуулагдах болсон шалтгаан, үйл ажиллагааны зорилго нь Монгол оронд үйл ажиллагаа явуулж буй бусад банкуудаас эрс өөр байсан бөгөөд энэ нь ч одоог хүртэл хадгалагдаж үлдсэнээрээ онцлог юм.

Хадгаламж банкны түүх нь Монгол улсад банк, санхүүгийн систем 1940-өөд оны үед анхлан үүсэн бий болж, Хадгаламжийн кассыг байгуулснаас эхэлсэн юм. Энэ үед үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд гараад бас чиг арав гаруй жил болж байсан болохоор иргэдийн мөнгөн дэвсгэртэй харьцах соёл харьцангуй гайгүй болоод байсан аж. Өмнө нь мөнгөн дэвсгэртийг цай, хонь, гурил, будаа зэрэг товар солилцоо орлож ирсэн байдаг. Мөнгөө найдвартай газар хадгалуулж, "Хүргэн хүү" киноны Жамц баян шиг хорин сайхан шараа хоёрхон хулганад идүүлчилгүй, бас өсгөж арвижуулан хуримтлалтай болоход нь тэрхүү Хадгаламжийн касс тусалж байлаа.

Тэтгэврийн хууль 1958 онд анхлан батлагдсанаар Монгол улсад тэтгэвэр, нийгмийн халамжийн тогтолцоо шинээр бүрэлдэн бий болж, энэхүү тэтгэвэр, халамжийн үйлчилгээний төлбөр тооцоог Хадгаламжийн банк нь гүйцэтгэж эхлэв. Хадгаламжийн банк нь ажилчин албан хаагчдын нийгмийн даатгал, хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн нийгмийн даатгалыг улсын төсөвт төвлөрүүлж өгөхөөс гадна улсын төсвөөс санхүүжүүлж буй тэтгэвэр, нийгмийн халамж, эмнэлгийн үнэ төлбөргүй тусламжийг ард, иргэдэд хүргэх төлбөр тооцоог орон даяар үзүүлж эхлэв. Үүнтэй холбогдон Хадгаламж банкны салбар нэгжүүд Монгол орны өнцөг булан бүрт хүрч байгуулагдав.

1960-аад оны сүүлчээр Улаанбаатар хотноо барилга бүтээн байгуулалтын ажлууд өрнөж, орон сууцны шинэ шинэ хорооллууд ашиглалтанд орж эхэлснээр дараагийн цоо шинэ үйлчилгээг Хадгаламж банк хийж гүйцэтгэх шаардлага тулгарав. Орон сууцанд амьдардаг иргэдийн орон сууцны талбайн болон цахилгаан, дулааны хөлс зэрэг ашиглалтын төлбөр тооцоог гүйцэтгэн, Нийтийн аж ахуйн конторууд, Цахилгаан, дулаан шугам сүлжээний байгууллагуудад төвлөрүүлж өгөх ажил нь түүний бас нэг гол ажил боллоо. Улаанбаатар хотын орон сууцны хороолол тутамд Хадгаламжийн банкны салбар нэгжүүд байгуулагдан ажиллаж эхлэв.

Ийнхүү Хадгаламж банк нь Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжин орох 1990-ээд оныг хүртэл буюу 50 гаруй жилийн туршид Монгол төрийн төлбөр тооцооны гол институт байдлаар ажиллан, төрийн үйлчилгээг ард иргэддээ хурдан шуурхай, найдвартай хүргэх зорилгыг агуулж ажилласан байна. Зөвхөн ард, иргэддээ үйлчлэх зорилго, агуулгаар 50 гаруй жилийн туршид оршин тогтнож, энэхүү зорилгыг л гүйцэтгэж ирсэн үйл ажиллагааны тогтолцоо, боловсон хүчинг бүрдүүлсэн, энэхүү зорилгод нийцсэн харилцагч, үйлчлүүлэгчтэй банкийг зах зээлийн эдийн засаг дахь арилжааны банкны агуулга, зорилгод нийцүүлэх нь тийм ч хялбар ажил биш байсан гэдгийг Хадгаламж банкны 1992-2009 онуудын түүх харуулдаг.

Ялангуяа үүнийг гадаадын хөрөнгө оруулагчид бүр ч хийж чадахгүй гэдгийг Хадгаламж банкийг 2007 оны сүүлээр хувьчилж аваад жил ч хүрэхгүй хугацааны дараа зарахаар шийдсэн Оросын хөрөнгө оруулагчид нотолсон. Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд банкны зах зээл дахь хамгийн ашигтай хэсэгт үйлчилж, тэдгээрээс богино хугацаанд ашиг олох нь гол тул төрийн халамж, орон сууцны төлбөр тооцоо зэрэг ард, иргэдийн өдөр тутмын ашиг багатай төлбөр тооцооны үйлчилгээ нь тэдний сонирхол огт биш байлаа. Иймээс банк, санхүүгийн зах зээл дээр хүчтэй өрсөлдөж байсан банкуудын аль нь ч энэ үйлчилгээ, зах зээлийг сонирхоогүй бөгөөд Хадгаламж банк нь энэ ажил, үйлчилгээгээ

алдагдалтай хэдий ч үргэлжлүүлэн энэ иргэдийн зах зээлдээ үнэнчээр ажилласаар өдийг хүрчээ.

2010 онд Монголын хөрөнгө оруулагч Хадгаламж банкныг 100 хувь худалдан авсны дараа тус банкныг Үндэсний банкны сүлжээ болгон улс орон даяар ард, иргэддээ хүрч үйлчлэх банк болгоно гэдгээ зарласан. Өөрийн оршин тогтнохын учир утга буюу эрхэм зорилгоо ард, иргэддээ банкны хамгийн төгс, энгийн үйлчилгээг үзүүлснээр эх орондоо баялаг бий болгох боломжийг хангуулахад оршино хэмээн тодорхойлов. Ашиг хурдан авчрах бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчийг сонгохоос илүүтэйгээр он удаан жил хамтран ажиллах харилцааг харилцагчтайгаа үүсгэхэд голлон анхаарч харилцааг эрхэмлэнэ гэв. Харилцагчтайгаа харилцан итгэлцлийг бий болгож, он удаан жилийн харилцааг өрнүүлж, тэдгээртээ банкны бүх төрлийн иж бүрэн үйлчилгээг үзүүлснээр банкаа үр ашигтай ажиллуулна гэв.

Хадгаламж банкны он удаан жил үйлчилж ирсэн "хадгаламжийн үйлчилгээ, тэтгэвэр, нийгмийн халамжийн үйлчилгээ, орон сууцны төлбөр тооцооны үйлчилгээ"-г Хадгаламж брэнд болгон тууштай үргэлжлүүлнэ гэдгээ тодотгож, ард, иргэддээ үзүүлж ирсэн эдгээр үйлчилгээгээ улам боловсронгуй болгон хөгжүүлэхээс ажлаа эхлэв.

Юуны өмнө банкны үйлчилгээг авахын тулд банкны салбар дээр ирж цаг алдаж буй болон ирж амжихгүй байгаа харилцагчдадаа зориулж цахим банкны "биллингийн үйлчилгээ"-г 2011 оны эхээр нэвтрүүлэв. Тус биллингийн үйлчилгээ нь харилцагчдадаа тэдний цахилгааны төлбөр, кабелийн хэрэглээ хэд гарсныг гар утас, интернет ашиглан хэлж өгөхөөс гадна тэдний захиалгаар төлбөр тооцоог нь банкны салбар дээр ирүүлэхгүйгээр хийж өгдөг байна.

Энэ мэтчилэн харилцагчдынхаа хүсэл, сонирхолд нь нийцүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг цааш, цаашдаа улам олноор нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

### **Амжилтын нууц**

- Ард иргэдийн амьдралд хамгийн ойр үйлчилгээг үзүүлдэг болохоор хэрэглэгчдийнхээ сэтгэл зүрхэнд хоногших чадвар сайтай. Иймээс тус банкинд хандах иргэдийн хандлага ямагт их байдаг.

- Жаст групп 100 хувийн хувь нийлүүлэгч болсноор шинэчлэлийн бодлогыг хурдацтай явуулж, олон улсын түвшинд өрсөлдөх бэлтгэлээ базааж байна. Монголын тэргүүлэх салбар болсон уул уурхайн салбарын үйлчилгээнд анхаарч Байгууллагын банк байгуулсан нь уг банкны ирээдүйг сайн сайхнаар харуулдаг.

- Банк, санхүүгийн салбар дотроо Хадгаламж банкны Биллингийн үйлчилгээ экспортын шилдэг брэнд болохоо харуулж чадав.

- Иргэд болон олон улсын томоохон байгууллагуудын үйлчилгээг зөв хослуулснаар Монголд төдийгүй олон улсын түвшинд гарах боломж бүрдэж байна.

## **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.savingsbank.mn](http://www.savingsbank.mn) Байгуулагдсан он: 1940 он

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар-13, ЧДүүрэг, Холбоочдын гудамж-4

Үйл ажиллагааны чиглэл: Банк, санхүү



## Эх орондоо хайртай брэнд


Хэн нэгний талаар юу гэж ярьснаас тухайн хүнийг "хэн бэ?" гэдгийг нь таньж болдог. Учир нь хэн ч өөрийгөө бүрэн дүүрэн тодорхойлж чадахгүй. Зөвхөн хөндлөнгийн нэгний ажил хэрэгч, шударга шулуун үг л жинхэнэ мөн чанарыг нь ил гаргадаг. Олон улсын үнэлгээний Fitch Ratings ([www.fitchratings.com](http://www.fitchratings.com)) болон Moody's Investors Service ([www.moody's.com](http://www.moody's.com)) байгууллагуудаас нийгмийн хариуцлагыг дээдлэн хэрэгжүүлэгч Хас Банкны талаар өгсөн үнэлгээнүүд нь тухайн банкиг тодорхойлж байна. Хас Банк нь Moody's олон улсын үнэлгээний байгууллагаар 2008 оноос хойш гурав дахь жилдээ хөндлөнгийн үнэлгээ хийлгэж байгаа бөгөөд уг байгууллагаас тус банкиг "Тогтвортой" гэж сайжруулан дүгнэсэн нь Хас Банкны зүгээс олон улсын хэмжээнд олж авсан нэр хүнд, компанийн засаглал, эрсдэлийн удирдлагыг улам баталгаажуулахын зэрэгцээ тус банкинд ихээхэн үүрэг хариуцлага, итгэл хүлээлгэж байгаагийн илрэл юм.

2010 оны Монгол банкны ээлжит шалгалтаар "Сайн" үнэлгээ авсан бөгөөд зургаан жил дараалан банкны салбарын хэмжээнд хамгийн сайнаар үнэлэгдсэн байна. Олон улсын болон дотоодын хяналт үнэлгээний байгууллагуудаас ийм үг сонссон



 **ХасБанк**  
Зөв Банк

*The Planet, People, Profit*  
*Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашиг*



Хаяг: Грохонг сайн Амгалан гудамж,  
Ш/Х-46/721, Улаанбаатар-14200,  
Монгол Улс



Утас: 318185, 1888  
Факс: 328701



Вэб: [www.xacbank.mn](http://www.xacbank.mn)  
И-мэйл: [info@xacbank.mn](mailto:info@xacbank.mn)  
SWIFT: CAXBMMUB

### ХасБанк нь

- Банк нь тогтвортой үйл ажиллагаа явуулсаар 12 жил болж байна;
- 2010 оны байдлаар Банкны активын хэмжээ нь 500 тэрбум тогрогт хүрсэн амжилтыг тогтоогоод буй;
- Монгол Улсын банкны салбарт 4 дүгээрт орлог томоохон арилжааны банк бөгөөд 21 аймагт 86 салбар, тооцооны төвүүдтэй, 1200 ажиллагсаатай;
- Нийт 370,000 харилцагчидтай бөгөөд тэдний 50,000 нь АМАР гар утасны үйлчилгээг хүлээн авдаг;
- Гадаадын 16 хөрөнгө оруулагчидтай хамтран ажилладаг;
- Гадаад дотоодын 50 гаруй байгууллагуудтай хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг.

### МАНЛАЙЛАА

- Эзэмийн багийн чанараар урт хугацаанд тогтвортой тэргүүлэгч;
- Хувийн хэвцлийн салбарт компанийн засаглал болон удирдлагын ур чадвараар олон жил манлайлагч нь байж ирсэн;
- Харилцагч төвтэй үйлчилгээг эрсэмжж, бүтээгдэхүүний чанар болон хүртээмжийг сайжруулах тал дээр мэдлэг, ур чадвараа бүрэн зарцуулдаг хамт олонтой;
- Олон улсын банк санхүүгийн тэргүүн туршлага, шинэлэг төсөл хөтөлбөр, орчин үеийн техник технологийг хамгийн түрүүнд нэвтрүүлж чадсан;
- Зах зээлийн эрсдэлийг даах чадвартай, өнцөр хариуцлагатай, ирээдүй рүүгээ чиглэсэн чигч бодлогоотой;
- Шуударга, ёс зүйтэй үйл ажиллагаа, өрсөлдөөнийг дэмжигч;
- Нийт үйлчлүүлэгч түмэндээ нэ тод, найдвартай үйлчилгээ, мэдээллийг хүргэдэг;
- Монголд Ногоон Банк гэдэг ухагдахууныг анх бий болгож, энэ чиглэлд хүчтэй түрэн орж буй байгууллагуудын нэг.

### НИЙГЭМИЙН ХАРИУЦЛАГА

ХасБанк нь нийгмийн хариуцлагаар тэргүүнд орлог банк бөгөөд Монгол улсын нийгэм болон эдийн засгийн хөгжлийн төлөө ямагт үйлчилж, Эх Дэлхий, Эрдэмт Хүмүүн, Эрүүл Ашгийг дээдмэлгээрээ бусад арилжааны банкуудаас өнцгөй юм.

### ҮНЭЛГЭЭ

2010 онд Мүүдийн, Фитч рэйтингс зэрэг олон улсын аудитын үнэмлэхний байгууллагууд ХасБанкны үйл ажиллагааны цар хүүрээ, чадмжийг В+ буюу тогтвортой хэмээн зарласан.

### ТОЛГОЙ КОМПАНИЙН ХУВЬЦЛАА ЭЗЭМШИГЧИД



### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД



Хас Банк 1998 онд байгуулагдсан юм. Монголын хамгийн анхдагч банк бус санхүүгийн байгууллага болох "Хөгжлийн Алтан Сан" ХХК болон "Говийн Эхлэл" ХХК нар нэгдэж нийлсэн нь энэ бөгөөд өнөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өөрийн 90 салбар нэгжээр дамжуулан санхүүгийн шинэлэг, цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэж байна.

Зээлээр дагнаж байсан санхүүгийн байгууллагууд нийлж, арилжааны банк болж өөрчлөгдсөнөөр банкны үйлчилгээнд шилжиж эхлэв. Байнгын үйлчилгээ, дээр нь иргэдийн хадгаламжийг байршуулж, байгууллагуудын данс нээх гээд эхний жил тэдний хувьд юм юм л хосолсон жил болжээ. Идэвхтэй зээлдэгчдийн тоо арван мянгад хүрэв. Хадгаламж байршуулагчдын тоо ч өслөө. Шижигнэсэн залуусаас бүрдсэн тус банкны удирдлага дараа жилээс ажилдаа гаршин шуурхай маневр хийж, стратеги нарийн боловсруулсан байна. Банкныхаа эх үүсвэрийн ихэнхийг үйл ажиллагааг тогтворжуулах, өсөлтийг хангах зэргээр бат бэх суурьтай болоход зарцуулав. Мөн бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, техник хэрэгсэл зэрэгтээ анхаарч хөрөнгө оруулалт хийжээ. Хас Банкны хамт олон байгуулагдаад жил гаруй болохдоо бүх аймагт хүрч, санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлж улмаар сум, баг, малчдад хүргэх зорилгоо хэрэгжүүлэв.

Олноо Зөв банк Хас Банк хэмээн танигдсан тус хамт олон гадаад түншээ бас л зөв



таньж, хамтарсан ажлуудаа эхлүүлжээ. Ингэснээр Олон Улсын Санхүүгийн Корпораци ([www.ifc.org](http://www.ifc.org)), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк ([www.ebrd.com](http://www.ebrd.com)) зэрэг томоохон банкууд Хас Банкинд урт хугацаанд хөрөнгө оруулалт хийж, ашигтай ажилладаг тул хөрөнгө оруулалтынхаа хэмжээг нь нэмэгдүүлж иржээ. Хас Банк харилцагчийнхаа хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, бичил санхүүгийн зах зээлд гарч буй асуудлуудыг шийдвэрлэх үүднээс дэлхийн шилдэг банкуудын программ хангамж болох FLEXCUBE-ийг өөрийн банкны үндсэн системээр сонгон хэрэгжүүлсэн аж. Энэхүү системийг хэрэгжүүлснээр Хас Банк нь дэвшилтэт техник, технологид суурилсан олон шинэ бүтээгдэхүүн, санхүүгийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх болжээ.

1998 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэргэдэх Micro Start буюу Бичил гараа төслөөс эх авсан жижигхэн "горхи" өнөөдөр удам эх орон даяар салаалан урсч хоорондоо сүлжигдэн холбогдоод "мөрөн" болтлоо томорчээ. Арав гаруй жилийн дотор тэд яаж ийм амжилт гаргаж чадав аа? "Эрдэнэт хүмүүн, эх дэлхий, эрүүл ашиг"-ийг тунхаглан мөрддөг болохоор гэж хариулахад хэн ч гайхах биз. Хоосон тунхаглал ажил хэрэгт ямар хамаатай юм ч гэх биз. Хас Банк тунхагласан л бол ажил хэрэг болгож, үйлчлүүлэгч, үйл ажиллагаатайгаа тэр "хоосон" зүйлийг уяж өгдөг. Ийм менежментээр явж, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлдэг дэлхийд нэртэй BRAC Bank, Triodos Bank банкууд Хас Банкны үйл ажиллагааг үнэлсэн байдаг. Эдгээр нь өөрсдийн өрсөлдөгчийг бодвол санхүүгийн элдэв хямрал бэрхшээлээсээ дархлаатай байгаа нь үйл ажиллагаагаа Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг гуравт төвлөрүүлсэнд байгаа гэж үздэг.

Юу гэвэл 2009 оны намар Хас Банк АНУ-ын Micro Energy Credits компаниар дамжуулан анх удаа дэлхийн хүлэмжийнхийн зах зээлээс нөхөн олговор авчээ. Ингэснээр тус байгууллага дэлхийн бөмбөрцгийн умард хэсэгт хүлэмжийн хийг бууруулсны нөхөн олговор авсан анхны Банк Бус Санхүүгийн Байгууллага болов. Дэлхийн хамгийн хүйтэн нийслэл болох Улаанбаатар хотын нийт хүн амын 60 хувь нь гэр хороололд амьдардаг. Өвлийн улиралд агаарын бохирдлын хэмжээ зунаас даруй 20 дахин их байдаг агаад Дэлхийн банкны хийсэн судалгаанаас харахад нүүрс түлсэнээс үүдэлтэй бохирдлын хэмжээ 60 орчим хувийг эзэлдэг байна. Тиймээс Хас Банкны хамт олон "Ногоон зээл" гаргаснаар харилцагчиддаа бага зардлаар ЭКО бүтээгдэхүүнтэй болох боломжийг бүрдүүлжээ. Тус бүтээгдэхүүн нь урт хугацааны баталгаатай бөгөөд түлшний зардлыг хэмнэж, дулаан өвөлжих боломжийг олгохоос гадна агаарын бохирдлыг бууруулна. ЭКО бүтээгдэхүүн болох түлшний хэмнэлттэй зуух, гэрийн сайжруулсан дулаалгыг авч хэрэглэснээр сард гаргах түлшний зардлаа хэмнэж, гэр бүлийн бусад зардалд нэмэрлэх боломжтой болов. Нүүрс, мод бага түлснээр агаар мандлыг бохирдуулагч хүлэмжийн хийг багасгах эерэг нөлөөтэй юм.

Өнөөдөр Хас Банкны нэвтрүүлсэн мобайл банкны "AMAR" ([www.amar.mn](http://www.amar.mn)) үйлчилгээг мэдэхгүй хүн ховор болжээ. Энэ үйлчилгээний үндсэн зорилт нь дэвшилтэт технологийг ашиглан банкны үйлчилгээг бага зардлаар иргэдэд хүргэхэд оршино. "AMAR" үйлчилгээ нэвтэрснээр иргэд гар утсаа ашиглан төлбөр тооцоо хийх, банкны бусад үйлчилгээг авахын зэрэгцээ банкны салбар нэгж байхгүй газар банктэй хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулсан агентууд дээр очиж үйлчилгээ авах боломжтой болов.

Хас Банк Монгол Улсад анх удаа АНУ-ын Kiva байгууллагатай хамтран санхүүгийн

зуучлалын үйлчилгээ үзүүлэх Кива төслийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Кива нь АНУ-д төвтэй дэлхийн 48 оронд үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн бус байгууллага юм. "Зээл таны амьдралыг өөрчилж чадна" хэмээх уриатай, нийгэм дэх ядуурлыг багасгах эрхэм зорилго бүхий энэхүү байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь хөгжингүй болон хөгжиж буй 50 гаруй орны орлого багатай бичил бизнес эрхлэгчдэд хэрэгтэй байгаа мөнгөний эх үүсвэрийг нь зуучлан олж өгөх үйлчилгээ үзүүлдэг юм.

Хас Банк АНУ-ын "Виттана сан" олон нийтийн байгууллагатай хамтран их, дээд сургуулийн оюутан залуусын сургалтын төлбөрөө төлөх хэрэгцээг нь хангах зорилготой санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх Виттана төслийг 2009 оны 10 дугаар сараас хэрэгжүүлж эхэлжээ.

Виттана зээлийн гол зорилго нь оюутан залуус хүссэн мэргэжлээ эзэмшин, улс орноо хөгжүүлж, мөрөөдлөө биелүүлэхэд тулгарч буй санхүүгийн бэрхшээл буюу сургалтын төлбөрөө төлөхөд шаардагдах мөнгийг дэлхийн өөр орны иргэд [www.vitta-na.org](http://www.vitta-na.org) цахим хуудсаар дамжуулан зээлдүүлэхэд оршиж байгаа юм. Оюутан залуус энэхүү төсөлд хамрагдаж зээл авч, зээлээ гэрээний дагуу хариуцлагатайгаар буцаан төлснөөр Хас Банкны бусад төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд хамрагдахаас гадна төлсөн зээлийн хүүгийнхээ есөн хувьтай тэнцүү хэмжээний Хадгаламжийн данстай болох боломжтой юм.

Зөв брэнд болсон Хас Банкны толгой компани нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэл. Тус компанийн зуун хувийн хөрөнгө оруулалтаар 2007 онд нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсээр худалдан авах боломжийг олгох үүднээс Хас Лизинг ХХК-г байгуулав. Хас Лизинг компани санхүүгийн түрээсийн үйлчилгээг хүргэснээр шинэ техник технологи, шинэ санаачлагыг нэвтрүүлэх, улмаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгон улс орны санхүүгийн түрээсийн бизнесийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна.

Хас Банк нь нийгэмд тустай, байгаль орчинд ээлтэй байхаас гадна харилцагчдынхаа үйл ажиллагааг ч тийм байхыг хүссэн юм. Тус зорилгод хүрэхийн тулд зээл хүсэгчдэд тодорхой шалгуур тавьж, уг шалгуурын үзүүлэлтийг 50 хувиас дээгүүр хангаж буй зээлдэгчиддээ зээлийн хүүний хөнгөлөлт үзүүлэх болов. Уг шалгуур үзүүлэлтэд байгаль орчныг нөхөн сэргээсэн байдал, хүрээлэн буй орчиндоо мод тарьсан эсэх, хогийн цэгийн төвлөрлийг шийдсэн эсэх, хаягдлаа дахин боловсруулдаг эсэх, усны тоолуур ашигладаг эсэх, том зээлдэгчдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байраар хангадаг эсэх зэрэг олон үзүүлэлт ордог байна.

Хас Банкныг хүмүүс эрүүл амьдралын хэв маяг болсон спортыг дэмжигч банк гэдгийг аль хэдийнэ мэдэх болсон. Мэргэжлийн сагсан бөмбөг, хөлбөмбөгийн Хасын Хүлэгүүд багууд лигийн аваргаар нэг бус удаа тодорч байсан билээ. Эх орондоо хайртай энэ л брэнд хүүхэд, залуучуудын дунд заалны хөлбөмбөгийн "Дуулиан-2020" тэмцээнийг орон даяар жил бүр уламжлал болгон зохион байгуулж хөлбөмбөгийн спортыг Монгол Улсад хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж байна. Монголын банкны системд хүүхдийн хадгаламж гэсэн ойлголтыг анх 2002 онд нэвтрүүлснээрээ Хас Банк олонд Хүүхдийн банк, Хүүхдэд ээлтэй банк гэдгээрээ хэзээний танил.

Тухайн үедээ бусад банкуудад байгаагүй зөвхөн хүүхдийн ирээдүйд зориулагдсан, хүүхдийн төлөө гэсэн энэ хадгаламж нь хамгийн өндөр хүүтэй, хүүхдийг 18 нас хүртэл урт хугацаатай, хадгаламжийн хүүг нийлмэл хүүгийн аргачлалаар буюу хүүнээс хүү бодох зарчмаар тооцон хамгийн бодит өндөр хүүг төлж эхэлсэн нь хүүхэддээ, ач зээдээ хайртай хэн бүхний сэтгэлд нийцсэн үйлчилгээ болсон. Хүүхдийнхээ төлөө, тэднийг ирээдүйдээ сайн сайхан амьдраасай гэдэг хүсэл бүх эцэг, эхчүүдийн хүсэл. Харин үүний төлөө тэдний хийж чадах зүйл нь хүүхдийнхээ төлөө багаас нь эхлэн бага багаар хуримтлал үүсгэн, 18 насанд хүрэхэд бодит хөрөнгө оруулалт, хуримтлалыг бэлэглэх боломжтой гэдгийг "Ирээдүйн Саятан" хадгаламж эцэг, эхчүүдэд ойлгуулсан билээ. Банкинд хадгаламж, хуримтлал хийнэ гэхээр л их мөнгөтэй хүмүүс хийдэг, эсвэл заавал их хэмжээний мөнгө аваачиж хийдэг байх гэсэн манайхны ташаа ойлголтыг өөрчилж, бага мөнгө ч хуримтлалыг бий болгож болно гэдгийг ойлгуулж чадсан энэ хадгаламжид эцэг, эхчүүд дуртай.

2003 онд Хас Банкны Ирээдүйн Саятан хадгаламж "Үндэсний брэнд" бүтээгдэхүүнээр шалгарсан бөгөөд өнөө хүртэл олонд таашаагдсан хэвээр, жилээс жилд энэ хадгаламж эзэмшигч хүүхдүүдийн тоо өссөөр. Мөн ерөнхий боловсролын салбарт өнгөрсөн хугацаанд олон дэвшилтэд ажлууд хийгдэж байгаагийн нэг нь БСШУЯ-ны дэмжлэгээр хэрэгжиж буй Хас Банк болон Хөгжлийн Алтан Сан Холбооны санаачилга болох Афлатон ([www.aflatoun.org](http://www.aflatoun.org)) нийгмийн болон санхүүгийн боловсролын хөтөлбөр юм. Эцэг, эх болон хөтөлбөрт хамрагдагч сурагчдын сэтгэлд ихээр хүрээд буй энэхүү хөтөлбөр нь хүүхэд багачуудад бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах чадвар, харилцааны соёл, санхүү удирдах чадвар мөн цаашлаад өөрсдийн санаачилга, бизнес эрхлэх чадварыг ч давхар эзэмшүүлдгээрээ уламжлалт боловсролын хөтөлбөрөөс ялгаатай юм. Афлатон хөтөлбөр нь олон улсад хэрэгждэг бөгөөд одоогоор дэлхийн 55 орны 800 мянга гаруй хүүхэд хамрагдаад байгаа юм. Монгол Улсад уг хөтөлбөрийг 2011 оноос илүү өргөн цар хүрээтэйгээр буюу одоо хөтөлбөрт хамрагдаж байгаа сургуулиас гадна нийслэл, аймгийн төв болон томоохон суурин газруудыг хамруулан 30 ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Хас Банк нь 2012 онд Афлатон хөтөлбөрийг Монгол Улсын хэмжээнд бүх Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах зорилгыг эрхэмлэн, Монголынхоо бүх хүүхэд багачуудад хүргэхээр шамдан ажиллаж байна.

Хас Банк нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, залуучуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаанд анхаарал хандуулж, нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажилласаар ирсэн билээ. Эдгээр үйл ажиллагааны нэг нь Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банк, Бичил Санхүүгийн боломж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй өсвөр үеийнхэнд зориулсан "Тэмүүлэл" санхүүгийн боловсролын хөтөлбөр юм. Санхүүгийн боловсролын хөтөлбөр нь 14-18 насны хүүхдүүдийг өсвөр наснаас нь мөнгөтэй харьцаж сургах, мөнгийг зөв удирдаж өөрийн ирээдүйд хувь нэмэр оруулахад туслах зорилготой байна.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл болон Хас Банк нь 2009 онд Киргиз Улсад үйл ажиллагаа явуулдаг Мол Булак Финанс бичил зээлийн байгууллагад хөрөнгө оруулалт хийж, тус байгууллагын 30 хувийг эзэмшиж удирдлага, хүний нөөц, зээлийн үйл ажиллагаагаа огцом сайжруулснаар олон улсын түвшинд гаргажээ. Харин дотооддоо Цахим Банкны үйлчилгээг нэвтрүүлсэн нь харилцагчдын талархлыг хүлээв. Тус банкны харилцагчид ийнхүү цаг

хугацаа, орон зайнаас үл хамааран интернэт холбогдсон ямар ч компьютер, гар утас, дурын суурин утаснаас банкны үйлчилгээг авах болсон нь үйлчлүүлэгчиддээ хүрч ажиллах шинэ менежментийг амжилттай хэрэгжүүлж буйн тодхон жишээ юм.

### **Амжилтын нууц**

- Ил тод, найдвартай санхүүгийн цогц үйлчилгээг нэвтрүүлсэн.

- Тулхтай хөгжлийг дэмжиж, нийгмийн хариуцлагыг дээдлэн хэрэгжүүлэгч банк болсон. Ижил төстэй менежмент явуулдаг дэлхийн бусад банкуудтай хамтарч ажилладаг нь Хас Банкны нэг хүч юм.

- Банкны удирдлагууд зоригтой шийдлүүдийг гаргаж зөв бодлого явуулсан.

- Олон улсын санхүүгийн байгууллагуудтай байнгын харилцаатай байж ирсэн.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.xasbank.mn](http://www.xasbank.mn) Байгуулагдсан он: 1998 он

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар -14200, Ерөнхий сайд Амарын гудамж, Хас Банкны төв байр

Үйл ажиллагааны чиглэл: Банк, санхүүгийн үйлчилгээ



## КАПИТАЛ БАНК

### **Капитал банк тогтвортой, найдвартай брэнд**

1990-ээд оны эхэн үе аугаа их өөрчлөлтийн эхлэл байлаа. Монголын банк, санхүүгийн зах зээл тогтворгүй болж эдийн засгийн амьдралыг бүхэлд нь өөрчлөн төвхнүүлэхтэй холбогдсон олон чухал арга хэмжээг авах хэрэгтэй болов.

Монгол орон эдийн засгийн шинэчлэл өөрчлөлтийг хийж, зах зээлийн харилцаанд шилжсэн нь нэг шатлалт банкны тогтолцоог халж, хоёр шатлалт банкны тогтолцоог бий болгох үндсийг бүрдүүлжээ. Энэ үеэс анхны арилжааны банкууд бий болж 1990 онд төрийн өмчийн оролцоотой хувийн хэвшлийн 16 үйлдвэр, аж ахуйн байгууллага хөрөнгө оруулж Үйлдвэрийн хувь нийлүүлсэн банкиг байгуулав. Одоогийн Капитал банкны суурь тавигдсан түүх ийм ажээ. 1998 онд Шинэчлэл банк хэмээн нэрээ өөрчилж улмаар 2003 оны хоёрдугаар сард бүх гишүүдийн хурлаар банкны шинэчлэн найруулсан дүрмийг баталж, тус банкиг Капитал хэмээн нэрлэжээ.

Шилжилтийн үеийн гэгдэх жилүүдэд буй болсон Монгол орны эдийн засаг, хууль эрх зүйн таатай бус орчин, бусад нөлөөллийн улмаас бий болсон санхүүгийн зах зээл дэх хямралт байдал арилжааны банкуудад хүндхэн цохилт болсон юм. Монгол банкнаас 1990 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт 29 банкинд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон байдаг ч одоогоор 14 нь л ажиллаж байгаа билээ. Капитал банкны хувьд хүнд хэцүү шалгуурыг амжилттай даван туулав. Чингэснээр иргэдийн мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, бусдад зээлдүүлэх, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх нийтлэг үйл ажиллагаатай, гишүүдийн хувь нийлүүлсэн дотоодын 100 хувийн хөрөнгө оруулалттай Монгол улсын арилжааны анхны банк болж чадлаа. Энэхүү онцлог нь түүнийг бусдаас ялгарч, өөрийн гэсэн хөгжил, шинэчлэл, зам харгуйг гаргасан брэнд банк болгосон юм.

Капитал банк нь зөвхөн хуулийн хүрээнд ил тод, шударга өрсөлдөөний зарчмыг баримталж, жижиг дунд бизнесийг дэмжсэн, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч, байгаль орчинд ээлтэй байх стратегийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Тус банкны хувь нийлүүлэгчид төдийгүй олон нийтийн зүгээс нийгмийн сайн сайхны төлөө тодорхой зүйл хийхийг хүсэн хүлээж байдаг. Тиймээс нийгмийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлэх бодлогыг барьж ажилладаг ажээ.

Сүүлийн үед нийгмийн зүгээс бизнесийн байгууллагуудад ёс зүйн болоод нийгмийн хариуцлагын хүрээнд өндөр шаардлага тавигдах болов. Энэ нь мэдээж байгаль орчны тулгамдсан асуудал ар араасаа цуварч, экологийн тэнцвэрт байдал алдагдаж нөөцийн

хомсдолд орсон, баян хоосны ялгаа улам гүнзгийрсэн, дэлхийн эдийн засаг бүхэлдээ хямарсантай холбогдон гарах нийгмийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээний илэрхийлэл



# КАПИТАЛ БАНК

 <p>Харилцах</p>	 <p>Зээл</p>	 <p>Гадаад мөнгөн гуйвуулга</p>	
 <p>Виза карт</p>	 <p>Сертификат</p>	 <p>Лавлах утас</p>	 <p>интернэт банк</p>
 <p>SMS маркетинг</p>	 <p>Баталгаа</p>	 <p>Онлайн үйлчилгээ</p>	 <p>Ubibor</p>
 <p>Аккредитив</p>	 <p>Хүүхдийн хадгаламж</p>	 <p>Эскроу</p>	 <p>Хадгаламж</p>

[www.capitalbank.mn](http://www.capitalbank.mn)



найдвартай

Аялбар

шуурхай

Капитал Банк

Coinstar

money transfer

SWIFT

Гадаад мөнгөн гуйвуулга

Харилцах, зээл

хадгаламжийн үйлчилгээ

www.capitalbank.mn

юм. Банкны нийгмийн хариуцлага нь байгууллагын хөгжлийн стратеги зорилтыг тодорхойлоход багагүй үүрэг гүйцэтгэдэг.

Ингэж нийгмийн хариуцлагаа ухамсарлаж үйл ажиллагааныхаа нэг хэсэг болгосноор өөрийн байгууллагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар бүрэн хариуцлага хүлээх, нийгмийн сайн сайхан, тогтвортой хөгжлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Мөн ил тод, нээлттэй байх, бизнесийн ёс зүйг эрхэмлэн дээдлэх, байгууллагынхаа үйл ажиллагааг гадаад орчинтой нягт уялдуулан зохицуулах зэргээр үйлчилгээний чанар, итгэлцэл, шуурхай байдалд мэдрэгдэхүйц ахиц дэвшил гарчээ. Капитал банк цаг үеэ маш сайн мэдэрч менежмент хийж чаддаг. Тийм ч учраас улс орны эдийн засгийн хөгжил, ирээдүйн чиг хандлагад нийцүүлж байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн өсөлтийг хангагч, ногоон эдийн засгийг дэмжигч банк байхыг сүүлийн жилүүдэд илүүтэй эрмэлзэн ажиллаж байна.

Тус банк нь байгуулагдсан цагаасаа санхүүгийн зах зээлд өөрийн гэсэн байр суурь, өнгө төрхийг бүрдүүлж үйл ажиллагаагаа тогтвортой явуулсаар ирэв. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод төв банк, 5 салбар, 14 тооцооны төв, 8 тооцооны касс, Өмнөговь, Орхон, Архангай, Дорноговь, Дархан-Уул, Хөвсгөл, Ховд аймгууд, Багануур дүүрэг, Замын-Үүд суманд салбар, тооцооны төв, тооцооны касс, валют арилжааны цэг зэрэг нийт 50 гаруй

нэгжид 300 гаруй ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Эдүгээ Капитал банк 450 мянган байнгын харилцагчдад банкны бүх төрлийн үйлчилгээг үзүүлдэг орчин үеийн дэвшилтэт техник, технологи дээр суурилсан банк болон өргөжив.

Банкны гадаад харилцаанд жил бүр ахиц дэвшил гарч 2001 онд олон улсын төлбөр тооцооны теле коммуникацийн S.W.I.F.T. сүлжээнд албан ёсны хувь нийлүүлэгчээр элсэн орж АНУ-ын Wachovia Bank, City банк, Японы Bank of Tokyo Mitsubishi UFJ Ltd, ХБНГУ-ын Commerzbank AG, ОХУ-ын International Bank for Economic Cooperation, БНСУ-ын Korea Exchange Bank, БНХАУ-ын China Construction Bank, ICBC банк, ӨМӨЗО-ны Хөх Хотын арилжааны банк зэрэг олон улсын нэр хүнд бүхий банкуудтай хамтран ажиллаж иржээ.

Түүнчлэн Ази, Номхон далайн бүс нутаг дахь банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, зах зээлийг судлах, туршлага солилцох зорилгоор Азийн Банкуудын Холбоо болон Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Санхүүгийн Байгууллагуудын Хөгжлийн Холбоо, олон улсын санхүүгийн зах зээл, дэлхийн санхүүгийн онлайн хөтөч Bloomberg-ийн албан ёсны гишүүн болов.

Капитал банкны нийгмийн хариуцлагын бодлого, банкны үйл ажиллагааны хэтийн зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлсэн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл, 40000 айлын орон сууц төсөл, Атрын III аян, Дэлхийн банкны Тогтвортой амьжиргаа, АДРА Монгол ОУБ-ын Бичил бизнесийг дэмжье, Мерси Кор Монгол ОУБ-ын Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр, Органик Монгол зэрэг төрийн болон төрийн бус байгуулага, олон улсын донор орнуудаас санаачилсан төсөл хөтөлбөрийг дэмжин хамтран хэрэгжүүлсээр ирэв.

Техник, технологийн өөрчлөлт шинэчлэлтээрээ өрсөлдөгчдөөсөө ямагт нэг алхам түрүүнд байж, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг дээдлэн, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж байна. Энэ хүрээнд банкны салбарт мэдээллийн технологийн чиглэлээр тэргүүлэгч Цахим банк байх эрхэм зорилго тавьж, банкны нийт салбар нэгжийг онлайн мэдээллийн сүлжээнд холбож 100% онлайн үйлчилгээтэй, цахим харилцаан дээр суурилсан банк болон өргөжин тэлжээ. Ийнхүү Капитал банкны гаргаж ирсэн шинэчлэлийн чиглэлүүд ихэнхдээ бодит ажил хэрэг болж байгаа юм.

### **Амжилтын нууц**

- Coinstar Money Transfer үйлчилгээг нэвтрүүлж, банк санхүүгийн чиглэлээр хилийн чанадад буй үйлчлүүлэгч нартаа найдвартай түргэн шуурхай үйлчилж, тэднийг Монгол улстай холбогч гүүр болсноор дэлхийн шилдэг үйлчилгээг нэвтрүүлэв.

- Бяцхан харилцагч нартаа зориулж Унагалдай хүүхдийн ирээдүйн санхүүгийн боловсролыг дэмжих хадгаламжийн шинэ бүтээгдэхүүнийг санхүүгийн зах зээлд нэвтрүүлсэн нь олон нийтэд хамгийн их таашаагдсан хүүхдийн хадгаламжийн брэндээр тодров.

- Харилцагчдынхаа төгрөгийн хадгаламжийг эрсдэлгүй найдвартай байлгах үүднээс UBIBOR хадгаламжийн бүтээгдэхүүнийг анхлан нэвтрүүлснээр хөвөгч, хамгийн боломжит



өндөр, хувьсах хүүтэй шинэ брэнд хадгаламжийг бий болгож чадав.

- Цахим банк байх эрхэм зорилгоо чиг болгон үндэсний бүтээн байгуулалт, оюуны бүтээмжийг дэмжиж, банк санхүүгийн салбарын цогц программ хангамжийн Монгол системийг анхлан нэвтрүүлсэн нь Монголын банкуудын брэнд программ болов.

- Дамжуулан зээлдүүлэх, барьцаалах, өвлүүлэх төлбөрийн хэрэгсэл бүхий даатгагдсан хадгаламжийн сертификатын үйлчилгээг нэвтрүүлсэн нь Монголын банкны салбар дахь шинэ брэнд үйлчилгээ болов.

- Зөв шийдэл, зөв удирдлага, зөв тогтолцооны хамгийн оновчтой гарц нь банкны цахим хамтын ажиллагааны талбар. Энэхүү нөхцөл боломжийг бүрдүүлж, банкны дотоод мэдээллийн урсгалыг сайжруулах, хөнгөвчлөх, удирдлагын мэдээллийн хяналтын иж бүрэн системийг дэлхийн тэргүүлэх IBM корпорацийн шилдэг бүтээгдэхүүн Lotus Notes Domino программыг банкны салбарт нэвтрүүлэв.

- Дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, техник технологийн өөрчлөлт шинэчлэлтэд ямагт нэг алхам түрүүнд явж, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг дээдлэн, банкны системд мэдээллийн технологийн чиглэлээр тэргүүлэгч Цахим банк байх зорилтынхоо хүрээнд иж бүрэн шинэчлэлийн төслийг амжилттай хэрэгжүүлсэн анхны банк болов.

- Харилцагч нарт үзүүлэх үйлчилгээг олшруулах, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг байнга соргогоор хүлээн авч анхдагч байхыг эрмэлзэн дэлхий нийтээр тархсан, 24 цаг тасралтгүй явагддаг Олон улсын валютын арилжаанд зуучлах буюу White label-ийн үйлчилгээг дэлхийд тэргүүлэгч Forex capital market /FXCM/ компанитай хамтран харилцагчиддаа хүргэн ажиллаж байгаа нь ч бас Монголдоо анхных юм.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.capitalbank.mn](http://www.capitalbank.mn) Байгуулагдсан он: 1990 он

Компанийн хаяг: Капитал банк, Төв байр, Самбуугийн гудамж-43, Улаанбаатар 211238, Монгол Улс

Үйл ажиллагааны чиглэл: Банкны үйлчилгээ

## Гадаадад зорчих санхүүгийн эрх олгосон брэнд

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй байсан Монгол Улсын хувьд 1995 он эдийн засгийн амьдрал нь ээдрээ нугачаа ихтэй, иргэдийн итгэл дээр тогтдог банк, санхүүгийн салбарын хувь заяа нь дээсэн дөрөөн дээр байж, шинээр банк байгуулах нь битгий хэл томорч бэхэжсэн банкуудын үйл ажиллагаа суларч, туршлагатай банкируудын сэтгэл түгшсэн хүндхэн жил байсан хэдий ч Бодь интернэшнл группын санаа нийлсэн залуус Монголын банк, санхүүгийн зах зээлийн ирээдүйг өөдрөгөөр харж, ирээдүйд хүчирхэг банк болж, хувийн банк хэрхэн ажилладгийг харуулах их зорилгыг өмнөө тавин 1995 оны 3-р сарын 6-ны өдөр зуун хувь дотоодын хөрөнгө оруулалттай Монголын анхны хувийн банкиг байгуулсан нь өдгөө салбарынхаа хөгжлийг тодорхойлон тэргүүлэгч болтлоо өсөн дэвжсэн Голомт банк юм.

Хувь хүмүүс хоорондоо итгэлцэж, хөрөнгө мөнгөө харилцан ашигтайгаар нэгэндээ хадгалуулах "хувийн" тодотголтой банкинд итгэх харилцагчдын итгэлийг сэргээж, монголчуудад дэлхийн улс орнуудад нэвтрэх санхүүгийн "виза" олгосон нь Голомт банкнаас үйлчлүүлэгчиддээ авчирсан хамгийн том шинэчлэл, өөрчлөлт юм. Өөрөөр хэлбэл тус банкиг Монголын зах зээлд олон улсын төлбөрийн картын систем цаашлаад зээлийн эрхтэй карт нэвтрүүлэхээс өмнө гадаадынхан Монгол хүнд санхүүгийн талаас нь итгэж өгдөггүй байсан хэрэг.

Гадаадын улс орнуудад Монгол улсаа төлөөлж, "дэлхийн" тодотголтой санхүүгийн брэндүүдийг "нутагшуулах" их ажлыг эргэлзэж тээнэглээхгүй, их эрсдэлээс айхгүйгээр хийж чадсан нь энэ банкны амжилтын үндэс болжээ.

Түрийвчиндээ түнгийтэл чихэж үе үе тэмтэрч үздэг байсан мөнгөө төлбөрийн карт гэдэг зүйлд багтааж болдог гэдгийг монголчууд огт мэддэггүй байсан ерээд оны төгсгөлөөр дэлхийн картын бизнест тэргүүлэгч Mastercard Worldwide байгууллагатай хамтран ажиллах гэрээг үзэглэж, өдгөө бидний өдөр тутмын хэрэглээ болсон төлбөрийн картыг нэвтрүүлсэн нь тухайн үедээ бизнес, ашиг гэхээсээ ирээдүйг харсан алхам байсан юм.

Mastercard Worldwide байгууллагатай үзэглэсэн гэрээ дотооддоо хийгээд олон улсын валют, үнэт цаасны арилжаа, Reuters, Bloomberg, мөнгөн шилжүүлгийн Western Union сүлжээ зэрэг анхдагч алхмуудаар үргэлжилж, Монголын банк санхүүг дэлхийн шилдэгүүдтэй мөр зэрэгцэн алхахад энэхүү брэнд болсон Голомт банк түүхэн үүрэг гүйцэтгэсэн гэж болно.

Түүнчлэн анхны төлбөрийн чек, 24 цагийн банкны үйлчилгээ, интернэт банкны шинэ дүр төрх хосолсон валюттай карт гээд салбарынхаа хөгжилд хурд, харилцагчдынхаа хэрэглээнд хувьсал хийсэн Монголд анхдагч гэсэн тодотголтой санхүүгийн брэндүүд энэ банкнаас эхтэйгээр ээлж дараалан гардаг нь Голомтын бусдаас ялгарах онцлог юм.

Үүсгэн байгуулагчдынх нь банкаа байгуулснаас хойш анхаарч ирсэн бас нэг зүйл нь "Голомтын соёл". "Манай амжилтын үндэс бол банкиндаа итгэл төгс, ирээдүйнхээ төлөө хамтдаа зүтгэх чадвартай, хичээл зүтгэлтэй ажилтнууд маань", "Манай банкны үнэ цэнэтэй баялаг бол ажилтнууд маань", "Манай банкны брэнд бол манай банкны ажилтнууд" гэж

өөрийгөө санхүүгийн толинд харсан бүх менежмент энэхүү байгууллагын бусдаас ялгарах соёлын нэг юм. Сүүлийн үед Голомтын гоёл бол Голомтын соёл гэх болов. Ингэж соёл, гоёл хоёрыг хослуулах нь тухайн банкны дүр төрхийг бусдаас ялгаруулж өгдөг.

Хаана бизнес, эдийн засгийн төвлөрөл бий болно, тэнд салбар сүлжээгээ нээдэг, байгууллагад хандсан санхүүгийн үйл ажиллагааг түлхүү дэмжиж улс орныхоо эдийн засгийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах зарчим баримталдаг нь Голомт банкны бас нэгэн онцлог. Мөн интернэт банк, мобайл банк, мессеж банк зэрэг шинэ дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээгээр дамжуулан харилцагч үйлчлүүлэгчдээ орон зай, цаг хугацаанаас хамааралгүй үйлчилгээ авах, шинэ дэвшилтэт технологийн давуу талыг мэдрэх боломжийг түлхүү олгодог юм.

Хэдийгээр Монгол улсын хамгийн том банк боловч "Банк том байх нь чухал бус шилдгийн шилдэг байх нь чухал" гэсэн үндсэн зарчмыг баримтлан ажилладаг тус банк Американ Экспресс байгууллагын Монгол дахь онцгой эрхт түнш, Олон Улсын Агаарын Тээврийн Холбооны төлбөр тооцоог гүйцэтгэгч банк зэрэг өрсөлдөгчдийнхөө эдэлдэггүй онцгой эрхийг дангаараа эзэмшдэг нь Голомтыг улам хүчирхэг болгожээ.

Мөн манай урд хөршийн хамгийн өргөн сүлжээ бүхий China Union Pay байгууллага БНХАУ-ын нутаг дэвсгэрээс гадна юанийн карт гаргах зөвшөөрлийг гадаадын аль нэг банкинд бус зөвхөн Голомт банкинд 2010 онд олгосон байх жишээтэй.

Анхнаасаа олон улсын стандартыг банкныхаа үйл ажиллагаанд хэвшүүлэх үүднээс Голомт банк Английн иргэн ноён Адриан Хиллийг зөвлөхөөр урьж байсан, Монгол улсаас анх удаа Кредит Свисс, Американ Экспресс зэрэг дэлхийн банк, санхүүгийн байгууллагуудтай Голомт банк анх холбоо тогтоож байсан бол 2007 оноос дэлхийд данстай банкир ноён Жон П.Финиган тус банкиг удирдах болсон нь Голомт банкны дэлхийд үнэлэгдэх үнэлэмжийг улам бүр нэмэгдүүлсээр байна. Ийнхүү Их Британи, Герман, Бруней, Катар, Арабын Нэгдсэн Эмират Улс гээд үсрэнгүй хөгжлийн гайхамшигийг дэлхий дахинаа мэдрүүлсэн улс орнуудад банк, санхүүгийн байгууллага удирдаж байсан тэрбээр Монгол улсыг ч мөн дээрхи улсууд шиг хөгжил дэвшлийн тэргүүн шугамд очно гэдэгт эргэлздэггүй аж.

Энэ их итгэл нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг ч тойрсонгүй, дэлхийд алдартай Кредит Свисс болон дэлхийн хамгийн баян сан болох Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөлөөс Монголын банк, санхүүгийн байгууллагуудыг удаан хугацаанд судалсны эцэст хувь эзэмших сонирхлоо илэрхийлж өглөг зээлийн гэрээг Голомт банктай байгуулсан нь Монгол Улс хийгээд Голомт банкны үйл ажиллагаанд итгэл төгс, ирээдүйд хүртэх хувиа сэтгэл хангалуун хүлээж байгааг илтгэнэ.

Ийнхүү дэлхийг Монголд, Монголыг дэлхийд таниулах зорилгоо хэрэгжүүлж байгаа Голомт банкны үйл хэрэг өдөр ирэх тусам өргөжин тэлсээр байна.

### **Амжилтын нууц**

- Зах зээлд манлайлагч. Голомт банк үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монгол

улсын банк, санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байр суурь эзэлж, 2010 оны эцсийн байдлаар Голомт банкны нийт актив нэг их наяд 574 тэрбум төгрөгт хүрч Монгол улсын хамгийн том банк болсон байна. Мөн Голомт банк Монгол улсын банкны системийн нийт активын 25%, нийт хадгаламжийн 30%, нийт зээлийн 26%, нийт капиталын 20%-ийг эзэлдэг, Монгол улсын банкны системийн нийт картын бэлэн бус гүйлгээний 60%-ийг, олон улсын төлбөр тооцооны 60%-ийг, гадаад худалдааны санхүүжилтийн 40%-ийг, гадаад валютын арилжааны гүйлгээний 40%-ийг дангаар гүйцэтгэдэг юм.

- **Найдвартай байдал.** Голомт банк үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн санхүүгийн хүчирхэг байдлаа байнга сайжруулж, тогтвортой байлгаж Монгол улсын ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төдийгүй олон улсын байгууллагын итгэлийг хүлээсээр ирсэн. Тухайлбал, Голомт банк нь Монгол банкнаас зээлийн эрсдэлийн үзүүлэлтээрээ "тэг"үнэлгээ авсан Монголын цорын ганц банк. Голомт банкны санхүүгийн үзүүлэлт нь Монгол улсын банкны системд хамгийн сайн, эрүүл үзүүлэлттэй байна. Тухайлбал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, чанаргүй зээлийн хувь, зээл хадгаламжийн харьцаа зэрэг санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд нь банкны системдээ хамгийн сайн үзүүлэлттэй банк юм.

- **Шинийг санаачлагч.** Монголд өмнө нь огт байгаагүй цоо шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг анхлан нэвтрүүлэгч гэсэн байр сууриа багтай хадгалж байнга шинийг эрэлхийлэн нэвтрүүлдэг. Аюулгүй байдлын номер нэг стандартад нийцсэн EMV олон улсын чип карт, бэлгийн карт, бэлгийн картын онлайн захиалгын үйлчилгээ, төгрөг-доллар, төгрөг-евро хосолсон валюттай карт, хүссэн зургаа хэвлүүлэх боломжтой "Нандин" picture карт, онлайннар данс нээх үйлчилгээнүүдийг нэвтрүүлсэн.

- **Шилдэг үйлчилгээ.** Монгол улсын иргэд, байгууллагын төдийгүй олон улсын томоохон байгууллагуудын санхүүгийн эрэлт хэрэгцээнд тохирсон иж бүрэн үйлчилгээг мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтнуудаараа дамжуулан хүргэдэг.

- **Хүчирхэг хүний нөөц.** Амжилтынхаа гол үндсийг мэдлэг чадвартай, хичээл зүтгэл бүхий ажилтан албан хаагчдаа гэж үздэг тус банкны тогтвортой, чадвартай хүний нөөц нь үйл ажиллагааны гол хүч юм.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.golombank.com](http://www.golombank.com)

Байгуулагдсан он: 1995 онд Л.Болд, М.Зоригт, Д.Баясгалан нар үүсгэн байгуулав

Компанийн хаяг: Сүхбаатарын талбай, Улаанбаатар -210620а, Монгол улс

Үйл ажиллагааны чиглэл: Банк, санхүү



# ХААН БАНК

## Түмэнд итгэлтэй, түгээмэл сүлжээтэй брэнд

Нэг шатлалтай системээр 70 гаруй жил явж ирсэн банк, санхүүгийн салбар хоёр шатлалт тогтолцоонд шилжсэн 1991 онд байгуулагдсан ууган арилжааны банкны нэг бол ХААН Банк юм. 1991-2000 онд ХААН Банкны үйл ажиллагаа хүндхэн нөхцөлд байлаа.

Ингэж их хэмжээний алдагдал хүлээж, төлбөрийн чадвар нь доройтож, нэр хүнд нь унаж, дампууралд тулж очоод байсан тус банкинд өөрчлөлт шинэчлэлт хийх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Монгол банк, Дэлхийн банк, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг хоорондын гэрээ хэлэлцээр явагдаж, олон улсын банк, санхүүгийн туршлагатай менежер, АНУ-ын иргэн Ж.Питер Морроу 2000 оны намар Монгол банкны эрх хүлээн авагчаар томилогдон ажиллах болов. Энэ үед 100 хувь төрийн өмчид байсан ХААН Банкнд шинээр томилогдсон удирдлагын баг өөр стратеги боловсруулан ажиллаж эхлэв.

Тэгэхдээ банкны үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, салбарын сүлжээний оновчтой бүтэц, хүний нөөцийн удирдлага зэрэг зангилаа асуудлыг барьж авчээ. Энэхүү "эрүүлжүүлэх"



**ХААН БАНК**

ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД



**KHAN BANK**

YOUR TRUSTED FRIEND



# ХААН БАНК

Таны **АМЖИЛТААР** бид бахархдаг



*Таны бизнесийн итгэлтэй тунш*

хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутагт санхүүгийн найдвартай үйлчилгээг сэргээх, санхүүгийн хувьд ашигтай, тогтвортой үйл ажиллагаа явуулах, хувьчлалд бэлтгэх ажлууд ч багтаж байлаа. Гурван жил орчим дээрх ажлуудыг хийсний эцэст Монгол Улсын Засгийн газрын шийдвэр гарч, 2003 оны гуравдугаар сарын 25-ны өдөр тус банкныг олон улсын нээлттэй тендер зарлан хувьчлах болжээ. Энэ тендерт Японы H.S.Securities компани ялж зургаан сая 850 мянган ам.доллараар ХААН Банкныг хувьчилж авчээ. Улмаар H.S.Securities компани хувьцааныхаа 35 хувийг Монголын тэргүүлэгч компаниудын нэгТаван Богд Трейд ХХК-д худалдав. Ингэснээр тус банк гадаад дотоодын томоохон хувь нийлүүлэгчтэй болсон байна.

Тус банкны эзэмшигч H.S.Securities үүний дараа хоёр сая ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт, мөн банкны ашгаар дахин хөрөнгө оруулалт хийснээр 2003 оны эцэс гэхэд долоон тэрбум 864 сая төгрөгийн хөрөнгөтэй болжээ. Хуучинсаг арга барилд шүтсэн, шинэчлэлт өөрчлөлтийг зоригтой хийж чадахгүй, төрийн өмчид зуун хувь багтаж байсан Хөдөө Аж Ахуйн банк нэр, имижээ ч өөрчилж ХААН гэсэн бүрэн товчлол бүхий нэртэй болж, байгаль орчинд ээлтэй, шинэ зүс царайгаар ажиллаж эхэлсэн нь энэ билээ.

Улс орны хэмжээнд 500 салбар нэгжтэй, Монгол улсын нийт айл өрхийн 80 гаруй хувьд үйлчилгээгээ хүргэдэг хамгийн том энэ арилжааны банк ийнхүү том аж ахуйн нэгж

байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчид, иргэдийг хамарсан түгээмэл үйл ажиллагаа явуулах боллоо. Тус банк дэвшилтэт үйлчилгээ үзүүлж, цогц бүтээгдэхүүнээ хэрэглэгч үйлчлүүлэгчиддээ хүргэж, хоёр гуравхан ажилтантай багахан хэмжээний нэгж нь хүртэл үйлчлүүлэгчийнхээ сэтгэл ханамжийг анхаарч, итгэлийг даан ажиллаж чадаж байгаа нь ажилтнуудынхаа ур чадварыг дээшлүүлж, олон төрлийн сургалтад хамруулж ирсэнтэй нь холбоотой билээ.

ХААН Банк харилцагчаа хүндэлж, нууцпалыг хадгалах, ил тод байдлыг хангах талаар дараах бодлого, менежментийг баримталдаг. Харилцагчаа нас, хүйс, арьс өнгө, ажил албан тушаал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, намын харъяаллаар үл ялгаварлан ил тод, ижил тэгш үйлчлэхийг чухалд үздэг. Мөн найз нөхөд, төрөл садангийн хүрээгээр түрий барьж үйлчлэхийг хориглох бөгөөд харилцагчаас төлбөр, бэлэг, шан харамж авахыг хатуу хориглодог билээ.

ХААН Банк ийнхүү авлига хээл хахууль, харилцагчийнхаа нууцыг бусдад дэлгэх зэрэг зохисгүй байдлыг гаргаагүйгээр барахгүй, хамгийн итгэлтэй банк байж чаддаг нь тухайн брэндийн дүр төрх юм. Ийм ч учраас олон улсын Фитч Рейтингсийн үнэлгээнд "ХААН Банк салбарын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хувьд Монгол Улсын шилдэг банк юм. Дотоодын бусад олон байгууллагуудад үгүйлэгддэг зохистой удирдлагын тогтолцоог хангаж чадсаны үр дүнд хадгаламж эзэмшигчдийн итгэлийг хүлээж чадсан явдал нь ХААН Банкны гол давуу тал юм" гэж тодорхойлсон байдаг. Үүгээр тогтохгүй ХААН Банкны нэр хүнд олон улсын түвшинд хүрч танигдсан менежментийг явуулж байна. Японы Sawada Holdings компани ХААН Банкны нийт хувьцааны 53.0 хувийг эзэмшдэг хамгийн том хувь нийлүүлэгч бол АНУ-ын Development Alternatives, 1пс 2.6хувь, Дэлхийн Банкны дэргэдэх Олон улсын санхүүгийн корпораци, Монгол улсын Таван Богд групп 35 хувийг нь эзэмшдэг. Аливаа банк хилийн чанадад хэдий чинээ танил болж чадвал эх орондоо төдий чинээ итгэл төгс байдаг. Энэ санааг ХААН Банк хэрэгжүүлж байна. ХААН Банк гадаад төлбөр тооцоо, валютын арилжаа, худалдааны санхүүжилтийн үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс олон улсын корреспондент банкны сүлжээгээ өргөтгөж гадаадын хорь гаруй банктай хамтран ажиллаж ирлээ. Тус банк 2000 оноос хойш Олон улсын аудитын байгууллагаас тогтмол өндөр үнэлгээ авч иржээ. Аливаа брэндийн хүч чадал, хөгжин дэлгэрэх боломжийг санхүүгийн чадвараас нь голлон харж болдог.

Тэгвэл ХААН Банкны нийт актив 2009 онд 1.1 их наяд хүрч банкны системд цоо шинэ амжилтыг анхлан тогтоож байсан бол жилийн дараа 1.5 их наяд болж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө 1.0 их наяд төгрөгт хүрсэн анхны арилжааны банк болоод байна. Монголын банкны системийн өдөр тутам хийгдэж буй нийт гүйлгээний 70 хувь нь ХААН Банкаар дамждаг гэхээр тус байгууллагыг ямар цар хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгааг хялбархан ойлгож болно. Салбар нэгжүүд нь 100 хувь онлайн сүлжээнд холбогдож, дансны мэдээлэл, лавлагаа, шилжүүлгийг цаг хугацааны "бодит цагийн горимд" орон даяар түргэн шуурхай гүйцэтгэдэг. Мөн тус банк нийгмийн хариуцлагыг хүргэх хүрээнд олон зүйлийг шинэ өнгө төрхтэйгээр хийж ирсэн брэнд. ХААН Банк боловсрол, соёл урлаг, нийгмийн хөгжил, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих, байгаль орчныг хамгаалах чиглэлийн төсөл, санаачлагуудад идэвхтэй оролцож, санхүүжүүлж ирлээ. Эдгээр чиглэлээр 100 гаруй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, нийт 1 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байдаг.



Үүнийг нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас үнэлж 2008, 2009 оны Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч шилдэг банкаар тодруулжээ. Ер нь ХААН Банк тэргүүлэгчийн байр сууриа улам баталгаажуулж, хөгжин дэвшиж ирснийг гадаад, дотоодын олон байгууллагаас шилдгээр шалгаруулсан үнэлгээ, шагнал, өргөмжлөл зэрэг нь бэлээхэн баталдаг.

2011 оны хувьд ХААН Банк хөгжлийн шинэ шатанд хөтлөх он жил юм. Олон улсын стандарт бүхий дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн банк болох зорилго тавьж харилцагчдынхаа итгэлийг даасан тэдэнд хамгийн ойр туслах байж цогц үйлчилгээ үзүүлэх зорилгоор "ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД" гэсэн уриаг дэвшүүлэн 2010 оны 8 дугаар сараас Олон улсын банк санхүүгийн түвшинд нэр хүнд бүхий банкны удирдлагад ажиллаж байсан туршлагатай банкир Саймон Моррис ХААН Банкны гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

### **Амжилтын нууц**

- 2010 оны арванхоёрдугаар сарын 31-ний байдлаар нийт актив нь 1 их наяд 556 тэрбум, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 1 их наяд 329 тэрбум болжээ. Өдгөө 4000 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.
- Санхүүгийн үйлчилгээгээр Монгол улсдаа тэргүүлэгч банк болсон. Монгол орны өнцөг булан бүрт хүрч үйлчилдэг 500 гаруй салбар нэгжтэй хамгийн том банк болсон.
- Олон улсын түвшинд үйл ажиллагаагаа тэлж Солонгос улсад төлөөлөгчийн газартай, дэлхийн хэмжээний 20 гаруй харилцагч банкны харилцаатай бөгөөд гол гол валютын данстай банк юм.
- ОН-ийн салбар нэгжийн материаллаг баазад 20 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.
- Нийгмийн сайн сайхны төлөө 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн
- Зөв менежмент. Банк, санхүүгийн шинэлэг менежментийг хувьчлалын өмнөөс хэрэгжүүлж, урьдчилсан төлөвлөгөө, бэлтгэлтэй ажилласнаар тогтвортой үйл ажиллагаа явуулж, асар богино хугацаанд үндсэн актив нь 1.5 их наяд төгрөгт хүрч Монголын хамгийн том брэнд банк болсон.
- Итгэлтэй, баталгаатай цогц үйлчилгээг бүхий л салбар нэгжүүд нь үзүүлдэг бөгөөд Монгол улсын хэмжээнд явагддаг өдөр тутмын гүйлгээний 70 хувь нь тус банкаар дамждаг. Мөн айл өрхийн 80 гаруй хувь нь тус банкны харилцагч бөгөөд энэ амжилтаа бататган үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж, харилцагчаа хүндэтгэж ажилладаг. Энэ шударга, шуурхай, цогц үйлчилгээ нь тухайн брэндийн имиж болсон.
- ХААН Банк нь найдвартай үйлчлүүлэгчийг эрж олоход гол анхаарлаа тавихын хажуугаар харилцагчийнхаа хариуцлагыг дээшлүүлэх хамтын ажиллагааны зөв менежментийг хэрэгжүүлж байна.

- Олон жилийн туршид тогтвортой ажилласан олон улсын удирдлагын баг нь тус банкиг харилцагчдынхаа "ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД" болох гарцыг тавьж чадсан.

### **Компанийн тухай товч мэдээлэл:**

Цахим хаяг: [www.khanbank.com](http://www.khanbank.com) Байгуулагдсан он: 1991 он

Компанийн хаяг: Сөүлийн гудамж-25, Улаанбаатар-44, Монгол Улс

Үйл ажиллагааны чиглэл: Банк, санхүү

## Томъёог

ТҮҮХ СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БРЭНДҮҮД 5

- МОНГОЛ ТҮМНИЙ БАХАРХАЛ БОЛСОН БРЭНД 7
- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЙХАМШИГТ БРЭНД 14
- ТҮХЛАГ ОРЧНЫГ ТҮМЭНД МЭДРҮҮЛСЭН БРЭНД 21
- МОНГОЛ ОРНЫГ ДЭЛХИЙД ТАНИУЛСАН БРЭНД 30
- ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЭРХЭМЛЭГЧ БРЭНД 37

ДЭЛХИЙН СТАНДАРТЫГ ҮЙЛДВЭРЛЭЛД

НЭВТРҮҮЛСЭН БРЭНДҮҮД 44

- МОНГОЛ ХҮНИЙ СЭТГЭЛ ШИГ БРЭНД 45
- ХҮН АМЫГ ХҮНСЭЭР ТЭТГЭГЧ БРЭНД 55
- БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ БРЭНД 63
- АМТ ЧАНАРЫГ ДЭЭДЭЛДЭГ БРЭНД 74
- ХҮНСНИЙ ТҮСГААР ТОГТНОЛЫГ ХАМГААЛАГЧ БРЭНД 84
- ЭХ ОРНЫ ХӨРСНӨӨС УРГАСАН ЦЭВЭР БРЭНД 93
- «МОНОПОЛЬ»-ООС МОНГОЛЫН НЭРИЙГ ДЭЛХИЙД ГАРГАХ ХҮРТЛЭЭ ХӨГЖСӨН БРЭНД 98
- ТҮҮХ АМТАГДАЖ СЭТГЭЛ СЭРГЭЭСЭН БРЭНД 108
- ДЭЛХИЙД ТАНИГДСАН МОНГОЛ БРЭНД 115
- МОНГОЛ НООЛУУРААР ДЭЛХИЙГ ГОЁСОН БРЭНД 124
- ХЭВЛЭЛИЙН САЛБАРЫН МАНЛАЙЛАГЧ БРЭНД 131
- АМЬДРАХ ОРЧИН, АЯ ТУХЫГ ХАНГАСАН БРЭНД 138
- ЭРҮҮЛ МЭНД, ГОО САЙХНЫГ БЭЛЭГЛЭГЧ БРЭНД 146
- ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН БАТАЛГАА БОЛСОН БРЭНД 155

дэлхийн жишгийг монголд тогтоосон брэндүүд 163

- ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД АВЧРАГЧ БРЭНД 164
- ШИНЭЧЛЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БРЭНД 168
- ГЭР БҮЛИЙН ДҮР ТӨРХТЭЙ БРЭНД 176
- ДЭЛХИЙН ШИЛДЭГ ТЕХНОЛОГИЙГ ИМПОРТЛОГЧ БРЭНД 184

үйлчилгээний ертөнцөд цахиур хагалсан брэндүүд 196

- АЗИ, ЕВРОПЫГ ХОЛБОСОН АМЬДРАЛ ТЭТГЭГЧ БРЭНД 197
- АГААР ТЭНГЭРТ АМГАЛАН ЗОРЧУУЛАГЧ БРЭНД 201
- ХОЛЫГ ОЙР ТУУЛАГЧ ХОЛБООНЫ АНХДАГЧ БРЭНД 211
- ҮРГЭЛЖ ШИНИЙГ ЭРЭЛХИЙЛЭГЧ БРЭНД 218
- ӨРТӨӨ ШУУДАН МОНГОЛЧУУДЫН БРЭНД 224
- ДААТГАЛЫН САЛБАРТ ЦАХИУР ХАГАЛСАН БРЭНД 231
- ТЕЛЕВИЗИЙН ТҮҮХЭНД ШИНЭЧЛЭЛ ХИЙСЭН БРЭНД 239

уул үурхайн шинэчлэл хийсэн брэндүүд 245

- МОНГОЛ БРЭНД ■ УХАА ХУДАГ 246
- БИЕ СЭТГЭЛ ДУЛААЦУУЛСАН БРЭНД 253
- ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛСАН БРЭНД 261

банк санхүүгийн тэргүүлэгч брэндүүд 268

- ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭГЧ ХАДГАЛАМЖ БРЭНД 269
- ЭХ ОРОНДОО ХАЙРТАЙ БРЭНД 276
- ТОГТВОРТОЙ, НАЙДВАРТАЙ БРЭНД 287
- ГАДААДАД ЗОРЧИХ САНХҮҮГИЙН ЭРХ ОЛГОСОН БРЭНД 296
- ТҮМЭНД ИТГЭЛТЭЙ, ТҮГЭЭМЭЛ СҮЛЖЭЭТЭЙ БРЭНД 302

# Table of Contents

[Өмнөх үг](#)

[Монгол түмний бахархал болсон брэнд](#)

["Женко тур бюро" ХХК](#)

[Аялал жүүлчлалын гайхамшигт брэнд](#)

[Тухлаг орчныг түмэнд мэдрүүлсэн брэнд](#)

[Монгол орныг дэлхийд таниулсан брэнд](#)

[Эрүүл мэндийг эрхэмлэгч брэнд](#)

[Монгол хүний сэтгэл шиг брэнд](#)

[Хүн амыг хүнсээр тэтгэгч брэнд](#)

[Байгаль орчинд ээлтэй брэнд](#)

[Амт чанарыг дээдэлдэг брэнд](#)

[Хүнсний тусгаар тогтнолыг хамгаалагч брэнд](#)

[Эх орны хөрснөөс ургасан цэвэр брэнд](#)

[«МОНОПОЛЬ»-оос Монголын нэрийг дэлхийд гаргах хүртлээ хөгжсөн брэнд](#)

[Түүх амтагдаж сэтгэл сэргээсэн брэнд](#)

[Дэлхийд танигдсан монгол брэнд](#)

[Монгол ноолуураар дэлхийг гоёсон брэнд](#)

[Хэвлэлийн салбарын манлайлагч брэнд](#)

[Амьдрах орчин, ая тухыг хангасан брэнд](#)

[Монос групп эрүүл мэнд, гоо сайхныг бэлэглэгч брэнд](#)

[Эрүүл амьдралын баталгаа болсон брэнд](#)

[Дэлхийн хөгжлийг монголд авчрагч брэнд](#)

[Шинэчлэлт өөрчлөлтийн брэнд](#)

[Гэр бүлийн дүр төрхтэй брэнд](#)

[Дэлхийн шилдэг технологийг импортлогч брэнд](#)

[Ази, европыг холбосон амьдрал тэтгэгч брэнд](#)

[Агаар тэнгэрт амгалан зорчүүлагч брэнд](#)

[Холыг ойртүүлагч холбооны анхдагч брэнд](#)

[Үргэлж шинийг эрэлхийлэгч брэнд](#)

[Өртөө шуудан монголчуудын брэнд](#)

[Даатгалын салбарт цахиур хагалсан брэнд](#)

[Телевизийн түүхэнд шинэчлэл хийсэн брэнд](#)

[Монгол брэнд - Ухаа худаг](#)

[Бие сэтгэл дүлаацуулсан брэнд](#)

[Эрсдэлийг даван туулсан брэнд](#)

[Харилцааг эрхэмлэгч хадгаламж брэнд](#)

[Эх орондоо хайртай брэнд](#)

[Капитал банк тогтвортой, найдвартай брэнд](#)

[Гадаадад зорчих санхүүгийн эрх олгосон брэнд](#)

[Түмэнд итгэлтэй, түгээмэл сүлжээтэй брэнд](#)

[Томъёог](#)